



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр, Пүрэв гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-10</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>11-129</i>
<hr/>	
<i>1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлт</i>	<i>14-36</i>
<i>2.“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.09.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>36-93</i>
<i>3.Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах</i>	<i>93-102</i>
<i>4.Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох</i>	<i>102-128</i>
<i>5.Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа</i>	<i>128-129</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
10 дугаар сарын 05-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 53.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 04 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Ж.Бат-Эрдэнэ, Х.Булгантуяа, Л.Мөнхбаатар, Д.Өнөрболор, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Ганхуяг, Ц.Сэргэлэн, Ж.Эрдэнэбат;

Тасалсан: А.Адъяасүрэн, Д.Батлут, С.Ганбаатар, Г.Ганболд, Ч.Хүрэлбаатар;

Хоцорсон: Ц.Анандбазар -15 минут, Т.Аубакир -22 минут, С.Батболд -2 цаг 46 минут, Б.Баттөмөр -19 минут, Х.Нямбаатар -3 цаг 03 минут, М.Оюунчимэг -15 минут, Ч.Ундрал -19 минут, Н.Учрал -09 минут, О.Цогтгэрэл -03 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар анхаарал хандуулах шаардлага үүсээд байгааг тэмдэглэж, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хяналт шалгалт явуулахыг холбогдох Байнгын хороод болон бусад байгууллагад үүрэг болгов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржоос ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

**Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлт**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Туулхүү оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Золжаргал, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Туулхүү, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл нар танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Ц.Мөнх-Оргил, Т.Доржханд, Б.Пүрэвдорж, Б.Баттөмөр, Ш.Адъяаа, Ц.Мөнхцэцэг, Ж.Батсуурь, О.Цогтгэрэл, Д.Ганбат, Н.Энхболд нар үг хэлэв.

*Байнгын хороодын санал тус бүрээр санал хураалт явуулав.*

**Г.Занданшатар:** 1.Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 15  
Бүгд: 44  
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 14  
Бүгд: 43  
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 14  
Бүгд: 43  
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонголт хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 12  
Бүгд: 43  
72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонгогч хийж...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 13  
Бүгд: 43  
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонгогч хийж...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 13  
Бүгд: 43  
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонгогч зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонгогчын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонгогчын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31  
Татгалзсан: 12  
Бүгд: 43  
72.1 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонгогч зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонгогчын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонгогчын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон

баталгаагаар хангагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 13  
Бүгд: 43  
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонгогч зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонгогчын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонгогчын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 13  
Бүгд: 43  
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонгогч явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 13  
Бүгд: 43  
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонгогч явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар ... Ерөнхийлөгч томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 14

Бүгд: 43  
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад "... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол." гэж заасны "... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно." гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 13  
Бүгд: 43  
69.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**Г.Занданшатар:** "Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийн тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 13  
Бүгд: 43  
69.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар "Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийн тухай" Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:46/

*Уг асуудлыг 11 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.** "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.09.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Н.Ариунбат, Төлбөр тооцооны газрын захирал Э.Анар, Судалгаа, статистикийн газрын захирал Д.Даваасүх, Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Эдийн засгийн шинжилгээ, бодлогын хэлтсийн захирал Б.Цэнд-Аюуш, Санхүүгийн мэдээллийн албаны дарга Б.Батбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, С.Одонтуяа, Д.Тогтохсүрэн, Д.Ганбат, М.Оюунчимэг, С.Чинзориг, Ц.Идэрбат, Б.Пүрэвдорж, Б.Энх-Амгалан, Э.Батшугар, Б.Баттөмөр, Ж.Батжаргал, Ц.Сандаг-Очир, Т.Доржханд, Т.Энхтүвшин, Г.Амартүвшин, О.Цогтгэрэл, Ш.Адьяа нарын тавьсан асуултад Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал Н.Ариунбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Адьяа, Д.Ганбат, Б.Баттөмөр нар үг хэлэв.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.*

#### ***Гурав. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, нэр дэвшигч, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Н.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөхийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Золжаргал нар байлцав.

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Танилцуулга болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Б.Баярсайхан, Д.Ганбат, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, нэр дэвшигч Н.Батзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурал Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцлаа.

*Уг асуудлыг 15 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.*

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох асуудлыг Засгийн газраас нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн тул хэлэлцэх асуудлын дараалалд оруулж, хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.



**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 23

Бүгд: 49

53.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

***Дөрөв.Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргад нэр дэвшигч Борхүүгийн Дэлгэрсайхан, Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайдад нэр дэвшигч Баттөмөрийн Энхбаяр нарыг сайдаар томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ танилцуулав.

Ерөнхий сайд болон томилогдох этгээдээс Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Б.Баярсайхан, С.Одонтуяа, М.Оюунчимэг, О.Цогтгэрэл, Б.Пүрэвдорж, Ш.Адьяаа, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг, Ц.Мөнхцэцэг, Н.Учрал нар үг хэлэв.

Улсын Их Хурал Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонслоо.

*Уг асуудлыг 17 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.*

*Хуралдаан 17 цаг 49 минутад түр завсарлаж, 18 цаг 20 минутаас үргэлжлүүлэн хуралдав.*

***Тав.Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын даргын зөвлөх О.Номинчимэг, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Дэд дарга Ц.Батбаатар, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох, Улсын Их Хурлын даргын Ажлын албаны дарга С.Зоригт нар байлцав.

Ёслолын ажиллагааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Төрийн ёслол, хамтын ажиллагааны газрын дарга Э.Одмөнх, мөн газрын референт П.Батжаргал, Ц.Уранчимэг, шинжээч Б.Мөнхбилгүүн нар зохион байгуулав.

Танхимын баруун хойд болон зүүн хойд дэлгэцнээ *“Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.”* гэсэн бичиг гарч байв.

“Их хуралдай” танхимын голд Төрийн далбаа, Үндсэн хууль, тангаргийн бичиг, үзэг тавьж тусгайлан бэлтгэсэн ширээг сандлын хамт, түүний урд Засгийн газрын гишүүний тангараг өргөх ёслолд зориулан бэлтгэсэн индрийг байрлуулж, Төрийн сүлдний баруун талд хүндэт харуул зогссон байв.

Монгол Улсын Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын дагуу тангараг өргөх ёслолын ажиллагаа эхлэв.

“Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжийг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ танилцуулав.

*Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын 2020 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын гишүүний тангараг өргөх журмын 10-т заасны дагуу шинээр томилогдож буй Засгийн газрын гишүүдийн нэрийг дуудав.*

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны даргад Борхүүгийн Дэлгэрсайхан;

2.Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Хууль зүй, дотоод хэргийн сайдад Баттөмөрийн Энхбаяр.

Нэр дуудагдсан Засгийн газрын гишүүд суудлаасаа босож индрээс *“Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.”* хэмээн тангараг өргөв.

Тангараг өргөсний дараа Засгийн газрын гишүүд Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, Төрийн далбааны өмнө баруун өвдөг мэхийн сууж адис аван, “Их хуралдай” танхимын голд

байрлуулсан ширээнд сууж, тангаргийн бичигт гарын үсэг зурж, Улсын Их Хурлын даргад тангаргийн бичгээ гардуулсны дараа Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулав.

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүний үнэмлэх, энгэрийн тэмдгийг гардуулж, дууссаны дараа Монгол Улсын Төрийн дууллыг “Их хуралдай” танхимд эгшиглүүлэхэд хуралдаанд оролцогсад суудлаасаа босож хүндэтгэл үзүүлэв.

Төрийн дуулал эгшиглэж дуусмагц Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд баяр хүргэн үг хэлж, Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэв.

*Тангараг өргөх ёслолын ажиллагаа 18 цаг 31 минутад дуусав.*

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн урилгаар Ховд аймгийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшингийн урилгаар Нийслэлийн Хан-Уул дүүргийн ахмадуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн урилгаар Нийслэлийн Баянгол дүүргийн ахмадуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Идэрбат нарын урилгаар Хэнтий аймгийн Дадал сумын ахмадуудын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэгийн урилгаар Нийслэлийн ерөнхий боловсролын “Оюунлаг” сургуулийн 10А, 10Б, 10В ангийн багш, сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 7 цаг 57 минут үргэлжилж, 73 гишүүнээс 58 гишүүн хүрэлцэн ирж, 79.5 хувийн ирцтэйгээр 18 цаг 32 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 04 минут.

### **НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданишатар:** Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Ирц бүрдсэн, 53,4 хувьтай байна. Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 3 асуудал хэлэлцэнэ. 1 дүгээрт Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 5 дугаар дүгнэлт, 2 дугаарт Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, 3 дугаарт Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах асуудал, 4 дүгээрт хэлэлцэх асуудалтай холбогдуулаад маргаашийн мэдээллийн цагаар энэ хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг ярилцах зайлигүй шаардлага гарч байна.

Эрхэм гишүүдээ энэ сүүлийн үед хүүхдийн эрх зөрчигдөж байгаа асуудал онцгой анхаарал татаж байна. Бараг өдөр болгон хүүхдийн эрх зөрчигдөж байгаа тухай мэдээлэл гарах боллоо. Хүүхэд авто замын ослын хохирогч болж байна. Амь насаа алдаж байна, бусдад дээрэмдүүлж байна, гэр бүлийн болон бусад орчинд хүчирхийлэлд өртөж байна. Гэр орондоо угаартаж байна. Хүүхдийг элдэв хэлбэрээр хүчирхийлэх, ялгаварлан гадуурхах, бүр хүүхдийн наймаа, худалдаа, хүний наймааны ноцтой мэдээллийн хэрэг явдлууд ч гэсэн мэдээлэгдэж байна. Өчигдөр мэдээлснээр 20 гаруй хүний наймааны хэрэг бүртгэгдсэнээс 8 насанд хүрээгүй хүүхэд гарч байна гэж байна. Хамгийн сүүлд Дорноговь аймагт 12 настай хүүхэд алга

болоод бүтэн 2 хонож байна. Эрэн сурвалжлах ажиллагаа хийж байгаа боловч хараахан үр дүн гараагүй байна. Энэ бол ийм эмгэнэлтэй үйл явдлууд болж байна шүү дээ.

Зөвхөн сүүлийн арваад хоног гэхэд л 13 настай охин сургуулийнхаа урд гарц дээр машинд дайруулсан, Дорнод аймагт 7 настай хүүхэд хойд эцгийнхээ гарт амь үрэгдсэн, бага насны 3 хүүхэд ээжтэйгээ хамт угаартсан, энэ сарын 2-нд орон сууцын хотхоны 9 давхраас 7 болон 5 настай хүүхдүүд унаж амь насаа алдсан гэсэн аймшигтай үйлдэл гэмт хэргүүд гарлаа. Бас гарц дээр хүүхэд ээжтэйгээ дайруулсан хэрэг гарлаа. Улсын хэмжээнд 48 цагаас эхлээд 20-оос 30 жил хүртэл эрэн сурвалжлагдаж байгаа одоо болтол олдоогүй ямар нэг сураг гараагүй 20 шахам хүүхэд байна гэж байна. Энэ Монгол даяар эмгэнэл, түгшүүр, айдас төрүүлж байгаа энэ гэмт үйлдлүүдийг томчууд ялангуяа төр засгийн байгууллагууд анхаараад зүгээр сууж байж ажиллахгүй. Монгол хүүхэд гэмт хэргийн золиос болж болохгүй. Хүүхэд хамгаалах тухай хууль чинь хүүхдийг эрсдэлт орчинд нөхцөл байдлыг тодорхойлж, хүүхдийг боловсролын орчинд, сургуулийн орчинд, гэр бүлийн орчинд эцэг, эхийн үүргээс авхуулаад төрийн байгууллага, боловсролын байгууллагуудын үүрэг чиглэлийг тодорхой заасан. Энэ хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Нийслэл, аймаг, дүүргүүдийн энэ камержуулалд, сургуулийн орчны камержуулалд, өч төчнөөн мөнгө төгрөг зарж улсын төсвийн хөрөнгөөр хийчихсэн энэ ажлууд яагаад хэрэгжихгүй байгаа юм. Монгол хүүхэд бол ийм гэмт хэргийн золиос байж таарахгүй. Монгол Улс Хүүхдийн эрхийн тухай олон улсын конвенцод 1990 онд элссэн. 1996 онд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль баталсан. 2016 онд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг шинэчилж баталсан юм. Монгол хүүхдийн эрхийг хамгаалах үүргийг дэлхий дахины өмнө

болон Монгол Улсынхаа иргэдийнхээ өмнө энэ хүлээсэн байгууллагууд тодорхой заагдсан байгаа юм. Гэвч энэ үүргээ бол бид шулуухан хэлэхэд маш муу хэрэгжүүлж байна. Энэ холбогдох байгууллагууд энэ эрсдэлт нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж байгаа юм алга байна. Хүүхдийн үндсэн эрх энэ амьд явах, хөгжих, хамгаалуулах, оролцох эрхүүд бүрэн хангаж чадаж байна уу? Энэ эрхүүд зөрчигдөж байгаа талаар маш олон баримтуудыг дурдаж ярьж байна.

Тийм учраас энэ дээр манай Улсын Их Хурлын гишүүд онцгой анхаарах хэрэгтэй байна. Хүүхдийг төрснөөс нь эхлээд өөрөө хариуцлага хүлээх чадвартай болох хүртэл нь буюу 18 нас хүртэл нь бид хамгаалах үүрэгтэй. Энэ үүргийг Монгол Улсын Их Хурлаас эхлээд, ЗГ, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, яам тамгын газрууд, орон нутгийн захиргааны байгууллагууд, Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж байгууллага, гэр бүл бүрийн эрхэм үүрэг гэж үзэж хэрэгжүүлэх ёстой. Хүүхэд гэр бүлийн орчин, сургуулийн орчин, нийгмийн орчиндоо бүх талаар хамгаалагдсан байх, хүүхэд хамгааллын тогтолцоо бүрдүүлэх нь нэн чухал тулгамдсан асуудал боллоо.

Бид энэ хүүхдэд ээлтэй орчин үйлчилгээ, үйл ажиллагаа бүрдүүлэхгүйгээр энэ зорилтыг шийдвэрлэж хангаж чадахгүй юм байна. Хүүхдэдээ ээлгүй улс үндэстэн улс орны ирээдүй бүрхэг болно. Учир нь бол хүүхэд бол улс орны ирээдүй маргааши юм. Манай нийгмийн ёс зүй, мораль хүүхэддээ ээлгүй байна. Хүүхдэд эрсдэлтэй орчин болсон байна. Зөвхөн өөрийнхөө биш бусдын хүүхдийг ч гэсэн өөрийн мэт хайрлан энэрэх Монгол ёс уламжлал алдагдсан байна. Тиймээс хүүхдийн эрхийн талаар нийгмийн ёс зүйг эрүүлжүүлэх нь маш чухал байна. Үүнийг үүний тулд бол энэ хүүхдийн эрхийн тухай, гэр бүл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгаалах тухай хууль

тогтоомжоо хэрэгжүүлэхэд манай Улсын Их Хурлын гишүүд ялангуяа эмэгтэй гишүүд манлайлал үзүүлж ажиллах шаардлагатай байна. Энэ чиглэлд Нийгмийн бодлогын, БСШУС-ын Байнгын хороод, Улсын Их Хурал дахь хүчирхийлэлтэй тэмцэх бүлгэмүүд онцгой анхаарлаа анхаарлаа хандуулж, ойрын үед шийдвэртэй арга хэмжээ авахыг үүрэг болгож байна.

Түүнчлэн хүүхдийн эсрэг гэмт хэрэгт оноох ялын бодлогыг чангатгах хэрэгтэй байна. Ямар нэгэн өршөөл, уучлалт хамруулдаггүй байх хэрэгтэй байна. Ийм эрх зүйн шинэчлэлийг хийж болно гэж бодож байна. Нийгэмд аймшигт автуулаад байгаа тэр гаж донтон, хүүхдийн эрхийг зөрчигчдөдөө хатуу хариуцлага тооцдог болох хэрэгтэй байна. Улсын Их Хурал хууль бүхэнд хүний эрхийг амин сүнс болгон суулгаж хүний эрхийг дээдэлнэ гэж тунхагласан. Хүний эрх хүүхдээс эхэлнэ. Хүүхэд ямагт 1 дүгээрт байх ёстой. Тэгээд энэ ажилд манай Улсын Их Хурлын гишүүд онцгой анхаарлаа хандуулж, хүүхдийн эрхийн төлөө, хүүхэд хамгааллын төлөө хүсэл зоригоо нэгтгэж өнөө маргаашигүй холбогдох Байнгын хороод хуралдаж, шаардлагатай бол маргааши мэдээллийн цаг дээр ч гэсэн мэдээлэл сонсож ярилцах хэрэгтэй байна. Үүнийг ингээд холбогдох Байнгын хороод хүүхэд хамгаалах бүлгэмүүдэд даалгаж байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орохын өмнө Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу гишүүн энэ хуулийн 9.5-д заасан хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржоос албан бичиг ирүүлсэн байна. Хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотойгоор үг хэлэх зөвшөөрөл олгоно уу. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны



*Пүрэвдорж гэсэн байна. Ингээд Бөхчулууны Пүрэвдорж гишүүнд үг өгье.*

**Б.Пүрэвдорж:** *Их Хурлын гишүүд чуулганы завсарлагаар ард иргэдтэйгээ уулзах ёстой. Энэ дагуу Ховд аймгийн 48 сум багаар болон Баян-Өлгий аймгийн 1, Архангай аймгийн 6 сумаар явж уулзалт хийж, 6200 гаруй иргэнтэй уулзлаа. Нийтдээ 400 гаруй хүн асуулт асууж, санал хэлсэн байна. Энэ дээрээс Чандмань сумын Гэсэр нарын бүх багийн малчид ер нь арьс шир хаягдаж байна. Махны үнэ малчны хотонд 5 мянга байна, үнээ өсгөх талаар ажиллаач, тэр ченжүүдийн асуудлыг зохицуулаач гэж хүсэлт гаргаж байна. Манхан сумын Улаан хүрээ баг дээр Мөнхөөгийн Цэндсүрэн эгч Улсын Их Хурлын гишүүд малчин аав ээжгүй учраас малчдын талаар ерөөсөө өөдтэй шийдвэр огт гаргахгүй байна. Энэ талаараа анхаараач гэж байна. Дуут сумын Хөх бэлчир багийн Отгоншар, Зэрэг сумын Бураа багийн Одноо нарын малчид чоно ихэдлээ малаа барлаа 20 тугалаас нэг нь үлдлээ. Талын чоно хангайн чоноо хориод, тэр уулын чоноо болиоч. Тэгэхгүй бол 100 мянгаар чоно ална аль эсвэл зөвшөөрөлгүй ачихаар торгоод ерөөсөө зүгээр байлгахгүй байна гэж байна.*

*Дуут сумын Шивэр багийн өндөр настан Д.Шилэг нарын ахмадууд нэгдлийн мал маллаж байсан хүмүүсийн тэтгэвэр толгой дараалан 50 мянган төгрөгөөр л нэмэгдлээ. Нэгдлийн мал маллаж байсан бидний буруу юм уу яахаараа ийм муу шийдвэр гаргадаг юм бэ гэж байна. Мөст сумын Идэш гуа, Зэрэг сумын Хандаа эгч, Цэцэг сумын Бямбадорж ах, Буянт сумын Насанбаатар, Дөргөн сумын Нордууд гуай нарын хүмүүс нүүрс, төмөр зам, Хөгжлийн банк, Боловсролын зээлийн сангийн хулгай хэрээс хэтэрлээ. Уудалж илчилж байгаа нь зөв байна. Гэвч нэгэндээ барьцаалагдсан эрх баригч нар нэгэндээ ерөөсөө хариуцлага тооцохгүй байна. Энэ хариуцлага тооцох ажлаа шуурхайл гэж байна.*

*Ховд сумын Хурметхан, Эрдэнэбүрэн сумын Шураг багийн Нямхүү нар бензин шатахууны үнийг АН шиг Улаанбаатартай адилхан болгооч. Энэ Алтанхуягийн энэ ЗГ чинь баруун аймгийнхыг Улаанбаатартай адилхан болгож байсан байхгүй юу даа. Тэгээд НӨАТ-ын татварыг чөлөөлөхөд Улаанбаатартай адилхан болчихно шүү дээ, энийгээ хийгээч гэж байна. Архангай аймгийн Өлзийт сумын Ариунаа багш сумд малын мах 5 мянган төгрөг байж, байхад сургуулийн хоол хүүхдийн хоолны мөнгө мах 11 мянган төгрөг байна хажууханд нь байгаа. Тэгээд энэ Тендерийн хуулиа эргээж хараач гэдэг ийм хүсэлтийг тавьж байна. Ядмаагийн Болдбаатар чинь аль сум билээ байз, уул уурхайгаас ганцаараа ашиг олдог тэр уул уурхайн эзэн. Гэтэл ХАА-гаас бултаараа, бултаараа ашиг ол хүртдэг. Тэгээд ХАА-г төрөөс дэмжих талаар ажиллаач. Хамгийн гол нь тэр Ерөнхийлөгчийн арга хэмжээ сум багт ер нь хүрэхгүй байна шүү гэдэг ийм зүйлийг хэлж байна.*

*Тэгээд ер нь бол олон хүмүүс бүгдээрээ л энэ бугшсан хулгайд л үзэн ядсан хүмүүс л дүүрэн байна шүү. Тэгээд яг та нарыг уулзалт хийж явж байх тэр ногоон автобусны асуудал гараагүй. Ерөөсөө энэ дээрээсээ доороо бүх бүгдээрээ энэ, дээр нь хулгай хийж байгаа юм чинь доор нь бид нар яадаг ч яасан юм гэдэг байдлаар энэ дунд, доод шатын хүмүүс чинь ерөөсөө бүгд тийм нэг авлигын системийг Монголд хөгжүүлсэн ийм нөхөд бий болчихож. Сумын сургуулийн захирал үйлчлэгч ажилд авахдаа юм өг гэдэг, нөгөөдөх нь өгөх юм байхгүй болохоор чиний 5 сарын цалинг чинь авна. Тэрний 6 дахь сараасаа чи цалингаа авна шүү гээд ингээд авлигал аваад л ажилд оруулж байна. Энэ Монгол орон ерөөсөө авлигаар бүрэн өвчсөн ийм л орон болж хувирч байна. Энэ төрийн өндөрлөгт байгаа, ялангуяа эрх барьж байгаа та бүхний энэ увайгүй үйлдлээс болоод энэ Монгол даяараа ийм замбараагүй, ийм одоо Монголыг ялзруулсан ялзралд оруулсан ийм л нийгэм*

болгож хувирч байна гэдэг дээр л манай ард иргэд маш их үг хэлж байна шүү. Тэгээд энэ гол нь хариуцлага тооцох асуудлыг л сайн хийхгүй бол тэгээд та нар ч мэдэхгүй. Та нарыг очихоор танай Ардын намын голоуу хэдэн хөгшичүүд ахмадууд уулздаг байх. Тэгээд бас халираад юм ярьж чаддаггүй байх л даа. Тэр хүмүүс чинь над дээр ирээд бас юмаа хэлээд байна шүү дээ.

**Г.Занданишатар:** Пүрэвдорж гишүүн үг хэллээ.

### **Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлт**

Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 5 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ. ҮХЦ-ийн дүгнэлтийг ҮХЦ-ийн гишүүн Гомбожавын Туулхүү танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Туулхүү:** Монгол Улсын Их Хурлын дарга болон эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 05 тоот дүгнэлтийг уншиж сонсгоё. Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль, Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль, Авлигын эсрэг хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай.

Монгол Улсын ҮХЦ-ийн дунд суудлын хуралдааныг ҮХЦ-ийн гишүүн Г.Баясгалан даргалж, ҮХЦ-ийн гишүүн С.Солонго, Г.Туулхүү, Ч.Эрдэнэбулган, Д.Гангабаатар нарын бүрэлдэхүүнтэй хуралдааны нарийн бичгийн даргаар Баяржаргалыг оролцуулан ҮХЦ-ийн хуралдааны танхимд нээлттэй хийлээ. ҮХЦ-ийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргах иргэн Ж.Батмөнх оролцлоо. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд хүндэтгэн үзэх

шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй бөгөөд биечлэн оролцох хүсэлт ирүүлээгүй болно. Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2 дахь заалт болон Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1, Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Дөчинесдүгээр зүйлийн 1, 3, 5, 6, Тавиннэгдүгээр зүйлийн 2, Тавинзургадугаар зүйлийн 2, Жарандөрөвдүгээр зүйлийн 2, 3, Жарантавдугаар зүйлийн нэг дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааны хянан хэлэлцлээ.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт ШЕЗ-ийн гишүүдийн 5-ыг шүүгч дотроосоо сонгож, бусад 5 гишүүний нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно. Мөн зүйлийн 6 дахь хэсэгт хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ноогдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлагыг, томилох журмыг хуулиар тогтооно гэж заажээ.

Энэхүү зохицуулалтын дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.11 дэх хэсэгт Улсын Их Хурлын ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнийг тодорхой журмаар нээлттэйгээр нэр дэвшүүлж, томилгооны сонгол явуулахаар заасан байх бөгөөд мөн хуулийн 95 дугаар зүйлийн 95.4 дэх хэсэгт Сахилгын хорооны бүрэлдэхүүнд Хяналт шалгалт, хяналтын шатын шүүхээс 1, Давж заалдах шатын шүүхээс 2, анхан

шатын шүүхээс 1 шүүгчийг нийт шүүгчдийн чуулганаар нууц санал хураалтаар сонгож, Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох бусад 5 шүүгчийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно гэж тусгайлан зааж, Сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг тус 76 дугаар зүйл, тус хуулийн 77 дугаар зүйлийн холбогдох заалтад зааснаар нээлттэй нэр дэвшүүлж томилгооны сонсгол явуулан томилохоор хуульчилжээ.

Ийнхүү Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн холбогдох зохицуулалтаар ШЕЗ болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн томилгооны сонсгол хийхээр хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурдсан зохицуулалтын дагуу нэр дэвшүүлж, томилох ажиллагаа нь нээлттэй байх үзэл баримтлалд нийцсэн байх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн тухай хуулийн зохицуулалттай уялдаатай байх тул Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй байна.

Хоёр. Авлигын эсрэг хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг АТГ-ыг авлигын эсрэг олон нийтийн соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэл, мөрдөн байцаалт явуулах энэ хуульд заасан этгээдийн ХОМ-ийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус бие даасан төрийн тусгай байгууллага гэж тодорхойлжээ. Мөн тухайн байгууллагын бүтэц, орон тоог батлах, түүнчлэн өөрчлөн батлуулах, татан буулгах асуудлыг ҮАБЗ-ийн зөвлөмжийг үндэслэн шийдвэрлэх, АТГ-ын дарга, дэд даргыг холбогдох журмын дагуу томилох, чөлөөлөх, огцруулах бүрэн эрхийг Улсын Их Хурал хэрэгжүүлэхээр уг хуулийн 15.17, 21, 22 дугаар зүйл тус тус хуульчилсан байна.

Үүнээс үзэхэд Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч тухайн

байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад тавигдах шалгуур бодлогыг нарийвчлан тодорхойлж, нэр дэвшүүлэн томилох журмыг хуульчлан тогтоох нь хууль тогтоогчийн бүрэн эрхэд хамаарч байна. Иймд Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 22.1.2 дахь хэсэгт томилгооны сонсгол гэж тус тус заасан нь түүнчлэн Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх хэсэгт АТГ-ын дарга, дэд дарга гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулаагүй байна.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт ҮХЦ, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна. Мөн хуулийн 3 дахь хэсэгт ҮХЦ-ийн гишүүний хараат бус байдал нь Үндсэн хууль бусад хуулиар тогтоогдсон баталгаагаар хангагдана. 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт ҮХЦ 9 гишүүнээс бүрдэнэ, эдгээрийн 3-ыг Их Хурал, 3-ыг Ерөнхийлөгч, 3-ыг Дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно гэж заасан. Мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана, 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт ШЕЗ-өөс Улсын Дээд шүүхийн шүүгчийг Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос 6 жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно гэс тус тус тогтоожээ. Монгол Улсын Үндсэн хуулийн эдгээр зохицуулалт нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч дээд байгууллагуудын бие даасан хараат бус байдлыг, баталгааг бүрдүүлсэн байх бөгөөд Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэгч болон шүүх эрх мэдлийн холбогдох албан тушаалд нэр дэвшүүлэх, томилох байгууллага, албан тушаалтныг Үндсэн хуулийн түвшинд тодорхойлон хуульчлан заасан байна.



*Дөрөв.Ийнхүү ҮХЦ-ийн гишүүнд нэр дэвшүүлэн санал болгох онцгой бүрэн эрхийг Үндсэн хуулиар тодорхойлж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Дээд шүүх зэрэг эрх бүхий этгээдэд олгосон байхад ердийн хуулиар буюу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад ҮХЦ-ийн гишүүнд томилуулахаар санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлаас томилгооны сонсгол хийлгэхээр зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурдсан заалтад заасан бүрэн эрхийг хөндөж, ҮХЦ-ийн гишүүн болон тухайн институтийн бие даасан хараат бус байдлын баталгааг алдагдуулах үндэстэй байна.*

*Тодруулбал Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын дээд шүүхийн болон холбогдох эрх бүхий этгээдийн нэгэнт сонгон шалгаруулалт хийж, нэр дэвшүүлэн санал болгосон байхад дээрх зохицуулалтаар тухайн бүрэн эрхэд нь хөндлөнгөөс нөлөөлөх, шууд бусаар халдах боломжийг олгосон нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2, 3, 65 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн байна.*

*Тав.Монгол Улсын Их Хураас 1921 оны 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалт баталсантай уялдуулж Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол хийхтэй холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулсан нь дээр дурдсан үндэслэлээр Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй.*

*Зургаа.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.1.2 дахь заалтад танилцах,*

*зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд Монгол Улсын Улсын Их Хурлын 9-өөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол явуулахаар заасан нь агуулгын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ШЕЗ-өөс Улсын дээд шүүхийн шүүгчийг Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно гэсэн заалтад нийцэхгүй байна. Тухайлбал уг зохицуулалтын дагуу тодорхой тооны Улсын Их Хурлын гишүүний саналаар Улсын Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчид холбогдуулан сонсгол хийж болох эрх зүйн үр дагаврыг үүсгэж байгаа нь Улсын Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтаар танилцуулах эрх бүхий этгээд болон улмаар тэднийг томилох Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулиар тодорхойлсон бүрэн эрхийг хязгаарлаж, хөндлөнгөөс шууд бусаар нөлөөлөх боломжийг бүрдүүлсэн гэж үзэхээр байна. Мөн дээрх зохицуулалтад зөвшилцөх гэж тусгасан нь УЕП түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч томилох талаар Монгол Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтад харшилж байна.*

*Долоо.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн заалтууд нь нийтлэг агуулгатай буюу анхан болон дахин томилогдож байгаа аль ч нэр дэвшигчид хамаарах ерөнхий утгыг илэрхийлсэн зохицуулалттай байна. Энэ нь маргаан бүхий зохицуулалтын хүрээнд авч үзвэл эрх бүхий этгээд Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд холбогдох албан тушаалтан, өмнө нь томилогдсон хүнийг дахин нэр дэвшүүлэн санал болгох тохиолдолд дахин томилгооны сонсгол хийх үр дагаврыг үүсгэж байх бөгөөд улмаар тухайн албан тушаалтны өмнөх бүрэн эрхийн хугацаанд гаргасан шийдвэр, үйл ажиллагаа, хамтын зарчмаар гаргасан эсэхийг үл хамааран шүүн хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт хийх*

боломжийг бүрдүүлж, хуулиар баталгаажсан хараат бус байдлын зарчмыг алдагдуулах нөхцөлийг үүсгэсэн гэж үзэхээр байна.

Иймд дээрх зохицуулалтыг боловсронгуй болгож, тухайн албан тушаалын онцлогтой холбогдуулан анхан болон дахин томилохтой холбоотой зохицуулалтыг нарийвчлан хуульчлах шаардлагатайг тэмдэглэх нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон тогтоох нь. Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь.

Нэг.Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад ҮХЦ-ийн гишүүн Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол хийж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. Нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш тухайн тайлан санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ҮХЦ түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусдад хүнээс хараат бус байна, 3 дахь хэсгийн ҮХЦ-ийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль бусад хуулиар тогтоогдсон баталгаагаар хангагдана, 65 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн ҮХЦ 9 гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн 3-ыг Их Хурал, 3-ыг Ерөнхийлөгч 3-ыг, Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их

Хурал 6 жилийн хугацаагаар томилно гэж тус тус зөрчсөн байна.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад эсхүл Улсын Их Хуралтай танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын 9-өөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол гэж заасны танилцах зөвшилцөх, танилцах зөвшилцөх гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана, 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ШЕЗ-өөс Улсын Дээд шүүхийн шүүгчийг Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно, 56 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн УЕП, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар томилно гэснийг тус тус зөрчсөн байна.

Гурав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад ШЕЗ-ийн шүүгч бус гишүүн, Сахилгын хорооны шүүгч бус гишүүн гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1, 3, 6, 5, 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

Дөрөв.Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэгт томилгооны сонсгол хийж гэж тус тус заасан нь түүнчлэн Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад АТГ-ын дарга, дэд дарга гэж заасан нь Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

Тав.Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад ҮХЦ-ийн гишүүн, 29.1.2 дахь заалтад танилцах зөвшилцөх, танилцах зөвшилцөх гэж Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 3

дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол хийж гэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн, 102 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. Нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш тухайн тайлан санал, дүгнэлтэд сонсголын тайланг агуулгыг нь өөрчлөхгүйгээр тусгана гэж тус тус заасныг ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

Энэхүү дүгнэлтийг ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариуг ирүүлэхийг Улсын Их Хурлын чуулганд уламжилсугай. Даргалагч Баясгалан, гишүүд Ш.Солонго, Г.Туулхүү, Ж.Эрдэнэбулган Д.Ганганбаатар. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Занданишатар:** Цэцийн дүгнэлтийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний эрхийн дэд хорооны дарга Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна. Индэрт орж байна.

**Ц.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хууль, Авлигын эсрэг хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 5 дугаар дүгнэлтийг 2023

оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хуралд ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан журмын дагуу ХЗБХ 2023 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа ҮХЦ-ийн дүгнэлтийг хэлэлцлээ. Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын ҮХЦ-ийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ганбат Улсын Их Хурлаас томилогдсон итгэмжилсэн төлөөлөгчийг ҮХЦ-ийн дунд суудлын хуралдаанд оролцох боломжоор хангасан эсэх, Цэцийн дүгнэлтийн хууль зүйн үр дагаврын талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил төрийн байгууллага хоорондын тэнцвэртэй байдлыг харгалзан зарим зүйл заалтыг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Адъяаа ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн авч Улсын Их Хурлаас томилогддог ШЕЗ болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүний сонсголттой холбоотой асуудлыг нягтлах талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнх-Оргил ҮХЦ-ийн 5 дугаар дүгнэлтийг нухацтай хэлэлцэж чуулганы нэгдсэн хуралдаанд үндэслэл бүхий саналыг оруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг Улсын Их Хурлаас нэр дэвшигчийн сонсгол явуулснаар олон нийт нэр дэвшигчийн талаар мэдэх эрхийг хангахад чиглэж байгаа тул ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн авах боломжгүй талаар саналаа илэрхийлсэн болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар хуульд тусгагдсан танилцах зөвшилцөх процесс нь хэн нэгэнд давуу эрх олгоогүй тул Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Раднаасэд ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн авч Улсын Их Хурлын хурлаас томилогддог албан тушаалтнуудыг томилохдоо сонсгол хийх бүрэн эрхээр эрхээ хэвээр хадгалж, бусад

институтээс санал болгосон нэр дэвшигчийн сонсголын зохион байгуулах асуудлыг цаашид анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ганбат ҮХЦ-ийн дүгнэлт иргэний ирүүлсэн мэдээллийн хүрээнээс хальж, ҮХЦ өөрийн эрх мэдлийг өргөжүүлсэн дүгнэлт гаргасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлаас нийт 40 гаруй нэр дэвшигчийн сонсгол явуулдаг ба хуульд заасан бусад шаардлагаа хангасан эсэхийг нээлттэй хэлэлцэж, олон нийт нэр дэвшигчдийн талаар мэдээлэлтэй болсноор ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож буй хэлбэр тул дээрх ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн авах боломжгүй талаар саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт ҮХЦ-ийн гишүүн Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол хийж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. Нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш тухайн тайлан санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ҮХЦ, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна. 3 дахь хэсгийн ҮХЦ-ийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана. 65 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн, 65 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн ҮХЦ 9 гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн 3-ыг Улсын Их Хурал, 3-ыг Ерөнхийлөгч? 3-ыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их

Хурал 6 жилийн хугацаатайгаар томилно гэж заасныг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад эсвэл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын 9-өөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол гэж заасны, танилцах, зөвшилцөх гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн шүүгч хараат бус байж гагцхан хуульд захирагдана, 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ШЕЗ-өөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно, 56 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн УЕП, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч 6 жилийн хугацаатайгаар томилно гэж заасныг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийг хэлсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Сарангэрэл:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын



ҮХЦ-ийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Авлигын эсрэг хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хуралд ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасан журмын дагуу ТББХ 2023 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийг хэлэлцлээ. Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын ҮХЦ-ийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Н.Энхболд нар Монгол Улсын Их Хурлаас сонсгол явуулснаар олон нийт нэр дэвшигчийн талаар мэдэх эрхийг хангахад чиглэж байгаа тул ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн авах боломжгүй талаар саналаа илэрхийлсэн.

Нэг.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад ҮХЦ-ийн гишүүн Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол хийж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйл зүйлийн 102 дахь 102.1 дэх хэсэгт энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. Нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш тухайн тайлан санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ҮХЦ, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна гэсэн 3 дахь хэсгийг ҮХЦ-ийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.

65 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн ҮХЦ 9 гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн 3-ыг Улсын Их Хурал, 3-ыг нь Монгол Улсын Ерөнхийлөгч, 3-ыг нь Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно гэж заасныг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад эсхүл Улсын Их Хуралд танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд хурлын 9-өөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол гэж дээр заасан нь заасны танилцах зөвшилцөх, танилцах зөвшилцөх гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана, 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ШЕЗ-өөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно, 56 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн УЕП, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар томилно гэж гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх нь хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Дашидондогийн Ганбат гишүүнээр тасаллаа.

Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн асуулт асууна.

**Ж.Сүхбаатар:** Би яах вэ, асуулт гэхээсээ илүүтэй бас байр сууриа хэлэх ёстой болчихоод байгаа юм. Энэ Их Хурлын хяналт шалгалтын хуулийн ажлын хэсгийн ахлагчаар бол би ажилласан л даа. Тэгээд Байнгын хороон дээр хэлсэн. Тэгэхдээ гишүүддээ хандаж бас хэлэх үг байгаа юм. Юу вэ гэхээр 2019 онд оруулсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хамгийн гол хэсэг бол ард түмний засаглах бүрэн эрхийг хангаж, парламентын хяналтын механизмыг хүчтэй болгох тухай асуудал байсан. Энэний хүрээнд тэр нийтийн сонсголын хүрээнд Улсын Их Хурал маань бол энэ нэр дэвшигч буюу томилгооны сонсголын асуудлыг бид хуульчилсан. Ингэснээрээ бол сүүлийн үед бол ҮХЦ, Дээд шүүхийн шүүхэд нэр дэвшиж байгаа хүмүүсийн талаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг хийгддэг. Тухайн байгууллагууд дээр нь дотоод ардчиллын зарчмаар бас шалгаруулдаг эд нар гэдэг юм уу ийм юмнууд дөнгөж эхэлж байгаа юм.

Тэгэхээр одоо харамсалтай нь бол энэ Дээд шүүхийн шүүгч, Цэцийн гишүүд, Ерөнхий прокурор дээр бол энэ танилцах, зөвшилцөх энэ ажиллагаа бол Үндсэн хууль зөрчсөн гээд дүгнэлт хийчихээр бид өмнө нь явж ирсэн алдаагаа засаж байсан зүйлүүдээ бол одоо ухарчих гээд байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол байгууллага албан тушаалтнуудын хооронд яригддаг хэлэлцдэг байсан маш богино хугацаанд заримдаа 1, 2 өдөрт шийдэгддэг байсан асуудлыг тодорхой цаг хугацаанд буюу 2 долоо хоногоор, 3 долоо хоногоор олон нийтэд танилцуулах боломжийг олгоод ингээд энэ нэр дэвшигч хүнийг бол тал талаас нь тухайн томилох эрх бүхий этгээд Ерөнхийлөгч ч гэдэг юм уу, нөгөө талд нь танилцаж зөвшилцөж байгаа Улсын Их Хурал ч гэдэг юм уу, түүнээс гадна Улсын Их Хурлын гишүүдийг өөрийг нь илгээсэн сонгогчид оролцоод ингээд энэ төрийн гол хууль сахиулах ажлыг хийдэг, Үндсэн хуулийг чандлан сахиулдаг энэ

албан тушаалтнуудыг ийм хяналтын нарийн шүүлтүүрээр оруулдаг ийм механизмыг хийсэн.

Тэгэхээр энэ механизмыг үгүйсгэх юм бол бид өмнөх байдалдаа орно гэсэн үг. Гэхдээ Цэцийн дүгнэлт дээр нэг авахаар ганц юм байгаа нь бол дахин томилох үед бол яг одоогийн процедур бол бас зөв биш байна, өмнөх хийсэн ажилтай нь холбогдуулаад үнэлэлт дүгнэлт өгчих ийм эрсдэл байна гэж үзсэн байна лээ. Тэрийг нь бол яах вэ бид Их Хурлынхаа хяналт шалгалтын хуулийг энэ Их Хурал маань нэг засаж сайжруулах шаардлага бол байгаа. Тэрэн дээрээ тусгаж болно. Түүнээс биш үндсэн механизмаа Үндсэн хууль зөрчсөн гээд энэ танилцдаг, зөвшилцөж байгаа яг хуучин шиг ийм хэлбэрдсэн хандлагаар хуйвалдаа ч гэдэг юм уу, хэн нэгэн даргын үзэмжээр шийдэгдсэн гэдэг энэ байдал руу нь буцаад оруулах байдлаар хийх юм бол энэ чинь маш том асуудал болох байхгүй юу.

Тэгэхээр энэ ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээж авахгүй гэж би энэ хуулийг батлуулах ажлын хэсгийг удирдаж байсан хүний хувьд хэлэхэд ингэж үзсэн юм байгаа юм шүү. Тэгэхээр Улсын Их Хурал маань энэ механизмуудаа цаашаа улам боловсронгуй болгох ёстой болохоос биш ингээд алга болгоход нь бол ингээд хүлээн зөвшөөрөөд байж таарахгүй. Цэц маань бас өөрөө дахиж энийг авч үзэх ёстой юм байгаа юм гэсэн ийм байр суурьтай байгаа юм.

**Г.Занданшатар:** Үг хэллээ Цэндийн Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа энэ манай Цэц энэ янз бүрийн л шийдвэрүүд гаргаад байгаа л даа. Бүүр заримдаа арай ч дээ гэмээр, бүүр гомдмоор шийдвэрүүд ч гаргаж байгаа. Сая тэр энэний өмнө Улсын Их Хурлаар тэр хуурамч түлшний дизелийн татварыг Үндсэн хууль зөрчлөө гээд л Цэц дүгнээд л оруулаад ирж байгаа байхгүй юу. Улсын Их Хурал чинь татвар тавих эрхгүй болох нь байна шүү дээ.

Тэгээд яаж байгаа юм бэ гэхээр бизнесүүдийг ялгаварлан гадуурхаж байна гэж. Тийм заваарсан энэ Улсын Их Хурал төр засгаа нулимсан шийдвэрүүд гаргаж байгаа юм.

Зарим нь бол яах вэ дээ тэгээд хувь хүнийхээр хараад болохоор нь, болох болохгүй нь янз бүрээр харахаар юм байгаа юм. Зарим нь бол их боломжийн шийдвэр байгаа юм. Жишээ нь энийг бол би их боломжийн шийдвэр гарчихсан байна гэж бодож байгаа юм. Энэ чинь бүх нээлттэй сонсголыг буруутгаагүй байгаа байхгүй юу. Жишээ нь ШЕЗ-ийн гишүүд, Сахилгын хорооны гишүүд, Улсын Их Хурал томилж байгаа бусад албан тушаалтнууд дээрээ хийдгээрээ хийчих. Наадах чинь бол зөв байна гээд.

Харин Ерөнхийлөгч Үндсэн хуулиар эрх аваад, эрхийнхээ дагуу Цэцийн гишүүнд нэр дэвшүүлээд тэр хүн чинь Ерөнхийлөгч чинь үзээд нөгөө сонгон шалгаруулалтаа хийчихсэн байна шүү дээ. Магадгүй тэнчээнээ нээлттэй сонсголоо хийчихсэн байж магадгүй байгаа байхгүй юу. Тэгэхэд нь Улсын Их Хурал дээр авчраад дахиад нээлттэй сонсгол хийгээд байхаар наадах чинь тэр Ерөнхийлөгчийн Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгогдсон эрхийг хөндөөд байгаа юм биш үү энийгээ хараач гээд. Прокурорыг ч гэсэн та нар сонсголоо хий л гэж байгаа байхгүй юу. Тэр нь бол би зөв байна гэж харж байгаа юм.

Улсын Их Хурал жишээ нь ҮХЦ-д 3 хүний нэр дэвшүүлж байхад тэд нар дээрээ нээлттэй сонсголоо хийх бол нээлттэй. Энэ чинь бол бүрэн эрхийн чинь асуудал гээд. Өөрөөр хэлбэл ялгаж салгаад байгаа байхгүй юу. Тэгээд миний зүгээр харж байгаагаар бол өнөөдөр уул нь би Байнгын хороон дээр санал хэлсэн юм л даа. Энийг ингээд яаруу сандруу гялс зөрчсөн, зөрчөөгүй гэж нэг талд нь гарахаасаа илүү, ялгаад энийг нь хүлээгээд авчихъя. Тэгэх юм бол хэдүүлээ хуулиа ингээд янзалчихъя. Энийг нь бол хүлээн зөвшөөрөхгүй гээд нэг жоохон

ярьж суумаар л байсан юм л даа. Тэгээд бүхэлд нь ингээд хэлэлцэхгүй болгоцхож байгаа юм.

2-т тэр дахин нэр дэвшүүлж байхад сонсгол хийдэг бол буруу гэдэг дээр би санал нэг байгаа юм. Сая Сүхбаатар гишүүн ч хэлж байна. Анх дэвшихэд нь сонсгол хийчихлээ шүү дээ. Тэгээд 4 жил ажиллачхаад ирэхээр нь дахиад нэр дэвшихээр нь дахиад сонсгол хийнэ гэдэг чинь өмнө нь 4 жил хийсэн ажлыг нь л ярих гэж байгаа байхгүй юу. Жишээ нь Цэцийн гишүүн байсан бол чи тэр шийдвэрийг тэгж гаргаа биз дээ, чи энийг ингээ биз дээ л гээд нөгөө Цэцийн гишүүний хараат бус байдал руу чинь халдаж байгаа л шинж л дээ. Ер нь бол сонсгол хийх нь зөв гэдэг дээр бол гишүүд бүгд санал нийлж байгаа юм. Тэгээд Улсын Их Хурал, Цэц 2-ын хоорондын харилцааны асуудал бол маш их эмзэг асуудал л даа. Ерөөсөө зөвхөн Монголд ч биш, хаа газар Цэц нэг талаас, тэгээд Дээд шүүх, өөрөөр хэлбэл шүүхийн эрх мэдлийн байгууллагууд, Улсын Их Хурал. Тэгээд энэ дээр бид нар бол хууль батлах эрхтэй, үүрэгтэй. Цэц чинь бас Үндсэн хуулиар олгогдсон үүрэгтэй байгаа байхгүй юу. Бидний баталж байгаа хууль Үндсэн хуультай нийцэж байна уу үгүй юу гэдгийг Цэц чинь хянах ажилтай үүрэгтэй. Тэр ажлаа л хийж байгаа юм.

Тэгэхээр энэ харилцаанд хэдүүлээ их тийм тал талаас нь бодолцож хандмаар байгаа юм. Тэгээд нэгэнт л бид нар хууль баталчихсан бол Цэц тэрийг Үндсэн хууль зөрчсөн байна гээд дунд суудлаараа шийдсэн бол бид нар юу гэдэг юм заавал ч үгүй, үгүй, үгүй, яагаад ч энийг бид нар зөрчөөгүй гэж бас зүтгээд ч юм уу эсвэл нөгөө томилогдож байгаа хүн нь очоод заавал тэрийгээ хамгаалаад байх бас албагүй байхгүй юу. Алдаатай байгаа бол бид нар алдаагаа засаад, хүлээн зөвшөөрөөд ингээд илүү ажил хэрэгч хандах тийм бололцоо байгаа юм. Тэгээд энэ дээр бол Улсын Их Хурал энэ нөгөө асуудлуудыг ялгаад салгаж харах болов уу л гэж найдаж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржийн урилгаар Ховд аймгийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт Ховдчууд та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. Асуулт, хариулт явж байгаа учраас асуулт, хариултын цаг. Байнгын хороод ТББХ-ны дарга Нямаагийн Энхболдыг сүүлд нэмсэн.

Ингээд саяын асуулттай холбогдуулаад нэг асуудал бас хэлмээр байна. 1 дүгээрт Ерөнхийлөгчийн ийм засаглалтай absolute засаглалтай улсууд ч гэсэн энд Ерөнхийлөгчийн томилгоонуудын confirmation hearing буюу нотлох сонсгол хийдэг. Солонгос, АНУ гээд Ерөнхийлөгчийн засаглалтай улсууд хүртэл Ерөнхийлөгчийн Тагнуулын дарга байдаг юм уу ингээд томилох бүх томилгоо дээр confirmation hearing хийж байгаа. Харин тэр нэг хувь хүний асуудал хэлэлцэх үү, мэргэжлийн асуудал хэлэлцэх үү гэдэг 2 сонсголыг ялгамаар юм байна лээ гэж бас Солонгосчууд бол сүүлийн үед үздэг болсон. Сайн хүн нэр дэвшихгүй болчихоод байна. Бас өнгөрсөн шийдвэр гаргаж байсантай нь холбогдуулж бас тэр асуудлыг үзэх үү үгүй юү гэдэг ийм асуудлууд бол байна. Тэгэхээр яах вэ процессыг нарийвчилж тодорхой болгох зайлшгүй шаардлага байж болзошгүй. Хүлээж аваад, хүлээж авахгүй ч гэлээ ч гэсэн.

2 дугаарт нь ер нь энэ Цэцийн шийдвэрүүд бол бас Үндсэн хуулийн 3.1-д заасан ер нь ардчилсан бүх Үндсэн хуульд төрийн бүх эрх мэдэл ард түмнээс эх сурвалжтай байна гэж байгаа юм. Тэгээд ард түмэнд мэдэх эрхийг нь хангаж байгаа, ард түмнээс эх сурвалжтай байх гэсэн энэ Үндсэн хуулийн зарчим, манай Үндсэн хуулийн 3.1-д байгаа төрийн бүх эрх мэдэл ард түмний гарт байна гэсэн энэ үзэл санаатай нийлж хийгдэж байгаа юмыг яагаад дандаа Цэц үгүйсгээд байдаг

юм бэ. Ийм учраас Цэцийг цэгцлэх шаардлагатай байна гээд Цэцийн хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг Мөнх-Оргил гишүүнээр ахлуулсан, жил өнгөрлөө. Энэ Батсуурь гишүүн ч, Пүрэвдорж гишүүн ч ярьж байсан. Манай Энхбаяр, Сүхбаатар гишүүн ч ярьж байсан. Энэ Цэцийн процесс, хууль энэ тэрийг их тодорхой болгохгүй бол энэ Цэц гэж шүүх ч юм шиг, шүүх ч биш юм шиг, хүнийг хамгаалаад ч байгаа юм шиг, хамгаалахгүй ч байгаа юм шиг, ерөөсөө энэ хяналт тэнцлийг хангаад ч байгаа юм шиг, хангахгүй ч байгаа юм шиг маш ийм эргэлзээтэй шийдвэрүүд хуульчдын дунд их гарч байгаа нууц биш болсон.

Ийм учраас энийг Мөнх-Оргил гишүүн тэр Цэцийн хуулийг яаравчилмаар байна гэж би хариу өгөх гэсэн юм. Тогмидын Доржханд гишүүн.

**Т.Доржханд:** Баярлалаа. Би энэ ХҮН намын даргын хувьд бас байр сууриа илэрхийлчихмээр байгаа юм. Тэгэхээр Монгол Улсын парламент бол үйл ажиллагаа нь тодорхой түвшинд ил тод болсон. Яагаад вэ гэхээр энэ томилгооны сонсгол хийдэг болсноос хойш. Яагаад вэ гэхээр нээлттэй сонсгол хийдэг болсноос хойш. Яагаад вэ гэхээр энэ парламентын энэ Түр хянан шалгах хороо байгуулснаас хойш иргэд илүү их парламентаа үздэг болсон. Яагаад вэ гэхээр энэ нээлттэй болсон байхгүй юу. Эсрэгээрээ хаалттай байснаар бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Нүүрсний хулгай 18, 19 их наяд төгрөгийн хулгай болсон шүү дээ. Гишүүд нь мэддэггүй, сайд нар нь ч мэддэггүй.

Өнөөдөр ногоон автобусны хулгай яаж үүсэж байгаа юм бас л адилхан нууц гэсэн ийм үндэслэлээр л явж байна шүү дээ. Тэгээд нууцлаад байх юм бол болохгүй юм байна, авлигаа дийлэхгүй юм байна. Нууцлахгүй тохиолдолд бол энэ ил тодоор явж болдог юм байна гэдгийг бол иргэд ойлгож байгаа ийм үед бид нар буцаж болохгүй. Ардчилсан улс байя гэж бодож байгаа бол ил тод байх ёстой зарчим нь ийм. Энийг хэн хангаж байгаа юм бэ



гэхээр парламент. Монгол Улс парламентын засаглалтай бол парламент дээрээ энийгээ ярьж хэлэлцээд, нийтэд ил тодоор тухайн томилогдож байгаа албан тушаалтнуудыг шүүгээд гаргадаг ийм л зарчимтай байх ёстой. Энэнээсээ ухарч огт болохгүй. Тийм болохоор манай Их Хурлын гишүүд энэ дүгнэлтийг бол хүлээж авч болохгүй.

Цэцийн хувьд бол шүүмжлэлтэй зүйл байгаа, байгаа, байсан. Гэхдээ зарим бас шийдвэрүүд бол зөв гарсан шүү дээ. Цэцийн 01 дүгээр шийдвэрийн үр дүнд бид нар пропорциональ элементийг оруулж ирж байгаа. Парламентын ардчиллыг бэхжүүлж байгаа, 30 жилийн маргаанд цэг тавьсан. Гэхдээ зөрүүлээд ийм байдлаар орж ирж болохгүй.

Би 2 үндэслэл бас хэлье. Манай хуульчдын зүгээс бол энэ ямар ч үндэслэл байхгүй байна гээд. Тухайлбал ҮХЦ болон Дээд шүүхийн хараат бус байдлыг алдагдуулаад байна гэдэг ийм үндэслэл орж ирсэн байна. Гэтэл хэзээ Дээд шүүх болон Цэцийн гишүүний хараат бус байдал яригдах вэ гэхээр томилогдсоны дараа шүү. Батлагдсаны дараа, батлагдсаны дараа энд сууж байгаа хүмүүс тэдгээр хүмүүсийн үйл ажиллагаанд нөлөөлж болохгүй. Ерөнхийлөгч болохгүй, Их Хурлын дарга болохгүй, Ерөнхий сайд болохгүй, аливаа намуудын дарга нар болохгүй. Гэтэл энэ үйл явдал чинь томилгооны сонсгол чинь өөрөө батлагдахаас өмнөх процесс шүү. Батлагдаагүй субъектийн асуудал ярьж байгаа тохиолдолд тэнд ямар нэгэн хараат бус байдалд нөлөөлж байна гэдэг үндэслэл байх ёсгүй. Тэгээд ийм болохоор энэ үндэслэл нь бол хүлээж авах боломжгүй байна гээд.

2 дугаарт тэр АТГ байна уу, Их Хурлаар батлагддаг албан тушаалтнууд нь бол яах вэ. Харин Ерөнхийлөгчийн зүгээс оруулж ирж байгаа ийм албан тушаалтнуудын хувьд өөр гэж ярьж байна. Яагаад вэ гэхээр үндэслэл нь болохоор тэр 5 дахь, 4 дүгээр үндэслэлдээ

болохоор Ерөнхийлөгчийн болон Улсын Дээд шүүхийн нэр дэвшүүлэх бүрэн эрхэд хөндлөнгөөс нөлөөлөх боломжийг бүрдүүлсэн байна гэж. Үгүй ээ бид нар нөлөөлөөгүй шүү дээ. Яагаад вэ гээд тэгэхээр Ерөнхийлөгч чинь өөрийнхөө бүрэн эрхийнхээ хүрээнд нэр дэвшүүлэх процесс нь болоод орж ирж байна шүү дээ. Тэрэнд бол би нөлөөлөөгүй, АН нөлөөлсөн юм уу, Ардын намынхан нөлөөлсөн юм уу, нөлөөлөөгүй шүү дээ. Энд нөлөөлөөгүй байхад энийг нөлөөлсөн гэсэн үндэслэлээр орж ирж байгаа бол энэ үндэслэлгүй байна, үндэслэлгүй байна.

Тэгээд энэ бүх зүйл чинь нийтээрээ үндэслэлгүй байна. Энэ агуулгаараа энийг хүлээж авч болохгүй. Цаашид парламент бол ил тод, нээлттэй байж, иргэд маань итгэнэ шүү. Үр дүнд нь парламентын ардчилал чинь бэхжиж явна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үндсэн зорилго бол энэ байсан юм. Хэн нэгэн нам ялахдаа биш, харин энэ нийтээрээ ялахын тулд ардчилсан Монгол Улс байхын тулд энэ өөрчлөлтийг хийсэн. Одоо энийгээ бол бэхжүүлээд явахын тулд өнөөдрийн энэ үндэслэлийг хүлээж авах.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Гарч байгаа, бичлэг дээрээ.

**Б.Пүрэвдорж:** ҮХЦ хамаа намаагүй асуудлаар шийдвэр гаргадаг болсон. ААН-ийн үйл ажиллагаа руу ордог болсон. Юун Үндсэн хуулийн асуудал, татварын асуудал руу ордог болсон, мөнгө төгрөгтэй холбоотой асуудал руу ордог болсон. Энэний нэг жишээ бол хуурамч шатахууны хууль дээр ҮХЦ хориг тавьсантай холбоотой байгаа юм. Тэгэхээр дүгнэлт гаргасан тэрэн дээр.

Тэгэхээр би энэ хуурамч шатахуун гэж юу байдгийг би та нарт ард иргэддээ бас тайлбарлаж өгье. Улаанбаатар хотод болон төв суурин газруудад том, том 200 тонн, 500 тонны шатахууны торхнууд байдаг. Энэ торх байлаа гэж үзье. Тэрний 75 хувьд нь оригинал дизелийн

тули юм уу, 92 бензин хийдэг. Үлдсэн 25 хувьд нь керосин, нафта зэрэг хольц авчирч хольдог. Тэгээд тэр торхных нь доод талд сэнс байж байдаг, тэр сэнсээр ингээд найруулаад холиод байж байна. Тэндээс нь шатахууны машин шатахуун ачаад Баянхонгор аймгийн Баянлиг сум дээр буулгалаа гэж бодъё. Тэгэнгүүт тэр Баянлиг сумын борлуулалт нь удахаар тэр доороо сэнс энэ тэр байхгүй учраас сумын тэр бензин түгээгүүрийнх нь бензин удахаар хүнд металл нь доошоо унаад, хөнгөн металл нь дээшээ гараад ирдэг юм. Тэгээд хөнгөн металлыг нь хэрэглэсэн машин, тэр хэсгийг нь хэрэглэсэн машин цагаан утаа хаяна. Хүнд металлтай нь хар утаа хаяна. Хоёулаа машин эвдэнэ.

Тэгээд Монголчууд ер нь бол приус та нарын унаж байгаа приус машин 20 жил тэр цахилгаан карбюратор нь эвдрэхгүйгээр зохион бүтээгдсэн машин байхгүй юу даа. Гэтэл тэр хуурамч шатахуунаас болоод 2 жил болоод л эвдэрдэг. Тэгэнгүүт нь яах вэ 2 жил гар хүргээгүй юм байна гээд л 2 хонь нядлаад л нөгөө машинаа засаад байдаг. Энэнээс болоод айл болгоны машин эвдэрч байгаа. Тэгээд ингэж эвдэн, эвдэн 3 компани энэ хуурамч шатахууныг хийж ашиг олдог. Нэг нь Эрдэнэтэд байдаг, нөгөөдөх нь Замын-Үүдэд байдаг. 70 хувийг нь Улаанбаатар хотын орчим газар хийж байгаа. Тэгээд эндээсээ тэр дээд талд нь байгаа 25 хувийн хольцыг онцгой татваргүй оруулж ирээд тэндээсээ ашгаа олдог. 100 тэрбум төгрөгийн ашиг олдог. Монголчуудын машиныг эвдэн, эвдэн.

Тэгээд энэ нөхдийн эсрэг би тэмцээд 2021 оны 7 сарын 6-ны өдөр энэ хуурамч шатахууны эсрэг хууль гаргасан. Гэвч харамсалтай нь ҮХЦ энэ ямар ч өөрт ямар ч хамаагүй үндэслэлээр энэ хуулийн эсрэг Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэлт гаргаад, тэрнийг нь Их Хурлын гишүүд ичихгүй хүлээж авсан. Тэгээд өнөөдөр энэ тэгээд би тэр албаны хүмүүсээс асуусан л даа. Үгүй ээ наадах чинь үйлдвэр байгаа юм уу гэсэн чинь байхгүй гишүүнээ.

Байнгын хороон дээр цех байгаа гэж байгаа. Цехээр бензин үйлдвэрлэхдээ байсан юм бол юугаа хийж тэр Алтаниширээт дээр 1,6 тэрбум доллароор үйлдвэр бариад байгаа юм бэ? Ямар ичдэггүй хуурууд вэ. Төрийн албан хаагч нараа арай хэтэрч байгаа юм биш үү. Энэ Их Хурал дотор ерөөсөө тэр хуурамч шатахууныг дэмждэг хүмүүс зүгээр хуйгаараа. ЗГ, тэр яам, тамгын газраар нь бүгдээр нь дүүрэн. Тэгээд ард түмэн дээрээ очоод бид нар та нарын төлөө шударгаар ажиллаж байна гээд бүх хүмүүс нь ярьдаг.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшиний урилгаар Хан-Уул дүүргийн ахмадуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд эрхэм хүндэт ахмадууддаа ахмадын баярыг хүргэж, эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. Баагаагийн Баттөмөр гишүүн. Баттөмөр гишүүн үгээ хэлээрэй. Үг хэлэхгүй бол дараагийн хүн хэлүүлэе.

**Б.Баттөмөр:** ҮХЦ, ҮХЦ-ийн гишүүн нэр дэвшигчийг бас холбогдох бусад улсууд нэр дэвшигчийг үндсэн, сонсгол явуулах нь Үндсэн хууль зөрчиж байна гэж ингэж дүгнэлт гаргасан байна. Энэ Цэц гэдэг байгууллага бол үндсэн Монгол Улсын Их Хурлын хууль тогтоох, төрийн эрх барих дээд байгууллагын үйл ажиллагаанд бол хөндлөнгөөс их оролцож байгаа юм. Энэ Цэцийн хуульдаа нэг өөрчлөлт хийвэл яасан юм бэ. Цэцийн асуудлыг ер нь нэг авч үзвэл яасан юм. 1992 оны 5 сард гарсан байна, 30-аад жил болчихсон хууль. Хэчнээн олон удаа өөрчлөлт орсон. Тэгээд Цэцийн 9 гишүүн байдаг. Мэргэжлийн бус хүмүүс томилогддог, лоббигоор томилогддог. Тэрийгээ хамгаалж хяналтын сонсголоос зугтаж байгаа юм шиг нэг ийм юм хийж байгаа юм.

Энэ Улсын Их Хурал энэ Цэцийнхээ асуудлыг авч үзвэл яасан юм бэ? Улсын Их Хурал чинь төрийн эрх барих дээд

байгууллага юм бол энэ томилгооны сонсголдуудыг маш сайн хийх ёстой. Одоо бол олигтой хийж чадахгүй байгаа шүү. Бас л нэг лобби ороод л ингээд л. Монголчууд жижигхэн, нэг танил талаараа яваад л. Ийм учраас тэр Хяналт шалгалтын хуульдаа бол хуулиа улам боловсронгуй болгох ёстой. Хяналтын сонсголыг бол маш сайн хийх ёстой, шүүлтүүрийг маш сайн хийх ёстой. Ингэж байж бидний ажил сайн сайхан явна гэж ингэж үзэж байгаа юм. Цэц 9 гишүүнтэй. Мэргэжил бол янз бүр. Уг нь бол би ойлгохдоо сайн хуульч нар, сайн эдийн засагч нар байх ёстой гэж ингэж ойлгоно. Гэтэл ямар байдаг вэ гэхээр зэрэг эдийн засгийн асуудал ярихаар мэргэжлийн бус хүмүүст нь өгчихдөг. Хуулийн асуудал ярихаар бас мэргэжлийн бус хүмүүст нь өгчихдөг. Ийм хуваарилалт нь ийм шог, ийм юм хийдэг.

Энэ 05 дугаар дүгнэлтийг бол манай Байнгын хороод бол хүлээж авах ёсгүй гэсэн ийм шийдвэр гаргасан байна. Би бол санал нэгтэй байна хүлээж авч болохгүй энийг. Урьд нь 04 дүгээр дүгнэлт гарсан. Сая Пүрэвдорж гишүүн ярьж байна. Тэгш бус байдлыг бий болгосон гэж байгаа юм. Тэгш бус байдлыг бий болгосныг энэ Пүрэвдорж хууль санаачлаад бий, тэгш бус байдлыг нь арилгачихсан байхгүй юу. Тэгтэл дахиад тэгш бус байдал бий болгочхож байгаа юм. Энийг нь Их Хурал хүлээгээд авчихсан. Өнөөдөр Улаанбаатар хотын утааны энэ агаарын бохирдлын 30 хувь нь автомашинаас, тэр хуурамч шатахуун гэдэг юмнаас чинь үүсэж байна шүү дээ. Энэ оны 7 дугаар сарын энэ эхний 7 дугаар сарын байдлаар онцгой албан татвар 98 тэрбум төгрөгөөр тасарч байгаа. Нөгөө нефть импортолдог компаниуд нь төлөөд байдаг, найруулдаг улсууд нь төлдөггүй. Тийм учраас энэ ЗГ бол хэрвээ энийг найруулахыг нь зөвшөөрч байгаа юм бол онцгой албан татвар тогтоох ёстой, бүгд л энд хүлээн зөвшөөрсөн шүү дээ. Энэ хуурамч шатахууны энэ юуны цаад талд бол авлигын асуудал байгаа шүү, баригдана даа энэ бол баригдана. Ийм юм

хийгээд байгаа улсууд өнөөдөр хууль хяналтын байгууллагуудаар шалгагдаж байгаа шүү дээ. Тийм учраас бол энэ дээр их онцгой анхаарч ингэж авч үзэх ёстой. Ийм учраас энэ гаргасан 05 дугаар дүгнэлтийг бол хүлээн зөвшөөрөх боломжгүй гэдэгтэй санал нэг байна.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

**Ш.Адьшаа:** Өнөөдөр ҮХЦ-ийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэж байна. Энэ Үндсэн хуулийн төрийн эрх мэдлийн хуваарилалттай холбоотой асуудлыг ҮХЦ гаргасан гэж ойлгож байгаа. Энэ ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээж авах нь хууль дээдлэх зарчимд нийцнэ гэсэн ийм ойлголттой байна. Энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн энэ томилгооны сонсголын асуудлыг энд ярьж байна. Энэ ярих ёстой. Энэ парламентын засаглалын амин чухал сүнс болсон ард иргэдэд нээлттэй байх энэ томилгооны сонсгол хийх нь энэ хуулиар шийдэх ёстой асуудал.

Гэхдээ бид өнөөдөр шүүх бие даасан, шүүх хараат байх энэ төрийн тогтолцооны үндсэн зарчим чинь өнөөдөр алдагдсан. Энийг Цэц гэхээс илүү энэ хууль тогтоогчид бид энд дүгнэлт хийх ёстой. Би удаа дараа энд ярьж байгаа. Шүүхийн тухай хуулийг бид баталсан. Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтөөр шүүх эрх мэдлийг бие даасан хараат бус байлгах зорилгоор ШЕЗ, Шүүхийн сахилгын хороо гэдэг Үндсэн хуулийн бүтцийн байгууллагыг бий болгосон. Энэ бүтцийн байгууллагаар дамжуулж хариуцлага алдсан шүүгч нарт хариуцлага тооцдог Шүүхийн сахилгын хороо хөрөнгө санхүү, боловсон хүчнийг нь шийддэг ШЕЗ гэдэг Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүтцийн энэ байгууллагын эрх мэдлийг Улсын Их Хурал өөрөө авсан. Энэ бол өнөөдөр байж боломгүй асуудал. ШЕЗ-ийн хараат бус 5 гишүүн, Шүүхийн сахилгын хорооны хараат бус гишүүдийг Улсын Их Хуралд томилдог болсон. Энэ бол өнөөдөр энэ

Цэцийн дүгнэлт ч бай, Үндсэн хуулийн зөрчилд хүргэж байна гэж ойлгож байгаа. Тийм учраас энэ ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээж авах нь хууль дээдлэх зарчимд зайлишгүй шаардлагатай байгаа.

Өнөөдөр Улсын Их Хурал хууль баталдаг, хуулийн хэрэгжилтэд хяналт тавьдаг ийм байгууллага. Гэтэл өнөөдөр Улсын Их Хурлын нэг гишүүн ахлаад ШЕЗ, Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг томилж байгаа шүү дээ. Шүүх эрх мэдлийг хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд авчирсан гэдэг ийм байр суурьтай байгаа. Тийм учраас өнөөдөр энэ ҮХЦ-ийн дүгнэлтийг тэр Ерөнхийлөгчийн эрх мэдэл, шүүх эрх мэдлийн шийдэх ёстой асуудлыг өнөөдөр шүүх бие даасан байх, хараат бус байх энэ Үндсэн хуулийнхаа зарчмыг биелүүлэх үү биелүүлэхгүй юу гэдэг асуудал энд яригдах ёстой. Үндсэн хуулийнхаа зарчмыг бид барих ёстой. Тэрнээс биш тэр органик хуулиудад бид өөрчлөлт хийж, нийгэмд хүлээгдээд байгаа шаардлага тавиад байгаа томилгооны сонсгол хийх, ил тод байх, томилогдох хүмүүсийн байдлыг иргэд, олон нийтэд нээлттэй байлгах нь энэ бол парламентын зарчим. Энийг дэмжиж байгаа.

Гэтэл Үндсэн хууль нь зөрчигдсөн, шүүх эрх мэдэл нь хууль тогтоох эрх мэдлийн хараа хяналтад орсон ийм асуудлыг бид өнөөдөр хүлээн авахгүй, зөвшөөрөхгүй бол бид өнөөдөр Үндсэн хуулиа дагах уу нийт улсын ашиг сонирхол гэдэг юмыг бид биелүүлж байна уу, биелүүлэхгүй байна уу гэдэг дээр бас бид олны өмнө, Монголын ард түмний өмнө энэ асуудал байгаа шүү гэдгийг би хариуцлагатай хэлье.

**Г.Занданшатар:** Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр энэ Цэцийн дунд суудлын хуралдаанаас энэ тодорхой нэр бүхий албан тушаалтнуудын томилгооны үед нээлттэй сонсгол хийхийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж

байгаа нь бол харамсалтай. Энэ бол ардчиллын эсрэг, тэгээд олон түмний мэдэх эрхэд халдсан ийм ухралт бүхий шийдвэр гарсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 3.1-д Монгол Улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна гэж байгаа. Тэгэхээр яг энэ заалтын дагуу төрийн урьд өмнө нууц далд байсан тодорхой томилгоонууд ямагт хардлага дагуулж, олон нийтийн шүүмжлэлд хүргэж байсан энэ алдааг бид нар бол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулиар зассан байгаа. Тэгээд ард түмэн бол тухайн төрийн өндөр дээд албан тушаалд хэн томилогдож байгаа, тухайн хүний мэдлэг боловсрол болон ажлын туршилага ямар байна, өмнөх ёс зүйн болон бусад бүх алдаа зөрчлүүдийг нээлттэй сонсон хэлэлцэх энэ процесс байгаа.

Гэтэл энэ нээлттэй сонсголын процессыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзэж байгаа нь хууль зүйн хувьд бол үндэслэлгүй байгаа юм. Тухайлбал энэ нээлттэй сонсголын үйл явц бол шийдвэр гаргаж байгаа биш, үйл явц биш. Өөрөөр хэлбэл ҮХЦ-ийн болон Дээд шүүхийн бүрэн эрхэд халдаагүй, энэ нь нээлттэй сонсголын үеэр ерөөсөө олон түмэн хэн, хэн хүмүүс нэр дэвшээд байна гэдгийг мэдэж байна. 2 дугаарт нь яг шийдвэр гаргах эрх мэдэл бүхий Ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын мэдээлэлжүүлэх ийм процесс явагдаж байгаа. Энэ бол угаасаа олон нийт улсуудын жишиг байна АНУ, БНСУ гээд их олон улс, Их Британи гээд ийм жишиг байдаг. Тийм учраас Улсын Их Хурал маань энэ ард түмэнд нээлттэй парламентыг бий болгох, ард түмнийхээ засаглах эрхийг хангах энэ зарчимдаа бид нар үнэнч байж энэ Улсын Их Хурлаар томилогдож байгаа албан тушаалтнуудын нээлттэй сонсголын процессыг бол хадгалан үлдэх ёстой.

Ер нь бол энэ сонсгол гэдэг бол тухайн бүх талын оролцоог хангасан, нээлттэй мэдээллийг олгож байгаа ийм дэвшилттэй процесс. Тийм учраас бид нар бол Үндсэн хуулиар олгогдсон



тодорхой албан тушаалтнуудын бүрэн эрхийг зөрчөөгүй, Үндсэн хууль зөрчөөгүй ийм шийдвэр гаргасан. Үүнийг бол манай Улсын Их Хурлын хяналт шалгалтын дэд, Хяналт шалгалтын хорооны өргөн барьсан энэ хууль, бид нар санаачлагч гишүүдийн хувьд бол энэ нэлээд бас олон улсын туршилага, олон улс дахь парламентын нээлттэй үйл ажиллагаа, ёс зүйн болон бусад хариуцлагын механизмыг судалж байж энэ заалтуудыг оруулсан юм. Тийм учраас бид нар энэ дэвшилттэй алхмаасаа ухрах ёсгүй гэдэг ийм байр суурийг хэлмээр байна. Тэгээд манай гишүүд ч гэсэн энэ дэвшилттэй, нээлттэй парламентынхаа төлөө олон нийтийнхээ мэдэх эрхийг хангахын төлөө энэ үйл ажиллагаа дээр бас санал нэг байна гэдэгт бол итгэж байна.

Тэгэхээр Улсын Их Хурал маань энэ ҮХЦ-ийн дунд суудлын хурлын шийдвэрийг хүлээж авахгүй. Улмаар яах вэ их суудлаараа энэ шийдвэрээ эргэн харах болов уу гэдэг ийм найдлага байна. ҮХЦ бол.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Жамбын Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Монгол Улсын ҮХЦ-ийн 05 дугаар дүгнэлтийг бол ингэж хүлээж авч болохгүй гэсэн хатуу байр суурьтай байна. Ер нь энэ ҮХЦ үнэхээр нэг даварсан байгууллага боллоо. Өнөөдөр олон удаа хэлж байна даа. ҮХЦ-ийн дарга нь өөрөө эрх зүйн чадамжгүй хүн шүү дээ. Төрийн албаны үйл ажиллагаагаа эрхлэх дээд насны дээд хязгаар нь хүрчхээд жил, 2 жил болж байна. Тэгээд улс төрчдийн, эрх баригчдын захиалгыг авч түүнд л шийдвэр гаргадаг ийм байгууллага болчихсон. Ард түмнээ сонсох, мэдэх ямар хүн ҮХЦ-д нэр дэвшиж байгаа асуудлыг олон нийтийн өмнө хамтран ярилцах л асуудал байгаа болохоос тэр ямар нэгэн Ерөнхийлөгчийн субъектэд нөлөөлж байгаа асуудал бол тэнд огт байхгүй.

Тийм учраас энэ ҮХЦ-ийн энэ гаргаж байгаа дүгнэлт бол нөгөө зүгээр л

нэг дураараа аашилдаг, дуртай үедээ эрх баригчдын, улс төрчдийн гар хөл болдог гэдгээ дахин батлуулсан ийм л дүгнэлт болж орж ирсэн. Ер нь ҮХЦ хийх ёстой зүйлээ хийдэггүй. Энэ олон жил болоход ҮХЦ хүний эрхийн талаар ярьж байх ярьж байсан энэ зүйлийг бид нар ер нь сонсож байв уу. Дандаа ардчиллыг боомилж байсан, дандаа улс төрчдийн гар хөл болж байсан. Тэгээд өөрсдийгөө өөрсдийнхөө толгой дээр байгаа бухлыг харахгүй байж, хүмүүсийн толгой дээр байгаа хялгасыг дандаа ярьж байдаг. Төрийн институтүүдийн хоорондын харилцааг алдагдуулж байдаг, сонгуулийн тогтолцоонд нөлөөлдөг, аль намыг ялуулах, ямар системээр явуулах, ямар хууль батлахад нөлөөлж байдаг. Дээр нь бүүр даварчихсан Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний сонголтоор сонгогддог, ард түмний хэлж ярьж байгаа зүйлийг олон түмэнд мэдээлдэг л ийм хүн байх ёстой. Энэ хүмүүсийг хэрэг үүсгэж Цэц дээр дуудаж өөрсдийн гар хөлөөрөө далимдуулж нухчин дарах гэж байгаа юм.

Бизнесийн захиалга авдаг. Хуурамч шатахууны асуудал байна, сонгуулийн тогтолцооны асуудал байна. Тэгээд өөрсдөө болонгуут ард түмний дунд нэр хүнд нь уначихсан, хууль биелүүлдэггүй ийм хүмүүсээр тэр 9 хүний ихэнх нь бүрдчихсэн. Тэгээд тэнд Монголын төрийн тогтолцооны институтүүдийг бүүр хааш нь бол хааш нь болгодог, аль нам ялахыг шийддэг, аль намд ямар эрх өгөхийг шийддэг. Жишээ нь давхар дээлийн асуудлыг та бүхэн АН ялсан он цагууд болгонд давхар дээл болохгүй гэж шийдвэр гаргаж байдаг. Ардын нам ялсан он цаг болгонд давхар дээлгүй бол, давхар дээлтэй бол болно гэж шийдвэр гаргаж байдаг. Тэгээд энэ эрх баригчидтайгаа нийлж ард түмний эсрэг дандаа үйл ажиллагаа явуулдаг. Тэрийг нь хэлсэн хүмүүсийг хянан шийдвэрлэх үйл ажиллагаагаар тийм ч тайлбар өг, ийм ч тайлбар өг Үндсэн хууль зөрчсөн гэж.

Өөрсдөө Үндсэн хуулиа зөрчдөг шүү дээ. Энэ ҮХЦ-ийг чинь ер нь татан буулгахивал яасан юм. Үндсэн хууль өнөөдөр ард түмний эрхийг хамгаалж, хүний эрхийг хангадаг ийм шийдвэр гаргаж ирснийг хэн, хаана харж байсан юм. Дандаа улс төрийн шийдвэр гаргадаг. Тийм учраас ер нь Үндсэн хуулийн тухай, ҮХЦ-ийн тухай энэ хуулийг дахин ойрын хугацаанд ярилцаж, бараг татан буулгах хүртэл зарим эрх мэдлийг нь Дээд шүүх рүү өгөх хэрэгтэй. Үгүй бол өөрсдийнх нь энэ бол, одоо бүүр даварчихсан Монголын төрийг бүгдийг базаж байна 9-хөн хүн. Ард түмнээс сонгогдоогүй, нэг хүнээс сонгогддог, нэг хэсэг хүнээс сонгогддог, хуйвалдаж сонгогддог. Тэгээд ингээд Улсын Их Хурал төрийн эрх барих дээд байгууллагад нөлөөлөх ийм тогтоол.../минут дуусав/

**Г.Занданишатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Яах вэ энэ хуулийн салбарын өндөр албан тушаалтнууд дээр Улсын Их Хуралд нээлттэй сонсгол явуулах эрх байхгүй, тийм эрх Үндсэн хуулиар олгогдоогүй гэж үзэж байгаа юм байна. Улсын Их Монгол Улсын Улсын Их Хурал гэдэг чинь ард түмний төлөөлөл. 2 үндсэн чиг үүрэгтэй. Хууль батлах, нөгөөдөх нь Монголын ард түмний төлөөлөл. Хууль батлах. Тэгэхээр хууль батлагчийнхаа хувьд бусад субъектийнхээ эрх мэдлийн хуваарилалт руу халдаж байна гэж үзэж байгаа юм шиг байна. Гэтэл Улсын Их Хурал чинь өөрөө Монголын ард түмний төлөөлөл буюу ард түмний өмнөөс шийдвэр гаргах эрхтэй, ард түмний өмнөөс нээлттэй байдлыг, ард түмний өмнөөс бүхий л зүйлийг хянан шалгах эрхтэй байгууллага.

Тийм болохоор яг өнөөдөр энэ хуулийн салбарт гарч байгаа энэ Цэцийн дүгнэлт бол үнэхээр бас тийм зарчимд нийцээгүй, ард түмний, ард түмнээс салбарласан, ард түмнээс олгогдсон эрх мэдлийг үгүйсгэсэн ийм л шийдвэр гарч байна л даа. Энэ бол хууль тогтоогчоосоо

гадна Улсын Их Хуралд Монгол Улсын ард түмнийг төлөөлөх эрх албан ёсоор олгогдсон ийм л байгууллага. Тэгэхээр тэр, ер нь энэ нээлттэй байдлыг хангаж ажиллана гэдэг энэ өөрөө яг өнөөдөр Үндсэн хуулийн зарчим. Тэгээд өнөөдөр цаг үеийн хувьд, үнэхээр энэ хуулийн салбарын хувьд хаалттай, цус ойртсон байдал ямар нөхцөл байдалд энэ хулгай луйвар бүхий л зүйлд, тэр тусмаа энэ нуугдмал хаагдмал, нууц байдлаар хийгддэг аливаа ажлууд ямар тийм нөхцөл байдалд хүргэдэг, ямар хэмжээний тийм буглаа үүсдэг, ямар хэмжээний тийм авлигын нөхцөл байдал цаана нь нуугдаж байдаг олон зүйлийг бид нар харж байна.

Тэгэхээр яг энэ Цэцийн дүгнэлтийг бол Улсын Их Хурал хүлээж авахгүй, яг энэ нээлттэй байдлыг, нээлттэй энэ бүхий л ил тод байдлыг хангасан энэ шийдвэрийнхээ талд зогсох ёстой гэж бодож байгаа.

**Г.Занданишатар:** Дашидондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Баярлалаа. Энэ камер байдаг бол энэ танхимыг нэг харуулчихмаар байх юм. Энэ 76 гишүүний суудалтай. Өнөөдөр 4, 5 хүн сууж байна. Энэ ажлыг хэн хийсэн юм бэ? Нөгөө Үндсэн хууль бол ард түмэнтэйгээ байгуулсан гэрээ л дээ. Үндсэн хууль бол засаглалыг хуваадаг, Үндсэн хууль бол хүний эрхийг хамгаалдаг ийм бичиг баримт. Энийг хэр баргийн нөхцөлд өөрчилж болохооргүй байх ёстой. Тэгээд Үндсэн хуульд хүмүүнлэг, энэрэнгүй, ардчилсан нийгэм байгуулна гээд тунхаглачихсан байгаа. Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна гэхихсэн. Тэрний дотор бас мэдэх эрх байгаа.

Гэтэл өнөөдөр хар л даа. Тэр 2019 онд хийсэн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт засаглалыг тодорхой болголоо, харилцан хяналттай ийм засаглалуудтай боллоо гэсэн. Тэгээд 2022 оны 8 сард бас Үндсэн хуулийг хэн нь батлаад, хэн нь

өөрчилчхөв. Одоо эзэн нь тодорхойгүй. Энэ хамаг Үндсэн хуулийг манаж байх ёстой ҮХЦ маань өөрөө Үндсэн хуулиа хулгайлчихсан. Одоо тэнд тийм л бүрэлдэхүүн байж байгаа. Тэгээд дараа нь ахиад нөгөө ард түмний мэдэх эрхэд халдаж байна. Мэдээжийн хэрэг шүүх хараат бус байх ёстой, шүүгч ч гэсэн хараат бус байх ёстой. Тэр үүргээ биелүүлдэггүй ҮХЦ-ийн гишүүд ч гэсэн. Гэтэл тийм биш байдаг.

Өнөөдөр эрх баригчдын хүссэн ганцхан намын, хэдхэн хүний захиалгыг л тэнд биелүүлээд сууж байдаг ийм л болчихсон. Тэгээд өөрөө өөрсөдөө зориулаад энэ ҮХЦ энэ гишүүд маань Үндсэн хуулийн нэрийн өмнөөс гээд ард түмний мэдэх эрхийг байхгүй болгож байна. Ийм л үйл ажиллагаа өнөөдөр явагдаж байна. Энийг дагалдаад хар, өнөөдөр бид нар бол Улсын Их Хурал ард түмний төлөөлөл энд хариуцлагагүй ЗГ-ыг энд яриад сууж байх ёстой шүү дээ. Хариуцлага яриад сууж байх ёстой. Гэтэл ямар байна тэнд л нэг намын удирдах зөвлөл дээр хэн нь ямар даргаар томилох вэ, албан тушаал бүлэглэлүүд хоорондоо булаацалдсан ийм л юм болж байна. Ийм хаалттай, харанхуй, ийм дарангуйлсан нийгэм рүү явж байна. Энэ чинь цаашилаад энэ 2 том орны дунд байдаг Монгол Улсын эрх ашигт аягүй буруугаар үйлчилж ийм магадлалтай, үйлчлээд эхэлж байна. Ийм юмыг ойлгодоггүй ҮХЦ-ийн гишүүд бол өөрийнхөө тэр нэр дэвшүүлсэн тэр эздэдээ үйлчилж байгаа болохоос биш ард түмэнд, Үндсэн хуульд, Үндсэн хуулийг хамгаалах талаар бол үйлчилж явж чадахгүй байна.

Энэ байдлаас чинь болоод энэ ЗГ танхимаараа хариуцлага хүлээгээд байж байх байтал, одоо хар Улаанбаатар хот өнөөдөр автобус ч үгүй, мөнгө ч үгүй байна. Тэгээд хар энэ дагуул намуудыг, охин намуудыг бүгдэд нь нэг дүр оноогоод өгчихсөн. Нөгөө хэвлэл мэдээллийн байгууллагууд нь худалдагдчихсан, хаалтын гэрээтэй. Хүмүүсийн тархи толгойг угаагаад байж байдаг. Ард

түмний амьдрал өдрөөс өдөрт дордож байдаг. Одоо би ингээд асуулт энэ яагаад ийм байгаа юм бэ, энийг яагаад өөрчилж болдоггүй юм бэ? Яг тэр Үндсэн хуулийнх нь манаачийн.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Цэцэд, Цэцийн тухай, Цэцийн хэрэг маргаан шийдвэрлэх тухай хуулийг хэлэлцэхгүй бол энэ нөгөө хариулдаг хүнгүй болчихоод байгаа юм. Дэгийн хуульд ч гэсэн өөрчлөлт оруулах байгаад байгаа юм. Байнгын хороод бол хариулт хариулж болно. Байнгын хороод хариулах хүн байгаа юу? Нямаагийн Энхболд гишүүн асуулт, хариулт, үг бүгдийг нь хэлбэл хэлэх болно. ТББХ-ны дарга.

**Н.Энхболд:** Өнөөдөр Улсын Их Хурлаар Монгол Улсын Их Хурлаас гаргасан Хяналт шалгалтын хуультай холбоотой Цэцийн дүгнэлтийн асуудлыг бид нар хэлэлцэж байна. ТББХ-гоор энэ хуулийг энэ Цэцийн 05 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн. Хүлээж авах үндэслэл байхгүй байна гэж үзсэн. Яагаад, гол нь бол энэ хуулийн гол үзэл санаа нь бол төрийн өндөр албан тушаалтнуудыг томилоход ямар хүн томилогдож байна, шаардлага хангаж байна уу үгүй юү гэдгийг олон нийт мэдэх эрхтэй. Энэ эрхийг баталгаажуулсан хууль учраас Улсын Их Хурлаас гаргасан хууль Үндсэн хуультай зөрчилдөөгүй, Цэцийн дүгнэлтийг хүлээж авах үндэслэл байхгүй байна гэж үзсэн.

Гэхдээ энэ асуудлаар жишээ нь өнөөдөр Их Хурал дээр ингээд хэлэлцэж байгаа байдлыг харахад, иргэн Цэцэд гомдол гаргасан байдлыг харахад энэ бас өөрөө цаашидаа бид нар хуулиа боловсронгуй болгох шаардлага байна. Нийгэмд янз бүрийн байр суурь байна, янз бүрийн ойлголт байна гэдгийг харуулж байгаа ийм үйл явдал болж байна гэж бодож байна. Улс төрчдийн дунд ч, нийгмийн дунд ч нэгдсэн ойлголт, нэгдсэн зохицуулалт шаардлагатай байгааг энэ Цэцийн дүгнэлт, Цэцийн дүгнэлтийг тойроод хэлэлцэж байгаа өнөөдрийн энэ асуудал харуулж байгаа юм.

Гол асуудал юундаа байна вэ гэхээр Байнгын хороон дээр үг хэлсэн хүмүүсийн байр суурь, өнөөдөр янз бүрийн өнцгөөс байр сууриа илтгэж байгаа гишүүдийн үгнээс харахад ерөөсөө ҮХЦ гэж ямар байгууллага юм бэ, яг ямар асуудлыг хэлэлцэж байх ёстой вэ гэсэн ийм нарийвчилсан зохицуулалтууд хэрэгтэй байгааг харуулж байгаа юм. Засаглалын 3 салбарын тухай ойлголт бий. Хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх засаглалын байгууллагуудын тухай. Энэ суурь зарчимтайгаа нийцүүлсэн хэн нь юугаа хариуцаж байх юм бэ гэдгээ маш сайн зохицуулсан ийм дараагийн асуудлууд хүлээгдэж байна гэдгийг бас харуулж байгаа юм.

Сая гишүүд бас ярьж байна. ҮХЦ сүүлдээ ААН-ийн байгууллагын асуудал руу хүртэл ордог боллоо гээд. Та бүхэн анзаарсан байх. Цэц дүгнэлт гарахдаа дандаа Үндсэн хууль бусад хууль тогтоомж гэсэн үг үндэслээд хуулийн өмнө бүгд тэгш эрхтэй байх ёстой гэсэн үндэслэлүүд хийж байгаад юмаа гаргадаг. Энэ нь ч арга ч байхгүй. Ялангуяа Үндсэн хуулийн зарчмуудтай. Тэгэхдээ дотор нь ялгаад ҮХЦ бол зөвхөн ийм асуудлуудыг ийм хүрээнд хэлэлцэнэ, бусдыг энэ захиргааны, иргэний, зөрчлийн, эрүүгийн бусад тусгайлсан шүүх нь шийдвэрлэдэг гэсэн ийм зохицуулалтад хэрэгтэй байна гэдгийг бас ярьж байгаа хүмүүс. Ингээж зохицуулсан улсууд байдаг юм байна лээ. ҮХЦ буюу Үндсэн хуулийн шүүх нь зөвхөн ийм, ийм хүрээнд асуудлыг хэлэлцэнэ, бусад нь бол тэр чиглэл чиглэлийнхээ асуудлыг тусгайлсан шүүхүүд нь хэлэлцэж байна гээд ингээд.

Тэгээд дээр нь ҮХЦ өөрөө шүүх мөн үү биш үү гэдэг дээр нэгдсэн ойлголт, нэгдсэн зохицуулалт хэрэгтэй болж байгаа юм. Энүүнийг бид нэг тодорхой болгочоод дараа нь яг өнөөдөр энэ маргаантай болгочихвол дараа нь энэ өнөөдрийн бид нарын санал зөрөлдөөд байгаа, янз бүрийн байр суурь илэрхийлж байгаа энэ асуудлууд их тодорхой болох

юм байна лээ. Тэгэхээр Мөнх-Оргил гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Цэцийн тухай, Цэцээр маргаан шийдвэрлэх журмын тухай хуулиуд, энэ хуулиудаа яаравчлан гаргаад, энэ зохицуулалтуудаа их нарийн болгочихвол. Тухайлбал бид нараас олон жилийн түүхтэй энэ хууль, эрх зүйт төр нь тогтворжсон энэ улсуудын сайн жишигүүдээс аваад хуульдаа зохицуулалтууд хийчихвэл дараа дараа нь өнөөдрийнх шиг ийм маргаан гараад байхгүйгээр асуудлыг шийдэж болох, улс төржилгүйгээр шийдэж болох ийм.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулах ёстой. Ер нь эрхэм гишүүдээ нэг зүйлийг анхааруулж тодруулж хэлэх нь зүйтэй байх. 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 28.2-т нэмэлт, өөрчлөлт оруулж, Улсын Их Хурал нийтийн эрх ашгийг хөндсөн тодорхой асуудлаар Хяналт шалгалтын түр хороо байгуулах эрх зүйн хэм хэмжээг тодорхойлсон. Тухайн үеийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлгийн протоколоос харахад энийг бол анх Мөрдөн шалгах хороо гэж бусад улс орнуудын жишигийг судалж байгаад, парламентын хяналт шалгалтын хэлбэрүүдийг судалж байгаад энэ нотлох баримтыг шинжлэн судлах зорилготой Мөрдөн шалгах хяналт шалгалтын хороо байгуулж ажиллана гэж томьёолж байсан юм. Ингээд хэлэлцүүлгийн явцад бол хяналт шалгалтын бусад чиг үүргүүдтэй хяналт тэнцлийг алдагдуулахгүйн тулд Хяналт шалгалтын түр хороо гэж нэрлэсэн.

Энийг үндэслээд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг үндэслээд Улсын Их Хурлаас Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийг бие даасан хуулийг анх удаа баталсан. Зөвхөн хууль тогтоохоос гадна хуулийнхаа хэрэгжилтийг хангах асуудал зайлиггүй чухал байна гэж Зөвлөлдөх санал асуулгын



үеэр, ер нь ард иргэдийн уулзалтын үеэр асуудлыг маш их тавьсан учраас баталсан хууль тогтоомжийнхоо хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг энэ тогтолцоог анх удаа бий болгосон. Энэ хуулийг 22 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлснээс хойш энэ Хөгжлийн банкны, нүүрсний энэ олон бүх асуудлууд чинь ил тод болж, нээлттэй болж, ард түмний мэдэх эрхийг хангаж байж ардчиллын энэ хөндлөн хэвтээ хяналтын тогтолцоо бий болсон. Босоо хяналтын тогтолцоо. Саяын ногоон автобуснаас авхуулаад бүх асуудал энэ ардчиллын олон түмний хяналт доор байгаа учраас ер нь авлигал хээл хахуулын хэрэг чинь гэнэт илэрчихсэн, гэнэт л юм болохоо больсон юм биш. Ил тод болгосон учраас олон жил бугшсан юмнууд ингэж нөхөөсөөрөө зад тавьж гарч ирсэн учраас энэ авлигал хээл хахуулын бугшсан хэргүүд илэрсэн. Энэ бол энэ ард түмний мэдэх эрхийг хангасны ил тод байдлын үр дүн.

Энэ бол Хяналт шалгалтын тухай хуулийн үр дүн. Энийг хэрэгжүүлж манай ХЗБХ-ны дарга, гишүүд, ТББХ-ны дарга, гишүүд олон сонсголуудыг хэрэгжүүлж, энэ томилгооны сонсгол ч гэсэн нийтэд байдаг журам. Энэ Ерөнхийлөгчийн томилдог субъектүүд дээр бусад улсууд бол тэр томилгоог нотлох сонсгол буюу *confirmation hearing* гэж хийж байгаа юм. Тэгэхдээ хувь хүний асуудлаар биш, мэргэжлийн асуудлаар нь хийж байх ёстой юм байна гэсэн ийм зөвлөмжийг бол бас бид судалж үзэх нь зүйтэй юм байна лээ. Тэгэхгүй бол нөгөө сайн хүмүүс орж ирэхээ больчихдог нэг ийм тал сонсголоос айгаад сайн хүн орж ирдэггүй болдог ийм тал байдаг гэдгийг бас яах вэ олон улсын байгууллагууд зөвлөдөг. Тийм учраас энийг улам төгөлдөржүүлж процессыг нь сайн болгох л асуудал чухал юм. Тийм.

Цэцийн тухай хууль, Цэцийн цэцэд хэрэг маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийг түрүүн яаравчлаач гэж би Мөнх-Оргил гишүүнд хэлсэн. Энэ чинь нэг зүйлийг хааж баймаар байгаа юм. Цэц

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хянан үзэх эрх байхгүй. Одоо хэлбэрийн агуулгын хяналт тэгж байгаад агуулгын хяналт руу ордог болчихсон. Дараа нь нэг өдөр нэг ухаантай Цэц гарч ирээд 126 байсан чинь Үндсэн хууль зөрчсөн байна гээд гаргачихвал төрийн хямрал бий болгох нь байна шүү дээ. Тийм ээ. Тэр дотор нь тэр тоо заасан нь үндэслэлгүй байна гээд. Сая чинь яг тоо заасан гээд аваад хаячихсан шүү дээ одоо давхар дээл дээр жишээлбэл. Тэгтэл 48, 78 гээд тоо заасан чинь буруу байна гээд яг энэ кэйсээр дараа нь Цэц энийг шийдэх бололцоотой. Энийг Цэцийн тухай хууль дээрээ хааж өгөхгүй бол энэ бүүр ингээд төрийг самарч болох бололцоо нээгдэж байгаа юм. Ийм учраас энийг бол Цэцийн тухай хуулийг, Цэцийн тухай, Цэцэд маргаан шийдвэрлэх тухай хууль 2-ыг хэлэлцэж, шийдвэрлэж өгмөөр байгаа юм.

Санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд. Асуулт, харуулт дуусчихсан, энэ дээр үг байхгүй. Энэ Цэцийн дүгнэлт учраас. Ер нь сая Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ нэн ялангуяа Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүд, манай эмэгтэй гишүүд нэг зүйл анхаараадхаач. Маргааш ингээд ЗГ-тай ярилцаад, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай ярилцаад Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт, хүүхдийн эрхийг хамгаалах асуудлаар мэдээлэл сонсохоор зохион байгуул.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109.10-д зааснаар цаг үеийн шинжтэй асуудлаар тулгамдсан асуудал үүсэх юм бол Улсын Их Хурал тэрнийг ард түмний төлөөлөгчдийн байгууллагын хувьд яаралтай хэлэлцэж мэдээлэл сонсох ийм эрхтэй. Гадаад, дотоод аль ч асуудлаар. Ийм учраас энэ хүүхдийн эрхийн асуудал, хүүхдийг хамгаалах асуудлыг бол нухацтай авч үзэх шаардлагатай байна гэж үзээд маргааш чуулганы хуралдаанд мэдээллийн цаг дээр нэмээд Ерөнхий

сайдын мэдээлэл байгаа, түүн дээр нэмээд энэ хүүхэд хамгаалалттай холбоотой байгууллагуудын мэдээллийг сонсохоор товд өөрчлөлт оруулж байна. Хүүхэд хамгаалалттай холбоотой энэ хүүхдийн эрүүл аюулгүй орчинд өсөж торних, сурч боловсрох нөхцөлийг хангах нь гол тулгамдсан асуудал гэж үзэж ярина.

Хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой 7096 дуудлага мэдээлэл ирснээс 75 хувь нь бол хүүхдийн эрүүл, аюулгүй байдлыг хангах шаардлагатай талаар ярьсан байгаа юм. Нийт дуудлагын 2501 хувь нь бол хүүхэд гэр бүлийн орчинд бие махбодын хүчирхийлэлд өртөж байна. 23,5 нь сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн дуудлага байгаа. Сүүлийн 10 жилийн хугацаанд улсын хэмжээнд насанд хүрээгүй хүүхдийн эсрэг гэмт хэрэг 16544 гэмт хэрэг үйлдсэнээс 10600 нийслэлд, бусад нь орон нутагт гарсан. 17036 хүүхэд энэ гэмт хэргийн улмаас хохирсон байна. 3108 хүүхэд нас барсан байна. 7503 хүүхэд гэмтсэн байна. Хохирогчдын 9452 нь эрэгтэй хүүхэд, 7584 нь эмэгтэй хүүхэд байна. Ийм учраас эдгээр шалтгаан нөхцөлийг судалж, тодорхой болгож, энэ эрсдэлт нөхцөл байдалд Хүүхдийг хамгааллын хуульд заасан байгаа шүү дээ. Энэ эрсдэлт нөхцөл байдалд хүүхэд орохоос сурч боловсрох, өсөж торних, эрүүл аюулгүй байдалтай орчинд эрхийнхээ хүрээнд урьдчилан сэргийлэх энэ нөхцөлийг бүрдүүлэхэд хүүхэд хамгаалах үндэсний тогтолцоог бий болгоно гэж хуульчилж заасан.

Тэгээд хуулийн хэрэгжилт маань ямар байна гэдгийг энийг шалтгаан нөхцөлийг судалж ярилцах ёстой. Ингэж байж шаардлагатай бол хууль, эрх зүйн арга хэмжээ авах хэрэгтэй. Хууль хэрэгжүүлэхгүй байвал холбогдох арга хэмжээг авах хэрэгтэй. Санал хураалт явуулахад ирц болсон байна уу. Ингээд санал хураалт явуулъя. Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулж гишүүд асуулт, хариулт авч дууссан. Одоо

Байнгын хорооны саналаар, байнгын хороодын саналаар санал хураалт явуулна.

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэснийг зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. 30 гишүүн байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хүүхэд хамгааллын асуудлаар сая ярьсан. Хууль хяналтын байгууллагууд, хүүхэд хамгааллын байгууллагууд дээр өнөөдөр ажиллаж, мэдээллийг цуглуулаад маргааш танилцуул гэсэн. Хөдөөгүүр энэ юугаар ажиллаж байгаа юм байна. Холбогдох газруудаар Булгантуяа сайд бол ажиллаад явж байгаа юм байна. Санал хураалт явуулъя. Санал хураалт. 65,9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэснийг зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 67,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэснийг зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 67,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонсгол хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэснийг зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 72,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонсгол хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэснийг зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 6. Дэмжье гэсэн саналын томъёоллоор. 69,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонсгол хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэснийг зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 69,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэснийг зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 72,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр



тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэснийг зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 69,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэснийг зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 69,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.”

гэснийг зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 69,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар ... Ерөнхийлөгч томилно.” гэснийг зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 67,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.” гэснийг зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 69,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хороодын саналаар санал хурааж дууслаа. ҮХЦ-ийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Болоогүй, бас дараа нь шүүгчтэй танилцана. 69,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Тогтоолын эцсийн найруулгыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. ҮХЦ-ийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийн тухай. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Нэг.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад ҮХЦ-ийн гишүүн Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол хийж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. Нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш тухайн тайлан санал, дүгнэлтээс, санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ҮХЦ, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага албан тушаалтан бус түүнээс хараат бус байна, 3 дахь хэсгийн ҮХЦ-ийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана. 65 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн ҮХЦ 9 гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн 3-ыг Улсын Их Хурал, 3-ыг Ерөнхийлөгч, 3-ыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно гэж заасныг тус тус зөрчсөн байна гэсэн

ҮХЦ-ийн 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад эсхүл Улсын Их Хуралд танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурал 9-өөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол гэж заасны танилцах, зөвшилцөх, танилцах, зөвшилцөх гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана. 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ШЕЗ-өөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно, 56 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн УЕП, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцсөн Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар томилно гэж заасныг тус тус зөрчсөн байна гэсэн ҮХЦ-ийн 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 05 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11.46 цаг

**Хоёр. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монголбанк 2023.09.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Дараагийн асуудалд оръё. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Ажлын хэсгийг оруулъя. Төслийн талаарх танилцуулгыг Монголбанкны Дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайван танилцуулна. Индэрт урьж байна.

**Г.Энхтайван:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монголбанкнаас Төрийн мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн барилаа. Дэлхий нийтийг хамарсан цар тахал, олон улсын геополитикийн зөрчилдөөнөөс улбаатай хүндрэлүүдийг Монгол Улс амжилттай даван туулж нийт эдийн засаг сүүлийн жил гаруй хугацаанд хурдацтай сэргээж байна. Гэвч дэлхийн эдийн засгийн орчны тодорхой бус байдал, түүхий эдийн үнийн гэнэтийн хэлбэлзэл өндөр байгаа хэвээр тул сэргэлтийг цаашид хадгалахын тулд эдийн засгийн гадаад дотоод орчны тэнцвэрийг хангахад чиглэсэн бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эдийн засгийн өсөлтийн төлөв өндөр байгаа нь манай улс цар тахлын үеийн уналтаас сэргэлт рүү эрчимтэй шилжиж байгааг илтгэж байна. Гадаад орчны нөхцөл байдал амаргүй, бүс нутгийн болон голлох худалдааны түнши улсуудын эдийн засагт бий болж буй доргио шууд болон шууд бусаар нөлөөлж байгаа хэдий ч манай улсын эдийн засаг энэ оны эхний хагас жилд 6,4 хувиар өслөө. Уул уурхайн түүхий эдийн экспортын өсөлт, түүнийг дагасан тээвэр логистикийн салбар мөн голлох ажлын байрыг бий болгодог үйлчилгээний салбаруудын үйлдвэрлэл сайн байсан нь энэхүү өсөлтийг голлон бий болголоо.

Мөн төсөв, мөнгө, санхүүгийн бодлогын цагаа олсон арга хэмжээнүүд чухал үр нөлөөтэй байсныг энд онцлон дурдъя. Энэ оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг Төв банкнаас шинэчлэн 5,6 орчим хувьтай байх, ирэх онд энэхүү өсөлтийн эрч хадгалагдан 6 хувьтай, 2025 онд 5,9 хувьтай байхаар төсөөллийг шинэчлэн боловсрууллаа. Инфляцыг Төв банкны зорилтот түвшинд хүргээж бууруулах нь эдийн засгийг тогтвортой, хүртээмжтэй өсгөх үндсэн суурь нөхцөл

болох тул инфляцыг дунд хугацаанд 6 дээр +, - 2 нэгж бүрийн интервалд тогтворжуулах мөнгөний бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Энэ нь Монгол Улсын эдийн засаг дунд хугацаандаа тогтвортой өсөх, эдийн засгийн өсөлтийг иргэн аж ахуй нэгж бүрд мэдрүүлэх, хувийн хэвшлийн хэрэглээ, хөрөнгө оруулалтыг дэмжих үндсэн хөшүүрэг болно гэдгийг энд онцлон тэмдэглэе.

Инфляц сүүлийн жил гаруй хугацаанд алгуур буурч, энэ оны 8 дугаар сарын байдлаар 10 хувьтай гарлаа. Монголбанкны зүгээс инфляцын эсрэг мөнгөний бодлогын төлөвийг чангаруулж, 2023 оны туршид бодлогын хатуу төлөвийг тогтвортой хадгалсны зэрэгцээ худалдааны түнши орнуудын инфляц саарч, тээвэр логистикийн зардал бууран тээвэрлэлтийн хугацаа багассанаар гадаад орчноос хамааралтай нийлүүлэлтийн гаралтай үнийн өсөлтийн дарамт буурсан нь энэ оны төгсгөлөөр инфляц нэг оронтой тоонд орох үндсэн нөхцөл болж байна. Хэдий инфляц энэ оны зорилтын түвшинд ойртож бууж ирсэн ч гадаад, дотоод эрсдэл, тодорхой бус байдал өндөр хэвээр байна. Иймээс мөчлөг сөрсөн, сахилга баттай төсөв мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, нийлүүлэлтийн гинжин сүлжээ ялангуяа дотоодын хүнсний тогтвортой тасралтгүй хангамжийг бий болгохгүйгээр иргэд, ААН, хөрөнгө оруулагчдын бодит орлогыг хамгаалсан нам дор түвшиний инфляцад хүрэх боломж маш хязгаарлагдмал гэдгийг энд онцлон тэмдэглэе.

Цаашид Монголбанкны Мөнгөний бодлогын хороо инфляцыг Төв банкны зорилтот түвшинд тогтворжих хүртэл зайлиггүй шаардлагатай мөнгөний болон макро зохистын, макро зохистой бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлнэ. Энэ оны эхнээс уул уурхайн түүхий эдийн экспортын өсөлтийн төлөв тогтвортой хадгалагдаж, үүнээс улбаатай манай улсын төлбөрийн тэнцэл 8 дугаар сарын байдлаар 551 сая долларын

ашигтай гарлаа. Ийнхүү гадаад валютын албан нөөц 9 дүгээр сарын эцэст 4,1 тэрбум ам.долларт хүрсэн нь сүүлийн 22 сарын хамгийн өндөр үзүүлэлт боллоо. Хэдийгээр экспорт сайн байгаа хэдий ч эрдэс бүтээгдэхүүний үнийн төлөв буурах хандлагатай байгаагийн зэрэгцээ, төсвийн өндөр зардал нь импортыг өдөөж, валютын гарах урсгалыг бий болгож байгаа нь төлбөрийн тэнцлийн нөхцөлийг муутгаж болзошгүй байна.

Иймд юун түрүүнд улсын санхүүгийн нөөц чадавхыг хамгаалахад онцгой анхаарсан хатуу төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, аливаа хөгжлийн бодлого, төсөл хөтөлбөрүүдийг гадаад эх үүсвэрт тулгуурлан дотоодын санхүүгийн чадавхтай нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байгааг дахин хэлье.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Энэ жилээс Улсын Их Хурал жил бүрийн Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөг холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн баталдаг болсонтой холбоотойгоор энэ удаагийн үндсэн чиглэлийн төслийг Монголбанк хуульд заасан өөрийн зорилтот чиг үүргийн хүрээнд тодорхойлж боловсрууллаа. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл нь инфляцыг тогтворжуулах замаар дунд хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, гадаадын банкны бие даасан салбар нэгжийг дотоодын банк, санхүүгийн салбарт нэвтрүүлэх, ногоон зээлийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийг хөгжүүлэх, хил дамнасан худалдааны цахим төлбөр тооцоо болон финтект суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжлийг дэмжих зэрэгт онцгойлон анхаарав.

Инфляцын зорилтыг хангахад эдийн засгийн суурь хүчин зүйлс, Төв банкны хараат бус байдал, төсвийн

сахилга бат, нийлүүлэлтийн шалтгаантай үнийн хэлбэлзлийг багасгах, дэд бүтэц, тээвэр логистикийн нөхцөл байдал ихээхэн үр нөлөөтэй. Иймээс Монголбанк инфляцыг онилох Мөнгөний бодлогын тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай суурь дэд бүтцийг бий болгохтой холбоотой зорилтыг энэ онд шинээр тусгалаа. Үүнд ЗГ-ын үүрэг оролцоо маш чухал гэдгийг энд онцолмоор байна. Банкны салбарт эх үүсвэрийн зардал багатай, урт хугацаатай хөрөнгө оруулалт, ногоон тогтвортой төслийн санхүүжилт, төслийг санхүүжүүлэхэд чиглэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгоход гадаадын банкны бие даасан салбар нэгжийг дотоодын санхүүгийн салбарт оруулах нь томоохон нөлөө үзүүлнэ гэж харж байна. Иймээс ирэх онд гадаадын банкны салбар, нэгж, тэдгээрийн үйл ажиллагаа явуулахад тавигдах нөхцөл шаардлагыг гадаадын банкны харьяалал, өмчийн төрөл, бизнесийн загвар зэрэгт нь тохируулан тогтоож, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны нарийвчилсан зохицуулалтыг бий болгоход онцгойлон анхаарал хандуулах болно.

Ногоон хөгжлийн зорилтуудыг хангах, тогтвортой санхүүжилтийн замын зурагт тусгагдсан банкны салбарын ногоон зээлийн багцыг 10 хувьд хүргэх зорилтыг хангахад ногоон зээлийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийг цаг алдалгүй хөгжүүлэх зайлиггүй шаардлагатай юм. Иймээс энэ чиглэлээр Монголбанк дээр хөгжүүлж эхлээд байгаа их өгөгдлийн суурь дэд бүтцийг ашиглан ногоон тогтвортой санхүүжилтийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийг шат дараатай бий болгох ажлыг арилжааны банкуудтай хамтран ирэх оноос хөгжүүлж эхлэхээр төлөвлөж байна.

Цаашид болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эдийн засгийн дотоод, гадаад тэнцвэрийг хангах, макро эдийн засгийн



бодлогуудыг чиглүүлэх нь чухал болж байна. Монголбанкны 2024 оны бодлого, үйл ажиллагаа нь инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшинд хүргэж, тогтворжуулах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бий болгоход дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийг баталж өгөхийг хүсье.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяагийн урилгаар БГД-ийн ахмадуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт ахмадууддаа эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ажлын хэсгийн гишүүд, эхлээд Чинбатын Ундрам гишүүн. Байнгын хорооны санал, дүгнэлтийг Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулна.

**Ч.Ундрам:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монголбанкнаас Төв банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт заасны дагуу 2023 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлсэн Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах Үндсэн чиглэлийн төсөлд зах зээлийн зарчим арга хэрэгслийг ашиглан инфляцыг дунд хугацааны зорилтот түвшин тогтворжуулах, эдийн засгийн тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, банкны

салбарын тогтвортой байдлын хүрээнд гадаадын банкны бие даасан салбар, нэгжийг дотоодын санхүүгийн салбарт нэвтрүүлэх, гадаадын банк үйл ажиллагаа явуулахад тавигдах нөхцөл, шаардлагыг банкны харьяалал, өмчлөлийн төрөл, бизнес загварт нь тохируулан нарийвчлан тогтоох, олон улсын худалдаа, цахим төлбөр тооцоо болон финтект суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хөгжлийг дэмжих, төлбөрийн системийн хяналт, зохицуулалтыг сайжруулах, ногоон, тогтвортой санхүүжилтийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийг хөгжүүлэх, банкны салбарын эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэх, зээлийн мэдээллийн зохицуулалтыг боловсронгуй болгох зэрэг асуудлыг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Дэлхий нийтийг хамарсан цар тахал, геополитикоос үүдэлтэй хүндрэлүүдийг Монгол Улс амжилттай даван туулж, эдийн засаг сэргээж байгаа боловч глобал эдийн засгийн орчны тодорхой бус байдал гүнзгийрч гэнэтийн хэлбэлзэл өндөр хэвээр байгаа энэ үед эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангахад чиглэсэн бодлогыг цаашид тууштай хэрэгжүүлэх, валютын ханшийн уян хатан байдлыг нэмэгдүүлэх, инфляцыг онилох мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх суурь дэд бүтцийг бэхжүүлэх, санхүүгийн системд эрсдэл хуримтлагдахаас сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцүүлэх явцад Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут ипотекийн зээлийн хүртээмж болон арилжааны банкны эрхлэх үйл ажиллагааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал мөнгөний бодлогыг төсвийн бодлоготой уялдуулах арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Банкны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ипотекийн зээлийн санхүүжилтийн эх



үүсвэрийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй ААН байгууллагуудад олгох зээлийн хүүгийн асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг 2023 оны мөнгөний бодлогын зорилтын биелэлт, улсын төсөв болон мөнгөний бодлогод ипотекийн зээлийг хэрхэн уялдуулан тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин уул уурхай эрдэс баялгийн салбарын томоохон төсөл хөтөлбөрийг дэмжихэд баримтлах бодлогын талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл инфляцын түвшинийг тогтворжуулахад баримтлах бодлогын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам Монголбанкны бодлогын хүү болон зээлийн хүүд холбогдуулан хөдөө орон нутагт баримтлах бодлогын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Эдийн засгийн өсөлтийг дэмжих чиглэлээр бизнес эрхлэгчдэд зээл олгох асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ч.Ундрам нар гадаадын банкнуудын Монгол Улсад үйл ажиллагаагаа эрхлэх хүсэл сонирхлын талаар тус тус асууж, хариулт авлаа.

Тогтоолын төслийг хэлэлцүүлэх явцад Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг банкнуудад байршиж буй хөнгөлөлттэй нөхцөл бүхий ногоон зээлийн эх үүсвэрүүдийг эргэлтэд оруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар гадаадын банкны салбар нэгж Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг бий болгоход Монголбанкны зүгээс идэвх санаачилгатай ажиллах талаар санал хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн үндсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийг танилцуулъя. Монголбанкны Ерөнхийлөгч Сөүл хотноо олон улсын хуралд оролцох Солонгосын Төв банкны ерөнхийлөгчийн урилгаар Эксим банкны төслүүдийн талаар томилолтоор ажиллаж байгаа байна. Ингээд Монголбанкны Дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайван, Монголбанкны ерөнхий эдийн засагч Доожавын Ган-Очир, Монголбанкны Бүтцийн өөрчлөлтийн бодлогын газрын захирал Найманжингийн Ариунбат, Монголбанкны Төлбөр тооцооны газрын захирал Энхболдын Анар, Монголбанкны Судалгаа статистикийн газрын захирал Дамдинжавын Даваасүх, Монголбанкны Хууль, эрх зүйн газрын захирал Дунхүүгийн Аюуш, Монголбанкны Мөнгөний бодлогын газрын Эдийн засгийн шинжилгээ бодлогын хэлтсийн захирал Болд-Эрдэнийн Цэнд-Аюуш, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны дарга Батжаргалын Батбаатар.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүдийн нэр авъя. Ганбат гишүүн 2 дараад нэрээс гарчихсан гэнэ оруулчих. Ингээд Сандагийн Бямбацогт гишүүнээр тасаллаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууна.

**Ц.Даваасүрэн:** Та бүгдийнхээ энэ өдрийн амгаланг эрье. Тэгэхээр мөнгөний бодлого гэдэг бол бидний хэлэлцэж байгаа тухайн жилд хэлэлцдэг хамгийн чухал асуудал. Тэгээд та сая Монголбанкны Ерөнхийлөгчийн энэ гадаад томилолтын талаар хийхэд бол тийм чухал асуудал биш байна шүү дээ. Би ОУВС, Дэлхийн банкны жилийн уулзалтад явчихсан юм

болов уу гэж бодохгүй юу. Тэгэхээр энэ хариуцлагагүй байдал чинь бидэнд байгаад байна. Бид нар өөрсдөө ингээд хариуцлагагүй хэлэлцээд байна шүү дээ. Бид хариуцлагатай хэлэлцэхгүй байснаас янз бүрийн асуудал үүсэж байна.

Тэгээд үүсчихсэн хойно нь, өнгөрсөн хойно нь нэргэнэ гэдэг шиг тэгээд л нэг хэлэлцүүлэг хийнэ, сонсгол хийнэ, тийм хуулийн өөрчлөлт хийнэ гээд. Та сая хүүхдийн асуудал дээр тэгж байна шүү дээ. Үгүй ээ иргэн юу гэж хэлэх юм. Та нар юугаа хийж байсан юм л гэж хэлж байгаа шүү дээ. Өмнө нь хэлэлцэж байхдаа яасан юм, өмнө нь ярьж байхдаа яасан юм л гэж хэлнэ шүү дээ. Тийм учраас хэдүүлээ жоохон анхаараагүй бол.../үг тасрав/

**Г.Занданшатар:** Урдах асуудлаа ярина. Хууль тогтоомжийнхоо хэрэгжилтийг, Хүүхэд хамгаалах хуулийнхаа хэмжилтийг хянан шалгалтыг шаардаж байгаа.

**Ц.Даваасүрэн:** Наад юугаа, юу шүүмжлэлээ сонсож сур Их Хурлын даргаа. Чи 2 удаа Их хурлын дарга хийчихсэн чинь ерөөсөө үг сонсохоо больчихсон.

**Г.Занданшатар:** Хэлэлцэх асуудлаа хэлэлцэнэ.

**Ц.Даваасүрэн:** Чамд би хэлэхгүй бол хэн хэлэх юм.

**Г.Занданшатар:** Хэлэлцэх асуудлаа хэлэлцье.

**Ц.Даваасүрэн:** Хариуцлагагүй байдлаа өөрөөсөө эхлээд зас за юу.

**Г.Занданшатар:** Хэлэлцэх асуудлаа хэлэлцье. Сайд нар ажлаа хий.

**Ц.Даваасүрэн:** Тэгээд давраад.../үг тасрав/

**Г.Занданшатар:** Сайд нарыг ажлаа хий гэж шаардаж байна.

**Ц.Даваасүрэн:** Орлогчоор нь танилцуулаад байхдаа яадаг юм.

**Г.Занданшатар:** Сайд нар ажлаа хий гэж байна.

**Ц.Даваасүрэн:** Энэ би Монголбанкинд би ямар хамаатай юм. Би үндсэн чиглэлийн.../үг тасрав/

**Г.Занданшатар:** Энэ Монголбанкинд хүүхэд хамгааллын асуудал ямар хамаатай юм.

**Ц.Даваасүрэн:** Мөнгөний бодлого ярих гэж байна. Өөрөө хариуцлагагүй хандаад байхаар чинь би хэлж байна шүү дээ.

**Г.Занданшатар:** Хугацаандаа асуудлаа хэлэлцэх ёстой, хуультай юм. Ажлаа хийдэг улсууд нь хийж байна энд.

**Ц.Даваасүрэн:** Үгүй ээ 1, 2 хоног зохицуулж болно шүү дээ. Болно даргаа.

**Г.Занданшатар:** Гол ажлаа хийдэг улсууд нь сууж байна.

**Ц.Даваасүрэн:** Тэгэхээр энэ оруулж ирж байгаа асуудал дээр ярих юмнууд байна. Жишээлбэл өсөлт 6 хувь гэж байгаа юм. Гэтэл ДНБ, экспортын өсөлтөд чинь гол нөлөөлөөд байгаа юм энэ гүний уурхай ашиглалтад орсонтой холбогдолтой байгаад байна. Мэдээж Оюу толгойн тэр борлуулалт чинь нэмэгдчихсэн байгаа шүү дээ. Гэтэл тэндээс чинь бид нар 8-хан хувийг авч үлдээд байгаа шүү дээ. Тэгэхээр бидний энэ өсөлт чинь цаанаа бас зарим нь худлаа байгаад байна. Энийг яах юм бэ гэдгийг бид бодох хэрэгтэй. GDP дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, экспортын өсөлт дээр чинь ОТ-н юм тооцогдож байгаа шүү дээ. Тэр чинь өндөр өсөлттэй харагдуулаад байна шүү дээ. Гэхдээ бидэнд наалдаж байгаа юм байхгүй

байгаа энэ тэрийг та нар сайн ярьдаг болмоор байна.

Мөн жил бүр орж ирж байгаа энэ үндсэн чиглэл дээр та нар үндсэн зорилгоо ерөөсөө тодорхойлж чаддаггүй. Монголбанкны үндсэн зорилго нь Монгол Төв банкны хууль дээр үндэсний мөнгөн тэмдэгтийг тогтвортой байлгах л гэж бичсэн байгаа юм. Би жил бүр ярьж байгаа шүү дээ. Тэгсэн мөртөө оруулж ирсэн үндсэн чиглэл дахиад л зах зээлийн зохицуулалтаар зохицуулна л гэж байгаа байхгүй юу. Энэ үнийн өсөлтөд нөлөөлөөд иргэдийг бухимдуулаад байгаа юмны чинь гол нөлөөлөл нь энэ ханиш байна, ханиш байна. Тэр ханишинд чинь мөнгөний нийлүүлэлт нөлөөлөөд байна. Та нар тэр мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлөөд байгаа юмнуудаа ярьж сур л даа. Хэлж сур л даа. Ипотек нөлөөлөөд байгаа юм уу. Өөр ямар ямар санхүүжилтүүд нөлөөлөөд байгаа юм. Төсвийн зарлага чинь нөлөөлөөд байгаа юм уу. Та нар бодитой хэлдэг байх хэрэгтэй байхгүй юу даа. Та нар дуугүй байгаад байхаар чинь энэ ханиш чинь тэгээд л хурдацтай яваад байна шүү дээ. Энэ ханишны өсөлтөөс чинь болоод үнийн өсөлт, энэ импортын барааны үнэ чинь өсчхөөд байна. Бид нар ихэнх бараа бүтээгдэхүүнийг гаднаас авч байгаа тийм үү.

Тэгэхээр энэ валютаар авч байгаа юм бүр чинь үнэ нь өсчхөөд байна гэдгийг л бид нар ойлгодог болмоор байна. Тэгэхгүй бол энэ эдийн засаг чинь өсөлт нь энэ иргэд гэдэг юм уу, энэ нийгэмд бууж өгөхгүй байгаа юм. Яагаад гэвэл юмны үнэ өсчхөөд байгаа учраас бүх юм чинь тийшээ хуваагдаад алга болчихоод байна шүү дээ. Энэ ололт амжилт чинь. Тийм учраас энэ жилийн хэлэлцүүлгийн явцад гишүүд минь нэг юм анхаармаар байна. Эд нарт энэ үндэсний мөнгөн тэмдэгтийг тогтвортой байлгана гэсэн энэ үүргээ хэрэгжүүлэх чиглэл дээр нь Эдийн засгийн байнгын хороо анхаараад тодорхой бүүр үүрэг өг эд нарт. Мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах чиглэлээр нь, тэр үйлдвэрлэлийг дэмжих зээлийг олгох

чиглэлээр нь, экспортыг нэмэгдүүлэгч зээлийг банкнуудтай хамтраад хийх чиглэлээр нь ийм тодорхой, тодорхой үндсэн юу.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Энхтайван дэд ерөнхийлөгч 83 байна уу? 83.

**Г.Энхтайван:** Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Төв банк жил болгон Мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг Улсын Их Хуралд өргөн барихдаа Төв банкны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд өргөн барьдаг. Төв банкны тухай хуулийн 4.1 дээр бол Төв банкны үндсэн зорилтыг бол үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах гэж томъёолж өгсөн байдаг. Төгрөгийн тогтвортой байдал гэдэг дээр Төв банкны зүгээс бол инфляцыг буюу төгрөгийн худалдан авах чадварыг тогтвортой түвшинд хадгалах мөн инфляцыг нам доор түвшинд дунд хугацаандаа тогтворжуулах бодлогыг бол авч хэрэгжүүлдэг.

Үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдал гэдэг дээр нөгөө талдаа бас ханишийн асуудал яг энэ үгийн утга дээр бол бас орж ирдэг. Хэдийгээр Төв банкны үндсэн үүрэг нь бол дараа дараагийн хууль тогтоомж, Төв банкны хуульд зааснаар ханишийг уян хатан байна, ханиш нь өөрөө зах зээлийн зарчмаараа тогтоно гэсэн хуулийн зохицуулалттай боловч энэ Төв банкны хуульд байгаад байгаа энэ төгрөгийн тогтвортой байдлыг хангана гэдэг хүрээнд бол Төв банк бол энэ дээр бол юу гэх юм далд ухамсраараа ч гэх юм уу, ямар нэгэн хэлбэрээр бол анхаарал хандуулаад явдаг. Ханишийг бол аль болохоор богино хугацаанд хүчтэй савлуулахгүй байх чиглэлээр бол бодлогын арга хэмжээнүүдийг авдаг.

Төгрөгийн америк доллартой харьцах ханиш бол 2023 оны 10 дугаар сарын 1-ний байдлаар бол 3459 төгрөг

буюу оны эхнээс бол 0,4 хувь орчмоор сулраад байгаа. Энэ дэлхийн бусад орнуудын мөнгөн тэмдэгтэй харьцуулбал бас харьцангуй тогтвортой байгаад байгаа. Төгрөгийн ханишийн тогтвортой байх үндсэн урьдчилсан нөхцөл бол төлбөрийн тэнцэл байгаад байгаа. Төлбөрийн тэнцэл маань өөрөө энэ оны эхний 8 сарын байдлаар 551 орчим сая долларын ашигтай гарсан нь энэ оны хувьд бол ханиш бол харьцангуй тогтвортой байх урьдач нөхцөлийг бүрдүүлж байгаа. Тэгэхээр бид бүхэн бол үнийн тогтвортой байдал, ханишийн тогтвортой байдлыг авч үзэхэд бол хамгийн зайлшгүй шаардлагатай зүйлс бол төлбөрийн тэнцлийн алдагдлыг бол аль болохоор эерэг байлгах, төлбөрийн тэнцэл ашигтай гарах нөхцөлийг бол заавал бүрдүүлэх шаардлагатай байгаад байгаа. Төлбөрийн тэнцэл ашигтай гарах бол үндсэн суурь нөхцөл нь бол хөрөнгийн данс болон урсгал дансны алдагдлыг багасгах, хөрөнгийн дансыг ашигтай гаргах. Үүний үр дүнд энэ нь бол экспортлох бид бүгдийн бараа бүтээгдэхүүний чадавхаас бол голчлон хамаарч байгаа.

Ипотекийн зээлийн хөтөлбөр дээр бол Даваасүрэн гишүүн бас саналаа хэлж байна. Ипотекийн зээлийн хөтөлбөр бол 2013 оноос хойш хэрэгжээд явж байгаа. Тухайн үедээ Улсын Их Хурлын тогтоол гараад хэрэгжээд явсан. Төв банкны зүгээс бол энэ нэгэнт нийгмийн дундаж давхаргыг дэмжсэн энэ бодлогын арга хэмжээг бол тасалдуулахгүй байх тийм энэ хөтөлбөрийг бол дунд хугацаандаа ЗГ-т шилжүүлээд, энэ хөтөлбөрийн үр дүнг бол илүү зорилтот бүлэгт чиглэсэн орон нутгийн хөгжлийг дэмжсэн, бүсчилсэн хөгжлийг тэтгэсэн хэлбэрээр нь явуулах зайлшгүй шаардлагатай гэж бол Төв банкнаас бол үзэж байгаа.

**Г.Занданшатар:** Цэрэнбалын Даваасүрэн гишүүн тодруулж асууна.

**Ц.Даваасүрэн:** Төгрөгийг үндэсний мөнгөн тэмдэгтийг тогтвортой

байлгахад чинь нөлөөлөөд байгаа гол 2 хүчин зүйл нь мөнгөний нийлүүлэлт өсөөд байгаа асуудал байгаа байхгүй юу. Тэгэхээр мөнгөний нийлүүлэлт өсөхөд төсвийн зардал талд ч юм уу өөр юу, юу нөлөөлөөд байна вэ гэдэг юмаа сайн яриад тэрнийг хязгаарлах юмаа энэ мөнгөний бодлого дээрээ тусгаж өг гэж хэлээд байгаа юм.

2 дугаарт валютын нөөц чинь нөлөөлж байгаа. Валютын нөөц чинь муудаад ирвэл ханиш чинь унана. Мөнгөний тогтвортой байдал нөлөөлнө. Тийм учраас экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл банкнуудаа зээллэгээ өгөх дээр нь та нар тодорхой бодлого явуул л даа. Валютын нөөцөө нэмэгдүүлэх дээр, валютаа гадагшаа урсгахгүй байх, валютын нөөцөө хадгалах дээр, импортын бараа бүтээгдэхүүнийг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа хувийн хэвшлийг дэмжих чиглэлд сайн юу Сангийн яамтайгаа хамтраад үгүй ээ ийм, ийм бодитой юм хийх боломж байгаа шүү дээ. Байхгүй биш байгаа байхгүй юу. Тэрийг яриад байгаа юм. Тэрнээс биш зөвхөн ХААЯ үйлдвэрлэе гэж болохгүй. Та нар зээлийн системээрээ мөнгөний бодлогоороо.../минут дуусав/

**Г.Занданшатар:** 83 Ганболдын Энхтайван дэд ерөнхийлөгч хариулъя.

**Г.Энхтайван:** Даваасүрэн гишүүний саналтай бол санал нэгдэж байгаа. Төв банкны зүгээс бас энэ уул уурхайн бус салбарын экспортыг дэмжих чиглэлээр бол 2020 оноос хойш урт хугацаатай репо санхүүжилтийн хөтөлбөрийг бол гаргаад явсан. Энэ хүрээнд бол арилжааны банкнуудаар дамжаад бас Төв банкны бодлогын хүү дээр 3 хувийн маржин нэмээд бас харьцангуй хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг бол уул уурхайн бус экспортлогч нарт бол бас олгоод явсан байгаад байгаа. Мэдээж юу гэдэг юм уул уурхайн бус салбарыг урт хугацаатай санхүүжилтээр, хүү багатай, өртөг



багатай санхүүжилтээр дэмжих бол зайлшгүй шаардлагатай гэдгийг ойлгож байгаа. Энэ хүрээнд Төв банкнаас 2024 онд гадаадын банк санхүүгийн байгууллагыг оруулж ирж, нэмэлт эх үүсвэрээр санхүүгийн салбарт эх үүсвэрийг бол нэмэгдүүлсний үндсэн дээр бол энэхүү урт хугацаатай, хүү багатай хөтөлбөрийг бол хэрэгжүүлж эдийн засгийг илүү солонгоруулсан бодлогыг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байгаа. Тэгээд энэ 24 оны үндсэн чиглэлийн гол нюанс нь агуулга нь бол энэ гадаадын банк санхүү.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг хариулъя.

**Ц.Цэрэнпунцаг:** Даваасүрэн гишүүний асуусан асуулт дээр бас нэмээд хариулчихъя гэж бодож байгаа юм. Инфляцын юмны үнэ өсөж байгаа бол гарцаа байхгүй хүн бүхэн бид бүхний санаа зовоож байгаа асуудал. Энэ бол хаа хаагүй байна. Тэгэхээр хамгийн гол нь энэ мөнгөний бодлого ярьж байгаа энэ Монголбанкныхан байгаа дээр бас нэг асуудал бас бид нар ярьчихмаар байгаа юм. Энэ ЗГ тэр ялангуяа БХБЯ хариуцах юм шиг байна лээ. Ипотекийнх нь зээлийг тэр хуулийнх нь хугацаанд авчихвал их тус болмоор байгаа юм даа. Энэ ипотекийн зээл нь энэ Монголбанкттайгаа ингээд л зууралдаад цаашаа явах юм бол бид нар яриад байгаа тэр инфляц эд нар чинь ялангуяа тэр юмны үнэ нэмэгдэж байгаа энэ асуудалд бас л их сөрөг нөлөөлөл болох байх гээд байгаа юм. Тэгэхээр зэрэг бас Засгийн газар дээр та нар бүхэн ярилцаад энэ зээлийг нь энэ хугацаанд нь.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулж асууя нэг минут.

**Ц.Даваасүрэн:** Үгүй ээ Цэрэнпунцаг чи асууж байгаа юмаа ч ойлгохгүй байна. Тэр ипотека чинь өөрөө мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлдөг эд

байхгүй юу. Чи асууж байгаа юмаа ойлгохгүй байна шүү дээ. Тийм учраас зүгээр дуугүй сууж байсан чинь дээр байхгүй юу. Эд нар харин хариулаад байгаа нь зөв. Мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлөөд байгаа юм. Мөнгө үйлдвэрлэх нь үйлдвэрлээд байгаа байхгүй юу тэр зээлийг чинь тавихын тулд. Тийм учраас энэ ипотека гаргаж байгаа 700 тэрбум чинь мөнгийг нь шууд бараг хэвлэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ бид нар ямар хэмжээнд хэвлэх юм гэдгээ Их Хурал дээрээ тогтоож авах хэрэгтэй. Инфляцын түвшинд, ханшинд яаж нөлөөлөхгүй байх хэмжээнд бид нар энэ зээлүүдийг энэ төсвийн зарлагын хэмжээ чинь мөнгөний нийлүүлэлтийг шууд өсгөчхөөд байна шүү дээ. Та нар мөнгө нийлүүлэлтээ нэмчхээд байна. Энэ чинь өөрөө ханшийг унагачхаад байна. Энэ чинь өөрөө юмны үнийг өсгөчхөөд байгаа юм. Энийгээ яаж зохицуулж явах юм гэдгээ илэн далангүй яг энэ үед ярьж явах ёстой байхгүй юу. Бидэнд ийм хэмжээ өгчих, ийм юу өгчих. Тэгэхгүй бол бид мөнгөнийхөө тоог нэмчхээд байна гэж.

**Г.Занданшатар:** Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга.

**Ц.Цэрэнпунцаг:** Даваасүрэн сайд та мэдэж л байгаа л даа бүгдийг мэддэг юм чинь. Тэгээд таны яг ярьж байгаа энэ Монголбанкин дээр байгаа учраас тийм асуудал байгаад, инфляцад нөлөөлөөд, юмны үнэ нэмээд байгаа учраас ЗГ дээрээ аваад та бүхэн мөнгө хэвлэчхээс чадахгүй биз дээ. Тэгэхээр та аваад, Хот байгуулалтын яам аваад ингээд ипотекаа аваад явбал, үгүй ээ та ипотекийн төлөлт орж ирэхээр тэрүүгээрээ л буцааж гаргана шүү дээ. Монголбанкин дээр ингэж байж болохгүй байхгүй юу. Өөр юм яриагүй наадхыг чинь ярьж байна шүү дээ. Тэгэхээр та ав л даа. Та тэр энэ ипотекийн энэ ипотекийн зээлийг нь ЗГ авах ёстой, та ав л даа. Та авахгүй л байгаа шүү дээ. Тэгээд энд Монголбанкныхан орж ирэхээр зэрэг олон амьтан хараад л попроод л ийм хачин,

хачин юм яриад байх юм. Юу яриад байгаа юм бэ?

**Г.Занданшатар:** Ер нь тэгээд ЗГ дээр авъя гэсэн санал тавьж байгаа юм байна. Тэгээд Монголбанк дээр бол шилжүүлж өгөөгүй. Тэгээд наадах чинь мөнгө хэвлээд байгаа биш төлөгдсөн хэмжээгээрээ олгож явж байгаа шүү дээ. Ипотекийн зээлийн эргэн төлөлтийнхөө хэмжээгээр олгож байгаа энэ тэр. Салдангийн Одонтуяа гишүүн.

**С.Одонтуяа:** Тэгэхээр энэ ипотека дээр энэ ард иргэдэд нэг тодорхой мэдээлэл өгөөч. Энэ ипотекийн зээл чинь цаашдаа явах юм уу, яах юм яаж явах юм. Хуучин энэ нөгөө МИК-ээр дамждаг байсан яахаар болчхов? МИК нь хувийн хэвшилээр дамжих нь буруу. Хувийн хэвшил ашиг олоод байна гээд болиод буцаад төрд авсан уу энийг нэг тайлбарлаж өгөөч. Яагаад гэхээр ипотекийн зээл бол яах аргагүй энэ нийгмийн дундаж давхаргыг дэмжсэн чухал хөтөлбөр байхгүй юу. Тэгэхээр энэ ипотекийн зээлээ ард иргэдэд нэг ойлгомжтой тайлбарлаад өгөөч гэж хэлэх гэсэн юм.

2 дахь асуулт бол энэ Монголбанк инфляцыг оны төгсгөл рүү 9 хувь бууруулахаар төсөөлсөн. Тэгэхээр энэ оны эцэст энэ үр дүнгээ яг энэ төсөөлсөн төсөөлөлдөө хүрэх боломж байгаа юу? Сая бол хамгийн сүүлчийн Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны хурлаар бол бодлогын хүүг 13 хувьд хэвээр байлгана гэсэн байсан. Тэгэхээр энэ хатуу бодлого бариад, энэ оны эцэст үр дүнгээ өгөх нь боломж байна уу? Энийг яг тодорхой харуулж өгөөч.

3 дахь асуулт банкны систем дэх авлига бол маш өндөр болж байна. Гишүүдээ, гишүүдээ чимээгүй байхгүй юу. Даргаа сонсогдохгүй байна шүү энэ хэрүүлийг нь болиулаач. Банкны систем дэх авлига бол маш өндөр болж байна.

**Г.Занданшатар:** Асуултад хариулъя.

**С.Одонтуяа:** Энийг авлигыг бууруулах чиглэлээр Монголбанк дээр хийгдэх гэж байгаа ажлууд байна уу? Яагаад гэхээр энэ Банкны тухай хуулийг чинь бүх банкнууд зөрчөөд байна шүү дээ. Тэгэхээр энийг Монголбанк ерөөсөө мэдээгүй царайлж байна Тэгэхээр энэ шалгасан шалгалтынхаа актуудыг ил тод мэдээлж болохгүй юу. Энэ ингээд юм асуулгах гэхээр ингээд дундуур нь.

**Г.Занданшатар:** Энд хүн асуулт асуугаад байна. Одоо больцгооё.

**С.Одонтуяа:** Даргаа нэг минутаа нэмж авна шүү. Энэ ерөөсөө юм асуухаар.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Энэ асуулт.

**С.Одонтуяа:** Хэрүүл нь дуусахаар асуухгүй бол ерөөсөө асуух ч боломж алга.

**Г.Занданшатар:** Больцгооё. Эдийн засгийн байнгын хороон дарга, сайд нар энэ чуулган үймүүлэхээ больё. Энэ Одонтуяа гишүүний асуулт хариултыг явуулъя.

**С.Одонтуяа:** Одоохон даргаа би асуултаа асуух гэхээр ингээд асуулгахгүй байна шүү дээ, орилолдоод. Дарга минутаа нэмж авъя. Би асуултаа асууя. Энэ банкны систем дэх авлига маш өндөр болсон байна. Тэгээд энэ МАН-ын үед бол зөвхөн хувийн хэвшил биш энэ төрийн байгууллагуудад авлигад цэцэглэх биш одоо бүүр хувийн байгууллагуудад авлига цэцэглэдэг болж байна шүү дээ. Тэгээд ажлаа хийхгүй ингээд хоорондоо хэрэлдээд суугаад байх юм. Энэ авлига чинь хувийн хэвшилд хүртэл цэцэглээд эхэллээ яах юм. Банкнуудад чинь авлига маш өндөр байна. Энэ дээр Монголбанк энэ чиглэлээр ер нь ажил хийх юм уу хийхгүй юм уу? Энийг мэдмээр байна. Тэгээд энэ банкнуудаа шалгасан шалгалтын актаа ил тод болгож болдоггүй юм уу?

4 дүгээр асуулт энэ харилцах дансныхаа дээд хувь 3 гэхчсэн. Энэ бодлогын хүүтэй чинь ямар ч уялдаа байхгүй хэт багаар тогтоочихсон. Тэгэхээр төрийн өмчийн компаниуд чинь зориуд харилцах дансандаа хүүгүй шахуу мөнгө байлгаад авлига аваад байна. Энийг зогсоох чиглэлээр юу хийж байна вэ?

5 дахь асуулт. Нэг хувьцаа эзэмшигч 20 хувийн хязгаарлалтыг 33,3 хувь болгож өсвөл энэ IPO нь буцаах ийм дүрэм журам байна уу? IPO 20 хувь гэж хийчхээд, тэгээд IPO хийж дуусангуутаа 33,3 хувь болгоё гэдэг ийм ёс зүйгүй үйлдлүүд бол банкнууд дээр байна.

Сүүлийн асуулт. Банкнуудын жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан заалтуудыг Монголбанк одоо болтол дүрэм журамдаа тусгаагүй байна. Тэгэхээр энэ нээлттэй ХК болсон ч гэсэн мэдээллүүд нь хаалттай байгаад байгаа юм. Би энийг яагаад хэлж байна гэхээр.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Одонтуяа гишүүнд нэг минут нэмж өгье.

**С.Одонтуяа:** Энэ банкнуудын жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан заалтуудыг одоо хүртэл дүрэм журамдаа тусгаагүй байна гэдэг сүүлийн асуулт. Өөрөөр хэлбэл Хөгжлийн банк шиг ил тод болох ёстой. Гэтэл балансын гадуурх муу зээлүүдийг хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр нь биш ТУЗ-ийн шийдвэрээс нь ингээд баланс нь хасаад байгаа ийм буруу жишиг яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр жижиг хувьцаа эзэмшигч чинь банкнуудынхаа муу зээлийн мэдээллээр ямар ч ойлголт байхгүй, ямар ч мэдээлэл байхгүй. Тэгээд л дээгүүрээ хэдэн хүн л найрлаж байдаг. Энэ үргэлжлээд явах юм уу, энэ чиглэлээр Монголбанк яг ямар бодлогын чиглэл явуулах гэж байна вэ? Ийм 6 асуулт асуулаа. Тэгээд хамгийн гол асуулт бол банкны систем дэх авлига маш өндөр болоод байна шүү, энийг бууруулах

чиглэлээр ажиллаж байна уу гэсэн ийм л гол асуулт байна.

**Г.Занданшатар:** 83 Ганболдын Энхтайван.

**Г.Энхтайван:** Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Эхнээс нь хариулаад явъя. Монгол Улсын Их Хурлаас өнгөрсөн оны төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг батлахдаа 2023 оны эхний хагаст багтаагаад ипотекийн зээлийн хөтөлбөрийг ЗГ-т шилжүүлэх тухай үндсэн чиглэлд оруулж баталсан. Энэ хүрээнд төв банкны зүгээс ЗГ-тай тэр дундаа БХБЯ-тай хамтраад хамтарсан ажлын хэсэг гаргаад энэ оны 7 дугаар сарын 1-нээр тасалбар болгоод засагт энэ хөтөлбөрийг шилжүүлэх ажлыг ажлын хэсэг гаргаад бол хамтарч ажиллаад явж байсан. Тэгээд ЗГ бол энэ дээр яг аль субъект дээрээ хүлээж авах гэдэг дээрээ бас нарийвчлан тохироогүй. 2024 ондоо багтаагаад Үндэсний орон сууцын корпорацыг байгуулаад, Үндэсний орон сууцын корпорацыг байгуулах хүртэл Төв банкныг энэ нэг хөтөлбөрийг аваад яваач гэдэг тийм бодлогын шийдэлд хүрсэн учраас Төв банкнаас ипотекийн зээлийн хөтөлбөрийг Үндэсний орон сууцын корпорац байгуулагдах хүртэл бол Төв банк хариуцаад явна буюу бондын өмчлөлийг Төв банк өөр дээрээ аваад явна гэсэн үг.

Ипотекийн зээлийн хөтөлбөр 2013 оноос хойш хэрэгжсэнээр бол хэрэгжсэнээс хойш бол 115 мянга орчим өрхөд бол ипотекийн зээлийн зээл бол олгогдсон. Энэ хүрээнд бол нийтдээ 7,2 их наяд төгрөгийн зээл бол гарсан байгаад байгаа. Үлдэгдэл нь бол 6,9 орчим их наяд төгрөгийн үлдэгдэлтэй байгаад байгаа. Тэгэхээр бол энэ оны төгсгөлөөс эхлээд бол Төв банк өөрөө ипотекийн зээлийн хөтөлбөрийг авч хэрэгжүүлж явахад бол Улсын Их Хурлаас Төв банкинд бол энэ дээр эрх олгосон тийм тогтоол болон түүнтэй адилтгах хэлбэрийн эрх зүйн шийдвэр гаргаж өгөх зайлигүй

шаардлагатай байгаад байгаа. Хэрвээ энэ шийдвэрийг гаргаад өгөх юм бол Төв банк ипотекийн зээлийн хөтөлбөрийг бол хэрэгжүүлээд явна. Одоогоор бол арилжааны банкнууд дээр бол ойролцоогоор 17 мянга орчим ипотекийн зээлийн өргөдөл хүлээгдэж байгаа. Тэгээд ипотекийн зээлийн хөтөлбөр хэвийн үргэлжлээд явсан буюу жилдээ 600-аас 700 тэрбум төгрөгийн ипотекийн зээл гараад явсан тохиолдолд энэхүү хүлээгдэж байгаа хүсэлтүүд бол тодорхой хэмжээнд бол шийдэгдээд явна.

Тэр харилцах дансны 3 хувьтай холбоотой асуудал бол Ковидын хуулийн хүрээнд бол харилцах дансанд хүү тооцох, хүү тооцохыг Ковидын хуулиар бол хориглосон байгаад байгаа. Ковидын хууль дууссантай холбогдуулаад арилжааны банкнууд харилцах дансандаа хүү тооцоод явж байгаа. Энэ хүрээнд бол харилцах дансны хүүгийн хэмжээг бол 3 хувь байхаар бол Төв банкнаас бол тогтоогоод явсан. Энэ нь бол бизнес эрхлэгчдийг буюу хувийн хэвшлийн ААН-үүдийг бол мөнгөн хөрөнгөө зөв зохистой удирдахад нь бол Төв банкнаас бол дэмжлэг үзүүлсэн ийм шийдвэр болсон гэж бол үзэж байгаа.

Арилжааны банкин дээр авлигатай холбоотой асуудал гарч байна гэж гишүүн бас хөндөж байна. Төв банкны зүгээс бол хяналт шалгалтын үйл ажиллагааг арилжааны банкнууд дээр бол тухай бүрд нь бол хуваарийн дагуу хийгээд явдаг. Төв банкнаас хийгдсэн хяналт шалгалтыг бол бид бүхэн бол гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүргийг хүлээдэг байгаад байгаа. Ер нь бол арилжааны банкнууд дээр авлигын асуудал байгаа эсэх дээр бол Төв банк тухай бүрд нь хяналт шалгалтын үйл ажиллагааг бол тухайн Төв банкны хяналт шалгалтын үйл ажиллагаа эрхэлдэг газар, хэлэлцээрээ дамжуулаад бол явуулдаг. Мөн арилжааны банк нь өөрөө дотоод хяналтын функцтэй байдаг. Дотоод хяналтын функцээрээ дамжуулаад энэ үйл ажиллагааг бас

хянадаг. Мөн арилжааны банкнууд өөрсдийн тайланд бол жил болгон олон улсын аудитын байгууллагын шалгалтыг бол оруулдаг. Энэхүү шалгалтын тайланг бол Төв банк арилжааны банкнууд бол бүгдээрээ тус бүрдээ өөр өөрсдийн сувгуудаар бол олон нийтэд бол нээлттэй байлгадаг.

ИРО-тай холбоотой асуудал дээр бол ИРО-г бол Төв банкны зүгээс бол активын чанарын үнэлгээнд үндэслээд арилжааны системийн нөлөө бүхий 5 банкинд ИРО гаргасан. 20 хувийн ИРО гаргасан банк бол байхгүй байгаад байгаа юм. Хамгийн өндөр нь бол 10 хувийн ИРО гаргасан. Энэ хүрээнд бол нийтдээ 1 478 орчих тэрбум.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Гүйцээгээд хариулчих 83 Энхтайван.

**Г.Энхтайван:** ИРО-ийн хэмжээнд бол нийт системийн нөлөө бүхий 5 банк 478 тэрбум төгрөгийн хувьцааг бол олон нийтэд арилжаалсан байгаад байгаа үнэлгээтэй. Энэ дээр бол 20 хувийн ИРО гаргасан банк бол байхгүй. Хамгийн дээд тал нь 10 хувь байгаа. Ер нь бол 5-аас 10 хувь гаргасан байгаад байгаа. Гишүүн бол 20 хувь дээр 33 хувь болох гэж байна гэдэг нь бол энэ оны 12 сарын 31-нээр тасалбар болж байгаа Банкны тухай хуулиар олгогдсон үүргийн дагуу нэг хувьцаа эзэмшигчийн эзэмших дээд хэмжээг бол 20 хувь байгаатай бол байгааг бол хөндөж гишүүн хэлэх шиг боллоо. Энэ дээр бол Төв банкны зүгээс бол бол хуулийн хугацаа бол 3 сарын хугацаа үлдэж байх шиг байна. Яг энэ 3 сарын хугацаанд бол их хэмжээний хөрөнгө оруулалт орж ирж, арилжааны банкны хувь эзэмшлийн хэмжээ нь 20 хувьд буурахад бол бас цаг хугацааны хувьд бол амжихгүй байх эрсдэлтэй юм гэж үзэж байгаа учраас Төв банкны зүгээс бол энэ Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг Улсын Их Хуралд бол холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үндсэн дээрээс бол өргөн барьж байгаа.



Мөн энэ авлигал ил тод байдалтай холбоотойгоор бол арилжааны банкнууд дээр ямар хяналт шалгалтын үйл ажиллагаа явагдсан, энэний үр дүн ямар байгаа талаар манай банкны бүтцийн өөрчлөлтийн газраас бас танд дэлгэрэнгүй мэдээллийг албан бичгээр танд хүргүүлье.

**Г.Занданиатар:** Болсон уу, баярлалаа. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Мөн төрийн 2024 оны мөнгөний бодлоготой холбогдуулж 3 зүйлийг тодруулъя гэж бодож байна. Тэгэхээр өнөөдөр Монголчуудын амьдралд хамгийн их хүндрэл үүсгэж байгаа асуудал бол энэ зээл, зээлийн хүүгийн асуудал байгаа юм. Иргэд маань бол ер нь зээлээс зээлийн хооронд л байна л даа. Цалин авдаг нь цалингийн зээлээр, бизнес гэдэг нь бизнесийн зээлээр, өрхийн зээлээр, малчдын зээлээр гээд л ингээд л зээлээс нэг зээлийн хооронд л байгаад байгаа юм. Иргэдийн амьдралын чанарт хамгийн их нөлөөлж байгаа юмны нэг нь яахын аргагүй энэ зээлийн хүү байгаа юм. Өнөөдөр зээлийн хүү аягүй өндөр 18-24 хувийн хүүтэй байна.

Тэгэхээр өнгөрсөн жил Улсын Их Хурал Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийг баталсан. Энэ хуулийг батлахдаа бол Улсын Их Хурал гаднын өөрийн эх үүсвэртэй томоохон банк Монгол Улсад орж ирэх боломж бүрдэнэ гэж үзсэн. Ингэснээрээ Монгол Улс зээлийн хүүгээ бууруулна, иргэдийн амьдралын чанарт нөлөөлөл бий болно гэж ингэж үзсэн юм. Энэ хууль хэрэгжиж эхлээд нэг жилийн хугацаа өнгөрлөө. Монголд гаднын банк ерөөсөө орж ирсэнгүй. Монголбанк энэ чиглэлээр бол би их тааруу ажиллаж байгаа гэж бодож байгаа. Монголбанк зүгээр хэн өргөдөл өгөх бол, хэн банк ороод ирэх бол гэж бодох биш гаднын олон улсын банк санхүүгийн байгууллагатай хамтарч ажиллаж

Монголд банк олон улсын томоохон банк орж ирэх тэр нөхцөлийг бүрдүүлэх, ёстой. Хууль, эрх зүйн орчноо сурталчлах энэ чиглэлээр би Монголбанк юу хийв? Өнөөдрийн байдлаар Монголд орж ирэхээр судалж байгаа банк байна уу гэж 1 дүгээрт нь асуух гэж байгаа юм. Гол нь энд Монголбанкны би идэвхтэй үйл ажиллагаа дутагдаж байгаа гэж бас зориуд тэмдэглэж хэлмээр байгаа юм.

2 дугаар асуудал энэ мөнгөний бодлого төсвийн бодлого 2 уялдах ёстой. 2024 оны төсвийг Улсын Их Хуралд ЗГ-аас өргөн барьсан байна. Энэ ЗГ-аас өргөн барьсан төслийг харахаар төсөв нэлээд нэлээд хэмжээгээр тэлсэн байгаа. Төсвийн бодлого бол ингээд тэлэгдчихэж байгаа. Төсвийн бодлого тэлэгдээд ирэхээр нөгөө талд нь мөнгөний бодлогод сөргөөр нөлөөлдөг, сөргөөр нөлөөлдөг. Төсвийн бодлого яаж тэлсэн байна гэхээр нэг талаасаа бол урсгал зардал нэмэгдсэн байна, нөгөө талаасаа хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна. Хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэдэг хэдий сайн боловчиг нөгөө талдаа мөнгөний бодлогодоо муугаар нөлөөлдөг. Ялангуяа валютын ханих валютын нөөцдөө. Тэгэхээр мөнгөний бодлого төсвийн бодлого 2 хэрхэн уялдсан бэ? ЗГ-тай энэ төсвийн бодлоготой мөнгөний бодлого уялдсан уу гэдгийг би 2 дугаарт нь асуух гээд байгаа юм. Энэ 2-ыг уялдуулах гэж бид нар Эдийн засгийн хөгжлийн яам гэдгийг байгуулсан. Эдийн засгийн хөгжлийн яам гэдгийг байгуулсан.

3 дахь асуудал сая ч өмнөх гишүүд асууж байна. Ипотекийн зээлийн асуудал байгаа юм. Өнөөдөр энэ төвлөрөл маш хүчтэй болсон Улаанбаатарт. ЗГ-аас орж ирж байгаа 2024 оны төсвийн бодлого бол энэ төвлөрөл, төвлөрлийг сааруулах, орон нутагт иргэд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэж байгаа. Тэгэхээр ипотекийн зээлийг бол би ирэх онд орон нутаг руу нэлээд түлхүү өгөгдөх ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа. Өмнө нь бол Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар 70, 30 гэсэн харьцаагаар яваад

байдаг. Нийслэлд 70, орон нутаг 30 гэж. Одоо би энэ бодлого өөрчлөгдөх болов уу гэж ингэж бодож байгаа. Орон нутаг руу бид нар энэ орон сууцын хангамжийг энэ нэмэгдүүлж байж бид төвлөрлийг сааруулна. Улаанбаатарын төвлөрлийг сааруулна. Энэ чиглэлээр ирэх онд Монголбанк ямар бодлогыг.../минут дуусав/

**Г.Занданишатар:** Тогтохсүрэн даргад нэг минут, нэмэлт нэг минут.

**Д.Тогтохсүрэн:** Тэгэхээр ЗГ-ын бүрэн эрхийн хугацаа дуусахад бол бараг л нэг энэ ирэх онд бол 6 сарын л хугацаа байгаа шүү дээ. Их Хурлын бүрэн эрх, ЗГ-ын бүрэн эрх дуусахад. Тэгэхээр би бол ямар бодлого байдаг вэ гэхээр энэ ипотекийн зээлийн асуудал өнгөрсөн 4 жил бараг 10 гаруй жил Монголбанк дээр байгаад л ирсэн байхгүй юу. Одоо тэгээд л тэр үлдэж байгаа хугацаандаа Монголбанк дээрээ л дуусчих ёстой гэж ингэж бодож байгаа юм. Тийм учраас бол энэ ипотекийн зээлийн асуудал дээр бол энэ орон нутаг руу чиглүүлэх, орон нутгийн бизнесийг дэмжих, орон сууцын борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлд ирэх онд бол би арай өөр бодлого барих болов уу гэж бодож байгаа юм. Энэ орон сууцын хангамж чинь төвлөрөлт түгжээнд шууд нэмэгдэл болж байгаа шүү дээ. Манайхан бол түгжрэл гэхээр ганцхан машин бодоод байгаа үгүй. Орон сууц чинь хамгийн том түгжрэлийн нэг болж байгаа байхгүй юу. Тийм учраас бол энэ чиглэлээр ямар бодлого барьж байгааг 3 дугаарт нь асууя гэж бодож байна. Баярлалаа.

**Г.Занданишатар:** 83 Энхтайван хариулъя.

**Г.Энхтайван:** Тогтохсүрэн даргын асуултад сүүлийн асуултаас нь эхлээд хариулчихъя. Ипотекийн зээл. Ипотекийн зээлийг орон нутагт илүү түлхүү олгох талаар бол Монголбанк ЗГ-тай хамтраад бас хэд хэдэн удаагийн уулзалтын хүрээнд бол ярилцаад,

бодлогын шийдэлд бол хүрээд явж байгаа. 2024 оны улсын төсөв одоо Улсын Их Хуралд өргөн баригдчихаад байгаа төсвийн хүрээнд бол нийт 16 орчим тэрбум төгрөгийг ЗГ-аас орон нутгийн ипотекийн зээлийн хүүгийн хөнгөлөлтөд бол суулгасан байгаад байгаа. Өмнөх жилийн төсөв дээр бол 8 тэрбум орчим төгрөг суулгасан байгаа. Тэгээд энэ 16 тэрбум төгрөгийг хүүгийн хөнгөлөлтөд сууснаар бол энэ нь бол ойролцоогоор 8 мянга орчим өрхийн 4300 орчим өрхийн бол ипотекийн зээлийн хүүгийн хөнгөлөлтөд бол явна.

Ер нь бол цаашид ипотекийн зээл бол илүүтэйгээр бол энэ төвлөрлийг сааруулах бүсчилсэн хөгжлийг дэмжих, энэ ЗГ-аас хэрэгжүүлээд байгаа энэ Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хөдөөгийн хөгжлийг дэмжих хүрээнд бол илүүтэйгээр орон нутагт олгогдоод явах нь зүйтэй гэдэг бодлогыг бол Төв банкнаас бол барьж байгаа юм. Яг энэ хүрээнд бол орон нутагт олгогдох зээлийн хэмжээг бол Төв банкны хувьд бол 150 сая төгрөг болгон бол нэмэгдүүлсэн байгаад байгаа юм. Тэгэхээр бол ер нь цаашидаа ипотекийн зээлийн хөтөлбөр маань бол илүүтэйгээр Улаанбаатар хотод бол гэр хорооллын дахин төлөвлөлт буюу гэр хорооллын газар дээр байшин баригдаад тэр нь бол утаа болон хөрсний бохирдлыг бууруулж байгаа, нөгөө талдаа бол орон нутагт баригдаж байгаа төвлөрсөн төвлөрлийг бууруулж байгаа, орон хөдөөгийн хөгжлийг дэмжиж байгаа чиглэлтэй ипотекийн зээлийн хөтөлбөр явах нь зүйтэй гэдэг дээр бол Төв банк бол санал нэгдэж байгаа.

Зээлийн хүү буурахгүй байна гэж байгаа. Зээлийн хүү бол одоогийн байдлаар бол жигнэсэн дундаж хүү бол 16,4 орчим хувьтай байна. Энэ нь бол яах вэ олон жилийн турш бол яах вэ бага багаар буураад л явж байгаа юм. Зээлийн хүүг бол ямар нэгэн захиргааны актаар ч юм уу эсвэл хууль батлаад юу тогтоол батлаад зээлийн хүү буурахад бол хүндрэлтэй. Тэгэхээр зээлийн хүүгийн

буурахгүй байгаагийн суурь үндсэн нөхцөл бол бид бүхэн эх үүсвэр байхгүй байгаа буюу арилжааны банкнуудад маань хангалттай эх үүсвэр байхгүй байна л гэсэн үг. Тэгэхээр хангалттай эх үүсвэрийг бий болгохын тулд гадаад зах зээл дээрээс мөнгө татаж оруулж ирэх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, гадаадын банк, санхүүгийн байгууллагыг Монголын санхүүгийн салбарт оруулахад бол бодлогын тийм шийдэл гаргах бол зайлиггүй шаардлагатай байгаад байгаа юм. Энэ хүрээнд бол Төв банк өнгөрсөн хавар, намрын ч, намрын чуулганаар бол Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийг бол Улсын Их Хурлаар өргөн барьж батлуулсан байгаад байгаа юм.

Энэ хүрээнд бол Төв банкнаас гадаад орны санхүүгийн байгууллагуудтай бол тухай бүрдээ бол уулзалт хийгээд явж байгаа. Яг одоогийн байдлаар бол гадаад орны банк санхүүгийн байгууллагаас бол Монгол Улсад бизнесийн үйл ажиллагаа эрхэлж гэсэн тийм бол хүсэлт бол ирүүлээгүй байгаад байгаа. Тэгэхдээ яг одоогийн байдлаар бол Монгол Улсад 2 гадаадын банкны төлөөлөгчийн газар ажиллаж байгаа. Хятад ард улсын Bank of china, ICBC industrial commercial bank of china гэсэн 2 банк бол үйл ажиллагаагаа явуулж байгаа, төлөөлөгчийн газраар дамжуулаад. Бид бүхний зүгээс бол энэ 2 банкны төлөөлөгчийн газартай бол тогтмол уулзалт хийж, тэдгээрийн үйл ажиллагааг бол Монгол Улсад нэвтрүүлэх үйл ажиллагааг нь дэмжих чиглэлээр бол мэдээж бид бүхэн бол харилцан ярилцаад явж байгаа.

Мөн энэ хүрээнд бол бид бүхэн БНСУ-ын арилжааны банкнуудтай бол Төв банкны зүгээс хэд хэдэн удаагийн уулзалтуудыг хийсэн. Тэдгээр Солонгос улсын банкнуудыг Монгол Улсад үйл ажиллагаа явуулах чиглэлд нь бол илүүтэйгээр сурталчилгаа хийх, Монгол Улсын санхүүгийн зах зээл болон нийт эдийн засгийн талаар бол гадаадын улсын

банкнуудад бол томоохон ийм танилцуулга судалгаануудыг бол Төв банк цаг тухайд нь хийж байгаа. Төв банкны Ерөнхийлөгчийн одоо БНСУ-д ажиллаж байгаа ажлын гол үндсэн агуулга нь ч гэсэн энэ БНСУ-ын банкнуудыг Монгол Улсад оруулах, тэдгээрийн үйл ажиллагааг Монгол Улсад идэвхжүүлэх чиглэлээр Төв банк.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Дашидондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Монголбанкны нэлээн том үүрэг нь бол хараат бусаар ажиллах. Монголбанк маань өөрөө хараат бус байж чадаж байгаа юу? Би бол чадахгүй байна гэж бодож байгаа. Өнөөдөр ингээд хэд хэдэн үзүүлэлтүүд байна. Тухайлбал энэ юмны үнэ хани 1 дүгээрт. 2 дугаарт валютын Монгол төгрөгийн худалдан авах чадвар. Ийм юмаа бол тавиад туучихсан. 2022 оны мөнгөний бодлогыг 23 оны мөнгөний бодлогыг бид нар 23 оны өдий хавьцаа ингээд яриад сууж байсан. Одоо 24 оны мөнгөний бодлогыг яг яриад сууж байна. Өнгөрсөн жилийн мөнгөний бодлого бол дампуурсан. Та бүхний яг өнөөдөр орж ирээд ярьдаг зүйл нь юу байсан бэ гэхээр бид нар юмны үнэ ханиийг 6 +, -2 хувьд барина л гэсэн. Тэгж барьж чадаагүй.

Тэгээд нөгөө талаар та нарын бодлогын хүү чинь байнга 2 оронтой тоон дээр явна, 13 хувьтай л явж ирлээ. 13 хувьтай л явж байгаа одоо ч гэсэн. Тэгээд энэ бараа бүтээгдэхүүний үнэ хани бол хэд дахин өсчихсөн. Арилжааны банкнуудын зээлийн хүү үнэхээр хүнд болчихсон. Энэ ипотекийн зээл бол та нар хариуцах ёсгүй шүү дээ. Энүүгээрээ юу хийж байна вэ гэвэл та нар ерөөсөө энэ данхайсан төр засгийн нэг эд хэсэг шиг энэ нэг ЗГ-ын гишүүн шиг л энд сууж байгаа байхгүй юу. Ийм учраас энэ орон сууцын үнэ хани энэ бүх юм чинь өсөж байгаа юм. Та нар ипотекийн зээлийг хэрэгжүүлэх хэрэгжүүлнэ гээд ороод мөнгө хэвлээд, өнөөдөр нь ингээд сайн сайхан асуудлыг шийдээд байгаа юм шиг

боловч цаад утгаараа орон сууцын үнийг өсгөчхөж байгаа юм. Энийг эдийн засаг ойлгодог хүмүүс бол ингээд мэдэж байгаа шүү дээ.

Нөгөөдөх нь своп хэлцэл гэж байгаа. Та нарын хэлэлцдэг, ярьдаг, та нарын хариуцдаг Монгол банкны хариуцдаг. Энэ БНХАУ-ын Ардын банктэй өнөөдөр своп хэлэлцэл чинь ямар хэмжээнд байна вэ? Сунгаад л яваад байдаг, сунгаад л яваад байдаг. Энийг чинь л нөгөө өрийн хавх гэж яриад байгаа шүү дээ. Энэ своп хэлцлийн үнийн дүн бол тэгс ингэс хийгээд л нууц байдал ч юм уу бараг тэгж ингэж яриад л өнгөрдөг. Энэ ЗГ-ын зээл Монгол Улсын өрийн хэмжээнд орж явж байна уу явахгүй байна уу? Ерөөсөө та бүхний энэ бодлого бол мөнгөний бодлого бол Монголбанкны мөнгөний бодлого бол ард түмнийг ядуу байлгах л ийм мөнгөний бодлого явуулж байгаа. Энэ данхайсан төр энэ эрх баригчдад үйлчилсэн Монголбанк маань хараат бус ажиллаж чадахгүй ийм л байдалтай байгаа. Энийг хүлээн зөвшөөрч байна уу гэх мэтчилний ийм асуултууд байна.

Нөгөө талаар валютын нөөц өнөөдөр 4,1 гэж байна. Ер нь бол маш эмзэг. Энэ хэдэн 7 хоногийн экспортод хүрэх импортын нөөц байгаа юм бэ? Энэ уул уурхайн бүтээгдэхүүний үнэ уналаа л бол дуусна. Урд талд Хятадын эдийн засаг маш хүнд байгаа. Үл хөдлөх хөрөнгийн компаниуд нь дампуураад эхэлчихсэн ийм байдалтай байгаа. Энэ энэтэйгээ уялдуулж та бүхэн 24 оны мөнгөнийхөө бодлогыг хийж чадсан юм уу?

**Г.Занданшатар:** Ганболдын Энхтайван Монголбанкны дэд ерөнхийлөгч хариулна.

**Г.Энхтайван:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Төв банкны бодлого үйл ажиллагаа, Төв банкны бодлого, үйл ажиллагаа ер нь ЗГ-ын үйл ажиллагаанаас салангид байна уу, бие

даасан институтийн хувьд хараат бус бодлогоо явуулж чадаж байна уу гэдэг дээр гишүүн асуух шиг боллоо. Төв банкны ч бодлого дээр ЗГ-ын бодлого ч дээр ер нь бол нэгдсэн 1 зорилготой гэж Төв банк ойлгодог. Энэ нь бол Монгол хүний эрүүл, аюулгүй орчинд сэтгэл хангалуун амьдрахыг амьдрах орчныг бий болгох л зорилготой. Энэхүү зорилтдоо яаж хүрэх вэ гэдгийг тус тусынх нь хуулиар үйл ажиллагааг нь зохицуулаад олгоод явдаг. Төв банк хуулиараа эдийн засгийн эрэлтийн талыг мөнгөний бодлогоороо удирдаад явдаг. Тэгэхээр Төв банкны мөнгөний бодлого маань өөрөө, ЗГ нийлүүлэлтийн талыг нь удирдаад явдаг. Төв банк эрэлтийн талыг нь удирдаад явдаг. Энэ 2-ын бодлогын нийлбэр нь өөрөө манай улсын эдийн засгийн бодлогыг бол тодорхойлдог. Тэгэхээр Төв банкны бодлого өөрөө дангаараа эдийн засгийн суурь нөхцөлүүдийг бол шийдэхэд бол боломжгүй.

Бид бүгдийн зүгээс мэдээж ипотекийн зээлийн хөтөлбөрийг бол 2013 оноос хойш хэрэгжүүлээд явсан. Энэ нь ЗГ-аас тухайн үедээ Улсын Их Хурлаас баталсан тогтоолын хүрээнд бол эрүүл, аюулгүй орчинд амьдрах, Монгол хүний амьдрах нөхцөлийг сайжруулах, дундаж давхаргыг дэмжих гэсэн маш олон бодлогын малгайн доор энэхүү хөтөлбөр хэрэгжээд явдаг. Нэгэнт ингээд хэрэгжээд явсан бодлогыг бол шууд ингээд зогсоох нь бас хүндрэлтэй. Тэгэхээр бол Төв банк бол нэгэнт ингээд хэрэгжээд явж байгаа бодлогыг ЗГ-т хугацааны дунд бол шилжүүлээд, зөв голдиролдоо ороод явах нь бол зүйтэй гэдэг бодлогыг бол баримталж байгаа. Энэ хүрээнд ч гэсэн өнгөрсөн жилийн мөнгөний бодлогын баримт бичигт бол энэ асуудал бол орсон байгаад байгаа юм. Бид бүхэн бол дараа жилдээ буюу Үндэсний орон сууцын корпорац байгуулагдахаар энэ өөрийн эзэмшилд байгаа бондын өмчлөлийг бол тухайн корпорацад шилжүүлээд өгнө.



Свопын хувьд бол Төв банк БНХАУ-ын Ардын банктай байгуулсан своп хэлэлцээр хүрээнд бол 12 тэрбум юанийн 15 тэрбум юанийн своп хэлцэл байгуулагдсанаас 12 тэрбумыг нь бол ашиглаад байгаа. 2016 оноос хойш бол нэг ч цент юанийг бол нэмж ашиглаагүй байгаад байгаа. Энэ оны 8 дугаар сард бол БНХАУ-ын Ардын банктай бол энэхүү своп хэлэлцээрийг бол сунгаад явсан байгаад байгаа, 3 жилээр сунгагдсан байгаад байгаа. Своп хэлэлцээр нь бол нийт өрийн статистикт бол ороод бүртгэгдээд явж байгаа.

Гадаад валютын албан нөөц 4,1 тэрбум ам.долларт хүрсэн нь сүүлийн 22 сарын бол хамгийн өндөр үр дүн. Энэ бол манай улсын импортын бол 6,6 орчим сарын хэрэгцээг бол хангаж байгаа.

**Г.Занданшатар:** Дашдондогийн Ганбат гишүүн тодруулъя.

**Д.Ганбат:** Миний нэг асуултад хариулсангүй. Өнгөрсөн жилийн мөнгөний бодлого, юмны үнэ хани инфляцыг 6 дээр нэмэх нь +, -2 гэсэн. Тэр чинь биелэгдсэн юм уу л гэж би асууж байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт ахиад энэ бодлогоо ахиад л оруулаад ирсэн байна. Та нарын бодлогын хүү чинь өөрөө 13 байгаа. Гэхдээ юмны үнэ хани бол өсчихсөн байгаа. Ийм бодлогын хүүтэй байхад энэ банкнууд чинь ямар зээлийн зээллэг гаргах юм бэ? ААН яаж 2 оронтой тоотой ийм зээлийн хүүтэй бараг 20, 30 хувийн зээлийн хүүтэй үйл ажиллагаа явуулах юм, чадахгүй шүү дээ, болохгүй, амжихгүй. Энийг юу гэж бодож байгаа юм бэ? Нөгөө арилжааны банкнуудыг олон нийтийн хяналтад оруулна гэсэн. Энэ бол ерөөсөө нэр төдий л юм хийсэн шүү дээ. Тэр хамгийн дээд тал нь аравхан хувь хувийн хувьцаагаа л гаргасан. Орж чадаагүй. Нөгөө талаар бол энэ хани нь бүгд унасан.

**Г.Занданшатар:** Ганболд Энхтайван 83 дэд ерөнхийлөгч.

**Г.Энхтайван:** 2023 онд Төрөөс баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлд инфляцыг нэг оронтой тоонд барина гэдэг үндсэн чиглэл батлагдсан байгаад байгаа. Энэ оны үндсэн чиглэл бол 6 дээр +, -2 хувийн интервалд дунд хугацаандаа тогтворжуулна гэсэн тийм агуулгатай орж ирж байгаа. Дэлхийн бүхий л орны Төв банкнууд инфляцыг дунд хугацааны зорилтын түвшинээ үндсэн чиглэл болгож барьж явдаг. Угаасаа мөнгөний бодлогын аливаа шийдвэрүүдийн үр дүн бол бас тодорхой хугацааны буюу 3-аас 4 улирлын дараа эдийн засагт бол үр нөлөөгөө үзүүлж эхэлдэг учраас бүх банк бүх Төв банкнууд бол инфляцаа дунд хугацаанд бол тогтворжуулахаар баримталдаг байгаад байгаа.

Инфляцын хувьд бол энэ оны 7 дугаар сарын байдлаар инфляц бол 9,2 буюу нэг оронтой тоонд орсон. Бас 7 дугаар сард төсвийн тодотголоос хамаараад бол инфляц 8 сард бол бас суурь үеийн нөлөөнөөс голчлон хамаараад бол 10 орчим хувьтай гарсан. Энэ оны.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Энэ оных 9,3 хувь. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Статистикаас харахад төсвийн орлого нэмэгдсэн, валютын нөөц 4 тэрбум ам.доллар-т хүрсэн гээд ингээд нааштай үзүүлэлтүүд гараад байна л даа. Гэтэл яг бид нарын иргэдийн амьжиргаанд энэ нь өөрөө яаж нөлөөлж чадаж байна вэ гэхээр үнийн өсөлтийн дарамтад ямар ч нөлөө үзүүлэхгүй, үнийн өсөлтийн дарамт буурах битгий хэл улам л өсөөд байна. Энийг бид нар бүгдээрээ харж байна. Тэгээд иргэдийн орлогыг хамгаалах энэ бололцоо ч гэсэн хумигдмал болчихоод байна шүү дээ. Тэгээд сая энэ гишүүдийн яриад байгаа бас үнэн. Бид нар инфляц өндөр байна, Монголбанк үнийн хатуу

бодлого явуулж байна, цаашидаа ч хатуу бодлогоо үргэлжлүүлж явуулна гэсэн дүр зураг энэ 24 оны Төрөөс баримтлах мөнгөний бодлогоос бол харагдаж байна л даа.

Тэгэхээр энэ нь өөрөө эдийн засаг тэлж, ажлын байр нэмэгдэх боломж ер нь байхгүй л гэж бараг шулуухан хэлчих гээд байна л даа. Тэгээд ажлын байр нэмэгдэхгүй, ажиллах хүчний түвшний оролцоо бараг сүүлийн 2 хэдэн жил 57 гэдэг нэг тоон дээр гагцхиад л байгаад байна. Яг энэ тоо нь өнөөдөр хэвээрээ байгаа юу үгүй юу гэдгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь гаргаж ирэхгүй, хууль дүрмээ ч оруулж ирэхгүй байгаад байна. Төсөв мөнгөний бодлого хэлэлцэж байхад энэ чиглэлийн сайд нар нь сууж байх хэрэгтэй байна л даа.

Монголбанкны энэ төрөөс баримтлах мөнгөний бодлогын нэг гол зүйл энэ ажлын байр л маш чухал байгаад байна шүү дээ. Ажлын байрыг нэмэгдүүлж чадахгүйгээс болоод иргэдийн орлогыг хамгаалж чадахгүй, үнийн дарамт өндөр байгаа болохоор л ажилгүйдэл, ядуурал нэмэгдээд байна. Энэ чинь өөрөө нийгмийг зэрлэгших энэ ноцтой хүнд, хүнд гэмт хэргүүд гарах, хүчирхийлэл, хулгай буурахгүй байх гол шалтгаан шүү дээ. Бид нар тэгээд энийгээ төсөв болоод төрийн мөнгөний бодлого хэлэлцэж байхдаа онцолж авч үзээд, энийг шийдэхийн тулд эхлээд төсвийн зөв хуваарилалтыг энд хийе. Төрийн мөнгөний бодлогыг төсөвтөө уяад энийг нь шийдье гээд явж байх ёстой л доо уг нь. Тэгээд бид нар бас энэ хараад байхад Төрийн мөнгөний бодлогыг Их Хурал хэлэлцэх эсэхээ ярьж байна. Мэдээж хэлэлцэнэ. Дараа нь төсөв орж ирнэ. Тэгэхээр төсөв мөнгөний бодлого 2 уялдаа бас л хангалтгүй харагдаад байна л даа. Яагаад гэвэл энэ төсөв тэлж байгаа юм чинь бид нар хатуу бодлого барихаас арга байхгүй гээд Монголбанк ярьж байгаа. Энэ мэдээж та нарын хувьд үнэн.

Гэтэл энэ чинь өөрөө яг саяын хэлээд байгаа нь арилжааны банкнууд ямар ч зээл гаргах боломжгүй байна шүү дээ. Жилийн 25 хувийн хүүтэй зээлийг ямар ААН аваад ашигтай ажиллах вэ, яаж ажлын байрыг нь нэмэгдүүлэх вэ. Энэ чинь бололцоогүй л дээ. Тэгээд бараг арилжааны банкнууд зээлээ ч гаргахгүй байна шүү дээ. Ийм байдлаар бид нар цаашидаа яаж явах вэ? Бид нар Улсын Их Хурал энэ тэр бид төсөв мөнгө ярьж байхдаа иймэрхүү зүйл дээр л анхаарч байж. Жишээлбэл нөгөө хүүхдийн хүчирхийлэл чинь эндээс буурна шүү дээ. Аав ээж нь ажилтай, хариуцлагатай, мөнгөтэй бол тэгж хүүхэд хол сургуульд яваад байж байх уу. Бид олон сургууль цэцэрлэг барьчихна. Хувийн таксинууд гээд ямар ч татвар төлдөггүй ийм ямар ч хяналтгүй такси энэ тэр ингээд явж байх уу. Тэгэхээр энэ дээр бид нар ингээд бодолцож Улсын Их Хурал нухацтай хэлэлцээд, одоо энэ төрөөс баримтлах мөнгөний бодлого дээр ажлын байрыг нэмэгдүүлэх, иргэдийн орлогыг энэ үнийн дарамтаас хамгаалах чиглэл дээр бид яг юу хийх вэ гэдэг дээр маш тодорхой хариулт би авахыг хүсэж байна л даа.

Сая хүнсний хувьсгал гэдгээр ХАА-н салбарт тодорхой хэмжээний зээл бодлогоор төсөвт мөнгө суугаад гарч байгаа. Тэгэхдээ энэ нь өөрөө ажиллах хүчний оролцоонд одоогоор нөлөөлөөгүй. Яг л нөгөө авдаг хэдэн ААН тодорхой хэмжээний зээл авсан. Үйл ажиллагаа нь одоогоор үр дүн нь яг харагдаагүй байгаа л даа. Тэгэхээр эхний асуулт байна. Бид нар энэ жилийн 25 хувийн хүүтэй зээлийг энэ мөнгөний 24 оны бодлогоор бууруулах бололцоо байгаа юу байхгүй юу гэдгээ бас шууд хэлчихмээр байна л даа. Төсөв ингээд тэлээд ороод ирж байгаа. Эдийн засаг ингэж тэлж байгаа үед та нар мэдээж үнийн хатуу бодлого явуулж байна. Бодлогын хүү 13 гэж байна. Энэнээс доошоо буух бололцоо харагдахгүй л байна л даа. Тэгэхээр ер нь их л бүрхэг харагдаад байна. Та бүхэн маань 6 дээр +, -2 гээд л энийгээ яриад л орж ирж байна.

Тэгээд энэ ганц Монголбанкнаас шалтгаалж байгаа зүйл биш л дээ.

Уг нь ЗГ маань Монголбанктэйгээ энийгээ ярьж байгаад төсөв мөнгөний бодлогоо уяад, яг ийм асуудлууд дээр анхаарлаа хандуулж бид төсвийн мэдрэмжтэй хуваарилалт хиймээр байна л даа. Тэгээд энэ дээр эхлээд хариулт авах.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ганболдын Энхтайван хариулъя.

**Г.Энхтайван:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Тантай ер нь бол зарчмын хувьд бол санал нэг байгаа. Тийм. Төв банкны хуулиар олгогдсон үндсэн үүрэг бол инфляцыг нам дор түвшинд тогтворжуулах байгаад байгаа. Инфляц маань өөрөө эдийн засгийн өсөлтийн хамгийн эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийн буюу иргэдийн, ААН-үүдийн орлогыг хамгаалах үндсэн суурь нөхцөл бол мөн. Инфляц өөрөө өндөр байх нь эдийн засагт ард иргэдийн карман дээрээс, ААН-үүдийн карма дээрээс шууд мөнгийг татвар хэлбэрээр аваад явчхаж байгаа л нэг л асуудал. Тэгэхээр Төв банк өөрөө бодлогын хувьд юуг 1 дүгээрт тавих юм бэ буюу ямар асуудлаа эхэлж барьж авах юм бэ гэдэг бодлогын эрэмбэ дараагийн асуудал энэ дээр гараад байгаа юм.

Тэгэхээр манай эдийн засаг өөрөө 53 орчим их наядын эдийн засаг байна. Үүний 66, 67 хувь нь өрхийн эдийн засаг гэдэг чинь 30 гаруй их наядын эдийн засаг. Үүнээс цаад чинь жилийн 10 хувийн инфляцаар бодох юм бол бараг 3 гаруй их наяд төгрөгийг үнийн өсөлтөд алдаад байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр өрхийн амьжиргааг тэтгэх, үнийн өсөлтөөс ард иргэдийн орлогыг хамгаалах хамгийн гол арга бол инфляцыг бууруулах. Тэгэхээр инфляцыг бууруулах үндсэн арга нь бол Төв банкны хувьд бол бодлогын хүүг бодлогын төлөвийг хатуу орчинд барих л ийм л сонголт бол байгаад байгаа юм. Тэгэхээр бол мэдээж энэ төсвийн

тэлэлттэй байгаа үед Төв банкны хувьд бол мөнгөний хатуу бодлогыг бол баримтлахаас өөр арга байхгүй.

Тэгэхээр тодорхой хугацаанд бол мөнгөний хатуу бодлогын үр дүн гарсны дараа бол инфляц нам доор түвшинд тогтворжоод ирэх үеэр бол мэдээж зээлийн хүүгийн асуудал, зээлийн хүртээмжийн асуудал, ААН-үүдийн бизнесийн үйл ажиллагааг тэтгэх асуудлууд бол ингээд гарна. Тэгээд яг энэ ажиллах хүчний оролцоо болон хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой энэ дэлгэрэнгүй яг хариултыг бол манай ерөнхий эдийн засагч Ган-Очир өгөх байх.

**Г.Занданшатар:** 85 Ган-Очир, 85.

**Д.Ган-Очир:** Оюунчимэг гишүүний асуултад тодруулъя. Хөдөлмөрийн зах зээл дээр яг оролцооны түвшин бол таны хэлсэнчлэн 57,9 хувь дээр бол сүүлийн 2 жил дээр бол байгаа. Тэгэхдээ хөдөлмөр эрхлэлтийн түвшин бол энэ онд 54,5 хувь болж өнгөрсөн оноос буюу 20 онд бол 52,7 хувь байсан үүнээсээ бол өссөн байгаа. ҮСХ-ноос зарлаж байгаа ажилгүйдлийн түвшин бол 5,8 хувьтай байна гэдэг ийм статистик мэдээлэл байгаа. Зүгээр яг эдийн засаг дээр юу болж байна вэ гэхээр уул уурхайн салбар маань түрүүлж сэргээд түүнийг дагаад тээвэр худалдааны салбар маань өсчихсөн явж байгаа. Тэгэхээр уул уурхайн бус салбар луу маань эдийн засгийн сэргэлт маань цаг хугацааны туршид бол алгуур бол шилжилт бол дөнгөж эхэлж байгаа. Тэгэхээр энэ өндөр өсөлтүүд маань уул уурхайн бус салбар луугаа орох юм бол энэ нь тэр нөлөөгөөр бол ажил эрхлэлт болон хөдөлмөрийн зах зээл дээр дам эерэг нөлөөллүүд нь бол цаг хугацааны туршид бол гарах бололцоотой гэж бол Төв банкны зүгээс бол харж байгаа. Тийм. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Оюунчимэг гишүүн тодруулъя.

**М.Оюунчимэг:** Манай Төв банкныхан бас жоохон буулгаж ярьж байна. Ярьж байгаа нь бас үнэн л дээ, 3 битгий хэл бүүр 4 их наядыг алдаад байгаа шүү дээ. Тэгээд энэ маань л нөгөө татвар төлөгчдийн мөнгө, энэ маань эргээд нөгөө үнийн өсөлтийн дарамтаас иргэдээ ямар ч хамгаалж чадахгүй харин өсөөд байна. Тэгэхээр одоо бид нарын яг яриад байгаа нь энэнийг бид нар яаж төсөв хэлэлцэхдээ энэ дээр та нар маань анхаараад энийг нэг янзлаадхаач, инфляцыг ийм өндөр байлгахгүй байх дээр мөнгөний бодлоготой уяж ийм юм шийдэх хэрэгтэй байна гэдэг тэр саналаа та нар маань бас хэлэх хэрэгтэй байна л даа. Тэгэхгүй бол ингээд инфляц 2 орон тоо байгаа юм чинь бид мөнгөний хатуу бодлого баримтлахгүй л бол арга байхгүй энэ бол Монголбанкны үүрэг юм гээд сууж баймааргүй байна л даа. Бид нар энэ яаж ийгээд л нээрээ ажлын байр нэмэгдүүлж, иргэдээ орлоготой байх, орлогыг хамгаалах асуудал чинь нэг номерт байгаад байна шүү дээ. Тэгээд энэ валютын нөөц 4 тэрбум ам.доллар-т хүрчихсэн гээд байгаа. Энэний эерэг нөлөө жишээ нь эдийн засагт иргэдэд яаж нөлөөлөх вэ? Нөлөөлөх үү нөлөөлөхгүй юу? Эсвэл нөгөө гаднах зээл тусламж маань өндөр байгаа учраас ийшээ явчих юм уу? Бид өнөөдөр бахархаад л яриад байна шүү дээ. Валютын нөөц.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ганболдын Энхтайван 83 хариулъя.

**Г.Энхтайван:** Гадаад валютын албан нөөц 4,1 тэрбум долларт хүрч, сүүлийн 22 сарын хувьд хамгийн өндөр хэмжээнд хүрсэн нь бол эдийн засгийн хамгийн гол үндсэн суурь үзүүлэлтүүд болж байгаа. Манай улсын эдийн засаг өөрөө 1 дүгээрт уул уурхайн дээр хамааралтай эдийн засгаас гадна импортын хамааралтай эдийн засаг. Энэ хэрэглээний үнийн индексэд тооцож байгаа 410 бүтээгдэхүүний чинь дийлэнх 50 хувь нь бол импортын бараа бүтээгдэхүүн байгаад байгаа юм.

Тэгэхээр импортын бараа бүтээгдэхүүн гэдэг маань өөрөө ханшинд бол маш эмзэг. Үүгээр дамжуулаад инфляцад бол маш их томоохон хэмжээний нөлөө орж ирдэг. Тэгэхээр хани өөрөө тогтвортой байх нь бол инфляцыг бас тогтвортой байлгах бол үндсэн нэг урьдчилсан нөхцөл болж байгаа юм. Тэгээд оны эхнээс бол хани бол 0,4 хувь орчим л суларсан нь бол хани бол энэ жилийн хувьд бол харьцангуй тогтвортой байгааг илтгэж байгаа. Тэгэхээр гадаад валютын албан нөөц маань өөрөө энэ эдийн засгийг тогтвортой байлгах бол үндсэн нэг үүрэг агуулгаа бол гүйцэтгэж байгаа. Мөн.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Цагаанхүүгийн Идэрбат нарын урилгаар Хэнтий аймгийн Дадал сумын ахмадуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт Дадалчууддаа Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. Буриадын хамт олон байна. Содномын Чинзориг гишүүн асуулт асуух уу? Содномын Чинзориг гишүүн.

**С.Чинзориг:** 2, 3 зүйл тодруулъя Мөнгөний бодлогоос. Яах вэ ер нь бол яах вэ төсвийн орлого нэмэгдэж байна, уул уурхайн бас нүүрсний гарц нэмэгдэж байна. Валютын хани үгүй ээ валютын нөөц нэмэгдэж байна эд нар гээд бас макро эдийн засгийн нааштай үзүүлэлтүүд бол байна л даа. Яг гишүүдийн яриад байгаа шиг энэ үзүүлэлтүүд нь яг иргэдийн амьжиргаанд хэр нөлөөлж байна вэ, өрхийн хаалгаар орж чадаж байна уу үгүй юү гэдэгт л жаахан асуудлууд бол байна. Төсвийн орлого нэмэгдэж байгаа. Нөгөө талдаа бас төсвийн бас бодлого бас тэлж байгаа асуудлууд байна. Нөгөө талдаа нэг энэ Монголбанкны бодлогын хүү бас хивэндээ 13 хувьдаа хадгалагдаад, мөнгөний бас хатуу бодлого бас үргэлжлэх нь.



Тэгээд энэ мөнгөний хатуу бодлого үргэлжлэхээр чинь бизнес л нэлээн хумигдах л бодит сектор маань нэлээн хумигдах л ийм юм руу л яваад байна л даа. Энийг жаахан тэлэх ямар арга байх юм бэ? Энэ та бүхний энэ номыг чинь харахаар бизнесийн зээлийн өсөлт харьцангуй нам түвшинд хадгалагдаж байна гэдэг чинь үндсэндээ бизнесийн явахгүй байна л гэсэн үг. Зээл бол гарахгүй байна л гэж байгаа юм. Тэгээд энэ ном дээр чинь харахаар зээлийн өсөлтийг өсөлтийн чинь дийлэнх нь хэрэглээний зээл, хадгаламж барьцаалсан зээл, худалдаа үйлчилгээний зээл л гээд. Тэгэхээр бид нар чинь энэ эдийн засгаа олон тулгууртай болгож хөгжүүлнэ, төрөлжүүлнэ гээд байдаг тэр бодлого маань хэрэгжихгүй, тэрнийхээ эсрэг зөвхөн нөгөө уул уурхайгаасаа хараат байдал маань улам л газар аваад л байна л даа. Энийг ер нь жоохон өөрчлөх, тэр эдийн засгаа олон тулгууртай болгох, энэ бизнесийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх ямар бодлого явуулах юм бэ? Та нар бол ингээд төсөв тэлж байна. Зээлийн хүү, бодлогын хүүг өөрчлөхгүй л гэх байх л даа Ямар гарц байх вэ?

Манай ажиллагсдын чинь бүтэц маш их эмзэг шүү дээ. 20 хувь нь төрийн албан хаагчид. Тэгээд 50 хувь нь албан бус секторт хөдөлмөр эрхэлж байна, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ЖДҮ эрхэлдэг малчид эд нар ороод, ийм бас ажиллах биш ийм бүтэцтэй. ААН байгууллагуудын чинь бас бүтэц маш их эмзэг. 80 гаруй хувь нь 9 хүртэх ажиллагсадтай жижиг ААН-үүд. Тэгээд эд нар чинь ингээд бизнесийн зээл олдохгүй, зээл хумигдаад олдоц нь муудаад, хүү нь өндөрсөөд байхаар чинь энэ бизнесийн бодит салбар чинь тэлэхгүй, зөвхөн уул уурхайгаасаа хараат энэ байдал чинь улам л газар аваад байна шүү дээ. Тэгээд хэзээ бид нар эдийн засгаа олон тулгууртай төрөлжүүлэх юм бэ, ямар бодлого явуулах юм бэ, ямар үр дүн гаргах юм бэ гэдгийг нэг тодорхой зүйл бол яримаар байгаа юм.

2 дахь асуудал нь энэ ипотекийн зээлийн хэрэгцээ орон нутагт маш их бол байна. Та бүхэн бол бодлогоороо 70 ипотекийн зээлийн эх үүсвэрийн 70 хувийг орон нутагт өгдөг, 30 хувийг нь 70 хувийг нь нийслэлд өгдөг, 30 хувийг нь орон нутагт өгдөг л гээд. Би сая танай улсуудаас асуулаа. Яг гүйцэтгэлийг нь аваад үзэхээр ипотекийн зээлийн санхүүжилтийг чинь 90 хувь нь Улаанбаатар хотод, 10 хувь нь л хөдөө орон нутагт өгч байна шүү дээ. Тэгээд энэ хөдөөд боловсон хүчин олдохгүй байна, багш дутагдалтай, эмч дутагдалтай гээд байдаг чинь энэ ипотекийн зээлийн чинь бодлогын л бас алдаа шүү дээ. Энийгээ яаж засах юм бэ?

Энэ ЗГ чинь Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулна, хөдөөгийн сэргэлтийг дэмжинэ гээд яриад байдаг. Тэгээд энэ ипотекийн зээлийн бодлого чинь яг Засгийн ярьж байгаа, явуулж байгаа энэ бодлого чинь эсрэг болчихоод байна шүү дээ. Ядаж энэ ипотекийн зээлийнхээ нэг 50 хувийг нь Нийслэлд өгдөг, 50 хувийг нь хөдөө орон нутагт өгдөг эд нар ийм бодлого хэрэгжүүлмээр байна шүү дээ. Та нар энэ дээр ямар бодлого яах юм бэ? Орон нутгийг дэмжсэн ипотекийн зээлийн санхүүгийнхээ санхүүжилтийн эх үүсвэрийг ядаж орон нутаг руугаа.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ, Ганболдын Энхтайван.

**Г.Энхтайван:** Чинзориг гишүүний асуултад хариулъя. Сүүлийн асуултаас нь эхлээд хариулчихъя. Ипотекийн зээлийн зээл олголтын хувьд бол орон нутагт 16,5 орчим хувь нь бол олгогдож байгаа. Төв банкны зүгээс бол ипотекийн зээлийн хөтөлбөрийг бол цаашидаа орон нутагт чиглэсэн хот хөдөөгийн хөгжлийг дэмжсэн, бүсчилсэн хөгжлийг дэмжсэн, төвлөрлийг сааруулсан тэр чиглэлд нь явуулах нь бол зүйтэй гэдэг бодлогыг бол баримтална. Энэ хүрээнд ч гэсэн өнгөрсөн

7 хоногт бол Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар орон нутагт ипотекийн зээл авч байгаа иргэний зээлийн дээд хэмжээг бол нэмэгдүүлсэн байгаад байгаа. 150 сая төгрөг бол болгосон.

Ер нь бол ЗГ-тай бол Төв банкны зүгээс ярилцаад энэ орон нутагт орон сууц худалдаж авч байгаа иргэдэд бол дэмжлэг үзүүлэх хүрээнд бол хүүгийн хөнгөлөлтийн хөтөлбөрийг бол ЗГ-аас хэрэгжүүлээд явж байгаа. Энэ удаагийн төсөв дээр бол 16 тэрбум төгрөгийн бол хүүгийн хөнгөлөлтийг бол төсөв дээр суулгаад өгсөн байгаад байгаа. Өнгөрсөн жилийн хувьд бол нэг төсөв дээр 8 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлт байсан. Ингээд 2 дахин нэмэгдэж байгаа нь бол цаашидаа орон нутагт бол энэ ипотекийн зээлийн хөтөлбөрийг нэмэгдүүлэх, орон нутагт шилжин суурьшиж байгаа болон орон нутагт ажиллаж байгаа иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах энэ нөхцөлийг нь бүрдүүлэх энэ хэрээр Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах чиглэлд нь бол Төв банк ЗГ-тай бодлого, үйл ажиллагаагаа бол нийлүүлээд явна.

Өрхийн бодит орлоготой холбоотой асуудал дээр бол мэдээж зээлийн өсөлт бол 13,5 хувьтай байгаа. Үүний 8,8 хувь нь бол хэрэглээний зээлийн өсөлт байгаад байгаа. Тэгэхээр бол бизнесийн зээл дээр бас хүсэлт бол харьцангуй бага байгаа гэдэг дээр бол хүлээн зөвшөөрч байгаа. Тэгэхдээ бол өрхийн орлогыг хамгаалах, бодит орлогыг нэмэгдүүлэх бол үндсэн урьдчилсан нөхцөл бол түрүүн бас хэлсэн. Инфляцыг бол яаралтай түргэн хугацаанд бууруулах, инфляцыг нам дор түвшинд бууруулсны дараа бол дараа дараагийн асуудлуудыг бол ярих боломжтой болж байгаа. Инфляцыг бууруулахгүйгээр бол зээлийн өсөлтийг нэмэгдүүлэх, эдийн засгийг тэтгэх, хүртээмжийг нэмэгдүүлэх гэдэг асуудал бол байхгүй. Тэгээд дэлгэрэнгүйг манай Ган-Очир эдийн засагч ярьчих байх.

**Г.Занданшатар:** Чинзориг гишүүн нэг минут.

**С.Чинзориг:** Тэгэхээр Энхтайван Ерөнхийлөгчөө ипотекийн зээлийн санхүүжилтийн 16 хувь нь зөвхөн хөдөөд өгч байна шүү дээ. 84 хувь нь Улаанбаатар хотод. Тэгээд энийгээ яг хэд болгох юм бэ гэдгээ тодорхой хэлэх хэрэгтэй шүү дээ. Ядаж 50, 50 болгох юм уу, Улаанбаатар хотод ядаж ипотекийн зээлийн санхүүжилтийн 50 хувь нь Улаанбаатарт, хөдөөд нь 50 хувь гэдгийг нь тодорхой хэлэх хэрэгтэй шүү дээ ийм бодлого баримталж байна гээд ингээд ерөнхий яриад суугаад байж болохгүй.

2 дахь асуудал нь тэр бизнесийн дэмжсэн, бодит салбарыг дэмжсэн зээлийн хүртээмжийг яаж нэмэгдүүлэх юм. Энэ байдлаар явбал наад зээл чинь улам хумигдах нь байна шүү дээ. Энэ бизнес эрхлэгчид чинь хаалгаа барих нь байна шүү дээ. Ажлын байр бий болгох, орлого бий болгох асуудал нэлээн муудах нь байна шүү дээ. Танай Монголбанкны үнэт цаасны хэмжээ 5 их наяд байсан, одоо 7 их наяд гараад явж байна шүү дээ. Энэ чинь бол үндсэндээ бодит салбар луу зээл гарахгүй байна л гэсэн үг. Энэ банкнууд чинь танай үнэт цаасыг худалдаж аваад л.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ганболдын Энхтайван 83 дэд ерөнхийлөгч, Монголбанкны дэд ерөнхийлөгч асуултад хариулна.

**Г.Энхтайван:** Түрүүн урьд нь бас хэлсэн 16 орчим тэрбум төгрөгийн хүүгийн татаас төсөв дээр суусан байгаад байгаа юм. Тэгээд энэ 4300 өрхийн Ипотекийн зээлийн хүүгийн хөнгөлөлт байгаад байгаа. Хэрвээ 4300 өрх яг энэ энийгээ бүрэн ашиглах юм бол жилдээ бол ойролцоогоор 7 мянга орчим өрхийн ипотекийн зээл бол гарч байгаа. 7-гоос 8 мянга орчим. Тэгэхээр бол 4300 бүгдээрээ орон нутагт олгогдоод явах юм бол энэ орон нутаг, Улаанбаатар хотын

ипотекийн зээлийн харьцаа бол 50 50 хувьд бол хүрэх бол бүрэн боломжтой гэж бол Төв банкны зүгээс бол үзэж байгаа.

Төв банкны үнэт цаасны хувьд бол 5,9 их наядын үнэт цаас бол Төв банкинд дээр хадгалагдаж байгаад байгаа. Тэгээд мөрдөгдөж байгаа банкны арилжааны банкны үйл ажиллагааг зохицуулж байгаа журмуудын хүрээнд бол Төв банкинд дээр байршиж байгаа үнэт цаасны хэмжээ бол 5 их наядаас бол буурах бол боломжгүй байгаад байгаа. Энэ бол банкны үйл ажиллагааг хэвийн зохистой хэмжээнд хадгалах зайлшгүй шаардлага.

**Г.Занданшатар:** Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууна. Дараа нь завсарлага. 2 цагаас хойш.

**Ц.Идэрбат:** Монголбанкнаас мөнгөний бодлого оруулж ирж танилцуулагдаж байна. Үндсэндээ 2021 оны өдийд л бас анх мөнгөний бодлогыг батлалцах хуралд бас гишүүн болоод орж байсан. Тэр үеийн гадаад хүчин зүйл маш хүнд байна. Тээвэр логистик муу байна, гадаад валютын албан нөөц багасчихсан байна. Тэгээд л олон учир шалтгаанууд яриад байж байсан. Ноднин ч бас жоохон буурах хандлагатай байна л гэж ингэж ярьж байна. Өнөөдөр буюу 2023 онд орж ирж байгаа энэ танилцуулга яг энэ Монгол Улсын төсөв танилцуулсан энэ төсвийн төсөл дээр мөн та бүхний энэ танилцуулсан тараасан энэ ном дээр ингээд энэ инфляцтай холбоотой асуудлуудыг хараад үзэхээр Монгол Улсын инфляцад нөлөөлж байгаа гадаад хүчин зүйлүүд бол харьцангуй байхгүй болсон байна. Гадаад валютын албан нөөц 4 тэрбум гарсан байна. Тээвэр логистикийн гацаа арилсан байна. Долларын ханиш бүр тэр битгий хэл 20, 30 төгрөгөөр буусан байна гээд. Ингээд гадаад хүчин зүйлүүд нэлээн гайгүй юм гараад байдаг.

Гэтэл бид нар дотоодын хүчин зүйлүүд чинь өөрөө инфляцыг чинь маш өндөр түвшинд болгоод байгаа юм биш

үү? Энэ Сангийн яамны танилцуулга дээр байна шүү дээ. Энэ малын махны үнэ, гурилын үнэ 2. Энэ хоёулаа дотооддоо үйлдвэрлэдэг юм. Энэ Монгол Улсын инфляцад маш өндөрөөр нөлөөлөөд байгаа юм байна. Инфляц өндөр гараад байгаа учраас та бүхэн бодлогын хүүгээ 13 хувьдаа хэвээр нь хадгалаад байгаа юм байна. Тэгэхээр тэр 2021 оны тэр хүнд үе байсан, одоо гадаад хүчин зүйлүүд чинь бас харьцангуй гайгүй болчихсон энэ цаг үед энэ бодлогын хүүгээ ийм өндөрт бариад байхаар энэ бизнесийн энэ зээлийн эргэлтүүд чинь ингээд багасаад, энэ гишүүдийн хэлээд байгаа ийм нөхцөл байдлууд үүсээд байгаа юм биш үү?

Тэгэхээр инфляцыг багасгах та бүхэн гол үүргээ энэ дотоодынхоо энэ асуудлуудыг яаж шийднэ гэж бас ярьж байгаа юм бэ, харж байгаа юм бэ? Эдийн засгийн хөгжлийн яам, энэ Монгол Улсын ЗГ, энэ Монголбанк энийг бас хамтад нь би өргөн барьсан байгаа болов уу гэж ингэж бодож байгаа. Та бүхний танилцуулсан энэ номыг би энэ төсвийн төсөлтэй 2, 3 хоног л сайн уншлаа л даа. Инфляцыг багасгах стратегийн төлөвлөгөө дээр чинь 2 дахь дээр нь бол энэ цаг үеийн нөхцөл байдлаас савладаг энэ нөхцөлд мөнгөний бодлогыг уялдуулж болдоггүй юм. Тэгвэл буруу тийшээ явчих гээд байдаг гэж байгаа шүү дээ. Гэтэл инфляцын гол хүчин зүйл гээд байгаа 10 хэдэн хувьтай байгаад байгаа энэ зүйлүүдээ цаг үеийн хүчин зүйл гэж үзэх юм уу, инфляцад гол нөлөө үзүүлээд байна гэж үзэх юм уу? Энэ засгийн энэ юун дээр гурилын үнэ гэхэд маш өндөр 49,6 буюу 50 хувиар нэмэгдчихсэн байна. Энэ инфляцад гол нөлөөлж байна. Махны үнэ нөлөөлж байна. Гэтэл яг нөгөө мал махыг бий болгодог малчдынх нь орлого бодитой нэмэгдсэн юм юу ч байхгүй байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр яг энэ инфляц юунаас болоод хөөрөгдөөд байгаа юм бэ гэдэг дээр бас Монголбанк ямар дүгнэлттэй байгаа юм бэ 1 дүгээрт энэ.

2 дугаарт энэ ногоон зээлийн асуудлыг жил болгон л ярьж байгаа.

Ипотекийн зээлийн асуудлыг жил болгон л ярьж байгаа. Би яах вэ орон нутгаасаа мэдээлэл авахад ипотекийн зээл сардаа нэг Хэнтий аймагт явуулж байгаа арилжааны банкнуудаас 7, 8 л гарч байсан бол 12, 13 руу сүүлийн 3 сар орж байна гэж байгаа шүү дээ. Тэгээд та нарын танилцуулж байгаа дүн энэ 2 чинь бас зөрөөд байна уу үгүй юү? Одоо тэгээд ипотекийн зээлээс гадна ипотекийн зээл рүү бүх анхаарлаа хандуулаад ногоон зээлийг 2-т тавих биш. Ногоон зээлийг бас нэлээн өндөр түвшинд гаргаж ирвэл нэгж айлд очих зээлийн хэмжээ нь тодорхой хэмжээнд буураад, тэнд хашаандаа аятай тухтай амьдрах орчин нөхцөл энэ улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр энэ шугам сүлжээнүүд чинь хийгдээд ингээд явж байгаа шүү.

Тэгэхээр тэр хүнийг хашаандаа сайхан амьдрах бололцоог бүрдүүлэх ногоон зээлийг ипотекийн зээлтэй бараг энэ чацуу авч үзэх юм бол бидний нөгөө зориод байгаа аятай тухтай орчин нөхцөлд амьдруулах энэ хэрэгцээ чинь хангагдана шүү. Тэгэхээр ипотека гэж ярьчихаад, ногоон зээлийг бол бас доош нь 10 хувийн түвшинд аваачна эд нар гэж бол би бас битгий яриасай. Энэ 33 сум, 330 сум, энэ 21 аймгийн төвд ногоон зээл.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ?  
83 Монголбанкны дэд ерөнхийлөгч Ганболдын Энхтайван.

**Г.Энхтайван:** Идэрбат гишүүний асуултад хариулъя. Гишүүнтэй бол ерөнхийдөө бодлогын хувьд бол санал нэгтэй байна. Ипотекийн зээлийн хөтөлбөр бол орон нутагт хот, хөдөөгийн хөдөөгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдруулах бол үндсэн урьдчилсан нөхцөл болж байгаа гэдгийг бол Төв банк бол ойлгож байгаа. Энэ хүрээнд бол ипотекийн зээлийн хөтөлбөрийг цаашидаа орон нутаг, Улаанбаатар хотын хувьд бол тэнцүү хэмжээнд олгох бодлогыг бол дараа дараагийн жилүүдэд бол бариад

явна. Төсөвт суусан 4300 айлын өрхийн яг зээлийн хөнгөлөлтийн хувь хэмжээ дараа жилдээ бүрэн ингээд аж өрх маань өрхүүд маань өөрөө зээлээ авах юм бол ингээд дараа жилийн хувьд бол ингээд нэг бараг 50, 50 хувьтай зээлийн олголт бол явагдана.

Арилжааны банкнуудад бол зээлийн хүүгээ бууруулахгүй байна, ногоон зээл бас харьцангуй бага гарч байна гэдэг тийм асуудлыг ярьж байна. Мэдээж дэлхий даяар сүүлийн үед дэлхийн бараг бүхий л оронд голлон хэлэлцэгдэж байгаа, *mainstream* болж байгаа энэ ногоон зээлийг нэмэгдүүлэх, байгаль цаг уурын өөрчлөлтөөс сэргийлсэн бараа үйлчилгээ, бүтээгдэхүүнүүдийг дэмжих, байгаль орчинд ээлтэй энэ санхүүжилтийн тогтолцоог бий болгох чиглэлд дэлхийн бүхий л Төв банкнууд бол энэ дээр анхаараад явж байгаа. Тэгээд 10 хувь гэдэг маань бас харьцангуй өндөр тоо. Бид бүхэн бол нэлээн том бодлогын алхмыг бол хийж байна гэсэн үг. Мэдээж энэ 10 хувь гээд гэдэг маань бол тодорхой жил жилдээ алхам алхмаараа дээшлээд явна. Дараа жилийн хувьд бол бид нар 10 хувь бол хүргэх ийм бодлогын зорилт бол тавиад явж байгаа.

Тэгээд ер нь бол цаашидаа Тогтвортой хөгжлийн зорилтууд болон НҮБ-аас баталсан энэ уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой энэ дүрэм журмуудыг бол хэрэгжүүлэх үүднээс бол Төв банкин дээр олон улсын байгууллагууд болон бусад холбогдох байгууллагуудтай бүхий л түвшинд хамтарч ажиллаад явна. Тэгээд манай ерөнхий эдийн засаг ч бас дэлгэрэнгүй энэ тоон мэдээллийг бас танилцуулчих байх.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, байж байгаарай. Ган-Очир тодруулах юм уу? 85 Ган-Очир ерөнхий эдийн засагч.

**Д.Ган-Очир:** Идэрбат гишүүний асуултад тодруулъя. Инфляцын хүчин зүйлсийн асуудлуудыг эхлээд хөндсөн. Үүн



дээр Монголбанк бол инфляцын гадаад хүчин зүйл бол ирэх онд ч гэсэн хадгалагдахаар байна гэдэг асуудлыг харж байгаа. Тэгэхдээ хүчин зүйлийнх нь хэлбэр нь бол өмнөх онуудаасаа бол харьцангуй ялгаатай болж орж ирж байгаа. Эхний асуудал бол гадаадын шууд хөрөнгө оруулалт бол өмнөх онуудаасаа бол нэлээд татрах, ялангуяа Оюу толгой дээр орж ирж байгаа гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ бол 2 дахин буурахаар байгаа.

Хятадад өрнөж байгаа эдийн засгийн уналтын нөхцөл байдал бол нүүрсний үнэ болон нүүрсний борлуулалтын хэмжээ дээр бол сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлт хүчин зүйлс бол өмнөх жилүүдээсээ илүү өндөр болж орж ирж байна гэж бас харж байгаа. Ялангуяа энэ оноос.

3 дахь нь бол газрын тосон дээр бол ОХУ, Саудын Араб бол газрын тосны нийлүүлэлтийгээ бол бууруулж эхэлж байгаа. Энэ бол нөгөө геополитикийн зөрчилдөөн бол газрын тосны зах зээл дээр тусгалаа олоод энэ хэлбэрээр бол газрын тосны нийлүүлэлт багассанаас болоод үнэ нь бол сүүлийн сар гаруй хугацаанд бол 94 ам.доллар хүртлээ өсчихсөн. Ер нь шинжээчид бол 100 хүрэх байх, 100 хүрэх юм бол буцаад улс орнуудын инфляцын дарамт бол илт нэмэгдэж болзошгүй гэдэг ийм эрсдэлт хүчин зүйлс бол гадаад талдаа бол бидэнд инфляц болон төлбөрийн тэнцэл дээр байгаа гэдгийг бол бас бидний танилцуулга ном дээр бол тодорхой бичсэн байгаа.

Дотоод талдаа бол таны хэлж байгаа яалт ч үгүй энэ мах, гурил буюу хүнсний дотоодын хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт бол өндөр түвшинд яваа. Өнөөдрийн инфляцын бол дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа. Энэ бол Монголын эдийн засгийн хувьд бол өмнөх жилүүдэд ч байсан асуудал. Энэ агуулгаар бол энэ бүтцийн шинжтэй энэ бараа бүтээгдэхүүний инфляцыг бууруулах

чиглэлд бол тээвэрлэлт логистиктой холбоотой, улсын нөөц бүрдүүлэлт, механизмыг нь тодорхой болгохтой холбоотой, зарим компаниуд салбаруудын ашигийн маржин өөрөө хэт өндөр, богино хугацаанд бас энэ үнийн өсөлтийг далимдуулсан өсөлт байж болзошгүй асуудлууд гээд тооцоо судалгаануудыг бол Монголбанк хийгээд, ЗГ-т бол бас удаа дараа танилцуулга зөвлөмжөө бол хүргүүлдэг. Энэ агуулгаар бол бас ЗГ-ын бүтцийн бодлого, төсвийн бодлогын уялдаан дээр бол энэ асуудлуудыг шийдэж явах байх гэдгээр бол асуудлыг харж байгаа.

Энэ асуудлыг шийдэхгүй бол манипуляц бол өөрөө богино хугацаанд хурдтай өсдөг энэ үр дагавар бол өнгөрсөн жилүүд ч байсан. Ирэх жилд ялангуяа ХАА-н салбар, тэр дундаа МАА-н салбарын махны үнэ дээр бол бас энэ өвөлжилт баруун аймаг дээр үргэлжлэн цаг уурын нөхцөл байдалтай хамааран бол үргэлжлэх тохиолдолд бол ирэх онд бол бас махны үнэ болон ХАА-н бүтээгдэхүүний нийлүүлэлт дээр бол үргэлжлэн нөлөөлж болзошгүй гэдгээр бол дотоодод инфляцыг бол бас бид харж байна.

Дээрээс нь нэмэх нь дэлхий нийтийн цаг уурын уур амьсгалтай холбоотойгоор бол Энэтхэг болон европт бол хэт халалт, үерийн асуудлууд энэ зун явсан. Энэ бол цагаан будааны үнэ, улаан лоолийн үнэ зэрэг хүнсний дэлхийн зах зээлийн дээрх үнүүд бол бас маш хурдацтай өссөн. Энэ бол импортын барааны үнээр бас үргэлжлэн орж ирж болзошгүй гэдгээр бол асуудлыг бас бид бүхэн харж байгаа.

2 дахь асуултын хувьд бол валютын нөөц сүүлийн саруудад огцом өсөж байгаа энэ асуудалд бол энэ ногоон зээлийн гадаадын санхүүгийн байгууллагуудаас дотоодын банкнуудад орж ирж байгаа 500 сая ам.долларын санхүүжилт бол гол нэг хүчин зүйл болж байгаа. Тэгэхээр банкнууд бол ногоон зээл

олгох зорилгоор бол сүүлийн бараг хагас жилд 500 орчим сая долларын эх үүсвэр зээлийг оруулж ирсэн. Тэгэхээр энэ зээлийн онцлог нь бол яг энэ зориулалтаар нь цаашаа олгохгүй бол цаад зээл олгосон тал нь бол мониторинг хяналт бол маш өндөр тавьдаг ийм онцлогтой зээл. Тэр утгаар бол банкнууд бол энэ ногоон зээл, түүний хүртээмжийг сайжруулах, тэдэнд шаардлагатай стандарт, дэд бүтцийг бэхжүүлэх ажлыг бол Монголбанктай хамтраад бол ирэх онд, одоо ч гэсэн хийж байгаа энэ ажил дээр бол нэлээд идэвхтэй ажиллана гэдгээр бол асуудлыг бол харж байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууна.

**Ц.Идэрбат:** Ногоон зээлийн асуудал дээр ийм ахиц гарч байгаад туйлын баяртай байгаа юм. Энийг энэ Монгол Улсын төсөв ч гэсэн тэр, орон нутгийн дэд бүтцийн асуудлуудыг маш сайн дэмжинэ, тусална, хийнэ гэсэн ийм том зорилтууд энэ 2024 оны төсөв дээр суугаад явж байгаа. Тэгэхээр энийг яг хэрэглэгчид хүргэхэд энэ ногоон зээл маш том дэм үзүүлэх юм. Уялдаа холбоотой байж чадвал бидний нөгөө ая тухтай тийм орчинд амьдруулах гээд байгаа тэр зорилт бол ипотекийн зээлээс илүү би үр дүнтэй гэж харах гээд байгаа юм. Ипотекийн зээл бас тийм хүн хүсээд байхаар юм биш шүү дээ. 100 саяын байрыг аваад 20 жилийн дараа 300 сая болгож л төлж байгаа ийм л зээл шүү дээ.

Гэтэл энэ ногоон зээл гэдэг бол шууд тэнд амьдрах орчноо сайжруулах гэж байгаа олон хүнд шууд хүрч байгаа. Ялангуяа орон нутагт бол маш хэрэгтэй ийм зээл байгаа. Энэний хүртээмж дээр бас ахиц гарч байгаад би баяртай байна. 2 дугаарт миний нэг хэлэх гээд байгаа юм энэ дотоодын инфляцад нөлөөлөөд байгаа гадаад хүчин зүйлийг бол энэ хойд хөршийн дайн байлдаан, энэ эдийн засгийн нөхцөл байдал гээд олон юмнууд байгаа ойлгож байгаа. Тэр Опекийн.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Энхтайван би таныг энэ Байнгын хороон дээр хэлсэн үгийг чинь давтаж үзүүлье. /Г.Энхтайваны дууны бичлэгийг сонсгов: Сектор байна гэсэн. Тэгэхээр 32 их наяд төгрөг дээр ч 10 дунджаар 15 хувийн инфляцад тооцохоор бол жилдээ Монгол Улсын нийт иргэдийн халааснаас бол 4 их наяд орчим төгрөг байгаа байх, аваад явчхаж байгаа гэсэн үг. Сүүлийн 3 жил дээр нь ингээд тооцоод үзэх юм бол түүрүүн Батдаваа даргын хэлсэнчлэн жилийн дунд 3 жилийн инфляц бол 34 хувьтай гэхээр бол ойролцоогоор ингээд тооцоод үзэхээр бол 12-оос 14 орчим их наяд төгрөгийг өрхийн сектороос авч явсан гэж бол ойлгож болно./ Тэгэхээр Монгол улс 1 сая өрхтэй гэж тооцоход бол 14 их наяд төгрөгийг өрхөөс инфляцаар хулгайлсан байна гэдэг чинь сар болгон 400 мянган төгрөгийг л тэр ядарч яваа тэтгэврийн өвгөд хөгшчүүд, тэгээд хамгийн бага орлоготой тэр үйлчилгээний ажилчид тэд нарын гэрээс л хулгайлж байна гэсэн үг л дээ.

Тэгэхдээ энэ чинь бол та нарын зүгээр албан ёсны тоо. Энэ тоонууд чинь бүгд худал. Би ганцхан жишээ дээр хэлье. 2020 оны 2 сарын 1-ний өдөр Монгол Улсын Их Хуралд төсвийн тодотгол хийж, ахмадуудын тэтгэврийг нэмсэн. 350 мянга байж байгаад 500 мянга болсон. 500 мянган төгрөгөөр яг тэр 2 сарын 1-ний өдөр 50 мянган төгрөгийн шуудай гурилын төгрөгийн үнэтэй шуудай гурилыг 10-ыг авдаг байсан байхгүй юу даа. Гэтэл үүнээс хойш нэг жил хагасын дараа өнөөдрийн байдлаар тэтгэвэр 550 мянган төгрөг болсон боловч 4 шуудай хагас гурил авч байна. Өөрөөр хэлбэл энэ хооронд инфляц зөвхөн гурил дээр 140 хувьтай явсан байна. Та нарын энэ саяын чиний ярьж байгаа 4 их наяд чинь 14 их наядынх байхгүй юу даа. 14 хувийнх байгаа. Тэгэхээр ер нь бол ийм эдийн засгийг ингэж үнэхээр энэ ард

иргэдийн карман суйлах ажлыг бол ЗГ, Монгол банк 2 бол дэндүү сайн хийж байна.

Яаж байна тэр муусайн ахмадуудыг май миний муусайн ахмадууд гээд 2 сарын 1-нд өнгөрсөн оны 2 сарын 1-нд тэтгэврийг нь 500 мянга болгож өгчхөөд, буцаагаад яаж байна бүх бараа бүтээгдэхүүнийг, эдийн засгийг бүгдийг нь буруу удирдаад, бүгдийг нь эдийн засгийг бүгдийг нь хог новш болгоод, буцаагаад тэр ахмадуудын тэтгэврийг бүгдийг нь инфляцаар бүгдийг нь хулгайлж авч байна шүү дээ. Шуудайн гурилыг хагас нэг жил хагасын дотор 50 мянгаас 120 мянган төгрөг болтол өсгөдөг ийм эдийн засгийг удирдана гэж юу байдаг юм бэ. Тэрнийгээ ингээд нэг тийм нэг жижигхэн ногоон эдийн засгийн, ногоон зээл гэсэн нэг ийм юм яриад л таглах гээд л. Та нар бол Монголыг бол ёстой үнэхээр завааруулж дуусаж байна. Та нарын хийж байгаа ажил гэж байхгүй.

Тэр юуны валютын нөөц өссөн чинь, тэр хулгайтай тэмцээд, тэр хулгайчдад нүүрсний юунаас хулгайнаас зайлсхийсний л үр дүн. Нүүрсний хулгайчдаа яадаг байсан бэ гэхээр хамгийн бага нүүрсний экспортыг гаргаад, тэндээсээ авлигал, хүнд суртал бий болгож байгаад тэндээсээ хулгайлдаг байсан байхгүй юу. С зөвшөөрлөөр дамжуулаад. Тэрний үр дүн дээр гарч ирсэн өсөлт болохоос биш та нарын хийж байгаа ажил нэг ширхэг ч юм байхгүй. Энэ нүүрсний өсөлтөөс орж ирж байгаа энэ зүйл чинь ард түмний кармад эергээр тусаж байгаа нэг ширхэг ч юм байхгүй. Энэ хүмүүсийн амьдралыг бол үнэхээр сүйрүүлж дуусаж байна.

Тэгээд хамгийн гайгүй инфляцтай тэр бараа бүтээгдэхүүний үнийг сагсанд оруулж байгаад л инфляц 10 хувьтай байна, 8 хувьтай байна гээд л юм яриад байгаа болохоос наадах амьдрал дээр наадах инфляц чинь бүүр сүйрээд дууссан юм шүү дээ. 140 хувьтай байна шүү дээ

гурилан дээр гэхэд нэг жил.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хариулт авахгүй юм байна. Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн алга байна. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга асууна.

**Б.Энх-Амгалан:** Би нэг Энхтайван дэд ерөнхийлөгчид өмнө бас хэлж байсан юм. Үр хүүхдэдээ нэг мөнгө төгрөг шилжүүлэх гээд 100 доллар шилжүүлэхээр 100 долларын хураамж авдаг ийм банк манайхаас өөр газар хаана байдаг юм бэ? Тэгээд дээрээс нь та бүхэн нэг юмыг ойлгох хэрэгтэй. Энийг чинь валютаар нь шилжүүлж болохгүй тийм учраас өнөөдрийн ханшаар бодож авна гээд авдаг нөгөө бага ханшаараа авчихна. Буцаагаад цааш нь шилжүүлэх болохоор зардаг ханшаараа зарна. Ингээд энэ чинь мөнгө шилжүүлэх ямар ч бололцоогүй ингээд яваад байдаг. Тэгээд энийгээ ингээд энэ чинь хуульдаа тийм юм гээд нэг юм яриад суугаад байдаг. Энийгээ цэгцлэхгүй юм уу? Энэ чинь бол нэг тийм нэг өдөр тутмынхаа юманд оролцох гээд явж байгаа үр хүүхэд нь гадна, дотно сурч байгаа хүмүүст бол маш том дарамт болж байна шүү дээ. 1 дэх нь энэ.

2 дахь нь та бүхэн яриад байна. Энэ бодлогын хүүгээ нэг бууруулахгүй юм уу? Наад бодлогын хүү чинь буурахгүй болохоор энэ арилжааны банкнууд чинь зээлийн хүүгээ бууруулахгүй байна шүү дээ. Зээлийн хүү буурахгүй болохоор энэ бизнес эрхлэгчид чинь, энэ ААН-ийнхэн чинь зээл авч чадахгүй байна шүү дээ. Зээлээс зээлийн хооронд давхисаар байтал наадуул чинь тэгээд хүүдээ шатаад, тэгээд юун ашиг олох, юун тогтож үлдэх дээрээ тулчхаад байна шүү дээ. Энэ дээрээ нэг зоригтой шийдэл гаргахгүй юм уу?

Инфляц бууруулахгүй бол зээлийн өсөлт нэмэгдэхгүй гээд яриад сууж байна. Инфляцаа бууруулах ямар арга хэмжээ авах юм бэ? Газрын тосны нийлүүлэлт

багасчихсан, тэгээд дээрээс нь нүүрсний үнэ уначихлаа. Тийм учраас инфляц өсөөд байна гээд яриад суугаад байдаг. Үгүй ээ тэгвэл инфляц өсгөхгүй байх, үнэ нь унаагүй ямар бүтээгдэхүүн байгаа юм бэ? Тэрнийхээ талаар арга хэмжээ авахгүй юм уу? Тэр зэс чинь яасан юм, алт чинь яасан юм бэ?

Энэтхэгт үер болсон учраас ингээд цагаан будаа үнэд орчихсон, үр тариа үнэд орчихсон гээд байдаг. Үгүй ээ дотооддоо тарьж болдоггүй юм уу энэ чинь. Импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэж болдоггүй юм уу? Энүүхэн хилийн цаана энэ Халх голын цаад талд байгаа Хянганд чинь тэр ургадаг будаа байна шүү дээ. Жилд нэг удаа ургац авдаг. Тэр нь бол дотоодынхоо зах зээлээс 3 дахин үнэтэй будаа байна. Тийм сортын будаа энэ тэр авчраад тарьж болдоггүй юм уу. Ийм байдлаар яваад байвал энэ чинь цаашидаа ингээд энэ инфляц чинь өсөөд, ард иргэдийн чинь гар дээр бэлэн мөнгө байхгүй боллоо шүү дээ. Бизнес эрхлэгчид чинь мөнгө, одоо юу үйлдвэрлэж чадахгүй, ажлаа явуулж чадахгүй, зээлээ авч чадахгүй байсаар байтал энэ чинь татвар чинь төлөгдөх үү? Ийм нөхцөл байдлаа надад нэг хариулаадхаач. Энэ чинь цаашидаа тэгээд ер нь яах юм бэ яг?

**Г.Занданшатар:** Ер нь тэгээд будаа тариалах, импортыг орлох үйлдвэрлэл тариалах энэ тэр бол ЗГ, ХААЯ-наас асуух ёстой асуулт л даа. Монголбанкны асуудал биш. 83 Ганболдын Энхтайван.

**Г.Энхтайван:** Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Таны асуултын сүүлээс нь эхлээд хариулчихъя. Энэ зээлийн хүүтэй холбоотой асуудал бол эмзэг асуудал. Ямар нэгэн захиргааны актаар хууль гаргаад эсвэл Монголбанкнаас чиглэл өгөөд бол хүү буурахгүй. Хүү гэдэг маань өөрөө манай улсын эдийн засгийн суурь нөхцөлүүдийг илтгэж байгаа нэг параметр. Хүүгийн бол хүү ямар нөхцөлд буурах вэ гэхээр

арилжааны банкин дээр эх үүсвэр нэмэгдээд, арилжааны банкнуудын эх үүсвэрийн зардал буураад, энэ хэрээр зээлийн хүртээмж нэмэгдээд, үүний дараа зээлийн хүү бол буурна.

Тэгэхээр зээлийн хүү буурах үнэ үндсэн нөхцөл бол хямд өртөгтэй нэмэлт санхүүгийн эх үүсвэр, эх үүсвэрийг оруулж ирэх буюу санхүүгийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, гадаад улсын банк санхүүгийн байгууллагыг оруулж ирэх тийм л бодлого байгаа. Түүнээс биш Төв банкны зүгээс бол аливаа захиргааны арга хэмжээ аваад бол энэ хүү буурахад бол хүндрэлтэй.

Инфляц дээр бол мэдээж Төв банк бол зээлийн өсөлтөөс өсөлтийг анхааралтай ажиглаж байгаа. Мэдээж инфляцын хэмжээ Төв банкны зорилтот түвшинээс өндөр байгаа үед бол бид бүхэн зээлийн өсөлтийг бол бүүр өндөр түвшинд барих бол боломж бол байхгүй. Тэгэхээр бол Төв банк бол өөрийн бодлого, үйл ажиллагаагаа эрэмбэлээд хамгийн I дүгээрт нь инфляцыг бууруулна. Инфляц нь өөрөө иргэд ААН-ийн орлого, бодит орлого дээр хүнд цохилт учирч байгаа. Татвар хэлбэрээр орлогыг нь бол багасгаж байгаа учраас инфляцыг бууруулах бол зайлшгүй шаардлагатай. Инфляцыг бууруулж, инфляцыг Төв банкны зорилтот түвшинд авчирсны дараа дараа дараагийн асуудлууд бол яригдана.

Тэр шимтгэлтэй холбоотой асуудал дээр бол Төлбөр тооцоо үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль болон Валютын зохицуулалтын хуулийн дагуу бол Монгол Улсад явагдаж байгаа аливаа төлбөр тооцоо бүгдээрээ үндэсний мөнгөн тэмдэгтээр явагдах ёстой. Иргэн хүн өөрийнхөө данс хооронд бол гадаад валютын төлбөр бол хийж болно. Түүнээс биш өөрийнхөө юу гэдэг юм хүүхдэдээ ч юм уу, ах эгч, хамаатан садандаа бол валютаар мөнгө шилжүүлэх бол хориотой байгаад байгаа. Гадагшаа бол төлбөр тооцоо бол хийх бол асуудал



нь бол нээлттэй байгаа. Хил дамнасан төлбөр тооцоон дээр. Шимтгэлийн асуудал дээр бол 100 мянга орчим доллароос хүртэлх дээр бол 30 ам.долларын шимтгэлтэй байгаа арилжааны банкнууд дунджаар. Тэгэхдээ энэ төлбөр тооцоо дээр хүндрэл учирч байгаа асуудал бол мэдээж энэ байнга бол гарч байгаа. Энэ дээр бол Төв банк бол ойрын хугацаанд л тодорхой ийм арга хэмжээ авч энэ хүндрэлүүдийг бол арилгана.

**Г.Занданшатар:** Батиугар, Энхбаярын Батиугар гишүүн асуулт асууна.

**Э.Батиугар:** Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Яах вэ олон гишүүн зээлийн хүү ярьж байна л даа. Зээлийн хүүгийн өндөр байгаа шалтгаан нь үндсэндээ бол үнэн өсөлтийн инфляц шүү дээ. Тэгээд банкнууд их хямдхан эх үүсвэр гэж байгаа юм. Банкнууд хямдхан эх үүсвэр гэхээсээ илүү эх үүсвэрийнх нь зардал нь юу вэ гэвэл ерөөсөө хадгаламжийн хүү. Хадгаламжийн хүү өөрөө зээлийн хүүгээс өндөр байж банкнууд хадгаламж татна. Тэгээд зээл гарахдаа бол хадгаламжийн хүүгээс өндөр хүүтэй байж байж зээл гарна. Энэ чинь бол цаашаага явахдаа бол дам, дам нөлөөгөөр бол тэгээд л ахиад л эргээд инфляцад нөлөөлж байгаа юм.

Яах вэ хэд хэдэн асуулт байна л даа. Тэгээд эхний асуулт нь бол мэдээж түрүүн яригдаад байсан энэ ЗГ болон Төв банкны уялдаа холбоо. Өнөөдөр бол инфляц 10 хувьтай байна 8 сарын сүүлийн байдлаар. Гэхдээ бол хүнсний инфляц үнэхээр өндөр байна. Ялангуяа мах, сүү, гурилан бүтээгдэхүүн. Тэгэхээр яг нийлүүлэлтийн гаралтай инфляцаа дотоодын нийлүүлэлтийн гаралтай инфляцаа эрэлтийг нь боомилохгүйгээр ямар байдлаар бид нар шийдэх боломж байна вэ, Энүүгээр Төв банк болон ЗГ тодорхой хэмжээнд хоорондоо ярилцсан зүйл байгаа юу? Ялангуяа махны тал дээр. 70 сая малтай байж бид нар чинь махны үнэ жил болгон өсдөг. Тэгэхээр бүсчилсэн

нийлүүлэлтийн *hub mode* гэх мэтчилэн юм байгуулж шийдэх бүрэн бололцоотой гэж би харж байгаа юм. Эхний асуулт.

2 дахь асуудал бол энэ ипотекийн зээл. Ипотекийн зээл 2020 оноос эхлээд 6 хувьтай гарч эхэлсэн. 20 оноос өмнөх 13 он гэхээр 8 хувьтай. Тэгэхээр энэ 2 хувийн зөрөөн дээр яг тодорхой хэмжээний арга хэмжээ авах нь зүйтэй гэж бодож байгаа юм. Яагаад гэвэл зүгээр цаг хугацааны асуудлаас болоод энэ бодлогын хүүгийн, бодлогын золиос болоод байна маш олон иргэд. Тэгэхээр энэ нийтдээ энэ 2 хувийн хүүг нөхөхөд хэдэн төгрөг хэрэгтэй вэ? Үүн дээр Монголбанкны талаас тодорхой хэмжээнүүдэд бодлого баримталж байгаа юу?

Жижиг, дунд бизнес эрхлэгч нь бол Монгол Улсын эдийн засгийн үндсэн суурь нь байдаг. Нийт ажлын байрны 60 хувийг нь эзэлдэг. Дээрээс нь нэмээд энэ бүртгэлтэй компаниудын 90 хувийг нь эзэлдэг. Тэгэхээр яг үүнтэй холбоотойгоор дэмжих тийм санхүүгийн бүтээгдэхүүн болон бодлого байгаа юу Төв банкнаас? Ялангуяа энэ хүртээмжтэй санхүүгийн оролцоо гэж бодлого тийм явдаг. *Financial influence т...* гэж ярьж байгаа. Тэгэхээр энүүн дээр ямар нэгэн тийм бодлого Төв банкнаас баримтлах уу ирэх жил?

Гадаадын хөрөнгө оруулалт гэж. Сая Их Хурлаас Хөрөнгө оруулалтын банкны дагуу хууль баталсан. Тэгэхээр хөрөнгө оруулалт, гадаадад том хөрөнгө оруулалттай банк орж ирснээр мэдээж Шинэ сэргэлтийн бодлогын төслүүд хэрэгжих бололцоотой болно. Валют орж ирнэ гадаад. Гэхдээ үндсэндээ бол яагаад өнөөдрийн байдлаар орж ирэх хүсэлт өгөөгүй вэ гэвэл ерөөсөө энэ ханины эрсдэл байгаа юм. Тэгэхээр Төв банкны талаас энэ дээр бол тодорхой хэмжээний тухайн банкнуудтай янз янз *h...* бүтээгдэхүүн болон бусад ханины эрсдэлээс хамгаалах тийм бодлогууд хэрэгжүүлснээр гадаадын хөрөнгө оруулалттай банк урих бүрэн бололцоо

нээгдэх юм. Үүн дээр ямар бодлого баримтлах вэ?

Мэдээж дэлхий технологи бол хөгжиж байна. Тэгэхээр Монгол Улсад ч гэсэн эдийн засгаа солонгоруулахын тулд бол инновацлаг, дэвшилтэт технологид суурилсан компаниуд гарч ирж байна. Эд нар дээр эд нарыг дэмжих тодорхой хэмжээний бодлого баримтлах уу? Ялангуяа финтекийг яаж дэмжиж байгаа вэ Төв банкны зүгээс? Мэдээж дэлхийн эдийн засаг ковидын дараах эдийн засаг, дээрээс нь нэмээд энэ геополитикийн хүнд нөхцөл байдал дээр болоод байдлаас болоод тэгээд шинэ энэ бодлогын хэрэгслүүд гарч ирж байгаа юм. Төв банкны ашиглаж байгаа. Жишээлбэл *dynatic...*, аль эсхүл *do lent s...* гэх мэтчилэн тийм шинэ мөнгөний болон хэрэгслүүдийг бусад улс орны Төв банкнууд ашиглаж байгаа. Тэгээд өнөөдөр бол Монгол Улсын Төв банк бол 2012 оноос хойш бол тодорхой хэмжээний шинэчилсэн бодлогын хэрэгсэл гаргаагүй. Тэгэхээр үүн дээр шинэ бодлогын хэрэгсэл гарах тийм зорилго байгаа юу?

**Г.Занданшатар:** Энхтайван 83.

**Г.Энхтайван:** Батшугар гишүүний асуултад хариулъя. Яг үнэхээр яг эдийн засагт тулгамдаад байгаа асуудлуудыг бол яг сууриар нь бол та асуулаа. Ипотекийн зээлийн хөтөлбөр дээр бол 2013 оноос энэ төрөөс хэрэгжүүлж байгаа хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр 8 хувьтай хэрэгжээд, 2020 оны төгсгөлөөс эхлээд 6 хувийн хүүд бол шилжсэн байгаад байгаа. Энэ хүрээнд бол 2 хувийн хүүгийн зөрөө бол үүсэж байгаа. Тэгээд яг одоогийн байдлаар Төв банкин дээр байгаа зээлийн нөгөө ипотекийг зээлээр баталгаажсан бондын хэмжээтэй харьцуулаад үзэхээр ойролцоогоор 400 орчим тэрбум төгрөгийн бол нэмэлт эх үүсвэр шаардагдах тооцоололтой байгаад байгаа. Одоо 8 хувь хувийн зээлүүдийг 6 хувь руу шилжүүлэхэд. Тэгэхээр энэ 400

орчим тэрбум төгрөгийг аль нэгэн санхүүгийн эх үүсвэрээс шийдвэл энэ одоо байгаа 8 хувьтай хүмүүс бол 6 хувь руу шилжих боломжтой болно.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн хувьд бол байгаа зээлийн хэмжээ бол 6,2 их наяд төгрөгийн бол зээл ЖДҮ-лэлийн ААН-үүдэд бол олгогдсон байгаад байгаа. Төв банк бол мэдээж эдийн засгийг солонгоруулах, солонгоруулах, ажлын байрыг хадгалах, хүртээмжтэй өсөлтийг бий болгох, иргэд, ААН-ийн орлогыг хамгаалах үүднээс бол ЖДҮ-лэгчдэд бол ээлтэй зээлийн бодлого хэрэгжүүлэх талаар бол 2020 оноос бол бас тодорхой бодлогын шийдлүүдийг бол авч хэрэгжүүлээд ажиллаж байгаа. Энэ хүрээнд бол урт хугацаатай репо зээлийн хөтөлбөр мөн уул уурхайн бус экспортыг дэмжих хөтөлбөр гэх мэтчилэн бол хэд хэдэн тийм бодлогын арга хэмжээнүүдийг бол Төв банк мөнгөний бодлогынхоо арга хэрэгслийн хүрээнд бол гаргасан байгаад байгаа.

Төв банк бол инфляцыг нам доор түвшинд бууруулахад бол зөвхөн эрэлтийн талаас нь оролцдог. Нийлүүлэлтийн талаас бол Төв банк бол оролцох бол тийм боломж бол хязгаарлагдмал. Гэхдээ бол мэдээж Төв банк энэ дээр бол бол инфляцын эсрэг мөнгөний бодлогыг бол чангаруулахын зэрэгцээгээр илүүтэй мөчлөг сөрсөн сахилга баттай төсөв, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, нийлүүлэлтийн гинжин сүлжээ, дотоодын хүнсний тогтвортой тасралтгүй хангамжийг бий болгох зайлиггүй шаардлагатай гэж үзэж байгаа. Энэ хүрээнд бол ЗГ-тай бол хамтраад бодлогын зөвлөмжүүдийг бол өгөөд явж байгаа.

Энэ гадаадын хөрөнгө оруулалтын банк орж ирэхэд бол мэдээж ханшийн асуудал бол маш эмзэг асуудал. Энэ хүрээнд бол Төв банк гадаадын хөрөнгө оруулалттай банкиг ажиллах боломжийг бол нэмэгдүүлэх хүрээнд бол зохистой харьцааг бол илүү уян хатан

байдлаар бий болгох, төв гадаадын хөрөнгө оруулалтын банк Монголд ажиллах гадаадын банкны салбар Монголд үйл ажиллагаагаа эрхлэхэд илүү уян хатан хяналт шалгалтын системтэй зохицуулалттай, илүүтэйгээр гадаадын хөрөнгө оруулалтыг татсан, гадаад валютын эх үүсвэрийг зах зээл дээр нэвтрүүлсэн энэ чиглэлийн үйл ажиллагааг дэмжсэн, уриалсан ийм хяналт зохицуулалтуудыг бол хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд бол Төв банк өөрийн журмууддаа бол өөрчлөлт оруулсан байгаад байгаа.

Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль батлагдсаны дараагаар бол Төв банк болон СЗХ хамтраад бол 8 дүрэм, журам, стандартыг бол баталж байгаа. Яг энэ чиглэлээр бол яг дэлгэрэнгүй яг ямар, ямар заалтууд дээр ямар хөнгөлөлт орж байгаа талаар бол танд мэргэжлийн хүний хувьд бол ийм илүү дэлгэрэнгүй санхүүгийн тооцооллуудыг танд албан бичгээр хүргүүлнэ.

Энэ финтектэй холбоотой асуудал бол мэдээж энэ санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг сайжруулах. Энэ бол гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжихэд бол маш чухал үр нөлөөтэй. Манай улсын финтек санхүүгийн технологид суурилсан үйлчилгээ бол маш сайн хөгжиж байгаа. Энэ дээр бол Төв банк бол 2016 оноос хойш бол маш олон бодлогын юу шинэчлэлүүдийг хийсэн. Төлбөрийн системийн шинэчлэл төслийг амжилттай хэрэгжүүлсний үндсэн дээр бол манай финтек салбарын компаниудын тоо бол нэмэгдэж байгаа. Энэ хүрээнд бол маш олон үйл ажиллагаа бол нэвтэрч байгаа. Хамгийн сүүлийн.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Батиугар гишүүн тодруулж асууя.

**Э.Батиугар:** Баярлалаа. Нэмээд 2 юм тодруулах гэсэн юм. 1 дүгээрт бол сүүлийн 12-оос 12 сард зээлийн өсөлт бол 23 хувьтай байсан. Гэхдээ бол бүтцийг нь

харахад бол бараг 9 хувийг нь бол талыг нь бол хадгаламж барьцаалсан зээл эзэлж байгаа юм. Тэгэхээр хөрөнгө оруулалтын зээл, бизнес зээл гарахгүй байгаа үндсэн шалтгаан нь юу юм бэ? Яагаад дийлэнхдээ ер нь retail л зээл гараад байна вэ? 2-т нь бол та хэлж байна. Төв банк бол эрэлт, нийлүүлэлтийнхээ энэ эрэлтэд нь илүү нөлөөлдөг гээд. Тэгэхдээ нийлүүлэлт дээр бол supply side гэж ярьдаг юм шүү дээ бид нар. Квантитизм... болон мөнгөний M2-оо хурдацтай нэмэгдүүлснээр шууд мөнгөний бодлогын хэрэгслээ canal-аар энэ нийлүүлэлтэд нийлүүлэх бололцоотой байдаг. Яах вэ энэ бол бодлогын онолын л мэтгэлцээн л дээ. Аль талд нь бол квантитизм, monetary policy байна, нөгөө талд нь бол кинзен гээд л явдаг энэ бол ойлгомжтой л доо. Эхний асуултад нь хариулчих даа. Энэ зээлийн өсөлтийн яагаад дийлэнх нь retail биш зээл рүү ороод байна вэ гээд.

**Г.Занданшатар:** 85-ын эдийн засагч Ган-Очир, Доожавын Ган-Очир. Доожавын Ган-Очир хариулаад.

**Д.Ган-Очир:** Батиугар гишүүн асуултад хариулъя. Энэ оны хувьд бол бид нар банкны салбарын зээл бол хэрэглээний зээл дээрээ илүү төвлөрөх, хэрэглээний зээл бол 36 орчим хувиар өсөх, ЖДҮ-лэлийн зээл бол гурав аравны, 13 хувийн өсөлттэй байх ийм төсөөлөлттэй бол байгаа. Хэрэглээний зээлийн бүтцийг авч үзвэл таны хэлсэнчлэн хадгаламж барьцаалсан зээл, цалин барьцаалсан зээл, тэтгэвэр барьцаалсан зээл гэсэн энэ 3 бүтээгдэхүүн дээр бол гол өсөлтүүд бол байгаа. Өрхийн санхүүгийн бүтэц орлого талаас нь аваад үзэхээр бодит орлого, бодит хэрэглээ 2-ыг нь бол хэрэглээ нь даваад байгаа. Тэгэхээр энэ бол нэг ёсондоо инфляц өндөр өрхүүдийн амьжиргааны түвшин дээр бол инфляцын болон ажил эрхлэлтүүдийн бусад орлогын дарамтууд тодорхой түвшинд байгаа болохоор энэ орлого зарлагынхаа зөрөөг бол зээлээр санхүүжүүлэх 1 дүгээрт шаардлага гарч байсан. Энэ бололцоо нь

хаанаас бий болсон бэ гэхээр тэтгэвэр цалин маань бас тодорхой дүнгүүдээр өнгөрсөн оны өвлөөс хойш өсөж байгаа. Энэ он, тэгээд өнгөрсөн оноос хойш өсөж.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Манай эдийн засаг өсөөд байдаг, хүртээмж байхгүй, өгөөжгүй, ядуурал буурдаггүй байгаа юм л даа. Тэгээд бидэнд бол юу гэхээр өрийн дарамтгүй, тогтвортой, өгөөжтэй, хүртээмжтэй ийм эдийн засгийн өсөлт хэрэгтэй байгаа юм. Тэгээд эдийн засгийн өсөлтөд бол энэ мөнгөний бодлого асар их нөлөөтэй. Ер нь хөгжилд бол мөнгөний бодлого асар их нөлөөтэй. Манай энэ төсвийн бодлого, энэ мөнгөний бодлого хоорондоо ийм уялдаатай явахгүй л байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл төсвийн бодлогын алдаа бол мөнгөний бодлого руу очиж гараад байдаг зарим үедээ. Ийм шинж тэмдгүүд л гараад байгаа юм л даа. Тэгээд энэ тэрийгээ та бүгд юу гэж тооцож байгаа юм бэ? Тооцох л хэрэгтэй юм шиг байгаа юм.

Энэ мөнгөний бодлогод бол инфляцыг 6 хувьд тогтворжуулна гэж байгаа байхгүй юу. Хэр зэрэгт тооцсон юм бол доо? Төсвийн орлого чинь 27 их наяд болчихсон байгаа шүү дээ тийм ээ. Энэ оныхоос 5 их наядаар давчихсан. Дээрээс нь миний сонссоноор бол ипотекийг энэ жил 3Г авахгүй, 24 онд орон сууцын корпорац байгуулж байж авна гээд нэг ийм юм яваад байх шиг байгаа юм. Тэгээд ингээд ирэх юм бол энэ инфляц чинь бол юу болох вэ? Энийгээ үзээч тийм ээ. Үнийн өсөлтийн хурд шүү дээ тийм ээ. Тэгэхээр энэ хэр зэрэг бодитой тооцсон юм бэ гэсэн нэг ийм эхний асуулт байна.

Дараагийн асуудал яах вэ гэхээр зэрэг яах вэ энэ инфляц бол энэ эхний 7, 8 сарын байдлаар 10 хувьтай байх шиг байна л даа. 22 оны жилийн эцсийн статистикаар 14 хувь байсан тийм ээ.

Ханшийн уналт 20 хувь байсан. Ингээд тооцохоор бол юу гэхээр нөгөө бодит эдийн засгийн чинь нөгөө өрхийн секторт ноогдох нь 65-аас 70 хувь гээд ингээд тооцохоор нэг 4-өөс дөрөв аравны, тийм 4,4 их наяд гэдэг байх. Ийм мөнгийг иргэдийн карманаас суйлчхаж байгаа шүү дээ. 3 жилийн байдлаар гэхэд л 14 их наяд төгрөг л суйлчихсан байгаа юм. Энэ нь хадгаламжаас, харилцахаас. Тэгээд дээрээс нь зээл аваад ингээж л нөхөж байгаа юм. Тэгээд энэ чинь бол өөрөөр хэлбэл нөгөө ядуурал гэдэг юмыг л дэвэргэж байгаа юм л энэ байгаа юм л даа.

Тэгэхээр ерөөсөө инфляцтай тэмцэх энэ асуудал бол Монгол Улсын нэг номерын асуудал. Энэ дотроос бол банкнаас гадна манай энэ 3Г төсвийн бодлогоор бас их ажиллах ийм шаардлагууд бол байгаа юм л даа. Өнөөдрийн байдлаар яг ядуу гэж байгаа 28, дээрээс нь ядуурах магадлалтай 15, ингээд 42 хувь нь ядуурчихсан байгаа юм л даа. Ийм өндөр инфляцтай байхад бол ядуурал бууруулна гэж хэзээ ч байхгүй. Энэ бол баталгаатай. Тэгээд энэ инфляц, цалин нэмдэг инфляцаас дахиад тэр нь инфляц болдог. Инфляц, барааны өсөлт, үнийн өсөлт тэгээд инфляц. Ханшийн өсөлт, тэгээд инфляц. Ийм нэг чөтгөрийн тойрогт орчихсон ийм л юм л яваад байна л даа. Тэгээд энэ тэрийг л та бүгд яаж харж байгаа юм бэ?

Дараагийн асуулт бол энэ нөгөө Банкны хуульд өөрчлөлтүүдээ оруулсан юм шүү дээ. 20 хувь, нөгөө 5-аас 10 хувийг нь худалдсан. Одоо 470-аад тэрбум долларын нэмэлт эх үүсвэр бий болчихсон байгаа шүү дээ. Энэ онд он дуустал та нар нөгөө хуулиар хүлээсэн үүргээ яаж биелүүлэх гэж байгаа юм бэ? Бодлогын хүү 13 хувь, одоо өнөөдөр банкны бодит хүү 16,4 хувь. Энэ маань инфляцад эерэг нөлөөлж байгаа боловч хөгжилд сөрөг нөлөөлөөд байгаа юм. Аль алийг нь бодолцсон тэр гибрид бодлого гэж юм байгаад байгаа шүү дээ тийм ээ



хэрэгжүүлдэг. Ийм юмыг та нар боддог уу? Энийг юу гэж харж байгаа вэ?

Төлбөрийн тэнцэл бол яах вэ энэ он гараад гайгүй явж байна. Жилийн эцсийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл юу гэж харж байгаа вэ? Ийм.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ганболдын Энхтайван хариулъя.

**Г.Энхтайван:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Сүүлээс нь хариулаад явчихъя. Төлбөрийн тэнцэл оны эхний 8 сарын байдлаар 551 сая долларын алдагдалтай гарсан, ашигтай гарсан. Яг энэ хувиа оны сүүлийн улиралд хадгалаад, 2023 оны төлбөрийн тэнцэл ойролцоогоор 550-аас 580 орчим сая долларын ашигтай гарах болов уу гэсэн төсөөлөлтэй байна.

Та түрүүн эдийн засгийн өсөлт 6,4 хувьтай ч гэсэн хүртээмж байхгүй байна. Иргэдийн карманаас нь инфляцаар дамжуулаад ихээхэн хэмжээний мөнгө бол алга болж байна гэж байна. Ер нь бол инфляц ямар эдийн засагт хор хөнөөлтэй юм бэ, инфляцыг нам дор түвшинд бууруулахгүйгээр эдийн өсөлт байхгүй. Эдийн засагт хамгийн нэн тэргүүнд шийдэх шаардлагатай асуудал л инфляц юм гэдэг дээр бол ойлгож байгаад бол маш их юу гэдэг юм талархалтай хандаж байна. Тэгээд инфляцыг бол урт хугацаанд ингэж өндөр буюу 2 оронтой тоонд барьж байгаа нь таны түрүүний хэлсэнчлэн инфляцын 2 дахь үеийн нөлөө буюу инфляцаас үүдэлтэй үнийн өсөлт эргээд инфляцаа өдөөдөг. Инфляцаас үүдэлтэй ханшийн сулрал нь дахиад өөрөө инфляцаа өдөөдөг гээд гэх мэтчилэн энэ бол эдийн засагт бол маш хүнд үр дагаврыг бол арилгаж арилгахад хүнд domino effect гэж ярьдаг үр дагаврыг бол үзүүлдэг. Тэгэхээр бол инфляцыг нам дор түвшинд бол бууруулах нь бол зайлшгүй нэг номерын бодлогын асуудал байгаад байгаа юм.

Барууны чиглэлийн эдийн засагчдын онолоор бол инфляц бол өөрөө

татвартай яг ижил түвшинд ойлгогддог. Инфляц бол татвар гэж үздэг. Тэгэхээр инфляцыг бол бага түвшинд бол бууруулах нь бол бодлогын сонголтын нэг номерын асуудал байгаа. Энэ дээр тийм учраас бол Төв банк бол 2023 онд бол бодлогын төлөвөө бол хатуу төлөвт барьсан. Инфляц буурахгүй бол 24 онд ч гэсэн бодлогын түвшин төлөв бол хатуу төлөвтэй байна. Тэгээд яах вэ түрүүн таны асуусан асуултад дэлгэрэнгүйгээр манай эдийн засагч тэр ерөнхий эдийн засагч энэ шилжих суваг энэ тэрийн талаар бол дэлгэрэнгүй тайлбар өгөх байх.

Тэр банкны 20 хувьтай холбоотой асуудал дээр бол одоо 12 сарын 31-нээр тасалбар болоод арилжааны банкны хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг бол 20 хувьд барих хуулийн зохицуулалт бол хэрэгжээд явна. Өнгөрсөн хагас жилээр бол арилжааны банкнууд бол энэ системийн нөлөө бүхий 5 банк бол IPO-оо хийж дууссан. Энэ хүрээнд бол 478 орчим тэрбум төгрөг бол зах зээл дээрээс бол татан төвлөрүүлсэн байгаад байгаа. Мэдээж 20 хувийн хязгаарлалтыг дагаж мөрдөхөд бол одоо яг бодит эдийн засгийн байдал бол хүндрэлтэй. Яагаад гэхээр дөнгөж 5-аас 10 хувиа банкнууд хувьцаа гаргахад 478 тэрбум төгрөг цугларч байна гэдэг чинь одоо үлдсэн 60-аас 80 хувийгаа бол гаргана гэдэг чинь бол хэдий хэмжээний мөнгө гарах вэ гэдэг чинь 4 их наядоос 5 их наяд төгрөг бол хамгийн наад зах нь бол шаардлагатай болно. Тэгэхээр бол энэ бол өөрөө маш эдийн засгийн хувьд бол боломж хязгаарлагдмал нөхцөл байдал. Тэгэхээр бол Төв банк энэ дээр бол бодлогын арга хэмжээг бол холбогдох байгууллагуудтай хамтраад бол аваад явна. Төв банкны зүгээс бол энэ чиглэл дээр бол арилжааны банкнуудтай бол ойрын хугацаанд бол нэг нэгдсэн бодлогын шийдэлд бол хүрнэ гэж үзэж байгаа.

Инфляцыг бол мэдээж бид бүхэн бол дунд хугацаанд нь тогтворжуулна гэсэн бодлогын зорилттой байдаг. 2024

онд бол мэдээж энэ төсөв хэрхэн батлагдах нь вэ гэдгийг бол төв банкнаас харж байгаа. Үүнтэй уялдуулаад бол бодлогын төлөв ямар байх талаар бол ишийдвэр гарах байх. Мэдээж инфляц бол 6 дээр +, -2 хувь гэдэг маань бол дунд хугацааны хөтөлбөр. Мөнгөний бодлогын үр дүн бол тодорхой хугацааны дараа гардаг. Дэлхийн бүхий л Төв банкнууд инфляцыг онилох бодлогоо зорилт болгон энийг бол 3-аас 5 жилийн хугацаанд энэ түвшинд хэрэгжиж, тогтворжуулна. Энэхүү инфляцын түвшин нь эдийн засгийг дунд, урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох юм гэдэг бодлогын хүрээнд бол инфляцын онилох түвшинээ бол.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ган-Очир,  
Доожавын Ган-Очир 85.

**Д.Ган-Очир:** Баттөмөр гишүүний асуултад тодруулъя. Инфляцын дотоод талдаа дээр дурдсан гурил, махны үнийн өсөлт өндөр байгаа, цаашид эрсдэлээс гадна бол яг макро эдийн засгийн зүгээс бол төсвийн өндөр тэлэлт бол инфляцын хамгийн том эрсдэлт хүчин зүйл болж байгаа. Бид бүхний тооцоогоор бол 23 их наяд буюу энэ оны 5 сард төсвийн хүрээний мэдэгдэл баталснаар бол төсвийн зардлыг авч инфляцыг тооцоход энэ, ирэх оны инфляцын төсөөлөл бол 7,9 хувь байх бололцоотой байгаад байгаа ийм тооцооллыг гаргасан.Тэгэхээр 23 их наядаас дээш гарч байгаа төсвийн зарцуулалт бол 1 их наяд тутамд бол 1 нэгж хувиар инфляцыг нэмэгдүүлэх дарамт хамт ирж байна гэдэг ийм тооцоолол байгаа. Энэ утгаараа бол энэ төсвийн зардлын хэт тэлэлт бол мэдээж инфляцад нөлөөтэй гэдэг ийм макро эдийн засгийн төсөөлөл бол гарч ирж байгаа.

Таны хэлдгээр зээлийн хүү өндөр байгаа нь бол яалт ч үгүй төгрөгийн бодлогын хүү өндөр байгаа. Энэ бол инфляцтай тэмцэх, төгрөгийн өгөөжийг хадгалах, долларжих үзэгдлээс сэргийлэх гэдэг энэ том агуулгаараа бол бодлогын

хүүгийн үр дагавар бол хадгаламж, зээлийн хүүд бол тусгалаа олж байгаа. Гэхдээ ЗГ-аас энэ орон нутаг дахь ипотекийн зээлийн хүү байна, хүнсний хувьсгал байна. Энэ зэрэг тэргүүлэх ач холбогдолтой эдийн засгийг төрөлжүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хамгаалах, таны хэлдгээр энэ хөгжилд хөтлөх гэсэн гол салбарууд дээр бол хүүгийн татааснуудыг тусгаад оруулаад явах юм бол зээлийн хүү нь бол бага байдлаар эдийн засгийн салбаруудыг дэмжсэн бүтцийн бодлого хэлбэрээр хэрэгжих бололцоо нь бол байгаа. Энэ хэлбэрээр практик дээр хэрэгжиж байгаа. Тэгэхээр төсөв болон бүтцийн бодлогын асуудал дээр бол энэ хэлбэрийн асуудлуудыг тусгах замаар хүүгийн татаасыг тусгах замаар явбал банкны салбар дээр бол өнөөдөр 7 орчим их наяд төгрөгийн Төв банкны үнэт цаас бол байна. Үүний бол 4,5 орчим их наяд төгрөгийн зээлжих бололцоотой эх үүсвэр бол байгаа.

Тэгэхээр ийм хэмжээний эх үүсвэр дээр бол хэрвээ хүүгийн татаас нь орж ирээд, эрсдэл хуваах зарчим буюу Зээлийн батлан даалтын сан нь өөрөө ажиллах юм бол энэ бол зээлдэх эх үүсвэр бол төсвийн бодлогын хүрээнд бол гарах бололцоотой байгаа гэж Төв банкны зүгээс харж байгаа юм.

**Г.Занданшатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн. Сандаг-Очир гишүүн алга байна, хаслаа. Жигжидийн Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Баярлалаа. Тэгэхээр мөнгөний бодлого орж ирж байна. Мэдээж хэлэлцүүлгийн түвшинд нэлээн сайжрах байх гэж би ингэж ойлгож байна. Ер нь мөнгөний бодлого төсвийн бодлого хоёрынхоо уялдааг бид хангахгүйгээр энэ яриад байгаа юмнуудыг ишийдэхэд төвөгтэй. 2 талаасаа нэлээн бодлогоо нэгтгэж, үндсэн параметруудээ зөв барьж явах тухай л асуудал байх ёстой гэж ингэж хараад байгаа. Бид аль болохоор инфляцыг бага,

зээлийн хүүг бага байлгах тухай л асуудал руу гол анхаарал бол төвлөрч явах ёстой л доо.

Тэгээд би ирэх онд энэ инфляцад нөлөөлөх хүчин зүйлүүдийг аваад үзэхээр зэрэг гадаад хүчин зүйлүүдийн одоо та хэдийн дурдаад байгаа юмнууд дотор энэ урд хөршийн чинь байдал бидэнд ер нь ямархуу нөлөө үзүүлдэг бол? 2010-аад онд шиг санаад байх юм. Би одоо энэ чинь Америк энэ дэлхийн эдийн засгийг хямруулахад ер нь ипотек үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой санхүүгийн эх үүсвэрийнх нь эргэлт л их том нөлөө үзүүлсэн шүү дээ. Тэгээд энэ урд айлын чинь одоогийн нөхцөл байдал ер нь яг нэг тийм байдалд байгаад байгаа юм байна лээ шүү дээ. Тэгэхээр тэр ер нь бидэнд ямархуу нөлөө үзүүлж, тэрнээс ер нь ямархуу байдлаар хамгаална гэж тооцоо юмнуудаа анзаарсан бол гэж нэг ийм зүйл.

2 дахь зүйл бид зээлийн хүүг бууруулах тухай их яриад, тэгээд үнэхээрийн хүндрэл хямралууд таараад, тэгээд аргаа барахдаа ёстой мөнгөний бодлого төсвийн бодлого хоёроо уялдуулах зарчмаар баялаг бүтээгчдээ дэмжье, тодорхой хүүгийн зөрөө олгоё гээд бид мөнгө тавиад яваад байгаа л даа. Тэгээд эргээд аваад үзэхээр зэрэг өнөөх рүү чиглүүлсэн гаргах ёстой мөнгөний ашиглалт зорилтот түвшиндээ хүрэхгүй байна л гэж хараад байгаа би бол. Би бараг тэр 229 тэрбум төгрөгийн чинь цаана 1 их наяд орчим төгрөгийн зээл яг зорилтот бодит салбар луу чиглэгдэж гарахаар байсан юм. Гэтэл олгогдсон байдлыг нь харахаар зэрэг тэгэхгүй байгаад байгаа юм шиг л харагдаад байгаа юм. Тэгэхээр энэний учир шалтгаан юу байгаад байгаа юм бэ? Эрсдэлийнх нь бараг  $\frac{3}{4}$ -ыг бараг төр хариуцаад, ингээд бодлогын чиглэл явуулаад байхад энд яагаад банкны салбар төдийлөн идэвхтэй оролцож чадахгүй байна вэ? Энэний учир шалтгаан юунд байгаад байгаа юм бэ?

Дараагийн нэг зүйл. Ерөөсөө эх үүсвэрийн өртөг түүн дээр нэмэх нь үйл ажиллагаа л байх юм шиг байгаа юм. Би бол бодоод байдаг юм. Үйл ажиллагааны зардал, тэгээд ашигт ажиллагааны түвшин, тэгээд л зээлийн хүүгийн л өртөг л гарах ёстой шүү дээ уг нь бол. Тэгээд одоо ер нь дэлхийн энэ банкны зээлийн хүү дотор чинь үйл ажиллагааных нь зардал ямар хувийг нь эзлээд байгаа юм бэ? Манайх хэдэн хувьтай яваад байгаа юм бэ? Энэ арилжааны банкнуудынхаа үйл ажиллагааны зардал гэдэг юм уу энэ талыг ер нь хязгаарлах барих тал дээр бид ер нь юу бодох ёстой юм бэ? Нэг л их олон данхайсан том, том байшингуудтай, баахан бүтэц орон тоотой. Энийг нь дагасан зардлыг яахаараа баялаг бүтээгчид хүүгийн юугаар төлөөд яваад байх ёстой юм бэ? Ерөөсөө бид нарын хүү бууруулж чадахгүй яваад байгаа үйл явц чинь нэг талдаа бараг мөнгө хүүлэхтэй холбоотой шахуу юм болж харагдаад байгаа юм биш юм уу? Энүүнийг юу гэж ойлгох юм бэ? Энийг ер нь ямар бодлогоор зохицуулах юм бэ?

Дараагийн нэг зүйл. Банкны системийн нийт эх үүсвэрийн хэдэн хувь нь гадаад эх үүсвэр байгаад байгаа юм бэ? Би бол гадаад эх үүсвэрүүдийг өртөг нэлээн хямдтай эх үүсвэр байгаа гэж ойлгоод байдаг. Нэлээдгүй хэсэг нь тийм эх үүсвэр байгаад байх шиг байгаа юм. Тэгээд яагаад бид нарын энэ зээлийн хүүгийн чинь.../минут дуусав/

**Г.Занданшатар:** 83 Энхтайван дэд ерөнхийлөгч.

**Г.Энхтайван:** Батжаргал гишүүний асуултад хариулъя. Хүнсний хувьсгал ХАА-г дэмжих зээлийн хүртээмжийн хувьд бол 980 тэрбум төгрөгөөс бол ойролцоогоор одоогоор 470 тэрбум төгрөг нь бол олгогдоод явж байна. Зээлийн олголтын хувьд бол энэ бол нийтдээ 5-аас 6 хувийн хүүтэй, ХАА-г дэмжих зээл бол байгаад байгаа. Үүнээс зээлийн ХАА-н сектор маань өөрөө бас яг

зээлийг энэ шингээх, аж ахуйн ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулж байгаа энэ ААН-үүд маань өөрөө энэ бас тухайн зээлийг авч ашиглах техникийн болон санхүүгийн хүчин чадлын хувьд бол бас эргэж харах зүйлс бол байгаа энэ дээр. Арилжааны банк маань өөрөө энэ дээр бас өөрийн бодлого шалгуураа бол тавиад явж байгаа. Мэдээж эрсдэлээ үүрч байгаа банкны хувьд бол мэдээж энэ дээр өөрсдийн шалгуураа тавих нь бол зайлиггүй юм. Ерөнхийдөө бол тэгэхдээ ХАА-г дэмжих хүнсний хувьсгалын хөтөлбөр бол амжилттай хэрэгжээд явж байгаа гэж бол үзэж байгаа. Олгогдож байгаа зээлийн хэмжээ бол энэ жилийн хувьд бол 470 тэрбум төгрөг гэдэг маань бас харьцангуй өндөр тоо.

Эх үүсвэрийн гадаад зах зээлээс гаралтай эх үүсвэрийн хувь хэмжээг асууж байх шиг байна. Энэ арилжааны банкнууд дээр байгаа эх үүсвэрийн долларжилтийн хэмжээ бол 26 хувьтай байгаад байгаа юм. 26 хувь гэдэг маань бол яг оргил үедээ бол 33 хувь хүрч байсан. Тэгэхээр 26 хувийн долларжилт гэдэг маань бас манай арилжааны банкнууд дээр байгаа гадаад валютын эх үүсвэр маань бас юу гэдэг юм бас учиргүй тийм өндөр тоо бол бас харьцангуй бол тоо бол биш. Тэгэхдээ бол мэдээж энэ бол манай систем өөрөө эх үүсвэрийн хувьд бол бас нэлээн дутагдалтай байгаа учраас гадаад валютын хувь хэмжээ бол бас нэлээн бага байгаа.

Төсөв мөнгөний бодлогын хувьд бол уялдаа холбоог хангах чиглэлээр бол бид бүхэн бол Сангийн яам болон Эдийн засгийн хөгжлийн яамтай бол тухай бүрдээ бол ажиллаад явдаг. Төрөөс баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн хувьд бол Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдаанаар бол хэлэлцүүлсэн. Мөн Сангийн яамны зүгээс бол 2024 оны улсын төсвийн тухай хуулийг бол Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар бол хэлэлцүүлсэн байгаад байгаа. Бид бүгд ч гэсэн энэ дээр бол төсөв мөнгөний

бодлогын уялдаа холбоог хангах чиглэлээр бол ЗГ-тай бол байнга хамтраад ажиллаад явдаг. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл бол улиралдаа нэг удаа хуралддаг. Монголбанкны Ерөнхийлөгч болон Сангийн сайд, СЗХ-ны дарга бол энэ хуралд бол тогтмол оролцож бодлого, үйл ажиллагаагаа бол нийлүүлээд явдаг.

Төсөв мөнгөний бодлогын нийцтэй хамгийн тод жишээ бол түрүүн яриад байгаа энэ ипотекийн зээлийн хөтөлбөрийг орон нутагт чиглүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих, бүсчилсэн хөгжлийг дэмжих, төвлөрлийг бууруулах хүрээнд бол энэ ипотекийн зээлийн хөтөлбөр дээр бол 16 орчим тэрбум төгрөг буюу 4300 өрхийн хүүгийн татаасыг бол суулгасан байгаа гэдэг дээр бол харагдаж байгаа. Бид бүхэн бол бодлого үйл ажиллагаагаа бол нийлүүлээд явж байгаа. Тэгээд дэлгэрэнгүйгээр манай ерөнхий эдийн засагч нэмээд тодруулаад хэлчих байгаа. Үйл ажиллагааны банкны салбарын үйл ажиллагааны зардал олон улсын жишиг энэ тэр дээр бол манай ерөнхий эдийн засагч хэлчих байх.

**Г.Занданшатар:** Ерөнхий эдийн засагч Доожавын Ган-Очир 85.

**Д.Ган-Очир:** Банкнуудын зээлийн хүүгийн бүтэц дээр бол 2020 оны 8 сард баталсан Стратегийн зээлийн хүүг бууруулах стратеги дээр бол бид бүхэн тодорхой ярьж байсан. Зээлийн хүүгийн бол 60-аас 65 хувийг нь бол эх үүсвэрийнх нь зардал нь, 10-аас 15хувь нь бол үйл ажиллагааны зардал нь, бас нэг 10-аас 15 хувийг нь бол зээлийн чанаргүй зээл тэрний эргэн төлөгдөхгүйтэй холбоотой гардаг зардал, үлдсэн 5-аас 10 хувь нь бол банкнуудын ашигт ажиллагаа байна гэдэг.

Тэгэхээр энэ 10-аас 15 хувийн үйл ажиллагааны зардал дотор нь бол яаж бууруулах бололцоо байгаа вэ гэдгийг бид нар бас стратеги дээрээ тодорхой тусгасан. Үүн дотроо бол хамгийн гол үйл ажиллагаа бол боловсон хүчний болон



үндсэн үйл ажиллагаанаас гадна ийм давхардсан олон АТМ машинууд, посын машинууд зэрэг ийм үйл ажиллагааг нь илүү үр ашигтай болгох, технологийн дэвшлийг шилжүүлэх замаар бол бууруулж болох үйл ажиллагаануудыг бол тусгаад Банкнуудын холбоотой бол ажилласан. Ингэснээр бол энэ АТМ посуудыг бол давхар уншидаг, аль болох давхардлыг нь бууруулах үйл ажиллагаа бол энэ оноос бол нэлээд идэвхжээд, нэгдсэн дундын компани байгуулаад тэр хүрээндээ бол үр ашгийг нь сайжруулж байгаа.

2 дахь хийгдэж байгаа ажлууд бол банкнууд үйл ажиллагааны салбарууд маш олонтой байсан. Салбаруудаа бол банкнууд багасгаад илүү технологижсон интернэт банк, Мобайл банк руугаа бол орж байгаа. Тэгэхдээ яг банкны салбар дээр гарч байгаа зардлын хувьд бол технологи бол өөрөө эхнийхээ үе шатууд дээр бол маш өндөр зардалтай байгаа. Технологийн шилжилт маань. Харин дунд болон урт хугацаандаа тэрнийх нь зардлынхаа нөхдөг ийм үйл ажиллагааны үр ашиг нь хожуу гардаг ийм нөхцөл байдал байгаа болохоор богино хугацаандаа бол илүү энэ финтек технологийн шилжилт маань зардал өндөртэй байгаа. Ийм гарчихвал. Тэгэхээр энэ дээр бол бид бүхэн Банкнуудын холбоотойгоо хамтраад бол илүү үр ашгийг нь сайжруулах чиглэлд зээлийн хүү бууруулах стратегид тусгасны дагуу бол бид бүхэн ажиллаж байна.

Урд хөршийн нөхцөл байдал бол яг л таны эхний давлагаа дээр бол яг л таны хэлсэнчлэн үл хөдлөх хөрөнгийн салбар унасан. Тэрнийг дагаад үнэ нь унасан. Зээлүүдээ өрөө хугацаандаа төлж чадахгүй байгаа. Тэгээд банкны салбар нь бол бас алдагдал хүлээж эхэлж байгаа үл хөдлөх хөрөнгийн салбарт өгсөн зээлээсээ. 2 дахь давлагаа бол яг таны болгоомжилж байгаа асуудлыг дэлхий нийтээр бол бичиж байна. Энэ бол банк санхүүгийн салбар нь өөрөө чанаргүй зээл

нь өндөр болоод эхлэх үед дахиад бусад салбарууддаа зээл олгох, санхүүгийн зуучлалаа гүйцэтгэж чадахгүйтэй холбоотой 2 дахь давлагаа орж ирэх юм бол Хятадын эдийн засгийн нөхцөл байдал одоо төсөөлж байгаагаас дорд болж болзошгүй гэдгийг Дэлхийн банк, ОУВС-ийн сүүлийн үеийн судалгаанууд харуулж байгаа.

Монголын эдийн засагт орж ирэх нөлөө бол санхүүгийн хувьд интеграци бол Монгол Хятадаас бол хамаарал маш багатай. Харин гадаад худалдааны хувьд бол маш өндөр. Тэгэхээр нөлөөлөл нь бол түүхий эдийн эрэлтүүд магадгүй өндөр биш байх, үнэ нь өөрөөр хэлбэл өмнөхөөсөө бага байх гээд энэ дотроо бол зэс болон зэсийн үнэ нь бол харьцангуй өндөр байна. Яагаад гэвэл ногоон шилжилт болон мөн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйл ажиллагаа бол зэс дээр бол эерэг нөлөөтэй. Харин нүүрс дээр бол сөрөг үр дагавартай орж ирэх болохоор нүүрсний үнэ, эрэлт бол илүү унах, тэр маань өөрөөр хэлбэл экспортын орлого, төлбөрийн тэнцэлд энэ сувгаар орж ирэх нөлөөлөл нь илүү сөрөг байх юм байна гэдгээр бол бид бүхэн харж байгаа.

Дэлхий нийтийн анхааруулж байгаа бол валютын нөөцийнхөө хүрэлцээг бол аль болох өндөр байлга. Банкныхаа салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээг өндөр байлга. Банкны салбар дахь эх үүсвэрийн хөрвөх чадварыг нь өндөр хадгал. Ийм бодлого банк, санхүү болон макро эдийн засгийнхаа төсөв мөнгөний бодлогыгоо бол энд нийцтэйгээр бол аль болох хатуу чиглэлтэй барьж явахыг бол хөгжиж байгаа Монгол шиг ийм жижиг нээлттэй эдийн засгуудад бол зөвлөж байгаа. Тэгээд энэ агуулгаар бол Монголбанкны ирэх жилийн бодлого маань өөрөө инфляцад чиглэсэн, аль болох хатуу банкны салбарыг нь илүү энэ 2.2 дээр заасанчлан банкнуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ, хөрвөх чадварын хүрэлцээг илүү өндөр байлгах, банкнуудыг энэ эрсдэлүүдийгээ өөрөө тооцож чаддаг болгох гээд энэ чиглэлээр бол бодлогууд

маань өөрөө бол томъёологдож орж ирсэн байгаа. Баярлалаа.

**Г.Занданиатар:** Тодруулъя. Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** 8 сарын байдлаар гадаад худалдааны тэнцэл 4 орчим тэрбум долларын нэмэх баланстай, тэнцэл 500 гаруй саяын эерэг, 3,5 тэрбумын зөрөө байгаад байгаа юм. Үйлчилгээ хөдлөлөөр л юм уу гэж харагдаад л байна л даа одоо би тэгж л ойлгож байна. Тэгэхээр энүүнийг ер нь хэдүүлээ цаашид аль болохоор ойролцоо болгох тал дээр мөнгөний бодлого талдаа бид ер нь юу барих ёстой юм бол, яах ёстой юм бол нэг ийм зүйл байна гэж.

Дараагийн нэг зүйл ерөөсөө төгрөгийн өөрийнх нь баталгаа гэж яривал үндэсний өөрийнх нь баялаг үйлдвэрлэлийн тухай л ойлголт шүү дээ. Тэгэхээр зэрэг дан ганц долларын нөөцөөр ч биш л дээ энэ өөрөө уг нь бол. Тэгэхээр зэрэг яаж хэдүүлээ тэр төгрөгийнхөө баталгаа болсон баялаг үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх, дэмжих вэ гэдэг асуудал руу л гол анхаарал төвлөрөх ёстой. Тэрнийг яаж их.../минут дуусав/

**Г.Занданиатар:** Ганболдын Энхтайван 83.

**Г.Энхтайван:** Батжаргал гишүүний асуултад тодруулъя. Мааш эмзэг сэдвийг гишүүн хөндлөө. Энэ гадаад худалдааны тэнцэл өөрөө 3,5 тэрбум долларын ашигтай гараад, төлбөрийн тэнцэл нь 550 гээд. Энэний зөрөө юун дээр байгаад байна вэ гэдэг. Энэ зөрөө бол үйлчилгээний дансны алдагдал буюу урсгал данс дээр гарч ирээд байгаа. Сүүлийн 20 жилийн хугацаанд урсгал дансны алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний 12, 19 хувь бараг 20 хувьд бол дөхөж байгаа юм дунджаар. Тэгэхээр жил болгон энэ урсгал тэнцлийн алдагдал дээр их хэмжээний валютыг бол бид бүхэн бол гадагшаа гаргаад байгаа юм. Тэгэхээр урсгал тэнцлийн алдагдал дээр өөр юу энэ

юу нөлөөлж байгаа вэ гэхээр боловсролын зардал, эмчилгээний зардал мөн зөвлөх үйлчилгээний зардал гэх мэтчилэн тээврийн зардал гэх мэтчилэн манай улсын өөрийнх нь суурь дэд бүтцийн хөгжил болон нийгмийн хөгжилтэй холбоотой асуудлууд бол хөндөгдөөд байгаа юм. Тэгэхээр бид бүхэн бол энэ экспортын орлогоор дамжиж орж ирж байгаа энэ валютын орлого болон бий болж байгаа энэ баялгийг илүүтэйгээр бол нийгмийн чиглэл.../минут дуусав/

**Г.Занданиатар:** Жамбын Батсуурь гишүүн алга байна. Цэндийн Сандаг-Очир гишүүн. Батсуурь гишүүнийг гаргалаа. Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Монголбанкнаас ирэх жилийн мөнгөний талаар баримтлах бодлогыг ярьж байна. Яах вэ эдийн засаг өссөн, валютын нөөц нэмэгдсэн, мөн гадаад худалдаа ашигтай гарсан гээд эдийн засгийн үндсэн үзүүлэлт сайжирсан зүйлүүд байна. Ноднин өдийд бас энэ зааланд шүүмжлүүлээд сууж байхыг бодоход бас харьцангуй бас авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээний хүрээнд нааштай эерэг үзүүлэлтүүд гарсан байна.

Гэхдээ манай улсын эдийн засаг эмзэг хэвээрээ байсаар л байна. Ганц уул уурхайгаас хамааралтай. Тэгэхээр та бүхний энэ танилцуулга дээр бас ганцхан үг өгүүлбэр байгаа нь ерөөсөө энэ цаг агаарын таагүй нөхцөл байдлын улмаас ХАА-н салбарын үйлдвэрлэл 10 хувиар агшсан л гэсэн үг, өгүүлбэр байна. Тэгээд зөвхөн цаг агаараас үүдэлтэй. Ер нь Монголбанкны зүгээс энэ ХАА-н салбараа бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг, боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэмжих тал дээр ер нь ямар бодлого барьж ажиллаж байна вэ? Ирэх жилийн бодлогод чинь ер нь ямар зээл зээлийн хүүгээр дэмжих бодлогууд явж байна вэ?

Монгол Улсын Ерөнхийлөгч хүнсний хувьсгал энэ санаачилгыг гаргаад

27, 28 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг байх энэ санал санаачилгыг гаргаад явж байгаа. Импортыг орлох бараа бүтээгдэхүүнүүдийг дотооддоо үйлдвэрлэх, дотоодын үйлдвэрлэгч ААН-үүдийг дэмжих, ЖДҮ-лэгчдийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, дотооддоо хийж чаддаг байсан зүйлүүдээ хийж чадахаа байсан эргээд энд чаддаг байсан зүйлүүдээ хийдэг байх гэдэг энэ хүнсний хувьсгалын зорилго энд оршиж байгаа. Тэгвэл Монголбанкны зүгээс ер нь энэ хүнсний хувьсгал хөтөлбөртэй холбогдуулж ирэх жил мөнгөний бодлого, зээлийн бодлого чинь яаж тусаж байна вэ? Эх үүсвэр яаж, хаана байна вэ? Энэ ХАА-н гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх тал дээр ер нь яаж дэмжих гэж байна вэ? Өнөөдөр ингээд энэ арьс шир, ноос ноолуур, энэ ХАА малын гаралтай түүхий эд ингээд хаягдаад байсаар байх уу? Энэ Дарханд 10 сая малын арьс шир бүтээгдэхүүн боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн аж үйлдвэрийн парк байгуулна гээд хэдэн 10 жил болж байна.

Гэтэл хувийн хэвшилүүд өөрсдийн хүч хөрөнгөөрөө тэр Өвөрхангай аймаг дээр жилд саяд малын арьс шир боловсруулах үйлдвэр барьчихсан байж байна шүү дээ. Яагаад ингээд ийм үйлдвэрлэлийг бий болгох тал дээр, эргээд ашиг өгөх тал дээр. Одоо энэ ДНБ чинь өслөө л гэж байна. Төсвийн орлого, зарлага нэмэгдлээ л гэж байна. Нэмэгдлийн чинь гол 77 хувь нь энэ төсөв цалин мөнгөний нэмэгдэл чинь 77 хувийг нь эзэлж байна шүү дээ. Үндсэндээ л бүх л зардал нь. Энэ дотор энэ төсвийн нэмэгдэл, энэ тэлэлт дотор чинь ерөөсөө эргээд ашгаа өгөх үйлдвэрлэл, хагас боловсруулсан боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа үндсэндээ бараг харагдахгүй байна шүү дээ. Дандаа зардал дагасан л төсвүүд нэмэгдсэн хэвээр байж байна. Ашиг өгдөг зүйл дандаа алга. Энэ тал дээр Монголбанк ирэх жилийн 24 оны мөнгөний бодлогодоо ямар зүйлүүдийг төлөвлөж байна вэ 1-д.

2-т та бүхэн орон нутагт ирэх жил ипотекийн зээлийг чиглүүлэхэд анхаарна нэмэгдүүлнэ гэж байна. Орон нутаг чинь 21 аймаг, энэ алслагдсан алсын 3 дүүрэг энэ орон нутагт чинь орж байгаа юу? Энэ Улаанбаатар хотын төвлөрөл бууруулах, сааруулахад энэ алсын 3 дүүргийн оролцоо хувь нэмэр их байх юм. Дэд бүтцийн хүрэлцээ хангамж.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ганболдын Энхтайван 83.

**Г.Энхтайван:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. ХАА-н салбар оны эхний хагас жилийн байдлаар бол 1,7 хувийн ажилттай гарсан. Энэ нь 2000 оноос хойш үзэх юм бол 3 дахь удаагийн ХАА-н салбарын ажилт болж байгаа юм. Зөвхөн 2002, 2009 онд л эдийн засагт ДНБ-нд үзүүлж байгаа өсөлтийнхөө хэмжээгээр бол хасахтай байсан. Энэ бол бас томоохон хэмжээний цохилт авсан гэсэн үг. МАА-н салбар бол зөвхөн малын хорогдлын хэмжээ бол 11,2 сая толгой хүрсэн. Үүнээс 4 сая гаруй нь бол зүй бус хорогдол байсан. Энэ нь бол мэдээж ХАА-н салбар тэр дундаа МАА-н салбарт бол томоохон хэмжээний цохилт өгсөн.

Мэдээж Төв банкны зүгээс бол уул уурхайн бус экспортыг дэмжих, уул уурхайн бус салбарыг дэмжих хүрээнд бол бодлогын арга хэмжээнүүдийг бол хэрэгжүүлээд явж байгаа. Үүний нэг жишээ бол Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачилсан ХАА-н салбарыг дэмжих хүнсний хувьсгалын хөтөлбөр байгаад байгаа. Оны зөвхөн эхний 8 сарын байдлаар 470 тэрбум төгрөг, бараг 500 гаруй, 500 тэрбум төгрөгийн зээл гарчхаад байгаа гэдэг маань бол бас урьд, урьд нь бол ерөөсөө гарч байгаагүй маш өндөр зээлийн үр дүн. Оны сүүлийн 8 сараас хойш дараагийн 5 сарын хугацаанд бол ингээд гараад явахад бол энэ зээлийн хэмжээ бол ойролцоогоор бараг 700 тэрбум төгрөгт бол хүрэх гэж байна.

Тэгэхээр бол ХАА-н салбарыг бол илүүтэйгээр энэ мөнгөний бодлогын зүгээс бол дэмжих арга хэрэгслийн хувьд бол энэ хүнсний хувьсгал дээр бол Төв банк гол нь төвлөрч ажиллана. Мөн мэдээж таны хөндсөн энэ боловсруулах салбар ХАА-н гаралтай бараа бүтээгдэхүүний бол нэмүү өртөг шингээсэн чиглэлд нь боловсруулж, энэ эцсийн бүтээгдэхүүн гаргах чиглэлд нь бол Төв банк энэ дээр бол бизнесийн холбоод, ХАҮТ болон ЗГ, ХХААХҮЯ-тай бол бодлогын арга хэрэгслүүдээ бол нийлүүлээд явж байгаа. Энэ хүрээнд бол Төв банк бол эдийн засгийг солонгоруулах эдийн засгийг бол илүү уул уурхайгаас хараат бус байх чиглэлд нь бол дараа дараагийн жилүүдийн мөнгөний бодлого бол энэ дээр бол уялдаад явна.

Ипотекийн зээл дээр бол алслагдсан 3 дүүргийн энэ асуудал бол энэ орон нутагтай бол ижил түвшинд авч үзэж байгаа. Мэдээж Төв банкны зүгээс бол ипотекийн зээлийн хөтөлбөрийг бол илүү төвлөрлийг сааруулах чиглэлд нь бол барина гэдгээ бол хэлсэн. Тэгэхээр бол дараа дараагийн жилүүдэд олгогдох зээлийн бол хэм хэмжээ Улаанбаатар хотод 50 хувь, орон нутагт 50 хувь болоод явна гэдэгт бол алслагдсан 3 дүүргийн ипотекийн зээлийн хөтөлбөр бол хамрагдаад явж байгаа. Ер нь бол Төв банк цаашидаа бол ипотекийн зээлийн хөтөлбөрийг бол илүү боловсронгуй болгож, иргэдэд илүү хүртээмжтэй орон нутагт амьдарч байгаа, Улаанбаатар хотоос бас тодорхой радиуст заагтай амьдарч байгаа иргэдийн ипотекийн зээлийн хөтөлбөрийг ипотекийн зээлийг илүү хүртээмжтэй байдлаар шийдэхэд бол бодлого үйл ажиллагаагаа бол чиглүүлээд явна. Энэ бол яг үндсэн бүсчилсэн хөгжил, орон нутгийн болоод хөдөөгийн хөгжлийг бол тэтгэх үндсэн гол суурь нөхцөл бол байна гэж бол үзэж байгаа.

**Г.Занданшатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууна.

**Ц.Сандаг-Очир:** Хүнсний хувьсгал хөтөлбөрийн хүрээнд 500 гаруй тэрбум төгрөгийн зээл өнгөрсөн хугацаанд олгогдсон л гэж байна. Энэ зээл юмнууд хаагуур яаж, хэндээ олгогдоод байгаа юм бэ? Үндсэндээ энэ зээлийн хөтөлбөрүүд чинь хэдхэн томоохон хувийн хэвилийнхэнд л олгогдоод явах юм. Энэ төсөл хөтөлбөрт хамрагдъя гэсэн ЖДҮ-лэл эрхлэгч нар, тэд нарт зориулсан тусгай хөнгөлөлттэй зээл юм бүтээгдэхүүн байна уу үгүй юү? Нөгөө л нэг өндөр хүүтэй зээл болохоор чинь хэн ч авч чадахгүй байна. Нөгөө л барьцаа хөрөнгө шаардсан болохоор, нөгөө л нэг үл хөрөнгө шаардсан болохоор ингээд л хаалга мөргөж байгаа юм.

Яг энэ үндэсний Хүнсний хувьсгал хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй зээл байна уу? Яг ЖДҮ-лэл эрхлэгчдийг дэмжсэн ийм зориулагдсан ийм зээлүүд байна уу үгүй юү? Яг арилжааны банкнууд чинь энэ зээлээ яг эзэнд нь хүргэж чадаж байна уу үгүй юү? Та бүхний танилцуулгаар бол ингээд л зээл гараад байгаа л гээд байгаа. Яг эзнээ олохгүй байна л гэж яриад байгаа шүү дээ. Зээл авахыг.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ганболдын Энхтайван.

**Г.Энхтайван:** Оны эхний 8 сарын байдлаар хүнсний хувьсгалын хөтөлбөрийн хүрээнд бол 578 тэрбум төгрөгийн зээл олгогдсон. Үүнээс бол Хаан банк 219 тэрбум төгрөг, Худалдаа хөгжлийн банк 117 тэрбум төгрөг, Голомт банк 161 тэрбум төгрөг, Төрийн банк 12 тэрбум, Хас банк 58 тэрбум төгрөг гэх мэтчилэн бол ингээд олгогдоод явсан байгаад байгаа. Зээлийн төрлийн хувьд бол газар тариалангийн үйлдвэрлэл дээр бол 90 тэрбум, хүнсний ногооны үйлдвэрлэл дээр 22 тэрбум, хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн эргэлтийн хөрөнгө дээр 135 тэрбум төгрөг, гурилын үйлдвэрийн эргэлт дээр 14,5 тэрбум төгрөг, тэжээлийн үйлдвэрүүд дээр 3



тэрбум, сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй дээр 5,1 тэрбум төгрөг гэх мэтчилэн бол яг ААН-үүдэд бол яг ямар төрлийн ААН-үүд аль банкаар авч байгаа вэ гэдэг дээр танд дэлгэрэнгүй мэдээллийг албан бичгээр хүргүүлье. Энэхүү хүнсний хувьсгалын хөтөлбөр маань өөрөө нэн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр байгаа. ААН-үүд маань бол 5-аас 6 хувийн хүүтэй зээлийг авч байгаа. Төсөв дээр бол 13 хувийн татаасыг бол суулгаад олгоод байгаа.

**Г.Занданшатар:** Тогмидын Доржханд гишүүн. Ариунбат.

**Т.Доржханд:** Баярлалаа. Мөнгөний бодлого өмнөх жилийн нэг орж ирж байсан тэр маань л бас яг л адилхан ороод ирлээ. Тэгээд үр дүнг нь ярихаар үр дүн маань яг ноднин жил батлагдсан, амьдралгүй ийм тоо батлагдсан. Тэгээд өнөөдөр яг л адилхан амьдралгүй бас тоо орж ирж байна. Яагаад вэ тэгэхээр энэ мөнгөний бодлогын зорилт нь инфляцыг онилж байна гээд. Тэгээд инфляц нь 6 +, - 2 хувьтай байна гээд. Тэгээд энэ чинь биелэхгүй шүү дээ л гэж ноднин жил ярьж байсан. Тэгээд л та нар нүдээ аниад л, тэгээд л доошоо чимээгүй харж сууж байгаад л батлуулсан. Гэтэл одоо инфляц чинь хэдэн хувьтай байгаа юм бэ оны дунджаар? Та нар 6, +2 дээрээ хадгалж чадсан юм уу? 2 оронтой тоон дээр л байгаа шүү дээ тийм биз дээ? Үгүй ээ тэгээд энийгээ бодитой болгочхооч гэхэд үгүй ээ үгүй энэ бол мөнгөний бодлогын зорилт юм гээд л батлуулчихдаг. Тэгээд яах вэ батлуулсан болоод л яваад байна л даа.

Гэтэл өнөөдөр дахиад энэ чинь дахиад цаас болно гэдгийг та нар бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ. Өнөөдөр төсөв чинь тэлэлт дахиад л 20 байсан бол 27 их наяд болчихоод байна шүү дээ. Тэгээд мөнгөний бодлогын ямар ч орон зай байхгүй байгаа үед та нар дахиад л ингээд бүгдээрээ тонгойж суугаад л, тэгээд Ерөнхийлөгч нь бас байхгүй байх шиг байна. Тэгээд л нэг

Энхтайван ноднин жил бас ингээд л орж ирээд л аргалаад л өнгөрсөн. Бас энэ энэ удаа ч гэсэн бас ингээд л явж байх шиг байна. Тэгэхээр нөгөө бодитой тоо ярихгүй болохоор парламент чинь өөрөө ингээд бодитой бус байдлыг баталгаажуулаад явахаар өөрөө ингээд нэр хүнд нь унаад байгаа юм.

Тэгэхээр яг асуух гэж байгаа асуулт нь та нар инфляцыг яг хэдэн хувьд гэж харж байгаа юм бэ? Сангийн яамтайгаа ярьсан юм уу? Төсвийн тэлэлт дээр та нар саналаа өгсөн юм уу? Яг ийм өндөр төсвийн тэлэлттэй үед, тэгээд сонгуулийн яг ийм жилд бид нар инфляцаа яг энэ түвшинд барьж чадах уу? Яг бодитойгоор хэлээрэй. Сангийн яамтайгаа мөнгөнийхөө бодлогыг уялдуулсан уу, Эдийн засгийн хөгжлийн яам нь бас энэ уялдаа дээр оролцсон уу? Монголбанкны албан ёсны байр суурь яг юу байгаа юм бэ? Төсөв дээр яг юу байгаа вэ? Төсвийн тэлэлтийг та нар дэмжиж байгаа юм уу? Та нарын мөнгөний бодлогын зорилт буюу 6 дээр +, -2 хувь дээр чинь төсөв яг ямар байдлаар орж ирэх юм бол зүйтэй байгаа юм бэ? Энэ дээр та нар яг нэг мэргэжилтний хувиар нэг хариулаадхаач. Тэгээд Төв банк чинь өөрөө хэн нэгнээс хараат бус ийм байгууллага. Улсын Их Хурлын дэргэд байдаг. Тэгээд улс төржилтөөс хол байх ёстой. Тэгээд энэ агуулгаараа танай байр суурийг нэг сонсчихмоор байна.

2 дугаарт энэ нөгөө гаднын банкиг оруулж ирнэ гээд. Яах вэ бид нар хуулийг нь баталсан л даа. Яг хаалгаа тогшиж байгаа банк байгаа юм уу? Яг та нартай уулзаад бид нар хөрөнгө оруулъя гэсэн яг банк байна уу, ямар банкнууд байна вэ? Яг ийм орчинд би бол жаахан эргэлзээд л байна. Тэгээд танай тайланг уншихаар аягүй ерөнхий 1 сайхан юмнууд ингээд биччихсэн. Нэг ажил хийж байгаа л гэсэн ерөнхий юмнууд яваад байдаг. Гэхдээ яг бодит байдал дээр энэнийхээ мэдээллийг өгөөдөх, бодитой байна уу, байхгүй байна уу, дунд хугацаандаа орж ирэхээр байна уу үгүй байна уу?

Дараагийн нэг 3 л асуулт асуучихъя. 3 дахь асуулт нь бол энэ ипотекийн зээлийн асуудлыг Монголбанк шийдэж болохгүй. Энийг бол ЗГ луу шилжүүлэх ёстой гээд би 2, 3 жил ярьж байгаа. Дэлхийн бүх макро эдийн засагчид бол яг л ийм байр суурьтай байгаа. Дэлхий дээр хэзээ ч Төв банк нь ийм ЗГ-ын төсвийн шинж чанартай үйл ажиллагааг явуулдаггүйг бүгд мэдэж байгаа. Гэтэл дахиад нэг ийм ипотекийн санхүүжилтийн асуудлыг шийдэх болно гэдэг ийм юм чихний хажуугаар өнгөрөөд байх юм. Тэгээд энэ ямар учиртай юм бэ? Ийм дахиад гоё нэртэй хөтөлбөрүүд яваад байна уу үгүй байна уу? Энэ сонгууль угтсан шоунд та нар бас орчхоод байна уу үгүй байна уу? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөрэй. Баярлалаа.

### **Г.Занданшатар: 83.**

**Г.Энхтайван:** Доржханд гишүүний асуултад хариулъя. 2023 онд төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн тогтоолын төсөл дээр Төв банкнаас бол 2023 онд инфляцыг нэг оронтой тоонд барина гэж бол батлуулсан байгаад байгаа юм. Инфляц энэ оны төгсгөлд 12 сард бол 9,3 орчим хувьтай байх болов уу гэсэн Төв банкны төсөөлөл байна. Инфляц 9,2 хувьтай бол 7 сард гарсан. Өнгөрсөн жил бид бүхэн инфляцыг энэ үндсэн чиглэл батлуулахдаа 23 оны 2 дугаар хагасаас эхлээд Төв банкны зорилтот түвшинд орно буюу нэг оронтой тоонд орно гэж бол хүлээж байсан, хүлээж байсан. Яг энэний дагуу бол 7 сард бол 9,2 дээр бол гарсан. 8 сард бол бас суурь үеийн нөлөөнөөс шалтгаалаад, мөн 6 сард гарсан төсвийн тодотгол бол ойролцоогоор 1,9 их наядаар нэмэгдсэн. Үүнтэй холбогдуулаад бол инфляц 8 сард бол 10 орчим хувьтай гарч өсөж гарсан байгаад байгаа. 10 сараас эхлээд бол инфляцын энэ төсвийн тодотголттой холбоотойгоор инфляцын төсөөллөө бол шинэчилсний хүрээнд бол 12 сард бол

инфляц 7,3 хувьтай, үгүй ээ 9,3 хувьтай гарах болов уу гэсэн хүлээлттэй байна.

Дараа жилийн буюу 2024 оны инфляц бол дунджаар бол 7,9 хувьтай гарах болов уу гэсэн төсөөллийг Төв банк хийж байсан. Гэхдээ энэ нь бол төсвийн зардал талдаа бол 23 их наяд орчим төгрөгийн зардалтай байх болов уу гэсэн тооцооллыг бид бид бүхэн төсвийн дунд, төсвийн дунд хүрээний нөгөө мэдэгдлээс бол авсан байсан. Яг энэ дээр бол тооцсон тооцоо бол 7,9 хувьтай гарна гэсэн байгаа. Төсөв одоо өргөн баригдаад байгаа 27 их наядын зардалтай байх шиг байна. Тэгээд яг энэ дээр бол Төв банк бол яг төсөөллөө бол шинэчлээгүй байгаа. Мэдээж бол төсвийн тэлэлт нь бол инфляцыг бол өдөөх, мөнгөний бодлогын орон зайг хязгаарлах нөлөөтэй гэдгийг бол Төв банк ойлгож байгаа. Инфляц дээр бол мэдээж энэ дээр бол дарамт ирнэ.

Гадаадын банктэй холбоотой асуудал дээр бол яг Төв банкинд бол саналаа илэрхийлчихсэн гадаадын банк, санхүүгийн байгууллага бол алга. Бид бүхэн бол гадаад орны банк, санхүүгийн байгууллагатай бол илүү нээлттэй ажиллаж байгаа. Яг энэ хүрээнд ч гэсэн яг одоогийн байдлаар бол Төв банкны Ерөнхийлөгч БНСУ-д ажиллаж, тэдгээрийн банк, санхүүгийн байгууллагуудтай манай улсад үйл ажиллагааг нь эхлүүлэхэд чиглэлээр бол уулзалтууд бол хийгээд явж байгаа. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Банкны хууль болон Хөрөнгө оруулалтын тухай хууль, Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулиар гадаад орны төрийн өмчит банк орж ирсэн тохиолдолд бол эхлээд бол төрийн захиргааны төв байгууллага, гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Эдийн засгийн хөгжлийн яамнаас бол зөвшөөрөл авах тийм процедуртай байгаад байгаа. Тэгэхээр яг одоо Монгол Улсад үйл ажиллагаа явагдаж байгаа төлөөлөгчийн газраараа явуулж байгаа 2 БНХАУ-ын төрийн өмчит 2 банкны хувьд

бол саналаа илэрхийлээгүй байгаад байгаа гэсэн үг.

Ипотекийн зээлийн хөтөлбөрийг бол Төв банк бол Ковидын хуулийн дагуу бол 2020 оноос хойш хэрэгжүүлээд явж байсан. Ковидын хууль маань бол удаа дараа сунгагдаад, 2022 оны төгсгөлөөр бол дуусгавар болсон байгаад байгаа. Оны эхний хагас жилийн хугацаанд бол буюу өнөөдрийг хүртэлх хугацаанд бол Төв банк ипотекийн зээлийн хөтөлбөр дээр бол нэмэлт санхүүжилтийг бол олгоогүй. Зөвхөн эргэн төлөлтөөрөө санхүүжээд явж байгаа. Ипотекийн зээлийн хөтөлбөрийг бол энэ оны хагас жилээр тасалбар болгоод БХБЯ-нд буюу ЗГ-т шилжүүлэх бол төлөвлөгөөтэй байсан. ЗГ-ын зүгээс бол одоогоор яг шилжүүлж авах субъектийг бол Үндэсний орон сууцын корпорац гэж байгуулаад, түүн дээрээ Төв банкин дээр байгаа ипотекийн зээлийн зээлээр баталгаажсан бондын өмчлөлийг шилжүүлж авах тийм ийм схем зураад явж байна. Яг энэ хүрээнд бол Үндэсний орон сууцын корпорац байгуулагдахаар бол Төв банк бол энэ ипотекийн зээлийн хөтөлбөрийг бол Сангийн яам, үгүй ээ ЗГ-т бол шилжүүлээд явна. Тэр болтол бол Төв банк бол энэ ипотекийн зээл.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Картаа унишуулаарай. Тийм учраас нэр чинь гарчихсан юм байна шүү. Тогмидын Доржханд гишүүн.

**Т.Доржханд:** Тэгэхээр гадаадын банк хөрөнгө оруулъя гэсэн ийм хүсэлт бол ирээгүй юм байна гэж ойлголоо. Өөрөөр хэлэх юм бол хаалга тогшоод танайд хөрөнгө оруулъя гэсэн ийм банк бол байхгүй байна гэж нэг.

Ипотекийн зээлийн хувьд бол бид нар энийг бол энэ ондоо багтаагаад шилжүүлнэ, тэр бүтэц үүссэний дараа шилжүүлнэ гэж ойлголоо 2.

3 дугаарт энэ мөнгөний бодлогоо ярьж байхдаа та нар Сангийн яамтайгаа, Хөгжлийн яамтайгаа яриагүй юм байна гэж ойлголоо шүү. Үүнтэй холбоотойгоор үгүй ээ тэгээд ярихгүйгээр ингээд 2 тусдаа орж ирэхээр чинь наад мөнгөний бодлого чинь ажиллахгүй шүү дээ. Миний түрүүчийн асуултад ахиад би нэг асуучихъя даа. Яг та нарын төсөөллөөр инфляцаа 6 дээр +, -2 дээр энэ коридортоо хадгална гэж байгаа тохиолдолд төсөв яг яаж орж ирвэл зүйтэй байгаа юм бэ? Төсвийн зарлагын тэлэлтийг ярьж байгаа шүү. Хэдэн их наяд байвал зүйтэй байх. Дотоодын нийт бүтээгдэхүүний хэдэн хувь байвал зүйтэй байх.

**Г.Занданшатар:** 83.

**Г.Энхтайван:** Ер нь бол Төв банкны зүгээс санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөрөө дамжуулаад Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яамтай бол энэ мөнгөний бодлого бол өргөн барихдаа бол хэлэлцүүлсэн. Тэгэхээр бол Сангийн яам болон ЗГ-тай энэ дээр бол санал солилцсон. Төв банк бол яах вэ инфляцын төсөөллийг бол хийхдээ төсвийн дунд хүрээний мэдэгдлийн хүрээнд бол 23 их наядын зардалтай байх үед бол тооцсон байгаад байгаа. Инфляц бол 7,9 хувиас бол нэмэгдэнэ дараа жилийн манай тооцоогоор бол. Төсөв ямар байх ёстой юм бэ гээд Доржханд гишүүн асууж байна. Төсөв бол ямар байх ёстой гэдэг нь аягүй ойлгомжтой шүү дээ. Алдагдалгүй л байвал мэдээж хамгийн сайн. Гэхдээ мэдээж манай улсын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал болон бусад холбогдох бодлогын арга хэмжээнүүд болон зайлшгүй шийдэгдэх ёстой арга хэмжээг бол Улсын Их Хурал төсөв батлахдаа эрэмбэлээд шийддэг гэж бол ойлгож байгаа. Тэгэхээр бол Төв банк бол энд энэ дээр бол мэдээж бодлогын.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Доржханд гишүүн тодруулъя.

**Т.Доржханд:** Тэгэхээр Монголбанкны байр суурь бол төсвийг алдагдалгүй батлах нь зүйтэй гэдэг байр суурь гэж ойлголоо нэг. 2 дугаарт Монголбанкны энэ мөнгөний бодлогын төсөөлөл бол төсвийн хүрээний мэдэгдэл буюу тэр 23 их наяд төгрөг дээр төсөөлөл дээр үндэслэсэн ийм бодлого орж ирж байна. Тийм болохоор энийгээ тохируулга хийх шаардлагатай гэж бас ойлголоо. Мөн үү? Тэгээд 3 дугаарт бол цаашаагаа хэлэлцэх явцаа бол ингээд та бүгд ЗГ-тайгаа буюу Хөгжлийн яам, Сангийн яамтайгаа цуг хамтраад энэ мөнгөний бодлогоо төсөвтэйгөө уялдуулаад орж ирнэ гэж би хүлээж байгаа шүү. Ингэж л явах учиртай. Ингэж чадах уу? Би тодруулж асууж байгаа шүү, баталгаажуулж хэлээрэй. Яагаад вэ гэхээр энэ маань нэлээн олон хэлэлцүүлэг бол явах байх. Тэгээд энэ маш олон эдийн засагчид энийг харж байгаа шүү дээ. Тэгээд сонгуулийн жилээр тохиолдуулаад Мөнгөний бодлого нь ямар байх юм бэ гэдэг нь бол.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ?  
83 Ганболдын Энхтайван.

**Г.Энхтайван:** Тэгэхээр одоо өргөн баригдчихаад байгаа төсөвтэй уялдуулаад бол Төв банкны зүгээс бол мөчлөг, мөчлөг сөрсөн мөнгөний бодлогын бодлогыг бол ирэх онд бол хэрэгжүүлээд явна. Мэдээж төсвийн тэлэлттэй холбогдуулан мөнгөний бодлого бол цаг тухайдаа бол тохиргоогоо хийгээд явна. Мөнгөний бодлого Их Хурлаар хэлэлцэгдээд ажлын хэсэг гараад явахад бол Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яамны холбогдох газар, хэлтсийн захирлууд бол оролцоод саналаа бол нэгтгээд явдаг. Тэгэхээр дараа дараагийн ажлын хэсгүүд дээр бол таны энэ хэлж байгаа бүх саналыг бол тусгаад явъя бид бүхний зүгээс бол. Төсөв мөнгөний бодлогын хувьд бол нийцтэй байна гэж бол харж байгаа. Ажлын хэсэг дээр бүгдийг нь бол шийдээд явна.

**Г.Занданшатар:** Төмөртоогоогийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

**Т.Энхтүвшин:** Баярлалаа. Жил болгон л тэгээд л ингээд л мөнгөний бодлого орж ирээд л, батлагдаад л явдаг даа. Тэгээд юу хэлэх гээд байна гэхээр энэ Монгол төгрөгөө л тогтвортой байлгах асуудал бид ярьж байгаа шүү дээ. Валютын урсгалыг нэмэгдүүлэх, ялангуяа дотооддоо бүх зүйлээ үйлдвэрлэж байж л бид Монгол төгрөгийг л тогтвортой байлгана шүү дээ. Тэгээд би энэ Монголбанкнаас орж ирсэн энэ мөнгөний бодлого дээр юу гэдэг юм энэ Засгийн газраас зарласан Шинэ сэргэлтийн бодлоготойгоо бас уялдуулж өөрчлөлтийг хийгээч л гэж хэлээд байгаа юм.

Аж үйлдвэрийн сэргэлтийн асуудал яриад жил гаруй болж байна. Бид уул уурхайн бүтээгдэхүүнээ аль болохоор түүхийгээр нь биш баяжуулаад, боловсруулаад, нэмүү өртөг шингээгээд, ажлын байрыг бий болгоод ингээд гаргая л гэдэг ийм асуудал ярьж байгаа шүү дээ. Арьс ширний, арьс ширнийхээ үйлдвэрийг байгуулья. Ноос ноолуураа эцсийн бүтээгдэхүүн болгоё, ажлын байрыг нэмэгдүүлъя. Ингэж байж Монгол хүн ажилтай, орлоготой, Монгол төгрөг тогтвортой байна л гэдэг асуудал яриад байгаа юм. Тийм учраас энэ Шинэ сэргэлтийн бодлоготой уялдуулаад ялангуяа энэ аж үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж байгаа энэ компани, ААН байгууллагууд түлхүү зээл өгөх, урт хугацаатай, бага хүүтэй энэ асуудлаа бас ингээд томъёолоод ороод ирж болдоггүй юм уу? Бид өөрсдөө бүх зүйлээ хийж байж л энэ Монгол төгрөг чинь л тогтвортой болно шүү дээ. Тэгээд бүх зүйлээ гаднаас ингээд аваад, уул уурхайн бүтээгдэхүүнээ ингээд түүхийгээр нь гаргаад байх юм бол тогтворгүй хэвээрээ л байгаад байна. Тэгэхээр энэ ЗГ, Улсын Их Хурлаас гаргаж байгаа бодлого шийдвэрүүдтэйгээ наад мөнгөний бодлогоо уяж өгөөч гэдэг ийм асуудал би тавиад байгаа юм.



2 дахь асуудал энэ Эдийн засгийн хөгжлийн яамны сайд Хүрэлбаатар сайд, Тогтохсүрэн нь дарга эд нар асуудал тавиад байгаа шүү дээ. Энэ гаднын банкиг оруулж ирэх асуудал чинь юу болж байгаа юм бэ гээд. Тэгээд хүлээгээд байх шаардлага байхгүй шүү дээ энийг. Өөрсдөө гадаад, дотоод руу явж энэ гаднын өндөр хөгжилтэй банкнуудад энэ хууль, эрх зүйн орчноо бас танилцуулах, тайлбарлах, тэднийг урьж залж Монголын нөхцөл байдалтай танилцуулах гээд ийм ажлуудыг л хийж явж байж л гаднын банкнууд орж ирнэ үү гэхээс биш ингээд л хүлээгээд байгаад байх юм бол хэн ч орж ирэхгүй шүү дээ. Хэн ч орж ирэхгүй. Тийм учраас энэ дээр та хэд нэг жоохон чармайлт гаргаад, идэвхтэй ажиллаач. Монгол Улсыг сонирхох бол би гадаад, дотоодын банкнууд бол байгаа л гэж бодож байна. Ийм их баялагтай, ийм олон их малтай, ийм том газар нутагтай энэ улсыг бол бүхий л банкнууд би сонирхох болов уу л гэж бодож байна. Хамгийн гол нь та хэд маань жоохон идэвх чармайлт гаргаад, тэдэнтэй уулзаач. Хойноос нь яваач, хүлээх хэрэггүй шүү дээ одоо бид нар очиж өөрсдөө уулзаж, урьж залж авчрах эрх зүйн орчноо танилцуулах, Монгол Улсаа танилцуулах ийм ажлуудыг л хийгээч л гэж бол хүсээд байгаа юм.

Бусдаар юу гэдэг юм инфляцын түвшнийг 6 хувьд барина, дээшээ 2, доошоо 2 гээд, 4-өөс 8 хувьд барина гээд ингээд яриад байж болохгүй л дээ. Бодитой л юмыг яримаар байна. Цаашидаа бид нар ингээд тогтвортой хөгжсө, тогтвортой эдийн засгаа авч явъя гэх юм бол бид яах аргагүй л энэ ажлын байрыг нэмэгдүүлсэн ХАА, уул уурхайн бүтээгдэхүүнийг эцсийн шатад боловсруулсан ийм үйлдвэрүүдийг л мөнгөний бодлогоор, зээлийн бодлогоор дэмжиж байж л бид цаашидаа сайхан амьдарна. Та бүхний хүсээд байгаа нөгөө ДНБ өснө, нэг хүнд ноогдох ДНБ өснө. Нөгөө яриад байдаг тэтгэвэр, цалин бүх асуудлууд чинь л өснө шүү дээ. Бид нар

энэтэй уяж байж л мөнгөний бодлого ярина уу гэхээс биш зүгээр л инфляцыг тэдэн хувьд барина гэдэг ийм асуудлаар бас хандаж болохгүй болов уу л гэж би бодож байна.

**Г.Занданшатар:** Асуулт, хариулт явж байгаа учраас 3 гишүүний дараа, 5 гишүүний дараа асуулт, хариулт дуусах учраас гишүүд чуулганы танхимд цуглаарай. Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэгийн урилгаар ерөнхий боловсролын Оюунлаг сургуулийн 10А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Сурлага сайтай Оюунлаг сургуулийнхаа оюунлаг сурагчдад сурлага хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөе. Асуултад Ганболдын Энхтайван дэд ерөнхийлөгч хариулна.

**Г.Энхтайван:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Энхтүвшин гишүүн яг манай 2024 оны мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн яг гол томъёолсон хамгийн гол нюансыг бүрдүүлж байгаа хэсэг дээр бол бас асуулт асуулаа. Гадаадын банк оруулж ирэх талаар. Бид бүхэн бол гадаадын банкиг оруулж ирэх талаар бол ихээхэн идэвх чармайлт бол гаргаж ажиллаж байгаа. Энэ оны 7 дугаар сард зохион байгуулагдсан Монголын эдийн засгийн форумын үеэр гадаадын 26 банк санхүүгийн байгууллагууд ирсэн. Яг энэ хүрээнд бол Төв банкнаас бол банкны салбарын үйл ажиллагааг танилцуулах, Монголд бизнесийн үйл ажиллагаа эрхэлбэл ямар боломж, бололцоо гарах юм, эдийн засгийн үр өгөөж нь ямар байх юм, Төв банкны зүгээс баримталж байгаа бодлого нь ямар байх юм, хяналт шалгалт, зохицуулалтын хүрээний асуудлууд нь цаашидаа ямар чиглэлтэй байх юм гэх мэтчилэн бүхий л чиглэлээр л Төв банкны зүгээс бол танилцуулга бол хийсэн. Энэ чиглэлээр бол Төв банк өөрсдөө бодлого гаргаад ажиллаж байгаа. Яг энэ хүрээнд.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ганибалын Амартүвшин гишүүн.

**Г.Амартүвшин:** Баярлалаа. Мөнгөний бодлого хэлэлцэж байна. Мөнгөний бодлого гэхээр манай нөхцөлд бол үндсэндээ Монголбанкны бодлогын хүүгийн талаар л бид нар яриад байгаа юм л даа. Бодлогын хүү гэж ганцхан хэрэгслээр инфляцын түвшнийг зорилтот түвшинд барих л асуудал байгаад байгаа юм. Мэдээжийн хэрэг инфляц бол чухал асуудал номер нэг зорилт гэдэг нь үнэн. Ер нь дэлхий даяар инфляцын түвшин өндөр байгаа, Америкийн Төв банкны бодлогын хүү ч гэсэн 16 жилийн дээд цэгтээ хүрчихсэн. Гэсэн ч гэсэн инфляцаа бас барихад төвөгтэй байна л гэж яригдаад байгаа.

Тэгэхээр бол гэхдээ Европын Төв банк болон Америкийн Төв банкны хувьд бол бусад өөр хэрэгслүүд байдаг болохоор илүү уян хатан ажиллаж болоод байгаа юм. Бидний хувьд болохоор яг үнэхээр бодлогын хүүгээсээ өөр хэрэгсэл байхгүй ийм л нөхцөл байдалтай. Гэтэл 10,6 билүү, 10,3 инфляцын түвшин байгаа. Оны эцэс гэхэд нэг орон тоо руу орно гэж таамаглаж байна гэж байгаа юм Монголбанкны төлөөлөл. Гэтэл саяхан л өнгөрсөн амралтын өдөр хонины мах авахад л 17 мянгаар л зарж байна лээ шүү дээ. Өөрөөр хэлбэл нөгөө гол инфляцын бүрэлдэхүүнд ордог хүнсний дотоодын хүнсний бүтээгдэхүүний үнэ чинь буцаад л өсөөд эхэлж байна л даа. Өөрөөр хэлбэл энэ чинь танай инфляцын зорилтот түвшинд хүрэх боломжийг чинь улам л бол багасгаад байна гэсэн үг.

Нөгөө талаас ингээд бодлогын зөвлөл нь хуралдаад хүү, бодлогын хүүгээ дахиад нэмлээ гэхэд нөгөө эдийн засгийн бодит эдийн засгийн үйл ажиллагаагаа дахиад л боогдуулсан нөхцөл байдал үүсээд байна л даа. Энэ зээлийн багцын бүтцийг харахад банкны салбар үндсэндээ иргэдийн зээл л өсөөд байна л даа 20 хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл

иргэд цалингийн зээлээрээ л амьдарч байна гэсэн үг. Энэ бол нөгөө инфляцын нөлөө л дөө. Гэхдээ нөгөө талаас нөгөө татвар төлдөг ААН, жижиг дунд бизнест гарч байгаа зээл нь бараг байхгүй. Ерөөсөө өсөхгүй байгаад байгаа юм. Тэр нь яагаад өсөхгүй байгаад байна гэхээр 1 дүгээрт хүү нь өндөр, 2 дугаарт нөхцөл. Одоо бас нэг хэрэгсэл Монголбанкинд байгаа л даа. Хүүгээс гадна. Тэр нь юу вэ гэхээр энэ зээлийн ангилал дээрээ жосоохон уян хатан байгаач, урт хугацаатай зээл гарах боломжийг нь банкнуудад өг.

Тэгэхгүй тэгээд жил болгон байцаагч нар орж ирээд л нэмэлт эрсдэлийн сан байгуулна гээд л улам зээлийн хүүг нь өсгөөд байгаа байхгүй юу. Нөхцөлийг нь чангалаад. Энэ дээр жосоохон уян хатан баймаар байна. ААН-үүдтэй уулзахад ерөөсөө больё бид нар зээлийн хүү өндөр байгааг хүлээн зөвшөөрье. Зүгээр бид нарт 3-аас 5 жилийн зээл өгчих. Одоо байгаа барьцаа хөрөнгийг үндэслээд энийг л яриад байгаа байхгүй юу. Яагаад гэвэл энэ манай эдийн засаг чинь ийм савлагаатай байдаг, нэг жил өсөөд л, дараа жил нь ингээд буурдаг. Энэ 2 мөчлөгийн 2 талд нь энэ компаниуд чинь ард нь гарч чадахгүй байгаад байгаа байхгүй юу.

2 дугаарт зээлийн багцын бүтцийг нь харахад ерөнхийдөө барилга, үл хөдлөх хөрөнгийн салбарын зээл хамгийн өндөр чанаргүй зээлийн хэмжээтэй байгаа. Энэ барилгын салбарын хөөс чинь ер нь тэгээд хагарч эхэлж байна шүү дээ. Олон жил энэ барилгын салбарын хөөс бол нэлээн явсан. Нийслэлийн байрны үнэ бол бүүр үнэхээр гайхмаар өндөр түвшинд хүрчээд байгаа шүү дээ. Гэтэл хүү нь өсөөд байдаг, иргэд нь байр авъя гэхээр урьдчилгаа төлбөр дээр нь ерөөсөө уян хатан байж болдоггүй. Хүү больё гэхэд урьдчилгаа төлбөр дээр нь бас уян хатан баймаар байна шүү дээ Монгол банкныхан. Тийм болохоор энэ зээлийнхээ ангилал болон нөхцөл дээр нь Монголбанк илүү уян хатан байх юм бол ядаж

бодлогын хүүгээ та нар инфляцаа онилоод бусад хэрэгслээрээ энэ банкнуудад илүү бодит зах зээлдээ хөрөнгө гаргах тийм боломжийг нь өгмөөр байна л даа. Тэгэхдээ энэ дээр та нар нэг хариулт өгөөч. Би тэгээд дахин асууя.

**Г.Занданшатар:** Ганболдын Энхтайван хариулъя 83.

**Г.Энхтайван:** Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Та яг банкны салбарт бас яг тулгамдаад байгаад байгаа бас зайлиггүй шийдэх ёстой асуудлыг л хөндлөө л дөө. Мэдээж арилжааны банкнууд өөрсдөө тодорхой зардалтайгаар эх үүсвэр татдаг, тодорхой хугацаагаар татдаг. Мэдээж урт хугацаатай хөрөнгө оруулалтын зээл олгоход бол мэдээж энэ хугацааны, татаж байгаа эх үүсвэрийн хугацаа бол бас харьцангуй зөрөөтэй байгаад байгаа юм. Бид бүхэн янз янзын нэр томъёогоор хэлдэг. Maturity mismatch гэж бол ярьдаг. Тэгээд мэдээж манай улсын арилжааны банкнуудын зээлийн эх үүсвэрийг бүрдүүлж байгаа эх үүсвэр маань өөрөө богино хугацаатай байдаг их дийлэнх нь. Богино хугацаатай эх үүсвэрээр урт хугацаатай зээл олгоход арилжааны банкин дээр бол тодорхой хэмжээний эрсдэл үүсдэг. Энэ дээр ч гэсэн Төв банк тухай бүрд нь хяналт шалгалтын үүрэг функцүүдээ бол үүрэг хяналт шалгалтын мандатаа бол хэрэгжүүлдэг.

Урт хугацааны санхүүжилтийг бол нэмэгдүүлж, урт хугацаатай эх үүсвэрийг нэмэгдүүлж байж л энэ зээлийн хугацааг бол нэмэгдүүлэх бол суурь нөхцөл бол болж байгаа юм. Тэгэхээр бол арилжааны банкнууд дээрх хяналт шалгалт дээр бол Төв банк бол энэ дээр өөрсдийн тавих хяналт шалгалтын хүрээнд тавигдаж байгаа өөрсдийн дүрэм журам стандарт харьцаануудаа бол зөөлрүүлээд явсан ч гэсэн энэ дээр бол санхүүжилт дээр нь бол асуудал байгаад байгаа учраас энэ бол хугацаа дээр нь бол ийм шууд ийм механик аргаар зохицуулалт хийхэд бол бас хүндрэлтэй.

Гэхдээ бол мэдээж Төв банкны зүгээс бол арилжааны банкнуудыг гадаад зах зээл дээрээс урт хугацаатай хөрөнгө оруулалт, санхүүжилт татахад нь бол дэмжлэг үзүүлээд явж байгаа. Сүүлийн Мөнгөний бодлогын хорооны 3 сарын хурлаар билүү дээ гадаад зах зээл дээрээс татсан 365 хоногоос доторх эх үүсвэр дээр заавал байлгах нөөцийн хэмжээ бодохыг бол болиулсан байгаад байгаа гэх мэтчилэн. Төв банк бол энэ дээр бол цаашидаа бодлогын арга хэмжээнүүдийг л аваад явна.

Тэгээд бусад энэ гадаадын банк оруулж ирж байгаа, гадаадын банкны салбарыг Монголд ажиллуулах асуудал ч гэсэн яг энэ урт хугацаатай санхүүжилтийг л бий болгох чиглэлээр бол Төв банкнаас бол ажиллаад явж байгаа нэг ийм бодлогын арга хэрэгсэл л гэсэн үг. Тэгээд яг тан дээр яг энэ дэлгэрэнгүй энэ статистик мэдээллүүдийг манай энэ ерөнхий эдийн засагч өгөх байх. Яг ямар, ямар зардлууд гараад, ямар, ямар хугацаа дээр ийм гаре гараад байгаа талаар бол. Манай бүтцийн өөрчлөлтийн бодлогын газрын захирал Ариунбат зээлийн ангилалтай холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.

**Г.Занданшатар:** 88  
Найманжингийн Ариунболд, Ариунбат.

**Н.Ариунбат:** Амартүвшин гишүүний 2 дахь асуултад тодруулга өгье. Зээлийн ангилалтай холбоотойгоор бол Төв банкны зүгээс зохицуулагч байгууллагууд бол тодорхой хэмжээний уян хатан бодлогыг бас хэрэгжүүлээд ер нь явж байсан. Ялангуяа Ковидын үед ч гэсэн бид нар хөнгөлөлтийн арга хэмжээ авсан. Ковидын үед ковидын хугацаа дууссанаар бол хэдийгээр жирийн хэмжээнд очсон ч гэсэн саяхан бол Банкны холбоо, Банкны холбоо болон банкнуудын хуульчдын зөвлөлтэй мэргэжлийн холбоо холбооны зөвлөлтэй уулзаж тодорхой саналууд Монголбанкинд хүргүүлсэн байгаа. Актив ангилалтын журамд газар дээр нь хэрвээ

өмнө нь бол хянан шалгагч, хянан шалгалтын газар хянан шалгагч нь газар дээрээ очиж шалгаж ангиллыг дээшлүүлдэг байсан бол банкны хувьд бол банкнууд маань 45 болон холбогдох тэр зээлээс бусад зээлүүдийг бол хэрвээ холбогдох төлбөр хийгдсэн, өөрчлөлт орсон, нөхцөл сайжирсан тохиолдолд бол банкнууд өөрснөө ангиллыг дээшлүүлэх боломжтой болох өөрчлөлтийг ойрын хугацаанд хийхээр Төв банкны зүгээс ажиллаж байна.

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэгийн урилгаар ерөнхий боловсролын Оюунлаг сургуулийн 10А ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Оюунлаг сургуулийн оюунлаг сурагч, багш нартаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. Ганибалын Амартүвшин гишүүн тодруулж асууна нэг минут.

**Г.Амартүвшин:** Актив ангиллын журмаа илүү уян хатан болгож байгаа чинь, болгож байгаа чинь зөв, зөв. Зүгээр би гол нь юу яриад байна гэхээр хугацаа мэдээж хэрэг актив пассивын хугацааны зөрөө бол гардаг. Mismatch бол байдаг. Манайд бол заавал энэ бол суурь асуудлын хувьд мөн. Гэхдээ энэ дээр харин би яг юу гэж хэлээд байна вэ гэхээр Монголбанк энэ арилжааны банкнуудаа тэр дунд хугацааны эх үүсвэрээр нь бас хангах боломж байгаа шүү дээ. Өөрөөр хэлбэл энэ Төв банкны үнэт цаасны үлдэгдэл чинь жилийн дотор дахиад л 1,7 их наядаар нэмэгдчихсэн л байна шүү дээ банкнуудын баланс дээр актив дээр. Өөрөөр хэлбэл сул юу нь байгаа боловч энэ нөгөө зүгээр зах зээлээс депозит юм уу хадгаламж хэлбэрээр татаж болохгүй нь үнэн. Гэхдээ энэ дээр бол Монголбанк илүү уян хатан, тэр боломжийг нь репо өөр хэрэгслээр нь дэмжээд өгчихвөл ААН-үүд зээлийн хүүгээ больё, хугацаатай урт хугацаатай зээл өгөөч л гэж яриад байгаа байхгүй юу. Энэ дээр л би илүү тодорхой хариулт.../минут дуусае/

**Г.Занданшатар:** 83 Ганболдын Энхтайван.

**Г.Энхтайван:** Гишүүний Амартүвшин гишүүний ярьж байгаа пойнтыг бол маш сайн ойлгож байгаа. Гэхдээ яг одоогийн нөхцөл байдал дээр бол инфляц өөрөө харьцангуй өндөр байна. Тэгээд бодлогын хүү үүнээс шалтгаалаад 13 хувийн хүүтэй байгаад байгаа учраас арилжааны банкнуудад санхүүжилт өгвөл 13 хувийн хүүтэй л өгнө гэсэн үг шүү дээ. Хүүгийн нэгдсэн бодлогынхоо хувьд бол. Тэгэхээр бол харьцангуй өндөр дүнтэй санхүүжилт, өндөр зардалтай санхүүжилт арилжааны банк аваад, тэрүүгээрээ эргүүлээд зээл гаргана гэдэг маань зээлийн хүү бас зээлийн хүүгийн өсөлтөд бас сөргөөр нөлөөлөлтэй. Мэдээж бол инфляц тогтворжоод, бодлогын хүүгийн төлөв зөөлрөөд, мөнгөний бодлогын төлөв зөөлрөөд, хүү багасаад ирэх үед бол банкнуудыг дунд хугацаандаа бол бага хүүтэй эх үүсвэрээр хангаад, зээлийг бол тэтгээд явах бол боломжтой. Тийм. Тан дээр тантай энэ дээр бол 100 хувь санал нийлэх нэгтэй байна.

**Г.Занданшатар:** Нанзадын Наранбаатар гишүүн алга байна, хаслаа. Сандагийн Бямбацогт гишүүн алга байна, хаслаа. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Мөнгөний бодлого ярилцаж байна. Ер нь төрөөс эдийн засагт оролцож байгаа 2 гол оролцоо төсөв, мөнгөний бодлого. Энэ 2 нийлээд нэг бүхэл бүтэн зүйл. Бүүр нэг бүхэл бүтэн зүйл гэдэг нь нэг нь томрохоор нөгөөдөх нь жижгэрнэ л гэсэн үг. Тэгэхээр яг нөхцөл байдал дээр Монгол Улсын төсөв сүүлийн жилүүдийн энэ төсвийн тэлэлт зөвхөн өнөө жилийн төсөв өнгөрсөн жилтэй харьцуулахад 30 хувиар өсчихсөн ийм л нөхцөл байдалтай. Тэгээд төсөв тэлэхээр яадаг вэ, төсөв тэлэхээр зах зээл рүү мөнгө их нийлүүлэгдэнэ. Зах зээл рүү мөнгө их нийлүүлэгдэхээр яадаг вэ инфляц болно. Инфляц болохоор яадаг



вэ Монголбанк бодлогоо хатууруулж байна гээд бодлогын хүүгээ нэмнэ. Бодлогын хүү нэмэхээр яадаг вэ зээлийн хүү өснө. Зээлийн хүү өсөхөөр яадаг вэ энэ төрд хамаагүй энэ иргэд, ААН-үүдэд мөнгө очихгүй. Иргэд, ААН-үүдэд мөнгө очихгүй. Ингээд Монгол Улс улам төржсөн, иргэд нь чөлөөт зах зээлийн эдийн засаг гэж тунхаглагчаад, иргэд нь эдийн засагтаа оролцдоггүй нэг ийм л эдийн засгийн загвар луу жилээс жилд маш том, том алхмаар ингээд л алхаад л явж байна л даа.

Тэгэхээр энэ бүгд дээр, энэ бүх бодлого дээр Монгол банк нэг яг өөрийн энэ Улсын Их Хурлаас байгуулагдсан ЗГ-аас хараат бус бие даасан байх ёстой энэ хуулиар бас хамгаалагдсан эрхээ эдэлж, энэ бодлогоо хэрэгжүүлээч гэдгийг л бас удаа дараа миний хувьд хэлээд л байгаа. Жишээ нь энэ дээр яг орж ирж байгаа бодлого дээр нэг ийм том асуудал ипотекийн асуудал. Яг үнэндээ Монголбанкны данс дээр ипотекийн зээлийн хүүг санхүүжүүлсэн 3,6, 4 орчим их наяд төгрөг байгаа. Энэ 4 орчим их наяд төгрөг чинь үнэндээ төсөв дээр байх ёстой л мөнгө шүү дээ. Төсөв дээр байх ёстойг Монголбанк санхүүжүүлж байна гэдэг чинь энэ бол яг үнэндээ энэ 3,6 их наяд чинь төсвийн алдагдал гэсэн үг. Монголбанк чинь баялаг бүтээдэггүй, Монголбанк мөнгө хэвлэж энийг нөхөж байгаа, инфляцыг өдөөж байгаа. Тэгээд энийгээ яаралтай төсөв рүүгээ шилжүүлж өгөөч.

Дахиад дээрээс нь энд орж ирж байгаа нь тэр Үндэсний ипотекийн корпорац гэнэ үү нэг байгууллага байгуулах юм байна лээб Одоо явж байгаа санхүүгийн зөв механизм МИК гээд ХК банкнууд хувьцаатай, олон улсын санхүүгийн аргачлалаар явж байгаа энэ тогтсон системээ ингээж нураагаад дахиад нэг ТӨК байгуулах юм уу, эрсдэлийг нь төр бүтэн үүрэх юм уу гэх мэтээр. Одоо тэр төсөв дээр та нар дуугардаггүй, дахиад нөгөө талаасаа ипотека гээд мөнгө хэвлэж л

санхүүжүүлж байгаа шүү дээ эцэстээ. Энэ чинь яг үнэндээ агуулгаараа энэ ипотекийн санхүүжилтийн 4 шахам их наяд чинь энэ бол төсвийн алдагдал гэдэгтэй энэ Монголбанкныхан та нар энд хариулж өгөөч. Энэ агуулгаараа төсвийн алдагдал мөн үү биш үү? Та нар магадгүй өөр нэг тайлбар хэлэх байх. Энэ дээр нэг тайлбар өгөөч.

2 дугаарт нь тэр төрийн өмчит ипотекийн корпорац байгуулж байгаа нь зөв юм уу? Та нар бодлогын хувьд зөв гэж үзэж байгаа юу? Төрийн өмчит ипотекийн корпорац байгуулж энэ санхүүгийн системийг дахин шинээр ингэж эвдэх гэж байгаа нь зөв юм уу? Та нар энэ дээр нэг бас нэг байр сууриа илэрхийлж өгөөч. Ер нь эцсийн дүндээ энд асар их том хэмжээний завхрал энэний цаана ингээж яваад, та бүгдийн тэр хараат бус байдал, бие даасан байдал гэдэг чинь бүрэн дүүрэн алдаж, та нар энийгээ хамгаалахгүй байгаагаас болж ямар томоохон үр дагавар гарч байгаад та нар бас дүгнэлт хийх хэрэгтэй.

**Г.Занданшатар:** Ганболдын Энхтайван.

**Г.Энхтайван:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Төсөв мөнгөний бодлогын уялдаа холбооны талаар ярилаа. Мэдээж төсвийн бодлого ч тэр, мөнгөний бодлого ч тэр нэгдсэн нэг зорилготой. Манай Монгол Улсын нийт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд сэтгэл хангалуун, амар тайван амьдрах боломжийг л бий болгох зорилготой. Тэгээд аль аль нь өөр өөрсдийн хуулиар олгогдсон мандатынхаа хүрээнд энэхүү зорилгод бол хүрдэг зохицуулалттай. Тэгээд төсвийн бодлого, мөнгөний бодлого маань өөрөө бол эдийн засгийн зөвхөн бол эрэлтийн талыг бол зохицуулдаг. Төсөв мөнгөний бодлого бол бас хэлэлцэгдэхийнхээ өмнө бол холбогдох байгууллагууд дээр хамтарсан зөвлөлүүдээр орж бол хэлэлцэгдээд уялдаа холбоогоо хангадаг.

**Г.Занданшатар:** Микрофоноо ойртуулж ярь. Микрофоныг нь ойртуул, сонсогдохгүй байна.

**Г.Энхтайван:** 2019 онд улсын төсвийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ бол 30,2 хувьтай байсан. 24 оны төсөв бол энэ дээр бол 37 орчим хувьтай байх шиг байна. Тэгэхээр бол улсын эдийн засагт эзэлж байгаа улсын төсвийн зардлын хэмжээ ихсэх тусам бол мөнгөний бодлогын орон зай бол хумигдаж байгаа. Энэ дээрээ бол тэгэхээр эдийн засгаа бол яаралтай тэлж байж л энэ төсвийн эдийн засагт эзлээд байгаа хувь хэмжээг бол зайлшгүй бууруулах, энэ нь эргээд баялаг бүтээгч, бизнес эрхлэгч нарын ажиллах орон зайг нэмэгдүүлэх, энэ нь эргээд улсын сан хөмрөг нэмэгдэх, санхүүжилт нэмэгдэх, эх үүсвэрийн зардал буурах гэх мэтчилэн маш олон эерэг үр дагавруудыг агуулна. Тэгэхээр Төв банк бол энэ дээр бол илүү бодлогын зоригтой шийдэл гаргаж ажиллана. Төсвийн эдийн засагт ДНБ-д эзэлж байгаа төсвийн хувь хэмжээг бол аль болохоор бага байх нь бол эдийн засагт бол эерэг үр нөлөөтэй гэж бол үзэж байгаа. Гэхдээ бол мэдээж GDP-г өсгөх, ДНБ-ийг өсгөх боломж маань бас хязгаарлагдмал байгаа.

Ипотекийн зээлтэй холбоотой асуудал бол мэдээж 2013 оноос хойш хэрэгжүүлсэн. Энэ бол төрөөс гаргасан нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлэх, иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах боломжийг хангах үндсэн суурь гол хөтөлбөр байгаад байгаа. Төв банкны зүгээс бол өнгөрсөн оны мөнгөний бодлогын хөтөлбөрт тусгагдсаны дагуу энэ оны 2 дугаар хагасаас эхлээд бол ЗГ-т шилжүүлэхээр бол туссан байсан. ЗГ бол өөрөө шилжүүлж авах субъектээ бол байгуулаагүй байгаа учраас энэ байгуулагдах хүртэл нь бол Төв банкинд дээр бол гараад үйл ажиллагаа нь бол өмчлөл нь бондын өмчлөл бол хэвээрээ явах нь. Мэдээж ипотекийн зээлийн хөтөлбөр маань өөрөө төрөөс хэрэгжүүлж байгаа нэн хөнгөлөлттэй хөтөлбөр учраас бол тодорхой

хэмжээний бодлогын зардал гарч байгаа. Энэхүү бодлогын зардлыг бол Төв банк өөр дээрээ бол алдагдал болгоод бол үүрээд явдаг.

Мэдээж бол энэ бол шууд төсвийн алдагдал гэж үзэхэд бол хэцүү. Хэрвээ бид бүхэн бол үнэгүй зээл олгочихсон байсан, үнэгүй хүүгүй зээл олгочихсон байсан бол, татаас олгочихсон байсан бол энэ бол алдагдал гэж бол үзнэ. Энэ бол тэгэхдээ бол зүгээр хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл. Бусад дэлгэрэнгүй асуудлаар бол манай холбогдох газрын захирлууд бол хариулах байх. Ер нь бол тэр ипотекийн зээлийн одоо хэрэгжиж байгаа энэ схем бол маш сайн схем. Дэлхий нийт одоогоор бол үүнээс сайн схем бол бодож олоогүй байна. Ипотекийн Монголын ипотекийн корпорацын хэрэгжүүлж байгаа үнэт цаасжуулж байгаа энэ схем дэлхийн бүх л оронд байдаг. Энэ схем бол зайлшгүй цаашидаа бол үргэлжлээд явах бол зайлшгүй шаардлагатай гэж бол Төв банк бол үзэж байгаа. Энэ бол арилжааны банк маань өөрөө бол ийм урт хугацааны зээлийг бол баланс дээрээ 20, 30 жилээр аваад явах боломжгүй шүү дээ. Тэгэхээр бол энэ зээлийг бол өөр нэгэн субъект үнэт цаасжуулаад авч явдаг. Одоо бол бид бүхэн бол энэ бас тогтчихсон ийм амжилттай хэрэгжээд явж байгаа ипотекийн зээлийн ийм хөтөлбөрийг хэрэгжүүлээд явж байгаа ийм зээлийн систем байгаа л гэж Төв банкнаас бол харж байгаа. Тэгээд дэлгэрэнгүй тань мэдээллүүдийг бол манай захирлууд өгөх байх.

**Г.Занданшатар:** Ган-Очир 85.

**Д.Ган-Очир:** Цогтгэрэл гишүүний асуултад тодруулъя. Яг өнөөдөр үйлчилж байгаа эрх зүйн баримт бичгээр бол 23 оноос баримтлах төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг баталсан тогтоолоор бол ЗГ-т Монголбанк шилжүүл гэдэг ийм даалгавар бол байгаа. Тэгэхээр энэ онд энэ даалгаврыг хэрэгжүүлэх ёстой. Тэгэхээр дахиж хэрвээ энэ асуудал энэ ондоо

багтахааргүй тохиолдолд бол бид бүхэл эргээд Улсын Их Хурал руугаа энэ асуудлыг танилцуулж хандана. Тэгэхээр Улсын Их Хурал бол яг энэ ЗГ луу шилжүүлэх үү үгүй юу яг эцсийн шийдвэрийг бол Улсын Их Хурал өөрөө даалгаврыгаа бол гүйцэтгэлийг нь бол шийдвэр гаргаж, Монголбанкинд өгснөөр бол энэ хөтөлбөр хэн нь цаашидаа хэрэгжүүлэх вэ гэдэг нь илүү тодорхой болох учиртай. Яг эрх зүйн баримт бичгийнхээ хувьд.

Яг ипотекийн МИК гээд ипотекийн корпорацыг Үндэсний ипотекийн корпорацаар солих гээд байгаа юм шиг бас гишүүн тайлбарлаж ойлгоод байна. Амьдрал дээр юу болоод байгаа вэ гэхээр энэ зээлийн багцыг Монголбанкн дээр байгаа балансын багцыг ЗГ луу шилжүүлэх гэхээр ЗГ хэд хэдэн аргаар авч болно. Хамгийн энгийн арга нь бол бонд гаргах юм уу, ЗГ-ын бонд гаргаад Төв банкинд өгөөд, оронд нь тэр үнэт цаасыг авах нэг хувилбар байгаа. Энэ бол өөрөө ЗГ-ын өрөнд шууд нөлөөлөх гэж байгаа. Тэгээд ЗГ-ын өрийн харилцаа харьцаа өөрөө бас тодорхой өндөр түвшинд байгаа. Энэ нь өөрөө механикаар өрийн нөхцөл байдлыг үүсгэх нь зээлжих зэрэглэл болон бусад улсын санхүүгийн харилцаанд бол сөргөөр нөлөөлж болзошгүй байгаа тохиолдолд бол үндэсний төрийн өмчит ямар нэгэн корпорац байгуулаад, тэр маань корпорац маань өөрөө үнэт цаас гаргаад, тэр үнэт цаасыг нь Монголбанкн дээр байгаа ипотекийн зээлийн үнэт цаасаар солих энэ механик ажиллагааг хийх зорилгоор Үндэсний ипотекийн корпорац гэдэг энэ нэгжийн асуудал яригдаж байгаа.

Түүнээс биш яг энэ хувийн хэвшил дээр явж байгаа Монголын ипотекийн корпорацтай хийгддэг ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаасжуулах энэ ажиллагаа бол мэдээж МИК дээрээ бол хийгдээд явах бол бололцоо нээлттэй. Мэдээж Үндэсний корпорац байгуулагдаад, энэ нь өөрөө чадавхжаад, энэ үйл ажиллагааг хийж болно гэх юм

бол тодорхой бага хувиар бол цаг хугацааны туршид бол шийдэх шилжүүлэх бололцоотой. Энэ бол мэдээж ЗГ шилжүүлж авсны хойно бол тухайн үедээ бол шийдвэрлээд явах бололцоотой. Тэгэхээр шууд хувийн секторыг орлуулах гээд байгаа биш, энэ юуг үнэт цаас шилжүүлэх процессыг л шийдэхийн тулд Үндэсний ипотекийн корпорац байгуулах ёстой болж байгаа юм гэдгийг бол тодруулж хэлье. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Төрийн өмчийн компани зөв юм уу л гээд байгаа шүү дээ. Тодруулъя Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Тэгээд яаж ч уншсан тэгээд л нэг шинэ төрийн өмчит компанийн тухай л яриа болж хувирна л даа наадах чинь. Нөгөө талаасаа тэр Монголбанкн дээр явж байгаа 4 их наядын хөтөлбөр, 4 шахам их наядын хөтөлбөр, одоо тодорхойгүй ирэх хугацаанд хаана суучихсан байгаа юм бүү мэд Ипотекийн хөтөлбөр хэрэгжүүлнэ гэсэн, ирээдүйд гарах дахиад энэ зардал мөнгө энэ бүгд чинь яг үнэндээ нуугдмал байдалтай ЗГ-ын л өр шүү дээ. Зүгээр л тэнд аваачаад нуучихсан байгаа болохоос биш энэ чинь төсөв дээр байх ёстой, төсөв дээр ЗГ-т байж төсөв дээр суух л ёстой мөнгө шүү дээ. Энийг аваачаад хойд талын кармадаа Монголбанкны дансанд бичүүлчихсэн. ЗГ-ыг өрийг бууруулчихсан, бараг шууд утгаараа төсвийн алдагдал дээр очиж суух ёстой л мөнгө шүү дээ. Тэгэхээр энэ зүгээр л тэр нэг балансын аргаар л өрөө бууруулж харагдаж байгаа нэг арга л энэний цаана явж байгаа л гэж үзэж байгаа. Тэгэхээр яг энэ дээр та нар юу гэж бодож байна вэ?

**Г.Занданшатар:** 83.

**Г.Энхтайван:** Үндэсний орон сууцын корпорац байгуулагдахтай холбоотой зохицуулалтуудыг бол ерөнхий эдийн засагч бас дэлгэрэнгүй тайлбарлая. Энэ бол яах вэ бондын өмчлөлийг шилжүүлж байгаа асуудал. Тэрнээс биш

яг үнэт цаасжуулах процесс бол МИК-ээрээ явагдана. Тэгэхдээ ер нь бол Төв банкнаас Төв банкны зүгээс бол ийм одоо явагдаж байгаа энэ ипотекийн зээлийн хөтөлбөрийн явуулж байгаа энэ систем бол бас харьцангуй боловсронгуй олон улсын жишигт нийцсэн, дэлхийн бүх л оронд явагдаж байгаа энэ систем бол гэж үзэж байгаа. Монголын ипотекийн корпорац дээр бол арилжааны банкнууд бол хувьцаа эзэмшиж байгаа. Тэгэхдээ энэ хувьцаа эзэмшигчдийн бүтцэд бол бас өөрчлөлт оруулаад явах бол боломж бол нээлттэй байгаа гэж бол Төв банкнаас бол харж байгаа.

Төв банкны баланс дээр бүртгэлтэй байгаа ипотекийн зээлийн баталгаажсан бондын хэмжээ бол 3,9 их наядын хэмжээтэй байгаа. Энэхүү бондын бондыг бол ЗГ-т бол шилжүүлэх асуудлыг бол олон улсын байгууллагууд.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Саранчимэгийн урилгаар Оюунлаг сургуулийн 10В ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Ингээд оюунлаг сурагчид, багш нартаа сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

**Ш.Адьяа:** Өнөөдөр энэ Монголын төрийн мөнгөний бодлогын асуудлыг бид Их Хурал дээр хэлэлцэж байна. Энэ мөнгөний бодлогын асуудал хэлэлцэхээр энэ Монголбанкны хүмүүсийн ярьж байгаа байдлаас харахад мухардалд орсон байдалтай л байна л даа. Мухардалд орсон. Тэгээд бид яах юм. Энэ мөнгөний бодлого гэдэг энэ асуудал чинь өнөөдөр ямар байдалтай болчихоод байгаа юм. Ялангуяа энэ зээлийн хүү бууруулах асуудал, энэ парламент байгуулагдсанаас хойш л ярьсан. Монголын банк санхүүгийн систем төр нь хэдхэн тооны арилжааны банкны барьцаанд орсон. Тэд нарын ашиг сонирхлын төлөө л үйлчилж байгаа ийм

байдалтай байна. Ард түмнийхээ эрх ашиг, бизнесийн эрүүл орчны төлөө юу ч хийхгүй байгаа гэж ингэж ойлгож байгаа. Аливаа асуудлыг гаднын хөрөнгө оруулалтыг банкны хүү бууруулах төрийн бодлогын асуудлыг ярихаар төртэйгөө нийлээд үндэсний аюулгүй байдлын асуудал гэдэг ийм ганцхан үгээр хаагаад, тэгээд өөрсдөө банк санхүүгийн системд ноёрхлоо банкны хүүгээр дамжуулж ард түмнээ мөн мөлждөг, жижиг дунд бизнесүүдийг мөлждөг энэ системийг энэ Монголын төр Монголбанк хийх чадваргүй гэж ойлгож байгаа.

Бид нар олон жил ярьсан. Энэ уул уурхайн бүтээгдэхүүнийг Монголын банкаар дамжуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж гэхээр бүрдүүлдэггүй. Тэгээд бид нар яаж өнөөдөр энэ мөнгөний бодлого, энэ банк санхүүгээ системийг эрүүлжүүлэх юм. Мөнгөний хүү бууруулья гээд энэ Улсын Их Хурлын гишүүд, улс төрчид ярихаар тоодоггүй юм байж. Иргэд чинь олон ярьж байна шүү дээ. Одоо бүүр тэр нэг Жагар гээд нөхөр байдаг. Байнгын тэмцэл хийгээд уйлаад дуулаад олон удаа ярьсан, гудамжинд ярьсан, Саарал ордонд орж ярьсан. Улсын Их Хурлын даргад ярьж байсан, Монголбанкинд. Энийг ч авч хэлэлцдэггүй. Иргэдээ тоодоггүй, улс төрчийг тоохгүй байх л даа эд нар ингээд ярьж л байдаг юм гэж. Энэ асуудал дээр бид нар ингээд байгаад байх юм уу? Бид нар хэдхэн тооны энэ арилжааны банкны ашиг сонирхол, мөнгө угаалт мэтийн энэ энэний өмнө Монголын төр Монголбанкны бодлого ингээд л байгаад байх юм уу? Хэдэн жил үргэлжлэх юм бэ?

Ялангуяа энэ уул уурхайн бүтээгдэхүүнийг Монголын банкаар дамжуулах энэ системийг яагаад өөрчилж болдоггүй юм бэ? Энэ дээр нэг хариулт авмаар байна. Бид чинь өнөөдөр ингээд тэр дэлхийг дамжсан хамгийн том үндэстэн дамжсан корпорац Рио Тинтотой Монгол Улсын эрх ашгийг хамгаалах асуудлаар хэлэлцээр хийгээд бид үр дүнд хүрсэн л гэж бодож байгаа



шүү дээ. Гэтэл энэнийг санаачлахгүй байна. Өнөөдөр Лхагвасүрэн Ерөнхийлөгч байхгүй байгаа юм байна. Энхтайван Ерөнхийлөгчийг одоо би 2 цаг гаруй сонслоо. Мөлийсөн ийм л юм ярих юм. Үнэн, төсвийн тэлэлт болж та нар бодлогоо алдаж байгаа нь үнэн. Тэгтэл энд мөнгө санхүүгийн бодлогын талаар ЗГ газраас хараат байна гэсэн юм чинь ингээд ЗГ-ынхаа барьцаанд орчихсон байна шүү дээ Монголбанк. Энэ дээр ер нь ямар бодлого барих юм бэ, үнэнээ хэлэх чадвар байна уу Монголбанкинд? Энэ төсвийн тэлэлтийн асуудлаар, хэлчихээр яах гээд байгаа юм бэ? Та нарыг ингээд ажлаас чинь авч хаях гээд байдаг юм уу аль эсхүл бодитой юмаа хэлээд явъя гэж өнөөдөр ЗГ-ынхан яриад байгаа шүү дээ. Энэ улс төрчид нь яриад байгаа шүү дээ, эрх баригчид нь яриад байгаа шүү дээ.

**Г.Занданшатар:** Түрүүн асуулт, хариултын явцад энэ чинь зөндөө л ярилаа л даа. Та байгаагүй учраас сонсоогүй юм шиг байна. Одоо ахиад хариул даа. 83 Энхтайван.

**Г.Энхтайван:** Адьшаа гишүүний асуултад хариулъя. Адьшаа гишүүн зээлийн хүү өндөр байгаа тухай асуудал хөндлөө. Зээлийн хүү энэ оны 9 дүгээр сарын байдлаар дунджаар бол ингээд 16,4 хувьтай байна. 90-ээд оны эхнээс эхлээд л Монгол Улс 2 шатлалтай банкны тогтолцоонд шилжсэнээс хойш зээлийн хүү тасралтгүй буурч байгаа. Олон жилийн турш бизнес хийж байгаа иргэд, ААН-үүд ч гэсэн энэ зээлийн хүүгийн өсөлт, бууралтын талаар бас илүү дэлгэрэнгүй мэдэж байгаа. Зээлийн хүү бол буураад явж байгаа. Гэхдээ зээлийн хүүг механикаар бууруулах, хууль батлаад эсвэл тогтоол гаргаад, эсвэл хэн нэгэн Жагартай уулзаад бол энэ хүү буурах ямар ч боломжгүй. Зээлийн хүү ямар нөхцөл буурах вэ гэхээр эдийн засгийн нөхцөл байдал сайжирч, инфляц буурч, эх үүсвэр нэмэгдсэнээр буурна.

Тэгэхээр шаардлагатай хямд өртөгтэй эх үүсвэрийг оруулж ирж,

зээлийн хүү нь зээлийн хүртээмжийг нэмэгдүүлснээр зээлийн хүү буурна. Яг энэ хүрээнд ч гэсэн Төв банк 24 онд баримтлах мөнгөний бодлогын үндсэн чиглэлээ оруулж ирж байгаа. Гадаадын банк санхүүгийн байгууллагыг оруулж ирж, урт хугацаатай санхүүжилтийг бий болгоод, гадаад эх үүсвэрээс гаралтай, эх, санхүүжилтээр томоохон төсөл хөтөлбөрүүдээ санхүүжүүлээд ирэх юм бол манай эдийн засагт байгаа эх үүсвэрийн хэмжээ нэмэгдэнэ. Үүнийг дагаад хүү буурна. Түүнээс биш шууд зүгээр захиргаадалтын аргаар хууль батлаад бол хүү буурахгүй. Тэгэхээр бол энэ дээр Монголбанк бодлого, үйл ажиллагаагаа бол нийцүүлээд явна.

Төсвийн тэлэлт бол мэдээж эдийн засагт бол ДНБ-ий 19 онд бол 30 хувьтай байсан бол, ирэх онд 37 орчим хувьтай тэнцэхээр байна гэж байгаа. Мэдээж төсвийн тэлэлт эдийн засагт нэмэгдсэнээр бол мөнгөний бодлогын орон зай хумигдаж байгаа, хумигдаж байгаа. Гэхдээ ЗГ ч тэр, Төв банк ч тэр нэгдсэн нэг л зорилготой. Монгол Улсаа хөгжүүлэх, хүн амаа сайхан амьдруулах. Тэгэхээр бол энэ нэгдсэн нэг зорилгодоо хүрэхэд бол аль алиных нь бодлого уялдаатай явагдаж байгаа гэж үзэж байгаа. Төсвийн бодлого ч гэсэн үүн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлуудаа эрэмбэлээд зайлиггүй санхүүжүүлэх ёстой бодлогуудаа оруулж ирж байгаа гэж үзэж байгаа, гэж үзэж байгаа. Их Хурал тэгэхдээ энийг бол батлаад явах байх.

Мөнгөний бодлого дээр ч гэсэн Улсын Их Хурал бол эцсийн шийдвэрийг гаргаад явдаг. Энэ дээр бол ямар, ямар чиглэл өгөх вэ гэдэг дээр бол Төв банк Улсын Их Хурал дээр гарах ажлын хэсэгтэй бол хамтраад үндсэн чиглэлээ боловсруулаад явна. Таны хэлж байгаа бол саналыг бол ойлгож байгаа. Гадаадын банк оруулж ирэх бол зайлиггүй шаардлагатай байгаа. Гадаадын банк орж ирснээр бол эдийн засагт бол либералчлах, санхүүгийн салбарын

нээлттэй байдал бол нэмэгдэнэ, эх үүсвэрийн хэмжээ нэмэгдэнэ, хүү буурах бол урьдач нөхцөл болно, төлбөрийн тэнцэл сайжирна гэх мэтчилэн маш олон эерэг үр дагаврыг бол дагуулна гэж бол Төв банк үзэж байгаа.

**Г.Занданшатар:** Тэгээд тэр гадаад орчин нөхцөл дэлхийд хүүгийн түвшин өсөж байгаа тухай асуудал, ер нь федийн ч гэсэн энэ долларын хүүгийн хани өсөж, доллар ч гэсэн өөрөө үнэгүйдэж байгаа ийм л цаг үе л дээ. Тэгэхээр хүүгийн түвшин өндөр байгаа, инфляцын түвшин өндөр байхад хүү буурах ямар ч бололцоогүй гэдгээ бол үнэн бодитой хэлэх хэрэгтэй л дээ энэ чинь. Төгрөгийнх чинь үнэ цэн шүү дээ. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Ганбат гишүүнээр тасаллаа, Баттөмөр гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Өнөө жилийн улсын төсөв бол хэт тэлэлттэй орж ирж байгаа. Тодотголоор маш их цалин, тэтгэврийн асуудлыг нэмсэн байж байгаа. Дахиад энэ жилийн 24 оны, 24 оны төсвөөр бол дахиад асар их зардал нэмэгдэхээр болж байгаа. Тэгээд энэ дээр хэчнээн мөнгө, мөнгөний хатуу бодлого явууллаа ч гэсэн бас нөгөө засгийн юу ЗГ-аас явуулж байгаа энэ хөрөнгө оруулалтын болон энэ эдийн засгийг тэлж байгаа энэ үйл явц чинь та нарын явуулж байгаа бодлоготой чинь ерөөсөө авцалдахгүй байгаад байгаа.

Тийм учраас энэ ялангуяа ЗГ нь ингээж их тэлэлт хийж байхад Монголбанк нь хатуу бодлого явуулах нь уул нь зөв л дөө. Тэгсэн мөртөө энэ чинь ерөөсөө болохгүй байгаад байна шүү дээ. Тэгэхээр энэ нь юуг илэрхийлж байна вэ гэвэл ерөөсөө хамтын ажиллагаа, Засгийн газар, Монголбанк хоёрын хамтын ажиллагаа ерөөсөө байхгүй байна гэсэн үг. Тэгээд өнөөдөр ингээд мөнгөний бодлого ороод ирж байхад нэг ширхэг ч юу сайд суухгүй байна шүү дээ.

Бүх сайд нар бүгдээрээ байхгүй. Тэгээд энэ ЗГ чинь ерөөсөө та бүхний явуулж байгаа тэр бодлоготой чинь ерөөсөө уялдаж ажиллахгүй, цаашидаа ч ажиллахгүй гэсэн ийм л бодлоготой байгаа нь эндээс харагдаж байна. Тэгэхээр энэ дараагийн хэлэлцүүлэг дээр энэ ЗГ-ын гишүүдээ суулга л даа. ЗГ-ын гишүүд чинь бүүр дэндүү айхтар их зардалтай юм байна лээ шүү дээ. Үгүй ээ юу гэнэ вэ тэр 150 хүнтэй баахан офицер, ахлагч нарыг дагуулчихсан Архангайд аймагт л нэг Батлан хамгаалахын сайд нь явж л байна шүү дээ. Ямар их зардал вэ, хэдэн сар ажиллав тэнд. Тэгээд энэ замбараагүй зардлуудыг нь ер нь танах талаар энд арай нэг жоохон гайгүй эдийн засаг мэддэг нь энэ Баттөмөр дарга сууж байна. Тэр юм хумаа хэлээч.

Их Хурлын даргаа энэ парламентын засаглалтай орон шүү дээ энэ. ЗГ чинь дээд талд, дээд талд нь гарчхаад ерөөсөө. Одоо ингээд сүүлдээ төсөв бүгдийг нь л оруулж ир, ЗГ бүгдийг нь мэдээд л оруулж ирж байгаа. Бид нар бол хөл дүнгээс нь зөрөхгүй ямар ч өөрчлөлт хийх болохгүй, нэг жоохон жоохон юуны тоог нааш цааш засах маягаар л өөрчилж байгаа. Бусад бүх хэрэг нь бүгдээрээ ЗГ дээр байж байгаа шүү дээ. Тэгээд тэр 24 оны төсвийг ЗГ өргөн барьчихсан, одоо бүх юм боллоо гээд л. Ийм байдалтай ЗГ нь парламентынхаа дээд талд гарчихсан ийм нөхцөл байдал чинь өнөөдрийн энэ хар л даа. Ардын намын 3 гишүүн сууж байна, бусад нь байхгүй. Их Хурлын даргатайгаа нийлээд 4. Хүмүүсийн кармад байгаа мөнгийг л яаж хамгаалж үлдэх вэ, яаж илүү зардал гаргахгүй байх вэ, яаж тэр кармад байгаа мөнгийг арвижуулах вэ л гэж ярьдаг энэ мөнгөний бодлого дээр чинь бүгдээрээ байхгүй, тэгээд алга болчихдог Ардын нам. Тэгээд гурилын үнийг нэг жил хагасын дотор 50 мянган төгрөг байсныг 120.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Улсын төсөв хэлэлцээгүй, энэ Мөнгөний бодлого хэлэлцэж байгаа л даа. Энэ эхний хэлэлцэх

эсэх, санал асуулт ч байхгүй энэ дээр. Асуулт, хариулт явж байгаа юм чинь. Тэгээд тэрнийгээ ярь л даа. Тэгээд шал өөр юм яриад л, төсөв л ярьсаар байгаад байх юм. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

**Ш.Адьяа:** Түрүүн бас нэмэлт хариулт авъя гэсэн амжсангүй. Тэгэхээр Энхтайван ерөнхийлөгчийн энэ банкны хүү буурч, буурсан сүүлийн жилүүдэд гэдэг энэ асуудалтай санал нийлэхгүй байна. Энэ та нарын цаасан дээр бичээд, төрийн эрх барих дээд байгууллагадаа худал мэдээлэл өгч байгаагийн анхны энэ баримт гэж би ойлгож байгаа шүү. 2 жил, 4 жилийн өмнө 2 мянган төгрөгөөр худалдаж авдаг юмаа бид 20 мянган төгрөгөөр авч байгаа шүү дээ бараа, хүнсний зүйлээ. Америк доллар 4 жилийн өмнө 2500 байсан одоо 3500 болсон. Тэгээд энийгээ энэ хүү буураад, инфляц буураад байгаа ийм ойлголт байж болох юм уу?

Дээр нь би удаа дараа хэлж байгаа юм. Энэ Монгол Улсаас гарч байгаа ашигт малтмалын бүтээгдэхүүний төлбөр цаасан дээр явагддаг. Оюу толгойн төлбөр гэрээ л явагддаг болохоос биш Монголын банк санхүүгийн байгууллагаар нэг ч удаа тийм валют орж ирдэггүй. Энэ дээр арга хэмжээ авъя гэхээр Монголбанк ямар нэгэн байр суурь илэрхийлдэггүй. Энэ 4 жилийн хугацаанд. Энд бол хоёрхон байгууллага байдаг юм шиг байгаа юм. Тэр муу сайн нэртэй тэр Мон-Эко мөнгөө оруулж ирдэг. Дээр нь тэр бас нэг уул уурхайн компани байсан. Би судалгааг нь. Бусад нь тэгээд л ерөөсөө цаасан дээр явж байна шүү дээ. Тэгээд энэний энэ асуудлаа яагаад шийдэж болдоггүй юм. Би түрүүн ярьсан. Оюу толгойд Монгол Улсын эрх ашгийг энэ Улсын Их Хурал, ЗГ хамтарч хэлэлцээр хийж шийдсэн шүү дээ. Тэгтэл энэ төлбөрийн асуудлыг яагаад Монголбанк банк санхүүгийн байгууллагаар явуулж болдоггүй юм бэ? Энэ дээр яагаад гэрээ хэлэлцээр хийж болдоггүй юм бэ? Хэдхэн

банкныхаа энэ барьцаанд орсон асуудлаа яагаад ярьж болдоггүй юм бэ.

Үндэсний аюулгүй байдлын асуудал гэдэг нэрийн доор Монголын хэдхэн арилжааны банкнууд энэ Монгол Улсын банк санхүүгийн системийг өөрсдийнхөө ашиг олох хэрэгсэл болгоод байна гэж ярьж байгаа. Энэ улс төрчийн байр суурь биш, бодит амьдрал шүү. Банкны хүү буурч байна гэж байгаа, буураагүй, буурсан юм бол тэр бараа бүтээгдэхүүний үнэ яагаад нисээд нэмэгдээд байдаг юм, валютын хани яагаад өсөөд байдаг юм. Ийм байхад чинь буурч байна гэдэг асуудалтай санал нийлэхгүй байна, санал нийлэхгүй байна. Тийм учраас энд энэ нэн ялангуяа энэ гаднын орнуудад зарж байгаа ашигт малтмалынхаа түүхий эдийн үнэ ханшийг Монгол Улсын банк санхүүгийн байгууллагаар дамжуулах асуудал, гаднын банк орж ирэхгүй байна гэж байгаа юм. Орж ирэх нөхцөлийг нь бүрдүүлэхгүй байгаа шүү дээ.

Үндэсний аюулгүй байдал гэдэг нэр нэрийн доор оруулж ирнэ гэж цаасан дээр сайхан яриад та нар хууль батлаад юу ч чадахгүй, үр дүнгүй байх гэж ингээд яриад сууж байдаг. Хууль, эрх зүйн орчин хөрөнгө оруулалтын орчныг бид шийдэж таатай нөхцөл бүрдүүлэхгүйгээр яаж гаднынхан орж ирэх юм бэ. Үнэн шүү дээ. Тэр ганц үнэн миний хэлж байна. Тэгэхээр энэ тамын тогооны энэ банк санхүүгийн энэ барьцаанаас гарах ийм шийдлийг төртэйгөө хамтарч, энэ Монголбанк мөнгөний бодлого барьдаг энэ банк төрийн байгууллага шийдэх хэрэгтэй юм байна. Өнөөдөр ингээд л нэг энд нэг мөнгөний бодлого яриад л, хэдэн асуултад хариулаад л, тэгээд л энэнийгээ нэг худлаа батлаад ингэж явах хэдэн жил энэ үргэлжлэх юм бэ гэдэг дээр бид хаана хаанаа бодох шаардлагатай юм байна л гэж ийм байр суурьтай байна.

**Г.Занданшатар:** Дашдондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Бид нар мөнгөний бодлогын талаарх та бүхнээс бараг 2, 3 цаг асуулаа гишүүд.../үг тасрав/

**Г.Занданшатар:** Гишүүдийг дуудаарай.

**Д.Ганбат:** Та бүхэн ч чадлаараа л хариулж байх шиг байна. Тэгээд 1 юм байна. Юу гэхээр Монголбанк чинь Улсын Их Хурлын харьяа Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог, Үндсэн хуулиараа бусад хуулиараа хараат бус ажиллах ийм л байгууллага шүү дээ. Гэтэл одоо ямар байна. Мөнгөний бодлого яах гэж Улсын Их Хурлаар энэ төсвөөс тусдаа орж ирж хэлэлцэх гэж байгаа юм. Энэ тэлж байгаа, энэ болохгүй бүтэхгүй байгаа энэ нэг намын бараг элий балай амласан энэ Монгол Улсын эдийн засгийг унагааж байгаа энэ юмыг та нар хязгаарлах ёстой шүү дээ. Энэ, энэ болохгүй байна, ийм ийм учраас Монгол Улсын эдийн засаг ийм байна гэж та нар ярьж байх ёстой шүү дээ. Та нар бол мэргэжилтнүүд байхгүй юу. Тэрнээс биш ямар нэг МАН-ын удирдах зөвлөлд тайлангаа тавьж байгаа МАН-ын кассын машин биш шүү дээ.

Юу гэнэ вэ Монгол Улсын хөгжил үзэцгээлтийн төлөө сайн сайхан амьдралын төлөө ч гэх шиг. Үгүй ээ мэргэжилтнүүд ийм юм ярьдаг юм уу. Ийм л юм яриад сууж байна шүү дээ. Болохгүй байхгүй юу. Яагаад гаднын банк орж ирэхгүй байна, яагаад энэ арилжааны банкнууд чинь өсөж томорч, хөгжиж, бага хүүтэй зээл бизнес эрхлэгчид олохгүй байна. Хувийн хэвшил өнөөдөр үүд хаалгаа өдөр болгон барьж байна шүү дээ. Монголын ард түмний амьдрал өнөөдөр тэсэхүйеэ бэрх байна шүү дээ. Тэр авч байгаа цалингаараа худалдаж авч байгаа юм нь бол өдрөөс өдөрт л багасаад байна шүү дээ. Тэр хадгалуулсан мөнгө төгрөг нь бол юу ч биш болж байна шүү дээ.

Тэр Оюутолгой, гаднын банкнууд итгэж мөнгөө байршуулахгүй байна шүү

дээ. Энэ дээр та нар дүгнэлт хийгээд, яах вэ нөгөө Монголбанкны Ерөнхийлөгч нь эрх биш мэргэжлийн хүн болохоороо л энэ юманд нэг хариулаад байдаг л даа. Цаагуураа нэг энэ ЗГ чинь болохгүй байна шүү, энэ эрх баригч чинь болохгүй байна шүү, эд нарын тэр ярьж байгаа, хэлж байгаа нь буруу шүү гэдгийг хэлээд байдаг байхгүй юу. Гэтэл та нарын өнөөдрийн энэ хариулт чинь бол үндсэндээ нэг ЗГ-ын нэг уйтгартай МАН-ынхны ярьдаг нэг уриа, амлалт нэг тиймэрхүү л юм яриад байна. Яахаараа ийм болчихдог юм залуучууд. Та нар чинь цалин цав муутай юм уу, багатай юм уу. Тийм л байх л даа. Тэгээд ийм байдалтай ажиллаж байдаг.

Та бүхний Монголбанкны үүрэг бол 1 дүгээрт бол Монгол мөнгө бол мөнгө шиг байх ёстой шүү дээ. Өнөөдрийн хүний авч байгаа цалин нь бол баталгаатай, өөрийнх нь амьдрал ахуй тэр бүх юманд үйлчилдэг ийм л байх ёстой. Тэр МИК гээд зөв шүү дээ. Дотоодын банкнууд нийлээд л юм хийж байсан. Тэрийг нь дэмжиж ажиллахын оронд унагаад хаяж байна шүү дээ та нар бол. Ийм л юм явагдаж байна шүү дээ ерөөсөө.

Энэ Ганбат гишүүн дандаа шүүмжилж байдаг энэ тэр гэж ярих байх. Үгүй ээ би та нарт зөндөө л тус болж байсан. Тэр нийгэм тэр чигээрээ эсрэг байхад би алтны хувийн татварыг 2,5 болгосон шүү дээ. Тэрнээс хойш Монголбанкинд жил болгон 20 тонн алт цуглардаг болсон. Монголбанкинд тушаавал 2,5, бусад газраар явбал 10 хувь гэсэн. Үгүй ээ энэ эдийн засгийн бодлогоо ингэж хийдэг байхгүй юу. Тухайн үедээ юу билээ Монголбанкны тэргүүний ажилтан гээд л надад цол тэмдэг өгөөд л байж байсан. Тэгээд ийм ажлуудыг би хийж байсан шүү. Өнөөдөр та нар чинь юу яриад байна вэ.

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Сүүлийн хэдэн жил энэ мөнгөний бодлого батлахад оролцож



байна. Ингээд харахаар нэг тогтчихсон нэг тийм л юм л орж ирэх юм л даа. Нэг ном орж ирдэг. Тэрний гол санаа нь бол юу гэхээр нэг инфляцыг нэг тэдэн хувь тогтворжуулна. Тэгээд нэг лоозонгийн шинж чанартай хэдэн зүйл хууль бичсэн ийм л харагдаад байгаа юм. Уг нь Монголын энэ санхүүгийн зах зээлийг бол бүхэлд нь их том хармаар байгаа юм. Мөнгөний бодлогоор. Энд би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр энэ яг өнөөдөр бол Монголын хамгийн эдийн засгийн хамгийн гэрэлтэй цэг бол энэ хөрөнгийн зах байгаа. Маши сайн хөгжиж, хөгжих ийм нөхцөл бүрдээд байна л даа одоо. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ бол их өндөр болчихсон байгаа шүү дээ тийм ээ. Зөвхөн арилжаалагдсан үнэт цаасны ширхгээр гэхэд л 3,5 дахин өссөн байгаа юм. Тэгээд энэ танай мөнгөний бодлого дээр ингээд л харахаар энд юм харагдахгүй л байгаа юм л даа. Хөгжингүй энэ эдийн засагтай орнуудад чинь эдийн засгийнх нь 30 хувь энэ тэр гэж ярьдаг шүү дээ. Зах хөрөнгийн захын хэмжээ нь.

Дараагийн нэг салбар бол энэ даатгалын салбар байгаа. Монголын эдийн засагт чухал ач холбогдолтой. Энэ даатгалын салбарыг мөнгөний бодлогыг яаж дэмжих юм. Бас юм харагдаж өгөхгүй байгаа.

Төсвийн бодлого мөнгөний бодлогын хоорондын уялдаа ямар байх юм. Ингээд, ингээд юмнууд л харагдахгүй л байгаа юм л даа. Сая тэр Ган-Очир бол маш зөв тоо хэлж байна л даа. 23 их наяд төгрөгөөс дээш бол 1 их наяд тутамд 1 хувийн инфляц дагалдана гэж, санал нэг байна. Та бүгдийн тооцож байгаа 7 хувийн инфляц дээр 27 гэдэг чинь 4 хувийг нь инфляц, ингээд 11 юм уу, 12 хувийн инфляц ирэх жил бий болж магадгүй юм байна. Тэгээд дээрээс нь энэ жил тэр ипотекийн зээлийг авахгүй гэж байгаа бол тэгээд нэмэгдээд наадах чинь 12, 13 руугаа явах ийм л дүр зураг л харагдаад байна л даа.

Тэгээд сая тэр түрүүчийн Эдийн засгийн байнгын хороон дээр хэд хэдэн юман дээр би хариулт олигтой аваагүй. Энэ алтны хэмжээ. Та нар 20, 22 тонн алт авна гэдэг. Оюу толгойн баяжмал дахь алтны хэмжээ чинь дахин, дахин нэмэгдэж байгаа шүү нөхдөө. 5,5 тонныг авдаг 300 сая орчим долларын алт авдаг гээд тэгж байгаа юм. Тэр хэмжээндээ байгаа гэж Лхагвасүрэн Ерөнхийлөгч нэг хэлчих шиг болдог юм. Энэ Оюу толгойн тэр дараагийн хурал дээр тэр тоогоо сайн мэдэж ирээрэй, би асуугаадахъя асууна.

Дараагийн асуудал энэ дээр нэг яригдах юм бол юу гэх юм чанаргүй зээлийн хэмжээ ерөөсөө буурахгүй байгаа. Танай мөнгөний нийлүүлэлт чинь 32,6 их наяд төгрөг. Тэгээд энэнээс чанаргүй зээл уул нь анхаарал хандуулах нь 3,6 их наяд. Ингээд 12, 13 их наяд төгрөг ингээд байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь бол энэ банкны системд бол муугаар л нөлөөлнө л дөө. Хадгаламжийн хэмжээ, валютын хадгаламж, төгрөгийн хадгаламж хоёулаа өссөн. Нэг нь 13, нэг нь 12 хувиар өссөн эхний 8 сараар явж байна л даа. Тэгээд олгосон зээлийн үлдэгдэл нь 25,8 их наяд төгрөг гээд. Бас нэг ингээд нэг хэмжээндээ яваад л байна.

Энд нэг ноцтой юм бол юу гэхээр Монгол Улсын гадаад өрийн хэмжээ 792 сая доллароор нэмэгдчихсэн явж байгаа. Энэ юунаас болж нэмэгдэв. Энэ дээр бас юм алга байна. Энэ Санхүүгийн мэдээллийн алба гэж байгууллага байдаг. Батбаатар дарга энд ирчихсэн сууж байх шиг байна. Ипотекийн юу, энэ мөнгө угаах терроризмын нөгөө 40 зөвлөмжийг дэлхийн түвшинд хүргэчихсэн гэж байгаа юм. Терроризм дээрээ бол тийм байдаг байж. Мөнгө угаалт гэдэг чинь юу гэхээр хууль бус мөнгийг хууль ёсны эргэлтэд оруулахыг мөнгө угаах гэнэ гэж эдийн засгийн шинжлэх ухаанд ярьдаг юм. Монголд бол далд эдийн засаг энэ мөнгө угаах 2 бол замбараагүй их байгаа. Тэгээд яаж энийгээ тооцдог юм байгаа юм.

Тэгээд энэ дараа дараагийн юун дээр энийгээ тайлбарлана.../минут дуусав/

**Г.Занданиатар:** Гишүүд үг хэлж дууслаа. Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ. Эдийн засгийн байнгын хороо нухацтай авч үзэх хэрэгтэй.

15.20 цаг

### **Гурав. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах**

Дараагийн асуудалд орно. Улсын дээд шүүхэд, Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах асуудлыг хэлэлцэнэ. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах асуудлыг хэлэлцэнэ. Нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг ШЕЗ-ийн дарга Ренчиндоржийн Онончимэг танилцуулна. Индэрт урьж байна.

**Р.Онончимэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт ШЕЗ-өөс Улсын Дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно гэж, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулснаар томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ гэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийн 104 дүгээр зүйлийн 104.2 дахь хэсэгт нэр дэвшигчийг ШЕЗ-ийн дарга ХЗБХ-ны болон нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж тус тус заасан. Үүний дагуу Улсын дээд шүүхийн шүүгчийн Иргэний хэргийн танхимын шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад 1 дүгээрт эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Намсрайн Батзоригийн Батзоригийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Нэг.Товч намтар. Намсрайн Батзориг 1975 онд Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд төрсөн, 48 настай, эрэгтэй, ам бүл 5. 1992 онд Хэнтий аймгийн 1 дүгээр 10 жилийн бүрэн дунд сургууль, 1993-аас 94 онд Дотоодын цэргийн 805 дугаар ангид хороонд байлдагч, 1995-1999 онд Шихихутаг Хууль зүйн дээд сургууль эрх зүйч бакалавр, 2016-2018 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль хууль зүйн ухааны магистрын зэргийг тус тус хамгаалсан. Эрх зүйч мэргэжилтэй. Тэрээр 1992-оос 93 онд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын ерөнхий боловсролын сургуульд биеийн тамирын багш, 1999-өөс 2005 онд Багануур дүүргийн шүүхийн Тамгын хэлтсийн төлөөлөгч, 2005-аас 2007 онд Улсын Дээд шүүхэд Танхимын тэргүүний туслах, 2007-гоос 2012 онд Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, 2012-оос 2013 онд Орхон аймгийн давж заалдах шатын шүүхийн шүүгч, 2013-аас 2015 онд Нийслэлийн Шүүх, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын 10 дугаар шүүхийн шүүгч, 2015 оноос Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгчээр ажиллаж байна. Нэр дэвшигч Батзориг нь 2023 оны 10 сарын 2-ны өдрийн байдлаар төрийн албанд 26 жил, шүүгчээр 16 жил 4 сар, үүнээс давж заалдах шатын шүүхийн шүүгчээр 11 жил 7 сар ажиллаж байна.

Хоёр.Хуульд заасан шалгуур хангасан байдал. Батзориг нь Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 3 хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан хяналтын шатны шүүхийн шүүгчид тавих болзол шаардлагыг дараах байдлаар хангаж байна. 1.Хууль зүйн дээд боловсролтой байх. Нэр дэвшигч Батзориг нь 1995-аас 1999 онд Шихихутаг Хууль зүйн дээд сургуульд эрх зүйч бакалавр, 2016-аас 2018 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан. 2.35 нас хүрсэн Монгол Улсын иргэн байх. Нэр дэвшигч Батзориг нь 1975 оны 5 сарын 9 төрсний өдөр төрсөн 48 настай, Монгол Улсын иргэн. 3.Эрүүгийн

хариуцлага хүлээж байгаагүй байх. Нэр дэвшигч Батзориг нь гэмт хэрэг зөрчилд холбогдон шалгагдаж байгаагүй тухай ЦЕГ-ын холбогдох албаны 2023 оны 5 сарын 2-ны өдрийн 13Б/14 03 дугаар албан бичиг мөн эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тухай *Emongolia.mn* цахим мэдээллийн сангийн 2023 оны 4 сарын 24-ний өдрийн лавлагаагаар тус тус тодорхойлогдоно. 4.Шүүгчид нэр дэвшигчээр, нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй байх. Батзориг нь шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй тухай Монгол УЕПГ-ын 2023 оны 6 сарын 7-ны өдрийн 4/49 59 дүгээр албан бичгээр лавлагаа ирүүлсэн. 5.Шүүгчээр ажиллахад хариллах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий байгууллагын мэргэшсэн эмчилгээ магадлаатай байх. Нэр дэвшигч Батзоригийг эрүүл мэнд, сэтгэцийн талаар холбогдох эрүүл мэндийн байгууллагын 2023 оны 3 сарын 30-ны өдрийн дүгнэлтээр эрүүл, тэнцэнэ гэж дүгнэсэн.

6.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх. Нэр дэвшигч Батзориг нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй. Монголын Хуульчдын холбооноос 2014 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн 18 16 дугаартай гэрчилгээг шинэчлэн олгосон. Нэр дэвшигчийн хуульчийн гэрчилгээг хүчинтэй тухай Монголын Хуульчдын Холбооны 2023 оны 5 сарын 3-ны өдрийн 2/441 дүгээр албан бичгээр лавлагаа ирүүлсэн. 7.Шүүгчээр ажиллах мэдлэг, чадвар, ёс зүйтэй байх. Нэр дэвшигч Батзориг нь хууль зүйн мэдлэг чадварын шалгалтад 53,03 оноо, мэргэшил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад 26,53 оноо авч хяналтын шатын шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн. 8.Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх. Нэр дэвшигч Батзориг нь шүүгчээр нийт 16 жил 4 сар, 2007 оноос 2012 онд Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, 2012-оос 2013 онд

Орхон аймгийн давж заалдах шатын шүүхийн шүүгч, 2013-аас 2015 онд Нийслэлийн шүүх, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын 10 дугаар шүүхийн шүүгч, 2015 оноос Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгчээр тус тус ажилласан туршилагатай.

9.Сүүлийн 6 жил улс төрийн болон улс төрийн намын удирдах албанд тушаал эрхэлж байгаагүй байх. Нэр дэвшигч Батзориг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 6 сарын 30-ны өдрийн 111 дүгээр зарлигаар Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгчээр албан тушаалд томилогдож, өнөөдрийг хүртэл ажиллаж байгаа тул сүүлийн 6 жилийн хугацаанд аливаа улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй гэж үзнэ. 10.Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн 2/3-оос доошгүйн доошгүй нь шүүгч байх шалгуур. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2/3-оос доошгүй нь энэ хуулийн 31.4.1-д заасан шүүгч байна гэж заасан. Одоогоор Улсын дээд шүүхэд 23 шүүгч ажиллаж байгаагаас 16 шүүгч, 7 нь прокурор, өмгөөлөл, өмгөөлөгч, магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их, дээд сургуулийн багш буюу бусад хуульчдын төлөөлөгч ажиллаж байна. Нэр дэвшигч Батзориг нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан тул дээрх шаардлагыг хангаж байна.

Гурав.Сонгон шалгаруулалтад тэнцсэн байдал. Нэр дэвшигч Батзориг нь Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9 дэх хэсэг, ШЕЗ-ийн 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 300 дугаар тогтоолд заасны дагуу хүчинтэй байгаа 79,56 үнэлгээгээр 1 дүгээрт эрэмбэлэгдсэнийг ШЕЗ-ийн 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 173 дугаар тогтоолоор баталсан.

*Дөрөв.ШЕЗ-ийн санал. ШЕЗ-ийн 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор шийдвэрлэсний дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийг баримтлан Монгол Улсын дээд шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад 1 дүгээрт эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Намсрайн Батзоригийг Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчээр томилуулах саналыг Монгол Улсын Их Хуралд танилцуулж байна. Баярлалаа.*

**Г.Занданшатар:** ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

*ШЕЗ-өөс 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Улсын Дээд шүүхийн шүүгчид Намсрайн Батзоригийг нэр дэвшүүлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд танилцуулахаар ирүүлсэн билээ.*

*Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт ШЕЗ-өөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт Улсын Их Хурал Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 104 дүгээр зүйлд заасан журмын дагуу танилцана гэж заасны дагуу ХЗБХ 2023 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцсэн бөгөөд Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг ШЕЗ-ийн дарга Онончимэг танилцуулсан болно.*

*Дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан ШЕЗ*

*шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах талаар ямар арга хэмжээ авч ажиллаж буй талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Улсын дээд шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтын үйл явц, тухайн нэр дэвшигч шүүгчид тавигдах болзол шаардлагыг хангаж буй эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир ШЕЗ-өөс бүх шатны шүүхийн шүүгчийн сул орон тоог нөхөх, ажиллах орчин нөхцөл, шүүх, шүүгчийн эдийн засгийн баталгааны талаар баримталж буй бодлогын талаар, Монгол Улсын Их Хурлаар 2021 онд батлагдсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг нэг мөр хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.*

*Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Шүүх байгуулах тухай хуулийн төслийг боловсруулахдаа хүн ам, газар нутаг, шүүгчийн ажлын ачааллыг харгалзан тойргийн шүүх байгуулж болох үндэслэл журмыг нарийвчлан тогтоох талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр ШЕЗ болон Сахилгын хорооны шүүгч гишүүнээр сонгогдсон шүүгчийн сул орон тоог нөхөх асуудалд анхаарч, Улсын Дээд шүүх бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байгаа талаар саналаа илэрхийлсэн болно.*

*Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,*

*Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Намсрайн Батзоригийг Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монголын Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасны дагуу ХЗБХ болон нэгдсэн хуралдаанд танилцуулж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа. Танилцуулгыг нь хийх шаардлагагүй байх тийм ээ.*

**Г.Занданшатар:** Энэ танилцах л ажиллагаа шүү дээ ердөө. Санал хураалт



байхгүй. ШЕЗ-ийн дарга болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

**Ш.Адьшаа:** Нэр дэвшигчээс ганц, хоёр асуулт асууя. Энэ Монгол Улсын Дээд шүүхэд нэр дэвшиж байгаа Намсрайн Батзоригийн тухайд бол Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан бүх шалгуур үзүүлэлтийг хангасан ийм нэр дэвшигч байна гэж ойлгож байгаа. Тийм учраас энэ нэр дэвшигчийн намтар болон бусад зүйлээс асуух юм байхгүй байх.

Монгол Улсын шүүхийн тухай хууль бид батлаад бас 2, 3 жилийн нүүрийг үзэж байна. 19 оны Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтөөр шүүх бие даасан байх, шүүх хараат бус байх тухай том хууль, эрх зүйн өөрчлөлт хийж, Үндсэн хуульд Монгол Улсын Шүүхийн сахилгын хороо, Монгол Улсын ШЕЗ гэдэг ийм 2 Үндсэн хуулийн бүтцийн байгууллагыг бид байгуулсан. Энэ Үндсэн хуулийн бүтцийн энэ байгууллагад ажиллах шүүгчдийн төлөөллийг нийт шүүгчдийн зөвлөгөөнөөс сонгууль явуулж томилдог ийм тогтолцоогоор бид явж байна. Миний үзэж байгаагаар энэ тогтолцоо маань бас тийм үр дүнгүй байх ийм магадлалтай гэж харж байгаа. Шүүх эрх мэдэл дотроо өөрсдийнхөө сахилга хариуцлагын асуудлыг, боловсон хүчний асуудлыг шийддэг ийм Үндсэн хуулийн бүтцийн байгууллагыг сонгуулиар явуулж байгаа энэ тогтолцоо хэр оновчтой байна вэ? Дунд шатын шүүх дээр бас л энэ сонгууль явагддаг, лобби үүсдэг. Хэн нэгнийхээ дэмждэг, тэгээд гарч ирсэн тэр ерөнхий шүүгч нь тэрний барьцаанд байдаг. Ийм барьцаалагдсан ийм систем бий болсон байж болзошгүй гэсэн ийм байр суурьтай байгаа.

Дээр нь бол энэ Монгол Улсын энэ Үндсэн хуулийн бүтцийн байгууллага болох дээрх 2 байгууллагын шүүгч бус гишүүнийг томилж байгаа энэ Шүүхийн

тухай хууль шүүх бие даасан, шүүх хараат бус байх энэ зарчимд нийцэж байгаа юу нийцэхгүй байгаа юу гэсэн ийм асуултыг танд тавьж байна. Энийг та хариулж өгөх хэрэгтэй. Мөн энэ асуултыг би ШЕЗ-ийн даргад бас тавьж байна. Энэ 2 хүнээс энэ асуултыг асууж, хариулт авъя.

**Г.Занданшатар:** ШЕЗ-ийн дарга Номинчимэг, Онончимэг, Ренчиндоржийн Онончимэг 82, 81.

**Р.Онончимэг:** Адьшаа гишүүний асуултад хариулъя. ШЕЗ болон Сахилгын хорооны ба шүүгч бус гишүүнийг парламентаас нээлттэй томилгоогоор сонгож байгаа явдал нь бие даасан хараат бус байдалд нөлөөлж байна уу гэсэн ийм асуулт тавилаа гэж ойлголоо. Тэгэхээр ер нь бол би өөрөө бас яг шүүгч бус гишүүний төлөөлөл болж ШЕЗ-д томилогдсон. Хамгийн одоо 2021 онд батлагдсан хуулиар хамгийн сайн хувилбар нь энэ байх боломжтой юм л гэж үзэж байна. Шүүгч нар дундаас ШЕЗ-ийн гишүүдийг сонгож байгаа. Тэгэхээр шүүхийн захиргааны дээд байгууллагын төлөөллийг шүүгч нар дундаасаа олонхын саналаар сонгоно гэдэг бол илүү тийм оновчтой хувилбар гэж миний хувьд ойлгож байгаа. Харин зүгээр нийт шүүгчдийн зөвлөгөөнөөр ерөнхий шүүгчээ томилдог эд нар асуудал дээр бол яг тухайн шүүгч нар нь бас өөрсдийнхөө саналыг хэлсэн нь зүйтэй байх гэж бодож байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Адьшаа гишүүнээ ойлгов уу? Хамгийн сайн хувилбар гээд байхад та шүүмжлээд л яваад байгаа юм. Балжиннямьн Баярсайхан гишүүн. Нэр дэвшигч, нэр дэвшигч 83, нэр дэвшигч Батзориг.

**Н.Батзориг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Адьшаа гишүүний асуултад хариулъя. Шинэчлэн батлагдсан Шүүхийн тухай хууль хэрэгжээд 2 жил орчим болж байна. Шинэ хуулийг бол хэрэгжилтэд

шүүмжлэлтэй хандах гэхээсээ илүү хууль хэрэглээний ийм зөв практик тогтоох нь илүү ач холбогдолтой гэж үзэж байгаа. Шүүгч нар ч гэсэн энэ талаар бол сая нийт шүүгчдийн чуулганаа хийсэн. Энэ дээр бол тодорхой саналууд гаргаад, санал хураалтууд явагдсан. Шинэ Шүүхийн тухай хуулийн холбогдох заалтууд дээр бас хэлэлцсэн. Саналаа Улсын дээд шүүхээр уламжлан хууль тогтоох байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэсэн байгаа. Тэгэхээр энэ сонгуулийн зарчмаар ШЕЗ, Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг шүүгчид дотроосоо сонгоно гэдэг бол өөрөө шүүхэд бол дотоод ардчиллыг бичүүлэх, өөрөө удирдах, ёсыг хөгжүүлэхэд бол дэвшилттэй ийм зохицуулалт болсон гэж үзэж байгаа. Энэ цаашидаа бол улам төгөлдөржүүлээд ингээд явах ийм боломжтой юм болов уу гэсэн ийм байр суурьтай байна.

Шүүгч бус гишүүнийг ШЕЗ-ийн гишүүнээр томилох энэ шинэ хуулийн зохицуулалт өөрөө асуудал дагуулж байна уу гэсэн ийм асуулт байна. Энэ дээр бол олон улсын чиг хандлага, манай шүүхийн тогтолцоо хэрэгжиж ирсэн энэ түүхэн энэ замналаас харахад улс төрийн байгууллага бусад төлөөллийг бол ШЕЗ-д оруулж энэ тодорхойлох нь өөрөө олон улсын чиг хандлагад бас нийцэж байгаа юм байна лээ гэж л хариулъя даа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Азербайжаны тунхаг гэж байгаа шүүхийн. Балжиннямын Баярсайхан гишүүн. Бакугийн тунхаг.

**Б.Баярсайхан:** Монгол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгчид нэр дэвшигч ажил мэргэжлийн хувьд бол мэргэжлийн ийм хүн дээд шатынхаа шүүхийн байгууллагад нэр дэвшиж байна гэж харж байна. Миний хувьд бол бас ШЕЗ-ийн дарга хамт орж ирсэн учраас та бүхнээс 3 асуулт асууя.

1 дүгээр асуулт энэ Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газраар дамжин хоригдож байгаа хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн этгээдүүд хүмүүжиж чадаж байна уу? Энэ хүмүүсийг соён гэгээрүүлж чадаж байна уу? Би яагаад ингэж асууж байна гэхээр яагаад 15 жил, 12 жил хорих ял эдэлсэн хүн гарч ирээд бага насны хүүхдийг, хүүхдийг хүчирхийлэх үйлдлээ дахин дахин давтан хийдэг юм бэ? Энэ татвар төлөгчдийн мөнгөөр хорих газар хоригдож байгаа гэж үзэж байгаа. Тэгээд энэ хүмүүжүүлэх ажил хэр явдаг юм бэ гэдэг дээр хариулт өгнө үү?

2 дугаарт энэ хүүхэд хүчирхийллийн эрүүгийн гэмт хэрэг хийсэн хүмүүсийг яагаад магадлангаар оруулж ирж ялыг нь ингэж багасгаад байдаг юм бэ? Яагаад хугацаанаас нь өмнө сулладаг юм бэ? Энэ хүүхдийг хүчирхийлсэн этгээдэд магадлангаар оруулахгүй байх ийм боломжтой юу? Энэ та Дээд шүүхийн шүүгч бол мөн ШЕЗ энд асуудал дээр онцгой анхаарал хандуулж, энэ анхныхаа хэрэг дээр удаан хугацаанд ялын бодлого нь чанга ял авсан мөртөө хэдхэн жил хоригдоод л магадлан гэдэг юмаар ороод ингээд гараад ирж байна. Энэ хуулийн цоорхой, энэ үйлдлийг яах вэ? Энэ дээр та бүхэн ямар нэгэн шийдвэр хийж байгаа, хийх гэж байгаа ажил байна уу? Энэ дээр хариулаач.

3 дугаарт нь энэ гэр бүл салсан эцэг, эхчүүдийн тэтгэмж ерөөсөө олгогдохгүй байгаа. Өнөөдөр Монгол Улсад өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо маш өндөр байна. Тэгвэл та бүхэн шүүхээр орж гэр бүл цуцлуулж байгаа энэ тохиолдолд хэдэн хувьтай энэ хүүхдийн тэтгэмжийг олгуулж чадаж байгаа юм бэ, хэлэх тоо баримт байна уу? Та бүхний гаргасан шийдвэрийг хэдэн эцэг, эхчүүд биелүүлж байгаа юм бэ? Яагаад өнөөдөр дундаасаа хүүхэдтэй болчихоод тухайн хүүхдийг насанд хүртэл хариуцлага хүлээхгүй байгаа юм бэ? Яагаад та бүхний энэ гаргасан шүүхийн шийдвэр амьдрал дээр биелэхгүй байгаа юм бэ? Энэ

3 асуултад хариулт авъя. Тэгээд шаардлагатай бол тодруулж асууя. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хэн хариулах вэ? Асуулт, хариулт явж байгаа. Ренчиндоржийн Онончимэг ШЕЗ-ийн дарга хариулна. Үг, асуулт хамт явж байгаа энэ чинь танилцах ажиллагаа.

**Р.Онончимэг:** Баярсайхан гишүүний асуултад хариулъя. 3 асуулт маань гурвуулаа яг ШЕЗ-ийн бүрэн эрхийн асуудал биш байна. ШЕЗ бол шүүгчийн бие даасан хараат бус байдлыг хангах, хуульчаас шүүгчийг шилж олох ийм чиг үүрэгтэй байгаа. Тэгээд ер нь бол хууль, эрх зүйн шинэчлэл явагдаж байгаа энэ хүрээнд иргэний шийдвэр гүйцэтгэлийг шүүхийн бүрэлдэхүүнд оруулж ирнэ гэсэн ийм эрх зүйн зохицуулалтын хүрээнд бас гишүүнийг асуулаа гэж би ойлголоо. Тэгэхээр энэ хуулийн төсөлд санал авах үед нь бол манай байгууллага байр сууриа илэрхийлж оролцоно. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Тийм, Их Хурлаар аливаа хэрэг маргааныг авч хэлэлцэхгүй. Үндсэн хуулиар. Ер нь ШЕЗ бол шүүгчийг шилж сонгох, шүүхийн хараат бус байдал яг хангах ийм үүрэгтэй байгууллага. Нэр дэвшигч хариулах уу? Нэр дэвшигч 83.

**Н.Батзориг:** ШШГЕГ хоригдож байгаа насанд хүрээгүй үгүй ээ, хүүхдийн эсрэг гэмт хэрэг хийсэн этгээдийн засрал хүмүүжлийн байдлын талаар асууж байгаа. Энэ бол яг хамааралтай асуудал гэж үзэхэд бол учир дутагдалтай харагдаж байна. Ер нь бол яг хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд магадлангаар оруулахгүй байх гэдэг асуудал бол хуульд бол тодорхой зохицуулалт бол байхгүй байх. Тодорхой энэ гэмт хэргийн ангиллаасаа хамаараад тодорхой хувийг  $\frac{1}{2}$ ,  $\frac{2}{3}$ ,  $\frac{3}{4}$ -ыг эдэлсэн тохиолдолд засрал хүмүүжилтэй байдлаа харуулсан тохиолдолд ингээд магадлангаар ордог гэсэн энэ ерөнхий зохицуулалтаар явж байгаа. Тухайлсан

хэрэг дотор хэрэг дээрээ хэргээр магадлангаар оруулахгүй гэсэн ийм зохицуулалт одоогоор байхгүй болов уу гэж би ойлгож байна.

Гэр бүлийн хэрэг дээр тэтгэвэр төлөлт ямар байна вэ гэсэн. Сая Онончимэг дарга хариуллаа. ШШГЕГ өөрөө гүйцэтгэх эрх мэдлийн хүрээний байгууллага байгаа. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд энэ шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг шүүхийн харьяалалд оруулах талаар бас асуудал явж байгаа юм байна лээ. Тийм учраас бол тодорхой тоо баримт бол шүүхэд бол ирүүлдэггүй. Ийм л хариулт байна даа.

**Г.Занданшатар:** Дашидондогийн Ганбат гишүүн.

**Д.Ганбат:** Ер нь бол нэг л биш байна. Энэ ШЕЗ шүүхийн энэ шүүгч нарыг сонгон шалгаруулж байхдаа хараат бус ажиллаж чадаж байна уу? Ямар байна вэ? Би бол нэг юм хэлчихмээр байна. Энэ шүүгч нарыг ямар нэгэн байдлаар нөлөөлж, тэгж шалгаруулж, ингээд гарсан шүүгч нар бол аягүй хариуцлагагүй байна. Бид энийг юугаар хэлэх гэж байна вэ гэхээр хүн 4 хүүхэдтэй аавыг төрийнх нь яаман дээр нь зодоод алчихсан хүн өнөөдөр 4 жил шоронд суухгүй гараад ирж байна шүү дээ. Өнөөдөр 40 их наядыг идэж уучихсан, 40 тэрбумыг идсэн хүн 40 саяар торгуулж байна шүү дээ. Энэ энэ шүүхээс гарч байгаа шийдвэрүүд байхгүй юу. Тэгээд ийм юманд чинь ард түмний итгэл найдвар алдаж байна.

Яг энэ жишигээр чинь Улаанбаатар хотод өнөөдөр автобус ч байхгүй, мөнгө ч байхгүй. Яг энэ жишигээр чинь өнөөдөр Дорноговьд 12 настай эмэгтэй хүүхэд алга болчихсон байна. Яагаад гэвэл хууль үйлчлэхгүй байна, шүүх үнэнч шударга байж чадахгүй байна. ШЕЗ дээр шүүхэд хэн нөлөөлж чадах вэ эрх мэдэлтэй хүмүүс энэ Ардын намынхан л нөлөөлж чадна. Тэр ШЕЗ хэлэлцээд энэ хүнийг нөлөөлж байна гээд Ардын намын даргыг

огцруулъя гэсэн нь үнэн юм уу. Энэ бол худлаа PR байх гэж бодож байна би. Тэрэнд нэг хариулчхаарай.

Энэ шүүгч ямар нутаг усныхаа янз бүрийнхээ юмаар допингтой шүүгч биш биз дээ. Допинг гэдэг нь бол би энэ эрх баригчдын нөлөөлөлтэйгөөр шалгарч гарч ирсэн хүн биш биз гэж байгаа юм. Хараат бус ажиллаж чадах уу үгүй юү гэдгийг асууж байгаа юм. Тэрийгээ хэлээрэй. Тэгж ажиллахгүй бол энэ улс орон бол үнэхээр уруудаж доройтож байна. Өнөөдөр хууль зүйн салбар өнөөдөр ямар байна вэ. Би түрүүний хэлсэн хэдэн жишгийг ярьж байна. Ийм л байна. Тэр хотын дарга Сумъяабазар, Түгжрэлийн сайд Сүхбаатар 2 маань тэр фронт дээрээ жагсаалаас гарчхав уу яачхав. Ардын намын Удирдах зөвлөл хуралдаад л баахан томилгоо хийгээд байх шиг байна. Уул нь энэ чинь Их Хурал дээрээ, ЗГ дээрээ яриад орж ирж байх ёстой юмыг зүгээр нэг нам ярьж байгаа юм шиг л буцаад 90 оноос өмнөх юмандаа оччихсон. Би Удирдах зөвлөлийнхөө шийдвэрээр гараад ирлээ гээд л нөгөө допингтой түрүүлсэн аварга шиг. Би Удирдах зөвлөлийнхөө даалгаврыг авлаа. Би илд болно. Үгүй ээ манай Байнгын хорооны даргыг Энхбаярыг огцруулаад байгаа юм уу, дэвшүүлээд байгаа юм уу? Манай Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн сайд Нямбаатарыг хууль зүйн салбар чинь муу байлаа гээд огцруулаад байгаа юм уу, дэвшүүлээд байгаа юм уу мэдэгдэхгүй.

Тэгээд энэ 2 нам нь би Сумъяабазарыг огцруулчихлаа, би Сүхбаатарыг огцруулчихлаа гээд л хөөрөөд л, хийрхээд л гүйгээд байх юм. Үгүй ээ тэр хэд тэд нарын огцруулдаг гэж юу байдаг юм. МАН-ын охин намын манай хэдэн дагуул нөхдийн. Үгүй ээ тэгээд үнэхээр аргагүй болоод л эд нар ийм юманд орхигдож байна шүү дээ. Би Дэлгэрсайхан сайдын талаар яриад яах вэ, сайд болчихсон хойно л ярья. Тийм. Эрх биш энд сууж байгаа юм байна. Тийм. Үгүй ээ, энэ чинь хамаатай хамаагүй юм гэж байдаг юм уу. Улсын Их Хурлыг

Улсын Их Хурал шиг болгоё л доо, байхгүй бол одоо Улсын Их Хурал таръя, тар. ЗГ бүрэн бүрэлдэхүүнээ огцор, үнэхээр хариуцлага хүлээж чадахгүй байна шүү дээ. Хэн нэгэн хүнийг золиосолж байна. Өдөр хоног өнгөрөөсөн, аргацаасан шийдвэрийг гаргаж байна. Бид нар бүх хуулиудаа баталсан шүү дээ.

**Г.Занданшатар:** ШЕЗ-ийн дарга Онончимэг, Ренчиндоржийн Онончимэг хариулт 81.

**Р.Онончимэг:** Ганбат гишүүний асуултад хариулъя. Нэр дэвшигч, нэр дэвшигч Батзориг нь анхан болон давж заалдах шатны шүүхэд, нийслэл болон орон нутагт ажиллаж байсан туршилагатай. Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд заасан шалгуурыг хангаж, сонгон шалгаруулалт сонгон шалгаруулалтад заасан журмын хүрээнд шалгалтдаа орж тэнцэж орж ирсэн. ШЕЗ бол өөрөө хамтын удирдлагын байгууллага, 10 гишүүнээс бүрдсэн хүмүүс сонгон шалгаруулалтыг авч өргөн мэдүүлж байна. Тэгээд хуулиараа илүү нарийвчлагдсан нь бол нэгд ямар нэгэн байдлаар онооны дээр доор гэсэн юм байхгүй, шууд нэгд эрэмбэлэгдсэн хүмүүсийг бид нар танилцуулах үүрэгтэй байгаа. Энэ хүрээн дээрээ танилцуулга хийгдэж байна.

Шүүхийн шийдвэртэй холбоотой, шүүгчийн гаргаж байгаа шийдвэртэй холбоотойгоор бол ямар нэгэн байдлаар байр суурь илэрхийлэх боломжгүй. ШЕЗ-ийн үйл ажиллагаа бол шүүгчээс хараат бусаар шүүн таслах ажиллагаанд оролцох боломжгүйгээр явагдах ийм зохицуулалттай байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Ер нь Ганбат гишүүн бол сайн мэдэж байх ёстой. Энэ Үндсэн хуульд 49.1-д байхаа. Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана. 49.2-т Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн, ЗГ-ын гишүүн шүүхийг хэрэг маргаан таслах үүрэг



хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй. Одоо ч гэсэн ингээд энэ чинь нөлөөллийн ажиллагаа шиг сонсогдож болно, тухайн тодорхой хэрэг яриад байвал, тэр хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтын хүрээнд л гаргаж байгаа шийдвэрийг эндээс шууд хэргийн зүйл анги, доторхыг нь уншихгүйгээр яллах, цагаатгах бололцоо бид нар бас болохгүй. Энэ чинь бас нөлөөлж байгаа ажил болчихно. Харин 49.3-д нь тэгээд ШЕЗ бол шүүхийн хараат бус байдал, бие даасан байдлыг хангаж ажиллаж шүүгчийг шилж, сонгож олох энэ хараат бус байдлыг хангах зорилготой ийм байгууллага.

Шүүгчийн сахилгын хороо нь бол тэр буруу, зөрүү шийдвэр гарч байна уу? хууль хэрэглээний зөрчил гарч байна уу, хууль хэрэглээний нэгдмэл байдал хангаж байгаа энэ тэрийг бүгдийг нь ингээд хянадаг байгууллага болчихсон юм шүү дээ. Тэгэх ер нь шүүгч гагцхүү хуульд захирагдаж, хараат бус байх ийм зарчмыг бол бид шаардах ёстой. Гэхдээ бид хууль хэрэгжүүлэхээ шаардана. Харин хуулийн хэрэгжилтийг Шүүхийн хууль батлагдсан. Шүүхийн хуулийн олон заалт хэрэгжихгүй байгааг, хэрэгжүүлэхгүй байгааг бол ШЕЗ-өөс шаардаж байгаа. Энийг дараа нь бол жич сонсоно. Өнөөдрийн асуудалд хамаагүй учраас. Энийг Энхбаяр дарга бас хэлж ярьж байгаа байх, хэлж ярьсан. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Дээд шүүхийн, шүүхийн шүүгчид нэр дэвшигч танилцуулгын хамгийн эхний хуудас, эхний мөрийг сөхөхөөр Хэнтий аймагт төрсөн гээд л эхэлж байна л даа. Тэгэхээр түрүүний тэр допингтой юм биш биз дээ гэдэг яриа одоо эндээс л гарч байгаа байх. Тэгэхээр тэр ингээд өөрөө тусдаа асуудал. Тэгээд мэдээж нэг ийм хардлага, сэрдлэг ингээд л явдаг учраас л ярьцааж байгаа байх.

Харин Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчээс 2 асуулт байна. Асуулт нь ер

нь Дээд шүүгч гэдэг чинь өөрөө Дээд шүүхийн шүүгч гэдэг чинь өөрөө хуулийн хэрэглээ тийм нэлээн тийм онолын чиг онолын чиг баримжаатай, онолын чиг баримжаатай, онолын, энэ хуулийн тайлбар өгдөг ёстой тийм түвшний ажил байх. Тэгэхээр энэ дээр бол нэлээн тийм онолын судалгаанууд хийсэн, тодорхой хэмжээний бүтээлүүд хэвлүүлсэн. Яг энэ талд хэр бэлтгэгдсэн нэр дэвшигч вэ? Та энэ дээрээ нэг тайлбар өгөөч.

Өөр нэг 2 асуулт байгаа нь Үндсэн хуульд байгаа нь 2 өгүүлбэрээс л асуух гээд байна л даа. 1 дүгээрт нь Улсын дээд шүүх бол Шүүхийн дээд байгууллага гэсэн нэг өгүүлбэр байдаг юм байна лээ. Шүүхийн дээд. Энэ өөрөө яг тэр, саяын тэр судлаач талаасаа харвал та энэ дээр нэг тайлбар өгөөч. Шүүхэд чинь тийм дээд, доод байгууллага гэж байх уу? Энэ нь дээд, энэ нь доод, анхан, дунд шатынх нь шийдвэр нь доод шатын шийдвэр, үйлчлэл, хуулийн үйлчлэл, шүүхийн шийдвэр эцэслээд гарчихсан, шүүхийн шийдвэр гарчихсан мөртөө энэ нь бол доод түвшний шийдвэр, тэгээд захиргааны дээд байгууллага ч гэлүү шүүхийн дээд, нэг ийм түвшний ялгаа заачихсан нэг өгүүлбэр харагддаг. Та жишээ нь энэ дээр нэг тийм тайлбар өгөөч? Тэгэхдээ магадгүй та энийг судлаач талаасаа тайлбарлаж болох юм. Мэдээж бид нар хуулийг тайлбарлах эрх байхгүй гээд олон зүйл байдаг. Тэгэхдээ та судлаачийн үүднээс.

2 дугаарт нь бас Үндсэн хуульд байдаг нэг өгүүлбэр Монгол Улсын иргэн шударга шүүхээр шүүлгэх эрхтэй гээд. Тэгэхээр нөгөө талд нь шударга бус шүүх гэж байж болдог, тэрнээс нь сонгож байгаад бид нар шударгаар нь шүүлгэдэг гэсэн утга энэний цаана байх юм уу? Аль эсвэл тэр шүүх чинь ер нь шударга байх ёстой юм уу? Шударга шүүхээр шүүлгэх эрхтэй гэдгийг дээр та судлаач талаасаа ямар тайлбар өгөх вэ? Олон шүүхээс сонгож байгаад шударга бусыг нь орхиод, шударгаар нь шүүлгэнэ гэсэн санаа юм уу? Энэ өөр утга санаа бүхий зүйл үү?

Тэгээд эдгээр дээр та тэр нэг судлаач, би гол нь энэ Дээд шүүхийн шүүгч гэдэг хүн нэлээн тийм судлаач, онолын чиг баримжаатай хүн байх ёстой байх тэгээд гэдэг үүднээс тодруулж асууж байгаа юм шүү. Та тэгээд эдгээрт хариулаач.

**Г.Занданшатар:** Нэр дэвшигч 83.

**Н.Батзориг:** Цогтгэрэл гишүүндээ баярлалаа. Энэ таны асуултад хариулъя. Онолын хувьд бол хэр бэлтгэгдсэн бэ гэсэн ийм асуулт байна. Шүүгчийн хувьд бол үндсэн ажлын зэрэгцээ шүүхийн байгууллагад бол судалгааны том объект байгаа. Шийдвэрлэж байгаа хэргүүд маань, тэр тэдгээр хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүд маань архивд байдаг. Энэ судалгааны объектод өөрсдөө шүүгч нар бас ажлын хажуугаар судалгаа хийж, тодорхой асуудлуудыг гаргаж ирж дэвшүүлж, шинжлэх ухааны өгүүлэл, нийтлэл бичдэг ийм бол байдаг. Бүх шүүгч биш ч гэсэн тодорхой судалгааны ажлын чиглэлээр сонирхолтой шүүгч нар ажилладаг. Миний хувьд бол анхан шатын шүүхэд ажиллаж байхдаа ч тэр, одоо давж заалдах шатын шүүхэд ажиллаж байхдаа бас судалгааны ажлууд хийж, өгүүлэл, нийтлэл хэвлүүлж байсан.

Тухайлбал давж заалдах шатын шүүхийн хэргийг бүхэлд нь хянах тухай асуудлаар судалгааны ажил хийж, өгүүлэл хэлэлцүүлэг МУИС-ийн Хууль зүйн сургууль дээр хэлэлцүүлсэн. Энд тусгагдсан дэвшүүлсэн санал, дүгнэлт бол энэ нь Шүүхийн тухай хуулийн ерөнхий үзэл баримтлалд бас тодорхой хэмжээгээр орсон. Цаашидаа Улсын дээд шүүхэд тайлбар гаргахад бас авч хэлэлцэгдсэн байна лээ. Ингээд зарим саналууд нь бол тусгагдсан байгаа. Мөн хэлцлийн хүчин төгөлдөр бус байдал, түүний шаардлага, үндэслэлийн талаар бол Монголын төр, эрх зүй сэтгүүлд өгүүлэл хэвлэж нийтлүүлсэн. Мөн үүний хажуугаар хууль зүйн сургуулиудад бол

гэрээт багшаар ажиллаж байгаа? Шихихутаг хууль зүйн сургууль, Санхүү, эдийн засгийн их сургууль дээр иргэний процессын эрх зүйн чиглэлээр сүүлийн 5, 6 жил бол хичээл орж байна. Одоо бас нэг өөрийгөө бас хөгжүүлэх шаардлага бас байгаа. Иргэний эрх зүйн хэм хэмжээг шүүхэд хэрэглэх онол арга зүйн асуудал сэдвээр докторын судалгааны ажил хийж байгаа. Онолын мэдлэг чадварын хувьд хэр бэлтгэгдсэн юм бэ гэдэг энэ асуудалд нь ингэж хариулъя.

2 дугаарт тэр шударга шүүхээр шүүлгэх гэсэн энэ асуудлын талаар асуудлыг тавьж хөндөж байна. Энэ чухал асуудал мөн. Үндсэн хуульд заасан байгаа. Шинээр, шинэчлэн батлагдсан Шүүхийн тухай хуульд ч гэсэн энэ талаар заалт орсон. Гол агуулга бол ерөөсөө шударга шүүх үү, шударга бус шүүх үү гэдэг ийм ойлголт, ойлголтын агуулга бол биш. Процессын асуудал байгаа. Шударгаар шүүлгэх тухай ийм ойлголт гэж үзэж байгаа. Гол нь бол шүүх дээр илүү түлхүү яригдана. Өөрөөр хэлбэл процесс нь шударга байж байж шүүхээс гарах шийдвэр өөрөө шударга гарна гэсэн энэ онолын үндэслэл бас энд яригдаж байгаа юм гэж хариулах байна, process.

**Г.Занданшатар:** Do process дээр. Шударга, юугаа хариулсангүй тэр. Шүүхийн дээд байгууллага гэдгийг.

**Н.Батзориг:** Үндсэн хуульд зааснаар бол Шүүхийн дээд байгууллага нь Улсын дээд шүүх, шаталсан тогтолцооны талаар бол асууж байна. Анхан шатын шүүхүүд бол, давж заалдах шатын шүүх, хяналтын шатын шүүх гэсэн үндсэн 3 шатлалын ийм тогтолцоотой. Энэ дагуу бол Шүүх байгуулах тухай хууль бас шинэчилж, шинэчлэн батлагдахаар ингээд хуулийн төсөл явж байгаа юм байна лээ.

**Г.Занданшатар:** Энэ нэг онолын маргаан байдаг гэж Дээд шүүх, шүүх бүгд шударгаар шүүж байвал адилхан. Зүгээр Дээд шүүх Үндсэн хуульд байгаа Монгол

Улсын дээд шүүх шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах хэргийг хэрэгжүүлнэ. Дараах үүргийг хэрэгжүүлнэ гээд тэр эрхийг нь тодорхойлохын тулд өөрөөр хэлбэл давж хэргийг хянах, хуулийн талаар тайлбар хэрэглээний тайлбар гаргах гэдгийг нь тодотгохын тулд онолын хувьд ч тэр, Үндсэн хуулийн тайлбарын хувьд ч гэсэн тэр дээд байгууллага гэдгээр нь тодорхойлсон гэж үздэг л дээ. Шударга шүүлгэх do process 2 ч гэсэн тэр. Тэгээд ингээд 50-иас ихэнх минут хувьдаа болохоор би гэдгээ яриад, энэ 2 гол асуулт дээрээ их сайн хариулаад, би ийм судлаач хүн гэдгээ хариулсан бол, харуулсан бол илүү оновчтой байлаа гэж.

Ингээд ШЕЗ-ийн дарга болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж дууслаа. Улсын Их Хурал Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчидтэй танилцлаа. Яг энэ ҮХЦ-ийн дүгнэлт гараад ингээд нэг хууль түдгэлзчихсэн сонсголоор ордоггүй үе яг ингээд нэг цонхоор таарч бас их азтай гарлаа гэж. Тэгээд баяр хүргэе, амжилт хүсье. Нотлох сонсголоор.

15.59 цаг

Гишүүдээ оруулаарай. Тогтохсүрэн даргаа гаргачих. Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн горимын санал хэлнэ.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Улсын Их Хурлын өнөөдрийн хэлэлцэх асуудлууд үндсэндээ дуусаж байна. ЗГ-аас Монгол Улсын Ерөнхий сайд яаралтай горимоор хэлэлцүүлж өгөөч гээд ЗГ-ын 2 гишүүнийг чөлөөлөх, 2 гишүүнийг томилох асуудлыг шийдэж байгаа юм байна. Ингээд Улсын Их Хурлын болон Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Улсын Их Хурал ЗГ-ын гишүүнтэй танилцах ийм үйл ажиллагаа байдаг. Энийг өнөөдөр явуулах зайлшгүй шаардлага үүсэж байна. Тийм учраас би ЗГ-ын гишүүн, Монгол Улсын сайд,

Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны даргыг чөлөөлөх, мөн нэр дэвшүүлэхтэй холбоотой асуудал. 2 дахь нь Монгол Улсын ЗГ-ын гишүүн Хууль зүй, дотоод хэргийн сайдад мөн чөлөөлөх, нэр дэвшүүлэх тухай асуудал 2-ыг өнөөдрийн хэлэлцэх асуудлын дараалалд оруулж, хэлэлцүүлэх саналыг горимын саналыг гаргаж байгаа юм. Гишүүд та бүгдийг дэмжиж өгөөд, өнөөдөр хэлэлцээд явчихъя гэж байгаа юм. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Тогтохсүрэн дарга горимын саналыг хэллээ. Тэгэхдээ бусад гэдэг асуудлаар бас Даргын дэргэдэх зөвлөл дээр бас ийм асуудлууд үүсэж байгаа учраас нэмж оруулж байсан л даа. Тэгэхээр шууд оруулчхаж болох нь уу? Санал хураалтгүй. ЗГ-ын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг энэ танилцах асуудлыг хэлэлцэх асуудлын дараалалд нэмье гэсэн горимын санал гаргасан. Уг асуудлаар Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл дээр бас өмнө хэлэлцэгдэж байсан учраас санал хураалтгүйгээр шууд нэмээд явчих уу? Санал хураалт. Санал хураалт явуулъя. Тогтохсүрэн даргын гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Саяын асуудлыг хэлэлцэх асуудлын дараалалд нэмэх. 26 гишүүн дэмжиж, 53,1 хувийн саналаар хэлэлцэх асуудал дээр асуудал нэмэх горимын санал нэмэгдлээ. Тийм учраас энэ асуудлыг хэлэлцэх асуудалд нэмлээ.

**Дөрөв.Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох**

Одоо ингээд ЗГ-ын гишүүнийг томилох, чөлөөлөх тухай Монгол Улсын Ерөнхий сайдын танилцуулгыг сонсоно. ЗГ-ын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Удахгүй та бид 2024 оны улсын төсвийг хэлэлцэх гэж байна. 2021 онд Шинэ сэргэлтийн бодлого хэрэгжиж эхлэх үед Монгол Улсын ДНБ 43,6 их наяд төгрөг байлаа. Нэг үгээр хэлбэл Монгол Улс 40 литрийн багтаамж бүхий эдийн засагтай байсан гэсэн үг юм. 2022 онд ДНБ 53,8 их наяд, 2023 онд 62,4 их наяд төгрөг болж тэлсэн байна. Ирэх 2024 оны улсын төсвийг ДНБ 74 их наяд төгрөгт хүрч нэг хүнд ноогдох ДНБ 6 мянган ам.доллар давна гэж тооцоолж байна.

Цар тахлын оргил үед -4,6 хувь байсан эдийн засаг 2021 онд 1,6 хувиар, 2022 онд 4,8 хувиар, 2023 онд 6,4 хувиар өссөн бол ирэх 2024 онд эдийн засаг 7 орчим хувийн өсөлттэй байхаар төсөөлж байна. Хөгжлийн банкны чанаргүй зээлийн эргэн төлөлт 1,4 их наяд давж, Мазаалай бондын 500 ам сая доллар, Гэрэгэ бондын 800 сая ам.доллар? Чингис бондын 1,5 тэрбум ам.долларын өр бүрэн төлөгдөж дууслаа. Улсын төсөв энэ жил 1,8 их наяд төгрөгөөр давж, төлбөрийн тэнцэл анх удаа 538 сая долларын ашигтай гарч, валютын нөөц 4 тэрбум ам.долларт хүрлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тоо худал ярьдаггүй гэдэг. Эдийн засагт гарч буй энэхүү томоохон өөрчлөлтүүд илүүхэн хэлэхэд Монгол Улсад ямар том хэмжээний далд эдийн засаг нуугдаж байсны тод илэрхийлэл юм. Эрдэнэтийн 49 хувь, Оюу толгойн 2,3 тэрбум ам.долларын өр тэглэлт, Таван толгойн нүүрсний хулгайг илчилж, ил тод, цахим арилжаанд илжүүлсэн. Хөгжлийн банкны чанаргүй зээлийн эргэн төлөлт зэрэг том түвшний системийн авлигатай Улсын Их Хурал, ЗГ, олон нийт хамтран тэмцээний бодит үр дүн бол энэ юм. Энэ нь том түвшний системийн авлигын бүтцэд задрал явагдаж, бүтцийн хувьд далд эдийн засаг, нууц мөнгө ил

болон бүртгэлжиж, эдийн засаг тэлж байгаагийн эхний дохио юм. Авлигатай амжилттай тэмцсэн улс орнуудын хөгжлийн түүх ч энэ үе шатыг давж эхэлдгийг та бид мэднэ.

Товчоор дүгнэж хэлбэл та бид авлигатай тэмцэх эхний үе шатаа давах дөхөж байна. Одоо эдийн засгийн өсөлт бүр иргэн бүрийн амьдралын чанарт нөлөөлөхөд саад болж буй хамгийн том хязгаарлагч хүчин зүйл бол дунд шатанд шимэгчлэн амьдарч буй авлигач түшмэд, том авлигачдын төлөөний этгээдүүд, эд эсүүд болж байна. Тэд улс төрчид ирдэг, явдаг, харин бид мөнх оршоор байдаг гэдэгт итгэдэг. Тэр дундаа өнөөдөр нийт хүн амын тал хувь нь амьдарч буй Нийслэл Улаанбаатар хотын 30 гаруй жил ужгирсан системийн авлигыг цогц хэмжээнд цэгцлэх цаг болжээ. Хууль хяналтын байгууллагууд ч том шатын авлигын хэргүүдийг шүүхийн шатад шилжүүлж, дунд шатын авлигал руу ханцуй шамлан орох итгэл үнэмшил цаг хугацаатай болж байгаа гэдэгт итгэлтэй байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал, ЗГ үндэсний хэмжээний асуудалд хэт төвлөрч, сүүлийн 30 орчим жил Нийслэлийн асуудлыг зөнд нь орхисноос болж Нийслэл хот маань өнөөдөр авлигын бэлгэ тэмдэг болсон цементэн ширэнгэн ой болон хувирлаа. Хот төлөвлөлтгүй олгосон газрын наймаа, тэндээс баяжиж хөрөнгөжсөн улс төрийн бүлэглэл, зөвшөөрлөө бариад байшин барих биш барилгаа бариад зөвшөөрлөө гаргуулдаг авлигын соёлыг хэзээ болтол бид мэдсэн ч мэдээгүй юм шиг харсаар явах вэ. Улсын Их Хурал, ЗГ-аар баталсан хууль, стандарт, дүрэм яагаад 30 жил Нийслэл Улаанбаатар хотод огт хэрэгжсэнгүй вэ? Байгалийн тусгай хамгаалалттай газарт сүндэрлэн боссон тансаг хотхонуудыг бид хэзээ болтол жуулчны отог гэж итгэсээр амьдрах вэ? Нийтийн тээвэрт монопол тогтоосон 3 компанийн



чөтгөрийн тойрогт хэзээ хүртэл хотынхон орооцолдож, ашигтай шугамын наймааны төлөө иргэдийнхээ эрх ашгийг зөрчих вэ? Нэгдсэн эмнэлгийнхээ нүүрийг хааж барьсан эмнэлгийн захирлуудын хувийн эмнэлэг, сургуулийн талбайг хүртэл хэсэгчилж зарсан үе үеийн дүүргийн удирдлагууд, төрийн байгууллагуудын газрыг тастаж аваад хувийн хороолол босгон ичих нүүргүйгээр өөрсдөө амьдарч буй үе үеийн хотын дарга нартай хэзээ хүртэл эвлэрэх вэ? Үерийн далан дээр бярдаж босгосон хууль сахиулахын хуучин дарга нарын авлигын хороололд олон нийтийн шаардлага хэзээ хүрч үйлчлэх вэ? Юутай ч Нийслэл дангаараа хүчин мөхөстсөөр ирснийг өнгөрсөн 30 жилийн түүх хангалттай нотоллоо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын Нийслэлийн маань асуудал улсын тулгамдсан асуудал болон хувирчээ. Том авлигын асуудлыг цэгцлэхэд нэгдмэл хүчээр ажиллаж чадсан шиг их хотын идээ бээрийг шахаж, ирээдүйг нь тодорхойлж өгөхөд Улсын Их Хурал, ЗГ иргэдтэйгээ хамт байж хэсэг хугацаанд шууд оролцоогоо Нийслэлд нэмэх зайлиггүй шаардлага та бидэнд урган гарч байна. Төрийн үйлчилгээний 70 гаруй хувь, төрийн мэдээллийн 11 11 төвд ирж буй гомдлын 80 орчим хувь зөвхөн Нийслэлтэй холбоотой байна. Нийслэлийн асуудал шийдэгдвэл Улсын Их Хурал, ЗГ-ын ачаалал бараг 70-аас 80 хувиар шууд хөнгөрөхөөр байна. Нийслэл 9 дүүргийнхээ тогтолцоогоор цаашид ирэгддээ хүрч үйлчилж чадах уу? Бид үүнд хамтдаа хариулт өгөх цаг болсон байна. Хороодын дарга, хэсгийн ахлагчид аймгаас том хүн амтай хороодыг хэрхэн удирдлагаар хангаж төрийн үйлчилгээг хүргэх вэ? Бид энэ асуудлыг ч бодитой авч үзэж яаралтай шийдвэрлэх шаардлагатай болжээ.

Гэр хорооллын тэлэлтийг нийслэл, дүүрэгт даатгаад уул уулаар уул ухахыг харсаар л шогширсоор л байх уу. Аль эсвэл

хотын асуудал надад хамаагүй гэж улс төрийн галаас хойш сууж, аргацааж аргалсаар дахиад 30 жилийг өнгөрөөх үү? Нийслэлийн асуудлууд шийдэлгүй үргэлжилбэл Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан хүний эрх, иргэдийн аюулгүй байдал, амьдралын чанарын үзүүлэлт бодитоор хэрэгжих огт боломжгүй нь ойлгомжтой юм. Тийм ч учраас Нийслэл Улаанбаатар хотын талаар ЗГ тусгай тогтоол гаргаж, 6 сарын хугацаанд ЗГ бүрэн бүрэлдэхүүнээрээ нийслэлийн ужгирсан асуудлыг цогц байдлаар шийдвэрлэхэд нь онцгой анхаарч ажиллахаар улс төрийн шийдвэр гаргалаа. Улсын нийслэл цогц байдлаар хийх энэхүү авлигын эсрэг ажиллагаа, энэхүү шинэчлэлийн реформд ЗГ-ыг дэмжиж ажиллахыг Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхнээс Ерөнхий сайдын хувьд хичээнгүйлэн хүсье.

Хаврын чуулганаар та бид хамтдаа ачаалалтай ажиллаж, авлигын эсрэг эрх зүйн орчинд шинэчлэлт хийж, Үндсэн хуулийн сонгуулийн тогтолцооны шинэчлэлийг хийж чадсан шигээ намрын чуулганаар өмнөхөөсөө илүү ачаалалтай ажиллаж нийслэл Улаанбаатар хотын урт болон дунд, богино хугацааны төлөвлөлт, хотын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын бүтэц, зохион байгуулалт, хотын соёлын, дүрэм, хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэр, нутаг дэвсгэрийн нэгж, хот тосгоны эрх зүйн байдал, газрын харилцаа зэрэг асуудлуудыг цогц байдлаар шийдвэрлэхэд хууль тогтоох болон гүйцэтгэх засаглал нийслэл Улаанбаатар хотод бүрэн дэмжлэг үзүүлэхэд хичээнгүйлэн оролцохыг та бүхэнд бас уриалж байна. Энэхүү зорилтыг ханган хэрэгжүүлэх үүргийг Улсын Их Хурлын гишүүн ХЗДХ-ийн сайд Нямбаатарт Ерөнхий сайдын хувьд даалгах нь зүйтэй гэж үзсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд ХЗДХ-ийн сайдаар

Баттөмөрийн Энхбаярыг Нямбаатар сайдын оронд томилохоор та бүхэнд танилцуулж байна. Монгол Улсын ЗГ-аас дэвшүүлсэн Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн багц шинэчлэлүүдийг үргэлжлүүлэхэд төрийн албанд 23 жил ажиллаж, ХЗДХ-ийн сайд байсан, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын ХЗБХ-г удирдсан мэргэжлийн болон улс төрийн туршлагыг харгалзан үзлээ. Мөн мэргэжлийн Байнгын хорооны даргыг тухайн салбарын яаманд ажиллуулах сонгодог парламентын засаглалын мерит зарчмыг үндэслэл болголоо.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд анх удаа Хөгжлийн банкны асуудлыг хянан шалгах Түр хорооны даргаар ажиллаж, 3 шатын нээлттэй сонголыг амжилттай зохион байгуулж, иргэдийн мэдэх эрхийг хангаж чадсан улс төрчийн эр зориг тууштай байдлыг нь харгалзан үзлээ. Энэхүү туршилага нь нүүрсний хулгайн сонголыг ч амжилттай зохион байгуулж, уул уурхайн системийн авлигыг илчлэх цаашид ийм алдаа гаргахгүй байхад бодит хувь нэмэр оруулж чадна гэдэгт мөн итгэж байна.

Монгол Улсын сайд нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны даргын албан тушаалд Борхүүгийн Дэлгэрсайханыг томилуулахаар танилцуулж байна. Нийслэл хотын асуудал бол цогц асуудал. Тэр дундаа аж ахуйн ажил гэдэг нь ойлгомжтой. Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, нийслэлд ЗГ-ын зүгээс улс төрийн дэмжлэг үзүүлэх гүүр болох, нийслэлийн төвлөрлийг ажлын байр, аж үйлдвэржилт, эдийн засагтай уялдуулан шийдвэрлэхэд Улсын Их Хуралд сонгогдон ажилласан улс төрийн туршилага, хувийн хэвшилд аж ахуй эрхэлж, авто зам, төмөр замын их бүтээн байгуулалтыг удирдаж байсан хувь хүнийх нь амьдралын туршилага, техникрат хандлагыг харгалзан үзэж энэхүү албан

тушаалд тохирно гэж үзлээ. Салбар дундын уялдааг хангаж, төр хувийн хэвшлийн түншлэлээр нийслэлд тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадна гэдэгт итгэж байна.

Шинээр томилогдож буй сайд нарын намтрыг та бүхэнд тараасан болно. Анхаарал хандуулсан баярлалаа.

**Г.Занданишатар:** Ерөнхий сайдад баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Даишэвэгийн Амарбаясгалан, 2 Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Бямбажавын Ганбат, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Чулуунбаатарын Дондогмаа. Ерөнхий сайд болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 101.2-т ЗГ-ын гишүүнийг чөлөөлөх, огцруулах, томилох асуудлыг нэгдсэн хуралдаанд танилцуулах бөгөөд гишүүд Ерөнхий сайд болон томилогдох этгээдээс асуулт асууж, үг хэлж болно гэж заасан. Ингээд Ерөнхий сайд болон томилогдох этгээдээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд. Асуулт, үг нэг. Сандагийн Бямбацогт гишүүнээр тасаллаа. Гонгорын Дамдинням гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг нэг.

**Г.Дамдинням:** Ерөнхий сайдын танилцуулгадаа маш тодорхой л дурдлаа даа. Тэгээд би энэ ХЗДХ-ийн сайдад нэр дэвшиж байгаа Энхбаяр гишүүнээс томилогдох өдөр нь олон түмний өмнө бас эргээд нэхнэ гэдгээ хэлж байгаад 2 асуулт асууя.

1 дүгээр асуулт бол энэ Улаанбаатар хотын газрын авлигал засаг замбараагаа алдсан. Энэний үр дүнг өнгөрсөн зуны турш бид нар харцгаасан. Дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтөөс хамаараад олон улсын судалгааны байгууллагуудын гаргаж байгаа судалгаагаар Улаанбаатар хот Монгол Улсын энэ бүс нутаг өөрөө үерийн онц

аюултай бүсэд орно, маш их хур тунадас унана. Энэний үр дүн манай 1,6 сая хүн амьдарч байгаа нийт хүн амын талаас илүү хувь нь шахуу амьдарч байгаа энэ хотод маань тохиолдсон. Эрдэнэт хүний амь ч үрэгдсэн.

Энэ Авлигал хороолол гэдэг хорооллыг ард түмэн ярьж байна. S outlet гэдэг газрыг бас ярьж байна. Төр засгийн байгууллагууд, мэргэжлийн байгууллагууд, БХБЯ нь очоод барилга эрхлэх зөвшөөрлийг нь цуцалчихаар зэрэг та нар юу юм бэ гэсэн маягтай ажиллаад зогсож байдаг юм. Хяналт шалгалтын байгууллагууд очоод акт тавьчихаар зэрэг хууль мөрдөгддөггүй юм. Ерөөсөө зогсдоггүй юм. Тэгэхээр энэ бол ер нь бяр чадалтай авлигачдын их том symbol юм даа. Бэлгэ тэмдэг болсон ийм барилгууд байгаа байхгүй юу. Энэ газруудад хууль хэрхэн очдогийг нэг харуулж өгөөч. Ингэж байж л бид нар энэ Улаанбаатар хотыг цэгцэлнэ шүү дээ. Улаанбаатар хот цэгцрэхгүй бол цаана нь манай бусад аймгийн төвүүд хараад л сууж байгаа. Авлигал хороолол ч гэдэг юм уу энэ Энхтайваны гүүрний дээр баригдаж байгаа эсвэл тэр Дунд голын ай савд баригдчихсан энэ S outlet энэ тэр гээд энэ барилгуудыг яагаад яриад байгаа вэ гэвэл дээр нь байгаа сул байгаа газрууд бүгдээрээ хоосон харагдаж байгаа газрууд бүгдээрээ эзэнтэй болчихсон.

Хэрвээ энэ барилгууд баригдаад л ашиглалтад орох л юм бол тэр барилгууд барьцаад баригдана. Ингээд бүгдээрээ үертээ дарагдаад, ундны усны хомсдолдоо ороод, төр засаггүй юм шиг ингээд л ичгэвтэр байдалтай л орно доо. Тэгэхээр энэ дээр та нэг хууль сахиулах арга хэмжээ авч өгөөрэй. Яаж ажиллах вэ, эргэж нэхнэ шүү 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт бол энэ нүүрсний хулгайтай холбоотой асуулт байна. Нүүрсний хулгайтай холбоотой асуулт дээр сонсгол явах байх. Сонсголыг бүх хүрээгээр нь дэлгэрэнгүй бүх талыг нь хамруулж зохион байгуулж өгөхийг хүсье.

Зөвхөн гэрээн дээр нь ч гэдэг юм уу, зөвхөн тээвэр дээр нь ч гэдэг юм уу, зөвхөн худалдан авалт дээр нь ч гэдэг юм уу, зөвхөн Эрдэнэс таван толгой дээр нь ч гэдэг юм уу хязгаарлаж явуулах юм бол болохгүй шүү. Энэ дээр ер нь таны бодол ямар байгаа вэ? Ийм 2 асуулт байна.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Дамдинням гишүүний асуултад хариулъя.

**Г.Дамдинням:** Улаанбаатар хотод сая Ерөнхий сайд хэллээ. Газрын авлига гаарсан, олон жил ярьсан. Тэгээд энэ дээр үнэхээр Ерөнхий сайд өөрийн онцгой анхааралд авч, бас туршилагатай, зоригтой Хууль зүйн сайдаа илгээж энэ асуудал руу нэг мөр олон жил эргэж буцаж ярихгүй байхын тухайтад орж байгаа. Энд хуулийн дэмжлэг мэдээж маш их хэрэгтэй болно. Яагаад гэхээр энэ бүх юмны суурь нь Газрын хуультай холбоотой. Манайх 2002 онд Газрын хуулийг баталсан. 2002 онд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг баталсан. Хот төлөвлөлттэй холбоотой өнгөрсөн онд ЗГ-аас өргөн Улсын Их Хуралд өргөн барьсан хууль байгаа, хуулийн төсөл байгаа. Энэ хуулийг яаралтай хэлэлцэж, Улсын Их Хурал батлах шаардлагатай. Энэ хуулийн ЗГ-аас өргөн баригдчихсан төслөөр бол хотыг хот төлөвлөлт зөвхөн төлөвлөгөөний дагуу газар олголтод хийдэг, хийгддэг.

Ялангуяа орон сууцтай холбоотой асуудал дээр гагцхүү стандартыг барьдаг. Стандарт нь өөрөө хууль болж үйлчилдэг бодлого Улсын Их Хурал дээр ЗГ-аас нэгэнт орж ирсэн байгаа. Энэ бодлого дээр Улсын Их Хурал, ЗГ хамтдаа шийдэх байх гэж бодож байна. Маш олон асуудлууд энд нөлөөлдөг, маш олон асуудлууд нөлөөлдөг. Таны хэлсэнчлэн нийслэл Улаанбаатар хотын хувьд тухайд газрын шинээр баталсан хууль тогтоомжийн үйлчлэлүүд дунд шатдаа

саардаг гэдгийг сая Ерөнхий сайд хэллээ. Тухайлбал 2017 онд батлагдсан Бүртгэлийн хуулиар газар эзэмшигч ашиглагчдын мэдээллийг нээлттэй болгох асуудлыг дэвшүүлсэн. Энэ хууль Улаанбаатар хотын газрын албан дээр очоод гацдаг. Бүх дүүргүүд өөр, өөр тусдаа программ хангамжтай. Хотын дарга нь хэлээд ч үгэнд нь ордоггүй, шалтаг заагаад. Энийг бол Учрал сайд бас томилогдсоноосоо хойш бас ол олон удаа ярьсан. Нямбаатар сайд ярьж байсан. Одоо яг өөрөө гардаж байсан. Би өөрөө дэд сайд байхдаа ярьж байсан.

Тэгээд их том болчихсон. Би өөрөө Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар 25 настай байхдаа газар өмчлөлийн ажлыг хариуцаж ажиллаж байсан. Газрын нэг дүүргийн газрын албаны нэг мэргэжилтэн авлига авч байгаа тухай мэдээлэл ирээд, газар дээр нь хуулийн хэлтсийнхээ даргатай очиж бариад, сейфт нь үзлэг хийгээд барьж байсан. Тэгтэл тухайн үед хууль тогтоогчоос, ЗГ ийм эрх бүхий хүмүүсээс хүртэл ярьж байсан асуудлууд байдаг. Тэр хүн нь өнөөдөр АН-д мундаг улс төрч болчихсон яриад байгааг би бас хараад л байдаг юм. Сонин л юм байна лээ. Тэгэхээр энэ бодлого дээр бол тууштай дэмжлэг үзүүлж ажиллана. Төрийн байгууллагууд газраа зардаг, орон сууц барьж зардаг асуудлыг цэгцлэх чиглэлээр би Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд хуулийн төслөө өргөн бариад, Улсын Их Хурал хэлэлцэх эсэхийг нь дэмжчихсэн байгаа. Мөн энэ асуудал шийдэгдэх юм бол нэлээн олон юм бас цэгцрэх байх. Улаанбаатар хотод нийтдээ 108.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Дамдинням гишүүн нэг минут тодруулна.

**Г.Дамдинням:** Энхбаяр гишүүнээ яах вэ энэ түрүүн Ерөнхий сайдын үгэн дээр бас гарлаа л даа. Би Улаанбаатар хотоос сонгогдоогүй гишүүн л дээ. Тэгээд Улаанбаатар хотын асуудал надад хамаагүй гээд нүдээ аньж чадахгүй. Бид нар Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол

Улсын бүх хүн иргэний төлөө, эрх ашгийн төлөө ажиллана гэсэн тангарагтай учраас би дуугараад байдаг юм. Тэгэхээр энэ газрын наймаа шударга ёсыг л газрын наймааг тас цохиж, шударга ёсыг сэргээгээд өгөөч. Энийг зогсоох гэж энэ төрийн яамнууд, агентлагуудын гаргасан шийдвэр хэрэгжихгүй байгаад өөрийнхөө удирдлагад байгаа агентлагуудыг ажиллуулж, хуулийг сахиулж өгөөч гэдэг л хүсэлт, асуултыг тавиад байгаа юм. Энэ дээр л хариулт авах гээд байгаа юм би.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Тэр Улаанбаатар хот үертэй холбоотой авлига хороолол, S outlet-тай холбоотой асуудал дээр би одоо яг шууд хариулахгүй. Би нураана, би нураахгүй гэдэг зүйлийг бол хариулах нь зохимжгүй. Мэдээж судалж үзнэ. Миний бодлоор хүн нь ч буруутай байна, хууль, эрх зүйн орчин нь ч асуудалтай байна гэж үзэж байгаа. Тусгай хамгаалалттай газарт бүтэн хорооллууд үүсчихсэн. Хан-Уул дүүрэг, хуучин Хан-Уул дүүргийг 2 дахин нэмсэн хороолол шинээр үүсчихсэн байгаа Зайсан, Яармагт. Тэгвэл эд нарыг яах вэ. Энд бол хуулийн буруу байхгүй. Тэгэхээр хуулийн асуудлыг давхар шийдэх ёстой. Нөгөө талаас энийг зөрчсөн хүмүүс нь өөрөө хуулийн цээрлэлээ бас үзэх ёстой. 2 жигүүрээр хоёулангаар нь шийдэх ёстой. Ганцхан хүн буруутгачхаад, хуулиа янзлахгүй үлдээвэл.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Балжиннямын Баярсайхан гишүүн.

**Б.Баярсайхан:** Баярлалаа. Ерөнхий сайдын томилгоог бол дэмжиж байгаа. Тэгээд Хууль зүйн сайдад томилогдох гэж байгаа Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр танаас 2 зүйлийг асууя. Өнөөдөр энэ Монгол Улсын ЗГ Алсын хараа 20 50 гээд хөгжлийн бодлогоо тодорхойлолтоо тодорхойлохдоо хүнийг 1 дүгээрт тавьж, хүний хөгжлийг суурь



хөгжил болгон ингэж бид нар зорьж байгаа. Тэгээд 1 дүгээрт хүнээ бид нар зөв байлгаад, үүнээсээ гэр бүл амар амгалан байлгаад, ингээд сайн сайхан нийгэм бий болгоно, эдийн засгаа сайжруулна гэсэн ийм дараалалтай байгаа гэж харж байгаа. Тэгэхээр өнөөдөр энэ бидний ирээдүй болсон хүүхдүүдийн хүчирхийллийн асуудал өнөөдөр ерөөсөө буурахгүй байна. Тэгээд Хууль зүйн яаман дээр Гэр бүлийн тухай хууль батлагдах гэж маш их удаж байгаа. Тэгээд та энэ Гэр бүлийн тухай хуулийг яаралтай батлуулах тал дээр 1 дүгээрт ажиллаж өгөөч гэж танаас хүсэж байна.

2 дугаарт энэ бага насны хүүхдийг хүчирхийлээд ял авсан хүмүүс ер нь хүмүүжиж чаддаг юм болов уу? Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын ажил ер нь ямар байдаг юм бол? Яагаад энэ 10, 15 жил ял эдэлчхээд гарч ирээд, бага насны хүүхдийг дахин давтан хүчирхийлэх ийм асуудал гардаг юм бэ гэдэг энэ асуудал дээр та бас анхаарал тавьж өгөөч, онцгой анхаарч өгөөч гэж хүсэж байна. 2 дугаарт энэ.

3 дугаарт Эрүүгийн хуульд байгаа энэ магадлан бага насны хүүхдийг хүчирхийлсэн этгээдийг хэдийгээр чанга ял өгсөн ч гэсэн магадлангаар ингэж ялыг бууруулдаг, хугацаанаас нь өмнө сулладаг ийм асуудлууд бол үнэхээр амьдрал дээр байдаг юм байна. Тэгээд энэ гэмт хэргийн төрөл дээр магадлан гэдэг зүйлийг үнэхээр байхгүй болгож өгөөч гэсэн бас нэг ийм хүсэлт байна.

Дээрээс нь хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн ялын бодлогыг чангатгах талаар Хүчирхийллийн эсрэг лобби бүлгийн ахлагчийн хувьд 2 удаагийн хэлэлцүүлгийг Хууль зүйн яамтай бусад ТББ-тай зохион байгуулсан байгаа. Энэ ялын бодлогыг чангатгаж өгөөч. Хамгийн сүүлд нь эцэст нь согтуугаар байна уу, эрүүлээр байна уу тээврийн хэрэгсэл жолоодоод гарцтай байна уу, гарцгүй байна уу газраар хүний

амь нас, хүүхдийн амь нас хохироосон этгээдийг яаж дахин тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх, ямар ял шийтгэл өгөх тал дээр энэ ажлыг та цэгцлэхгүй бол энэ зам тээврийн осолд яг дайн байлдаанд үрэгдэж байгаа юм шиг ингэж хүмүүс маань, хүүхдүүд маань амь насаа алдаж байна.

Эцэст нь энэ хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэж байгаа, амь насыг нь хохироож байгаа этгээдүүдийг бүх л насаар нь хорих, ялын хамгийн өнөөдрийн мөрдөгдөж байгаа хуулийн дээд хэмжээг өгдөг, түүнийгээ яг эдлүүлдэг байх тал дээр та анхаарч. Тэгээд энэхүү асуудлуудад та ямар бодолтой байна вэ? Эцэст нь энэ цахим орчны хүчирхийлэл газар авсан. Тэр контейнер дээр байгаа хүүхдүүдийн асуудал бол гадаадын контентыг гар утсаараа үзэж байгаа хүүхдүүдэд ирж байгаа ийм буруу үлгэр дуурайлал байгаа. Тэгэхээр цахим орчинд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг мөн энэ намрын чуулганаар хэлэлцүүлэх ийм ажлыг бас гишүүний хувьд хийж байгаа. Энэ ажил дээр та ямар байр суурьтай байна вэ гэсэн асуултуудад хариулт авъя. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

**Б.Энхбаяр:** Хүүхдийн эсрэг хүчирхийлэл сэтгэл түгшээсэн асуудлууд ард иргэдийг чилээж байна олон жил. Сошиал орчинтой холбоотойгоор энэ мэдээлэл илүү их цар хүрээтэй, хурдан хугацаанд, тэр байтугай гэмт хэргийн мөрдөн шалгалтын үйл ажиллагаатай зэрэгцэж, бараг урьтаж олон нийтэд хүрч байгаа ийм асуудлууд ч яригдаж байна. Хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг манай улс 2017 оны Эрүүгийн хуулиараа хүүхдийн эсрэг гэмт хэрэг гэсэн бие даасан бүлгээр зохицуулж, урьд нь 3 зүйл ангиар ял шийтгэдэг байсныг 30 гаруй зүйл ангитай, ялгамжтай байдлаар зохицуулж шийдвэрлэсэн байдаг. Бага

насны хүүхдийг хүчирхийлэх гэмт хэрэгт манай улс эрүүгийн хууль тогтоомжид заасан ялын хамгийн дээд хэмжээ болох бүх насаар хорих ялын бодлоготой ийм улс байгаа. Аливаа ялын бодлогыг тодорхойлоход гэмт хэрэг явдал буюу криминологийн шинжлэх ухааны үүднээс хандах байр суурийг би урьд нь ч барьдаг байсан, энэ байр суурин дээрээ бас байдаг.

Энэ хүрээнд хүчирхийллийн шинжтэй, ялангуяа хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчирхийллийн үйлдлийг зураг, дүрс мэдээллээр олон нийтэд түгээх нь асар өндөр эрсдэлтэй гэдгийг бол би хэлэх байна. Дэд сайдаар ажиллаж байх үед хүүхдийн эсрэг хүчирхийлэл дээр цаазаар авах л хэрэглэх ёстой гэдэг акц бүтэн сарын турш явсан байдаг юм. Талбай дээр жагссан байдаг, ЗГ-т шаардлага тавьж байсан байдаг. Тухайн үеийн төрийн тэргүүн ч гэсэн энэ асуудлыг хөндөж байсан байдаг. ХЗДХЯ өдөр болгон улс оронд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн талаарх мэдээллийг өглөө болгон Хууль зүйн сайд танилцдаг. Тухайн нэг сар энэ үйл явдлын талаар олон нийтэд шуугьсны дараа 7-гоос 10 хоногийн хугацаанд бага насны хүүхдийг хүчирхийлсэн гэмт хэрэг эрс өссөн байдаг. Өөрөөр хэлбэл энэ асуудлыг ярьснаараа гаж донтон манекенуудад сэдэл өгдөг. Бага насны хүүхдийн эсрэг хүчирхийллийг үйлдэнэ гэдэг бол эрүүл хүнээс гарамгүй үйлдэл. Энэ бол сэтгэцийн өвчтэй ноцтой гэмт хэрэг.

Тийм учраас таны энэ хөндөж байгаа энэ асуудлыг магадлангаар гаргах ёсгүй гэдэг энэ бодлоготой би хувь хүний хувьд санал нэг байна. Санал нэг байна. Энэ бол өвчин, сэтгэцийн өвчтэй хүн. Тийм учраас энэ сэтгэцийн өвчтэй хүмүүст манай улс Эрүүгийн хуулиараа бүх насаар нь хорих ял ноогдуулж байгаа хамгийн дээд ялын бодлоготой байгаа.

Хүсэх зүйл байна. Энэ асуудлыг ярьснаар, зургийг нь тавьснаар буурахгүй. Улам хүмүүст нөлөөлдөг юм байна лээ гэдгийг би дэд сайдаар ажиллах

хугацаандаа цагдаагаас, улс орон дотор яг энэ асуудлыг гарсны дараах өдрүүдэд бүүр нэмэгдээд байсан. Би тухайн үед хэвлэлийнхнээс уулзалт хийж гуйж байсан. Битгий энийг бүүр.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Батсүхийн Саранчимэг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Б.Саранчимэг:** Баярлалаа. Тэгэхээр нийгэм, эдийн засгийн ийм амаргүй үед Нийслэл хотын захирагчаар ажиллах гэж ажиллахаар болж байгаа Нямбаатар сайд болон Монгол Улсын сайдаар томилогдож байгаа Энхбаяр сайд, Дэлгэрсайхан гишүүн нартаа бас амжилт хүсье. Тэгэхээр нийслэл хотын асуудал гэдэг бол ганц 1,5 сая хүний асуудал биш. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн асуудалд маш том асуудал болохоор ийм асуудал болж байгаа. Тэгэхээр 1,5 сая хүний асуудал биш, Монгол Улсын нийгэм, эдийн засагт нөлөөлөх том асуудал. Тэгэхээр Нямбаатар сайд бол Хууль зүйн сайд хийж байх хугацаандаа энэ хууль, эрх зүйн салбарт бас маш олон шинэчлэлүүдийг хийж чадлаа. Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийг бас эргэн харж, Монголд ашигтайгаар тохиролцож шийдвэрлүүлж чадсан. Энэ ЗГ-аас байгуулсан олон ажлын хэсгийг ахалж бас ажлын ард гарч чадсан.

Бүр цаашилбал бас Улаанбаатар хотын хамгийн том дүүрэг болох энэ СХД-ийг анхан шатаас нь удирдаж, бас Улаанбаатар хотын хүмүүсийн жаргал зовлонг мэдэх хүний хувьд бас өнөөдөр ингээд захирагчаар томилогдох гэж байгаад бол би бас Хууль зүйн сайдыг маш сайн хийж чадсан шигээ Улаанбаатар хотын Захирагчийн ажлыг бол сайн хийж чадна гэдэгт бас итгэлтэй байна байна. Тэгэхээр та бас сонгогдоод Улаанбаатар хотын иргэдийнхээ болон бүүр хүүхэд багачуудынхаа эрүү, аюулгүй орчин, ногоон хот болгохын төлөө илүү бас анхаарч ажиллаарай гэж хүсэж байна.

Нөгөө талаар Хууль зүйн салбарт шинэ залуу сайд томилогдож байна. Энхбаяр сайд бол бид 2 БЗД-ээс бас хамтдаа ингэж сонгогдсон. Тэгээд яг бас сонгогдох гээд явж байх үе болоод, одоо бас ярьж хэлж байгаа зүйлүүдээ яг ажил хэрэг болгох гээд энэнийхээ төлөө тууштай бас яг үнэнч ингэж явдаг, ингээд шударга, энэ салбартаа бэлтгэгдсэн ийм залуу сайд бас Хууль зүйн сайд болох гэж орж ирж байгаад бас үнэхээр баяртай байна. Тэгээд бас танд амжилт хүсье. Цаашидаа бас хүний эрхийг хамгаалах, бүүр цаашилбал бас энэ төрийн албанд үүрлээд байгаа авлигал, хээл хахууль мөн шударга бус асуудлуудтай хатуу тэмцэнэ гэдэгт бас итгэлтэй байна.

Эцэст нь бас Дэлгэрсайхан сайдад сайд болох гэж байгаад бас амжилт хүсье. Өнөөдөр бол хийсэн бүтээсэн ажилтай ийм хүн. Өнөөдөр яг 200 гаруй километрийг 8 сард хийчихсэн тийм компани, хувь хүн байна уу үгүй юу гэвэл бас л хэцүү. Тэгэхээр өөрөө өнөөдөр ажлаараа харуулчихсан, бас иргэдийн төлөө өөрийгөө гэхээсээ илүү дандаа л иргэд сонгогч, нутаг усныхаа төлөө явж байдаг. Тэгээд говь манай говь нутгаас бас сонгогдсон, говь нутаг шигээ тийм сайхан уужим ийм сайхан бас цэлгэр Улаанбаатар хотыг байгуулахад бас том хувь нэмрээ оруулаарай гэж хүсэж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Үг хэллээ. Салдангийн Одонтуяа гишүүн.

**С.Одонтуяа:** Хууль зүйн сайдад нэр дэвшиж байгаа Энхбаяр гишүүнээс асууна. Саяхан Монгол Улс НҮБ-ын хүний эрхийн комиссын индэр дээр бас л шившгээ л дэлгэлээ шүү дээ. Монгол Улс шүүхийн шийдвэргүй баривчилгаа 99 хувьтай гээд дахиад л ярилаа. Би ноднин жилийн турш л хэлсэн. Энийгээ асуудлуудыг нь хурдан хурдан шийдээд, энэ 10 дугаар сарын хурлаас өмнө энэ асуудлаа цэгцэлж болохгүй юу гээд л хэлсэн. Тэгээд л хийхгүй байсаар байгаад л

дахиад л сая тэр хүний эрхийн илтгэлд дурдагдсан.

Тэгэхээр би танд 3 албан бичиг танд ч юу байх вэ дээ өмнө нь энэ 7 дугаар сард, 8 дугаар сард, 6 дугаар сард ингээд 3 албан бичиг биччихсэн байгаа. Энэнийхээ хариултыг бол нэхэл хатуу нэхнэ. 2 асуудал нь бол энэ шүүхийн шийдвэргүй баривчилдаг асуудлыг зогсоох асуудал байгаа. Бүүр хуулийн төслийг нь бэлдээд, зүйл ангиар нь бичээд санаачлаад ингээд хүргүүлчихсэн. Одоо шууд та нар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульдаа оруулаад батлуулахад бол Монгол Улс шүүхийн шийдвэргүй баривчилдаг энэ асуудал бол нэлээд багасна. Энийг энэ та онцгой анхаараарай. Би бол протоколд тэмдэглүүлж байгаа.

2 дахь асуудал бол энэ бага насны хүүхдийг хүчирхийлсэн, бага насны хүүхдийг хүнд гэмтэл учруулж зодсон занчсан энэ асуудлыг ялыг хүндрүүлэх асуудлыг бол санал хүргүүлсэн байгаа. Тэгэхээр энэ асуудлыг, одоо энэ асуудлыг бас шийдэж өгөөрэй. Сая таны үгэнд бол орлоо, шийднэ зөв л гэж байна.

2-т энэ Нямбаатар сайдад хэлэхэд бас ажлаа өгч байгаа. Тэгээд энэ нэг өнгөрсөн 6 дугаар сард энэ хэд хэдэн кэйс дээр гадаадын иргэд, гадаадын хөрөнгө оруулалтын асуудал дээр бас нэг шуурхай шийдэж өгөөд асуудлуудыг нь яасанд бас баярласнаа илэрхийлье. Тэгээд шинэ ажилд бол би бол АН-аас нийслэлд ганцаараа сонгогдсон хүн. Доржханд бас сөрөг хүчин. Шаардлага өндөр тавьж ажиллана шүү. Үнэхээр танай Ариунзаяа сайд хэлж байна шүү дээ фронт руу явуулж байгаа. Та нар Улаанбаатар хотыг дайны байдалтай болгож байна шүү дээ үнэхээр. Одоо бүүр энд чинь ингээд л үер нь ус нь, одоо тэгээд тэр газар хөдлөлийн асуудал дээр ямар байр суурь байх юм. Энэ бүх зүйл дээр маш өндөр шаардлага бол тавьж ажиллана шүү. Тэгээд энэ Ерөнхий сайд ч гэсэн ер нь энэ нэг энэ нийслэлд яагаад ийм ингээд л

бид нарын яриад байдаг энэ түгжрэл, ширэнгэн бетон ширэнгэ гээд байдаг юм. Энэ дээр нэг бүүр ул үндсээр нь нэг юу шийдвэр гаргах хэрэгтэй судалж.

Яагаад ингээд 30 жил МАН засагласан шүү дээ. Тэгээд өнөөдөр нийслэл хот ийм байдалд байна вэ гэдэг дээр онцгой анхаарч бол ажиллах ёстой. Яг энэ утаа, түгжрэл энэ дээр чинь бол тэр нам, энэ нам гэхээсээ илүү Улаанбаатарчууд хохирч байна шүү дээ. Одоо хүмүүс гадагшаа бол ерөөсөө эрүүл орчинд хүүхдээ аваад явъя гэдэг бүүр ийм байдал руу орж байна. Тийм учраас энэ асуудлаа энэ намынхаа түвшинд ярь. Тэр буруу хот төлөвлөлт хийсэн бол МАН хариуцлага хүлээх ёстой. Буруу тэр түгжрэл үүсгээд, энэ нэг заваан хотыг ингээд нэг тосгон ч юм шиг, юу ч юм шиг ийм балиар болгосныхоо хариуцлагыг МАН хүлээх ёстой. Энэ дээрээ сайн ажилла. Энэ бол шинэ сайдууд нь бол онцгой анхаарч ажиллах байх. Тэгээд ер нь сөрөг хүчнээ их сонсохгүй, бага сонсоод, бид нарыг хэн хэлдэг юм гэсэн юунд л орохоор энэ хулгай чинь гаарч байгаа юм, энэ авлигал чинь цэцэглэж байгаа юм шүү. Энийг үргэлж анхаарч ажиллах ёстой гэдгийг хэлье.

Ерөнхий сайдад бас нэг хэд хэдэн гомдол байна. Нөгөө гүйх нохойд гүйхгүй нохой саад гэж үг байдаг. Бид нар 13 гишүүн 2021 оны 3 дугаар сард Хүүхэд хамгааллын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах өргөн барьсан. Энэ асуудлыг бол ЗГ өнөө маргаашгүй оруулж ирэх гэж байгаа шинэчилсэн найруулга, тэгээд хамтаръя гээд одоо хүртэл хэлэлцэхгүй байгаа. Тэгэхээр яагаад одоо хүртэл энэ Хүүхэд хамгааллын хууль орж ирэхгүй байна вэ? Яагаад Гэр бүлийн тухай хууль 2 парламент дамжаад орж ирэхгүй байна вэ?

**Г.Занданшатар:** Эхлээд Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Одонтуяа гишүүнтэй санал нэг байна. Энэ өнгөрсөн хугацаанд нийслэлд болсон зүйл ойлгомжтой авлигаас болсон. Байшин барихаас барихдаа зөвшөөрөл авахгүй, байшин барьчхаад зөвшөөрөл аваад ингээд яваад байхаар чинь яаж хот төлөвлөлт, яаж стандарт норм дүрэм хангах вэ энэ ойлгомжтой. Авлигатай нам харгалзахгүй тэмцэх ёстой гэдэг дээр санал нэг байна. Тэгж байгаа. Хатуу хариуцлага тооцож явна.

Харин АН-ын хувьд та бас сая нам ярьсан учраас та нар өөрсдөө бас яг энэ агуулга дээр хатуу байгаарай. Миеэгомбын Энхболд, Бадамжунай гээд нөхдүүд хариуцлага хүлээх ёстой. Бадамжунай нь баригдчихаад байж байгаа. Нийтийн тээвэртэй холбоотой энэ асуудал ч гэсэн анх Бадамжунай эхлүүлсэн бизнес юм билээ. Бид нар тийм мэдээллийг аваад, ингээд нягтлаад явж байгаа. Гэхдээ 2009-өөс авхуулаад олон удаа энэ нэг 3, 4 компаниуд их л асуудалтай байдлаар явсан юм байна лээ. Энийг бид нар бүгдийг нь ингээд углуургаар нь үзэх ёстой юм байна лээ ер нь бол. Энэ ингээд хийгдээд явж байгаа.

Би бас журмын нөхдүүддээ хэлж байгаа авлига бол одоо надад битгий гомдоорой гээд. Энэ ч агуулгаараа би их хатуу хандаж байгаа. Та хэд маань бас л энэ дээр зөвхөн мултарч үлдэх гээд ингээд улс төржөөд байвал бас юу болно доо нөгөө бас л нөгөө хотын асуудал цэгцэрэхгүй. Жишээлбэл Эрдэнэбилигт, Бат-Үүл дарга хотын дарга байхдаа хотхон бариад өөрөө амьдарчхаад, Эрдэнийн төгөл билүү нэг ийм хотхон байж байдаг юм. Удирдлагын академийн уг нь газар байсан юм байна лээ. Би чинь Хэрэг эрхлэхийн сайд байхад гайхаад байсан. Энэ асуудал дээрээ яг бид нартай адилхан та хэд маань бас хандахгүй бол бас нөгөө нэг хүнээ ингээд хамгаалах гээд л хариуцлага тооцоод ирэхээр сөрөг хүчин рүүгээ дайраад байна гээд ингээд улс төрийн байдлаар хэн нэгнийг хаацайлаад байгаад байвал болохгүй. Энэ дээр бас



Одонтуяа гишүүн Их Хурлын даргын хувьд бас хатуу байх ёстой шүү.

Сайханбилэг байна. Одоо Бадамжунай баригдаад л хүрээд ирлээ. Сайханбилэгийгээ та хэд авчрах хэрэгтэй. Тэгээд энчээнээс ингээд хадгаламж зээлийн хоршоогоор дамжуулаад ингээд санхүүжүүлээд байхаа бас болих хэрэгтэй. Энийг Энхбаяр дарга удахгүй энэ системийг нь олон нийтэд ил болгоод хэлэх нь зүйтэй байх. Тэгээд бас тэр нөгөө нэг АН-ын байр юу билээ нөгөө байраа яачихсан гээд Эрдэнэбилэгээс намынхаа санхүүжилтийг хийгээд байхаа та нар зогсоох ёстой. Наадах чинь бас л асуудалтай асуудал шүү ер нь бол. Тэгээд тал талдаа л энэ асуудлыг шийдье. Би тэгээд бас Их Хурлаас хүсэж байгаа нь энэ нийслэлтэй холбоотой авлигын асуудлыг энд хүрээд хэдүүлээ цэг тавьцаая. Газрын багц хуулиас авхуулаад бүх зүйлийг нь гаргаж өгье. Би бас Их Хурлын даргад ийм санал тавьсан. Дахиад хэлэхэд бид Ерөнхий сайдын хувьд миний бие хатуугаас хатуу хандана. Харин та хэд яг энэ хатуу зарчим дээрээ яг шаардаж байгаа шигээ, ярьж байгаа шигээ байгаарай. Тэгэхгүй бол тэгээд л энийг маань ч ингээд байна, тэрийг маань ч ингээд байна, Ажнайг маань ч больчхооч. Энэ дээр ингээд нэг ийм юмаар тохирчихъё, энэ дээр завсарлага авъя, больё гээд нэг ийм шалчигнасан зан бол битгий гаргаад байгаарай.

Та өнөөдөр нам хөндсөн учраас би бас буцаагаад ярилаа шүү. Тэрнээс би өнөөдрийг хүртэл нэг ч удаа улс төржссөн ямарваа нэгэн асуудлыг гаргаж яриагүй хүрсэн. Яриад байвал бас яриад байж болно шүү.

**Г.Занданшатар:** Хишигээгийн Нямбаатар сайд.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Би Одонтуяа гишүүн ХЗДХЯ-ны хуулийн бодлоготой холбоотой асуудал асуусан учраас Энхбаяр сайдаар томилогдох, тангараг өргөгдөхөөс өмнөх хугацаа дахь

энэ ХЗДХЯ-ны бодлогын асуудал надтай холбогдож яригдана.

Миний бие ХЗДХ-ийн сайдаар томилогдоод 3 жил 3 сар боллоо. Энэ хугацаанд ХЗДХЯ нийтдээ 60 хуулийн төсөл дээр ажиллаж, 27 хуулийг Улсын Их Хурлын чуулганаар батлуулж өнөөдөр хэрэгжүүлж байна. Товчхондоо яривал Цахимын багц хуулиуд, хувийн эрх зүйн салбарыг бэхжүүлэх, нийтийн эрх зүйн салбарыг гүнзгийрүүлэх хуулиудыг батлуулсан. Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатад 13 хууль өргөн баригдаад хэлэлцэх эсэхээ шийдчихсэн явж байна. Үлдсэн 20 хуулийг нь би цагийн дараа Энхбаяр даргад хавтаслаад хүлээлгэж өгөөд, энийг яаралтай Их Хурлаар өргөн барьж батлуулах ёстой шүү гэдэг ийм ажлын бас урьд өмнөх дарга цэргийн халаа солгио хийхдээ баримталдаг зарчмын дагуу төрийн ажлыг залгамж шинж чанартай хүлээлгэхэд бэлэн болж байна.

Одонтуяа даргын хэлж байгаа шүүхийн зөвшөөрөлгүй баривчилдаг гэдэг энэ ойлголтыг манай ХЭҮК-ын нэр бүхий гишүүд гуйвуулж орчуулж, ойлгуулж ийм олон түмэнд төөрөгдөл учруулж байгаа юм. Гэмт этгээд хүнийг хөнөөсөн, эд зүйл хулгайлсан, хүчиндсэн, баривчилсан тохиолдолд цагдаагийн эрх бүхий ажилтан газар дээр нь таслан зогсоогоод, прокурорын байгууллагад мэдэгдээд 48 цагийн хугацаатай баривчлах шийдвэрийг гаргуулдаг энэ зүйлийг шүүхийн шийдвэргүйгээр баривчилж байна гэж та маш удаан улс төржиж байгаа шүү. Өөрөөр хэлбэл шөнийн 02 цагт алуурчин хүнийг таслан зогсоогоод шүүх хурал хуралдуулах боломж хязгаарлагдмал байдаг.

Тэгэхээр бид нар энийг гэтлэн давахын тулд энэ сарын сүүлээр өргөн барих Шүүх байгуулах тухай хуулиар орон нутаг болгонд жижүүрийн шүүгч томилж ажиллуулах ийм эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа. Тэгэхээр та гэмт этгээдтэй халуун гараараа тэмцэж

байгаа хууль сахиулагчид шөнийн 02 цаг, 03 цагт гэмт этгээдийг баривчлаад тэр дор нь шүүх бүрэлдэхүүн хуралдуулах тухай ойлголт маш хүнд байдаг. Тийм учраас Монгол Улсын шүүхийн системд анх удаагаа Зөвшөөрлийн шүүхийн тогтолцоог оруулж ирж байгаа. Би энэ дээр нэг их нам улс төр ярихыг хүсэхгүй байна. Зүгээр энэ 48 цагаар баривчилдаг зохицуулалт өмнө нь 72 цаг байсан юм. Энийг хар баасан гарагийн баривчилгааг зогсоохын тулд бид 2017 оны 7 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн хуулиар 48 цаг болж, хүний эрхийн дэвшил гаргаж ирсэн.

Одоо бид нар бүх орон нутагт зөвшөөрлийн шүүхийн тогтолцоог анх удаагаа нэвтрүүлж, шүүгчийн зөвшөөрлөөр хойшлуулшгүй баривчлах энэ шийдвэрүүдийг гаргуулдаг энэ хуулийг өргөн барихаар байгаа гэдгийг хэлье. Гэр бүлийн хууль болон бусад таны дурдсан хуулиуд одоо Энхбаяр даргын ширээ рүү шилжих гэж байгаа. Эцсийн, ажлын хэсгүүд хэлэлцээд хурлаа хийгээд, өргөн барих бүх бэлтгэл ажил хангагдсан.

Эцэст нь хэлэхэд НИТХ хуралдаж НЗД-д нэрийг нь дэвшүүлж, Монгол Улсын Ерөнхий сайд батламжилж байж, НЗД-ын бүрэн эрх хэрэгжиж эхэлдэг. Тийм учраас би Үндсэн хууль давж янз бүрийн байдлаар өнөөдөр томилогдоогүй, тохоогдоогүй ажлын төлөө үүрэг хариуцлага, амлалт өгөх ийм боломж байхгүй гэдгийг хэлье. 2 дугаарт би Одонтуяа эгчид хандаж хэлэхэд томилогдохоос өмнө угаадас цацаад хэрэггүй дээ. Ядаж томилогдоод 2, 3 сар болсны дараа та бүхэн нийлээд.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Баттөмөрийн Энхбаяр томилогдох этгээд хариулна.

**Б.Энхбаяр:** НҮБ-ын хүний эрхийн шинжээчтэй миний бие ХЗБХ даргын хувьд уулзаж байсан. Ойлголтын зөрөө байдаг юм байна лээ. Сая Нямбаатар сайд бас хэлж байна. Бүх нөгөө асуудал

шүүгчийн зөвшөөрөлгүйгээр явж байна гэдэг нь манай улсын тухайд нүүдэлчин иргэншил соёлтой. Нөгөө хөдөө жишээлбэл сумд баригдчихсан хүнийг зөвшөөрлийг нь гаргах шүүгч нь аймгийн төв дээр байж байгаа байхгүй юу. Тэгэхээр манай улсын хамгийн алслагдсан сум 300 гаруй километр аймгийн төвөөсөө. Энэтэй холбоотой хамгийн боломжит бага хугацаа буюу хугацаа нь хуучин 2017 оноос өмнө 72 цаг байсан, 3 өдөр байдаг байсан.

Тухайн үед миний бие Хууль зүйн дэд сайдын хувьд энэ асуудлыг 24 цаг болгоё гэдэг хувилбараар Улсын Их Хуралд хуулийн төсөл өргөн барьж байсан. Хотод бол энэ асуудалгүй, төв суурин газар ямар ч асуудалгүй. Таны хэлж байгаа энэ асуудал үүсдэггүй. Гэтэл хуулийг аймгийн төвд болохоор ингэнэ хэдэн цаг, сумын төвд хэдэн цаг, Улаанбаатар хотод хэдэн цаг гэж нөгөө гаргаж болдоггүй. Хууль алагчлалгүй яг улсын хэмжээнд нэг мөрдөгддөг ийм үйлчлэлтэй байх ёстой гэдэг манай нөхцөл байдлаас улбаалаад 48 цаг гэдэг асуудал гарч ирсэн юм.

Сая Нямбаатар сайд хэлчихлээ. Хуулийн төслөө бэлэн болгочихсон буюу Шүүх байгуулах тухай хуулийг дагалдуулаад зөвшөөрлийн шүүхийн тогтолцоог оруулж ирэхээр бэлтгээд дууссан байна. Энэ хүрээнд таны сэтгэл чилээж байгаа НҮБ-ын шинжээчдийн мөн дүгнэлтэд орсон энэ асуудал хууль зүйн хувьд шийдэгдэнэ гэдэгт бол би бас итгэж байна.

**Г.Занданшатар:** Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр Монгол Улсын сайдад нэр дэвшиж байгаа 2 Улсын Их Хурлын гишүүндээ амжилт хүсье. Энэ ХЗБХ-ны гишүүний хувьд би энэ Хууль зүйн сайдад нэр дэвшиж байгаа Энхбаяр нэр дэвшигчид хандан бас тодорхой саналууд байна. Манай Монгол Улсын хөгжлийн хамгийн том чөдөр болсон

авлигын эсрэг асуудлаар, нийгмийн шударга ёсыг тогтоох асуудлаар Энхбаяр гишүүн маань манлайлан ажиллаж энэ Улсын Их Хурал дахь хамгийн их олны итгэл дэмжлэг хүлээсэн Хөгжлийн банкны нээлттэй сонсголыг бид нар хамтран зохион байгуулсан. Тэгэхээр энэ асуудлаар бол олон нийт бол их өндөр хүлээлттэй, үр дүнтэй байгаа. Тийм учраас дараагийн ноцтой асуудал буюу нүүрсний сонсголын асуудлыг мөн өндөр түвшинд хийж, олон нийтийн мэдэх эрхийг хангах, хуучин бид нарын нүднээс далд байсан иргэдийн нүднээс далд байсан асуудлыг ил болгох, парламентын нээлттэй сонсгол гэдгийг олон улсын жишигт хүргэх ажилд бас анхааран ажиллаасай гэдгийг хэлмээр байна.

Мөн дараагийн нэг асуудал нь сүүлийн үед Монгол иргэдийн маань хамгийн их айдас төрүүлсэн хүүхдийн эрхтэй холбоотой шил шилээ дарсан ноцтой хэргүүд гарч байна. Хүүхэд ерөөсөө гэрээс сургууль хүрэх замдаа л эрдэлтэй аюултай орчинд байна. Тийм учраас энэ хүүхэд хамгааллын асуудлаар Улсын Их Хурал, ЗГ холбогдох яамдын зүгээс хамтын ажиллагаа эрх зүйн томоохон шинэчлэлүүдийг хиймээр байна. Энэ чиглэл дээр Улсын Их Хурал дахь Хүний эрхийн дэд хорооны гишүүд бид нар бол санаачилгатай ажиллана. Энэ дээр хамтран ажиллах шаардлагатай байна.

Мөн энэ сүүлийн үед энэ хүүхдийн алга болсон асуудлаар бас тодорхой улс орнуудын хууль тогтоомжийг судалж байна. Ер нь хүүхэд алга болно гэдэг бол жирийн эрүүгийн мөрдөн байцаах процесс биш юм байна. Энийг бол асар өндөр түвшинд мэргэжлийн хүмүүс, мэргэжлийн байгууллага хийдэг. Энэ үйл явцын цаг минут бүхэн бол хүүхдийн ам настай холбогдож хэмжигдэж байдаг учраас энэ дээр бол нарийн зохицуулалт шаардлагатай. Өнөөдрийн манай цагдаагийн газрын мөрдөн байцаах бүтцэд бол хүүхдийн хулгайн асуудлаар тусгайлсан нэгж тасаг байхгүй байгаа. Тэгэхээр энийг бид нар тодорхой

шаардлагатай Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль юм уу бусад хуульд оруулах шаардлагатай байна. Энэ тал дээр бас Хууль зүйн сайдаар томилогдохоор анхааран ажиллаарай гэдгийг хэлмээр байна.

Мөн Монгол Улсын иргэд дунд гадаад руу зорчиж, хилийн чанадад урт, богино хугацаагаар амьдрах, сурч хөдөлмөрлөх явдал их нэмэгдэж байна. Тийм учраас бид нар энэ эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх нийт 23 улстай гэрээтэй байгаа. Энэ гэрээт улсуудынхаа тоог цаашид их нэмэх шаардлагатай байна. Их олон улс орнуудад бас иргэд маань эрх зүйн туслалцаа авч чадахгүй байна. Тэнд байгаа ЭСЯ-д, консулын газар хичээн зүтгээд ч гэсэн тодорхой эрх зүйн ийм гэрээгүй учраас тодорхой энэ үр дүнд хүрэхгүй, гацаанд орох магадлалтай байна. Тэгэхээр энэ тал дээр бас сайд маань манлайлан ажиллаарай гэдгийг хэлмээр байна.

Тэгээд ер нь бол Монгол Улсын ард түмэн бол энэ шударга шүүхийг, нийгмийн шударга ёсыг хүсэн хүлээж байна. Хэн нэгэн этгээд ял завиш гардаг давуу тал хамаарал бүхий этгээдэд олгодог энэ байдлын эсрэг бол зоригтой тэмцэж ирсэн. Түүнийгээ мөн үргэлжлүүлэн энэ хаврын намрын чуулганаар хэлэлцэх тодорхой хуулиуд дээрээ бас нэлээн сайн заалтуудыг оруулж ирнэ байх гэдгийг хэлмээр байна.

**Г.Занданшатар:** Санал хэллээ. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Би Ерөнхий сайд Оюун-Эрдэнийн хэлсэн үгийг сонсоод юуг илүү Их Хурал, ЗГ-тайгаа нийлж байгаад нээрээ хүний өөрийн биш энэ өнөөдрийн ийм байдалд хүргэсэн хулгайчдыг хатуу шийтгэх энэ арга хэмжээ дээр нээрээ тултал явах хэрэгтэй юм байна. Түүрүүн Нямдорж Нямбаатар сайд маань Хууль зүйн сайд байхдаа бас энэ ажил дээр нэлээд анхаарч байсан байх. Энхбаяр өчигдөр бас хэлсэн байна лээ. Энэ

хулгайтай тэмцэхэд илд шиг ажиллана гээд. Энэ дээр нээрээ бүгд ингээж ажиллах хэрэгтэй болж байна л даа. Өнөөдөр ингээд үүсээд байгаа бүх юм байна шүү дээ одоо энэ гэр хорооллыг хар, агаар, хөрсний бохирдлыг хар өнөөдөр хүүхдийн хүчирхийлэл гээд нэг кэйс гарч ирэхээр л бүгдээрээ шаагилдаад л шуугиад л явчихдаг. Тэгээд арга хэмжээ авдаггүй. Яагаад авдаггүй, төсөв мөнгө хүрдэггүй, хүний нөөц хүрдэггүй. Тэгээд мөнгө нь хаачсан ихэнх нь хулгай руу ингээд явчхаад байна шүү дээ. Том томоороо, нүүрсийг хар, Хөгжлийн банк тэрний өмнө олон зүйлүүд байна шүү дээ. Газрын наймаа, гэр хорооллын дахин төлөвлөлт гээд Чингис бондоос баахан мөнгө аваад бас алга болгочихсон 12-оос 16 оны ч жишээ байж байна.

Сүүлийн энэ Хөгжлийн банк, нүүрс гээд л харъя. Энэ мөнгөнүүдийг хэрвээ бид нар Улаанбаатар хотыг камержуулчихсан, смарт хот гээд юу аюулгүй хот чинь өөрөө юу юм бүх талаасаа камержуулчихсан, аюулгүй байх ёстой байхад өнөөдөр камерын асуудлаа ч шийдэж чадахгүй байж байна шүү дээ. Мөнгө байхгүй гээд. Гэтэл асар их мөнгө хулгайн замаар орж байна, авлигын замаар орж байна. Энэ нээрээ үнэхээр хэцүү байдалд орж байна шүү дээ. Хүүхэд хүчирхийлэх, хүүхэд алга болох энэ асуудал одоо үндэсний аюулгүй байдлын түвшинд ярих хэрэгтэй болж байна. Одоо бид төсөв хэлэлцэхдээ энэ камержуулалтын асуудлыг ёстой үнэхээр хангалттай шийдэх хөрөнгийг нь суулгах хэрэгтэй байна. Би Энхбаяр ХЗДХ-ийн сайдад та томилогдоод очихдоо энэ төсөв орж ирнэ. Мэдээж Нямбаатар сайд маань боосон байгаа байх. Гэхдээ энэ камержуулалтын асуудал дээр үнэхээр дорвитой арга хэмжээ авах хэрэгтэй байна. Энэ нэг номерын асуудал шүү.

Бид нар өмнө нь бас хэлж байсан. Энэ нэг хүсдэг юм байдаг юм. Бид хүүхдийн төсөв нэмээд л байна гээд. Жишээ нь 17 оноос бид нар ажлын хэсгийн ахалж байгаад төсөв дээр

эмэгтэй гишүүд нийлж байгаад 1 тэрбум хүрэхгүй байсан төсвийг өнөөдөр бид нар 11 тэрбумд авчирсан. Гэтэл төсөв нэмээд байгаа хэр нь хүүхдийн хүчирхийлэл, гэмт хэрэг нь буурахгүй. Харин ч улам өсчихсөн, онцгой түвшинд оччихсон байна. Тэгээд энд ямар байна гэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Гэр бүл, хүүхэд, залуучуудын том агентлагтай болчихсон хэр нь тэнд өнөөдөр хүмүүс нь үнэхээр өрөвдөлтэй ажиллаад байна. Бид нар бас тэд нарыг шүүмжлээд л байгаа хэр нь өнөөдөр тэд нар бичиж ярьж байна шүү дээ. Бүгд ядаргаанд ороод, ихэнх нь өвчин тусаад, цалин багатай мөнгөгүй, ажлаараа явахад хүртэл унааны мөнгө ч байхгүй учраас ихэнх нь ажлаасаа гарч байна. Тэнд хүний орон тоо байхгүй байна.

Хөдөө орон нутагт хүүхэд хамгааллын ажилтан бүүр 1, 2-хон байгаа. Тэгээд л жил болгон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарт та нар энэ дээр хүний нөөц дээр төсвөө нэмээч, энийгээ шийдээч гээд л бид нар хэлдэг. Бүүр нэг удаа Нямдорж сайдыг Хууль зүйн сайд байхад өмнөх 18 онд эмэгтэй гишүүд ярьж байж 13 хүүхдийн байцаагчийн орон тоог шийдсэн. Энэ маш том түлхэц болсон гэж ярьсан. Гэхдээ одоо энэ үнэхээр 50, 60-аар нь шийдэх хэрэгтэй байна гээд байгаа байхгүй юу. Тийм учраас бид нар нэг том, том юмаа барьж авахаасаа илүүтэй эхлээд ийм асуудлуудаа шийдэхгүй бол бид нээрээ гуравхан сая хүн амтай ийм дөнгөж өсөж явж байгаа ирээдүй хойч үеийнхээ эзэд болсон хүмүүсийг ингээд багаас нь алдаад байдаг. Тэгээд л нэг кэйс гарахаар л эмэгтэй гишүүд юм хийхгүй байна гээд.

Гэтэл бид нар төсөвт мөнгийг нь суулгаад л, хүний нөөцийг нь шийдээд байцаагч ингээд байдаг. Салбарын яам нь энэ дээрээ ингээд анхаарах тал дээр нээрээ сууж ажил хийх хэрэгтэй байна. Тэрнээс тэрэнд ажиллаж байгаа хүмүүс нь үгээ хэлж байгаа байхгүй юу. Тэгэхээр бодлогоор дэмжих хэрэгтэй байна гэдгийг хэлээд, би тэгээд Энхбаяр



гишүүнээс тэгж асуух гэж байна л даа. Одоо мэдээж ЗГ дээр Ерөнхий сайд маань ч энд байж байна. Тэр камержуулалттай холбоотой асуудал дээр бид нар ер нь дорвитой арга хэмжээ авах хэрэгтэй байна. Энийг олон улсын байгууллага яаж шийдэх юу байна вэ нэгд энэ дээр ер нь бас төлөвлөж, бодож байгаа зүйлүүд юу байгаа бол? Энэ дээр бид нар нэг анхаарах хэрэгтэй байна.

Сая Чингэлтэй дүүрэг smart city гээд бид нар бас олон улсын байгууллага, цагдаагийн газар Нямдорж, Нямбаатар сайдтай ярьж байж камержуулалтыг төвийн юундаа шийдсэн. Үнэхээр хэрэг болж байна. Яг энэтэй адилхан бүх хот аймгийг ийм болгох хэрэгтэй байна 1-д. 2-т нь түрүүн та бас яг хэлж байна.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хариулт хангалтгүй бол гэж байгаа. Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Түрүүн бас Одонтуяа гишүүн бас хариулж байхад минут дуусчихсан. Энэ хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой, хүний эрхтэй холбоотой бас ийм асуудал дээр бид нар үнэхээр бас ийм том хэмжээнд яг нийслэлтэй адилхан ийм дүгнэлт хийх цаг болсон бас. Энэ дээр би манай санал хэлж байгаа эмэгтэй парламентын гишүүд маш сайн ойлгож байна. Энхбаяр дарга бол одоо бас томилогдоогүй байгаа учраас шууд хэлэхэд бол бас бэлэн биш байгаа байх. Тэгэхээр 24 оны төсөв бол бас өмнөх төсвүүдээс нэлээн ийм хөрөнгө оруулалтын орон зай сайтай ийм төсөв болж өргөн баригдсан. Тэгэхээр энэ дээр ажлын хэсгийн явцад манай парламентын гишүүд ялангуяа эмэгтэй гишүүд маань ярьж байгаад та бүхэн камержуулалттай холбоотой яг ийм цогц асуудлыг гаргаж тавиад, энийг яг бүтэн хэмжээнд шийдэхэд бол миний хувьд бол дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна гэдгээ 1 дүгээрт илэрхийлье.

2 дугаарт бас яах вэ тэгээд энэ мэдээж 2 талтай асуудал ч гэсэн ер нь бид нар тэгээд л ялын бодлогоо яг энэ хүчирхийлэлтэй холбоотой асуудал дээр бол чангалах хэрэгтэй дээ. Чангалах хэрэгтэй. Тэгээд манайх яах вэ ер нь авлига дээрээ ч тэр ингээд бид нар, энэ шүүхийн процесс ч тэр ер нь л нэг тийм бас нэг тийм хэт нэг ийм зөөлөн, тодорхойгүй ийм эрх зүйн орчинтой шүү дээ. Одоо сая тэр нэг хүн алсан Махбал билүү нэг нөхөр тэгээд л одоо ял авлаа л гэнэ, гарлаа л гэнэ. Тэгээд л яаж байгаа ч юм тэгээд л ингээд л ер нь манай шүүгч тэгээд би сая бас 21 аймгаар тойроод, 21 аймгаар тойрсон уулзалт бараг л 8-аас 10 цаг, бараг 70, 80 хүн үг хэлсэн ийм л том уулзалтууд боллоо. Иргэдийн маань хувьд бол бас шүүх засаглалд их л тийм сэтгэл хангалуун биш байгаагаа илэрхийлж байна.

Гэхдээ манай шүүх засаглалынхан нэг зүйлийг бас ойлгох хэрэгтэй байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр ард түмэн эрхээ бариулах гэж парламентыг сонгодог. Нэг үгээр хэлбэл төлөөлөх эрхээ парламентад түр хугацаанд шилжүүлж байна гэсэн үг. Ингээд парламент гүйцэтгэх засаглалыг томилдог. Тэгэхээр ард түмний хүсэл эрмэлзэл шударга ёсыг тогтоох, шүүх шударга биш байна, албан тушаалтанд аядуу зөөлөн хандаж байна, ард иргэддээ хатуу хахир хандаж байна гэдэг ийм ойлголт 90 орчим хувь болчихоод байхад парламентаас төрсөн гүйцэтгэх засаглалын тэргүүн яаж дуугүй байх юм бэ. Энийг шүүхэд нөлөөлж байна, нөлөөлөх гэж байна гэж оролдож намайг огцруулах ийм санал хураалт эд нар хийж явахын оронд өөртөө дүгнэлт хиймээр байгаа юм. Адаглаад суурь судалгаа хийж үзэх хэрэгтэй.

Яагаад нийгэм ингэж хараад байна гэдгийг бас том зургаар нь харахгүй бол энэ өөрөө төрт ёсны асуудал болчихоод байна. Энэ дээр бас манай парламентын гишүүд та хэд маань бас хууль тогтоох эрхийнхээ хүрээнд энэ эрх зүйн орчныг

илүү чангатгах хүрээнд бас ЗГ-т дэмжлэг үзүүлээч. Авлигын асуудлууд бол бас нэлээн ингээд чангараад явчихсан. Одоо энэ хүүхэдтэй холбоотой, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой энэ асуудал дээр Энхбаяр дарга ч гэсэн бас уулзаж ярилцсан. Би бол нэг хэд хэдэн зүйл хэлсэн. Авлигын эсрэг хатуу байгаарай. Хүний эрхийн маш мэдрэмжтэй байгаарай. Хүний эрхтэй холбоотой саяын гарсан, Одонтуяа гишүүний хэлсэн тэр тайлан дээр үндэслээд бүүр тийм цогц байдлаар асуудлыг илүү тийм агуулгаар нь харах ёстой шүү. Тэрнээс нэг удаа яриад ингээд өнгөрөөд явах бол биш гэдэг ийм агуулгаар хандсан байгаа шүү гэдгээ бас илэрхийлье. Тэгээд өөр дэлгэрэнгүй хариулах зүйл байвал Энхбаяр.

**Г.Занданишатар:** Хариулах уу? Нямбаатар гишүүнээс асуулт асуухгүй, санал авах. Тодруулж л асууна. Хариулт хангалтгүй гэж үзвэл тодруулж асууна. Томилогдох этгээдээс гэж байгаа юм. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

**О.Цогтгэрэл:** Ерөнхий сайдын өнөөдрийн үг болоод өнөөдрийн энэ томилгоог нэгтгээд харахаар авлигын эсрэг гэдэг зүйл дээр зангидагдаж байна л даа. Тэгэхээр авлигын эсрэг байна, авлигын эсрэг тэмцэл гэдэг бол нээлттэй байдал ил тод байдал гэдэгтэй салиггүй холбоотой. Яг энэ хүрээнд бас тодорхой хэмжээний үр дүнгүүд гарч байгааг, үр дүнгүүд гарч байгааг бас үгүйсгэх аргагүй. Харин үр дүн гарч байгаа эсэхийг хэрхэн яаж үнэлж дүгнэх вэ? Яг энэ авлигын эсрэг тэмцэл болоод энэ дээр үр дүн гарч байгаа эсэхийг хэн нэгэн эрх баригч аль эсвэл сөрөг хүчин ч энэ дээр үнэлж дүгнэнэ гэдэг өөрөө бас субъектив. Яг олон улсын байгууллагууд авлигын эсрэг индексээр үнэхээр авлигын эсрэг ил тод олон зүйл нээлттэй болоод, авлигын үр дүнгүүд гараад байна гээд байгаа.

Гэтэл олон улсын индекс, авлигын эсрэг индекс яагаад сүүлийн жилүүдэд 76-д байсан билүү, одоо 116-д жилээс жилд

хойшлоод байна вэ? Олон улсын энэ байгууллагууд нь яагаад ингэж үнэлж дүгнээд байгаа юм бэ? Бизнес эрхлэхүй *doing business* гээд индексээр Монгол Улсад бизнес эрхлэлтийн нөхцөл байдал төрийн дарамт шахалт болоод бусад нөхцөл байдлуудыг үнэлээд бас яагаад 56 дугаар байранд байсныг сүүлийн жилүүдэд одоо бүүр 80 орчим байранд орчихсон байгаа байх. Яагаад бизнес эрхлэхэд Монгол Улсад улам төвөгтэй болоод байна гэж энэ индекс үнэлээд байгаа юм бэ?

2 дугаарт нь Ерөнхий сайдаас бас дахиад асуухад энэ хот доор бараг дайн болж байна. Хот доор том асуудал үүсэж байна гэж байна. Гэтэл тэр дайн болж байгаа фронт дээр чинь фронт гэж нэрлээд байх шиг байгаа юм. Энэ дээр чинь яагаад ийм салаа удирдлага тавигдаад байгаа юм. Хотын дарга гээд бүрэн эрхт орон нутгаасаа томилогдсон, бие даасан байдал бүхий удирдлага байна. Нөгөө талд нь бас нэг асуудлыг нь тасалж аваад тэрний сайд гээд тавьчихсан. Гэтэл тэр шуурхай удирдлага хэрэгтэй болчихоод байгаа, тэр дайн болоод байгаа хэсэг дээр чинь ийм салаа удирдлагатай, 2 удирдлагатай, асуудал нь нэг асуудал нь тийм төвөгтэй нийлмэл. Жишээ нь түгжрэл гэж байна. Түгжрэл чинь хот төлөвлөлт хотын даргаас олон зүйл хамаарсан ийм нөхцөл байдалтай байдаг.

Гэтэл энэ Түгжрэлийн сайд гэдэг хүн чинь яг эрх хэмжээ нь хүрч байгаа юм уу? Магадгүй энэ чинь өөрөө 2 хүний хооронд зөрчлийн асуудал руу аваачаад, нөгөө нэг хүссэн үр дүнд чинь хүрэхэд энэ удирдлага зохион байгуулалтын энэ эрх мэдлийн хуваарилалт чинь өөрөө сайнаасаа илүү саар байгаа юм биш үү? Та энэ дээрээ яг ямар бодол саналтай байдаг юм бол? Энд Сүхбаатар гишүүнээс асууж болох билүү, болохгүй билүү? Яг энэ асуудлыг энэ зовлонг нь туулаад, зовлонг нь гэж хэлэхээс дээ. Туулаад өнгөрсөн хүний хувьд яг та энэ түгжрэлийн асуудлыг шийдэхэд эрх

хэмжээ, менежмент явуулахад чинь, бодлого явуулахад чинь энэ зохион байгуулалтын асуудалд энэ Засгийн бүтэц бүрэлдэхүүн, орон нутгийн удирдлага хоорондын асуудал чинь танд ажил хийх боломж бололцоог олгож байсан уу?

Дараа нь яг үргэлжлээд яг дараагийн сайд аваад явахад илүү үр дүн гарна гэж та Сүхбаатар сайд бодож байна уу? Яг энэ дээрээ нэг, энэ чинь өөрөө хэн нэгэн хувь хүмүүсийн асуудал биш. Энэ яаж ч бодсон энэ шуурхай нэгдмэл удирдлага, зохион байгуулалттай бүтэц дээр чинь энэ салаа удирдлагатай бүтэц чинь угаасаа энэ чинь өөрөө том бодлогын алдаа яваад байгаа юм биш биз дээ гэдэг үүднээс л тодруулж асуугаад байгаа юм шүү.

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Яах вэ бид нар хотын асуудлыг ингээд зөнгөөр нь орхиод 30 жил явчихсан байгаа юм л даа. Тэгээд ЗГ болохоор хотын асуудал бол тэрүүгээрээ л ингээд шийдэгдэнэ биз дээ гээд ингээд орхичихсон. Тэгээд хааяа сайд нар нэг салбар салбараараа очиж нэг тийм хотын удирдлагуудыг жоохон зэмлэдэг нэг ийм агуулгатай. Нөгөө талдаа хотод бол өөрөө их тийм бие даасан том бүтэц учраас бараг ЗГ-аас хамаагүй том бүтэцтэй. Ингээд яг хот өөрөө энийгээ ажиллаад, цэгцлээд явж байна уу гэхээр үгүй. Ингээд л яваад байсан юм байна лээ. Тэгээд хэрвээ энэ зөв байсан бол өмнө нь томилогдсон энэ Хотын дарга нар асуудлаа шийдчих л байсан л даа. Тэгээд бидний нүдэн дээр л Богд уул маань нэг мэдэхэд л тэгээд л нүхлэгдсээр байгаад л нэг ийм эрэмдэг зэрэмдэг юм шиг л боллоо. Бидний нүдэн дээр энэ хойшоогоо чинь ингээд зуслангууд тэлсээр байгаад ингээд бүүр уул руугаа гараад явчихсан байна. Баянзүрхийн Гачуурт байсан гэр хороолол дахиад бүүр 2, 3 уул даваад ингээд явчхаж байна. Нүдэн дээр баахан зөвшөөрөлгүй

байшингууд баригдаад байдаг. Зайсан маань уг нь бол отог гэдэг нэртэй ийм аялал жуулчлалын зөвшөөрөлтэй майхнууд юм байна лээ шүү дээ. Тэгээд майхан гэж бодоод ингээд л ЗГ яваад л байсан.

Гэтэл энэ маань тэгээд сүүл рүүгээ байшин болж таараад байдаг. Тэгээд одоо нөгөө нүднийхээ шилийг арчиж байгаад дахин дахин хараад ч энэ бол яалт ч үгүй отог биш байшин байгаад байдаг. Газрын харилцаа нэг тусдаа. Ингээд хот маань өөрөө асуудлаа даахаа больчихоод байна л даа. Гэтэл хүн амын 50-иас дээш хувь төвлөрчхөөд байдаг. Одоо энэ 11 11 төвийн би мэдээллүүдийг ингээд аваад үзсэн. Ерөөсөө л 80 хувь нь зөвхөн Улаанбаатар хоттой л холбоотой гомдол ирдэг. Тэрнээс нэг их тийм өөр гомдлууд ирэхгүй. Өдөр тутмын харилцаатай асуудлууд нь маш хүнд болчихсон. Явган хүний зам дунд нь шонгийн мод зоогоод барьчихсан. Бид нар мэднэ шүү дээ ингээд л 3 дугаар эмнэлэг гээд л бид нар хүүхэд байхдаа 3 дугаар эмнэлгийн нүүр харагдахгүй нөгөө хөшөөг нь аваачаад хажууд нь тавьчихсан байна лээ шүү дээ. Сураг сонсоход тэгээд дандаа л хувийн эмнэлгүүд байдаг юм гэнэ лээ. Сургуулийн газрууд бүгд байхгүй болчихсон. 1 дүгээр хорооллын энэ тэр дундах байшингуудын газрууд бүгд байхгүй болсон байна лээ.

Тэгэхээр яах вэ Цогтгэрэл гишүүн ийм л байгаа юм л даа. Бид нар ингээд энэ бол хотын асуудал гээд даатгаад орхичхож болно. Гэхдээ ингээд байгаад байвал цаашаагаа 30 жил одоо байгаагаас хүнд байдал руу орчихвол яах вэ? Энэ агуулгаараа энэ түгжрэлтэй холбоотой энэ Үндэсний хорооны дарга гэдэг албан тушаалыг гаргасан юм. Энэ бол би маш зөв зүйл болж гэж бодож байгаа юм. Яагаад гэхээр хоттой холбоотой олон асуудал дээр ЗГ шууд мэдээлэлтэй болж байгаа юм. Өнөөдөр бид нар бүхэлдээ ЗГ Их Хурлаар орох гэж байна. Ингэж байж асуудлаа цэгцрэхгүй бол бид нар тэгээд л нэг одоо яваандаа

ингээд яг энэ хавиараа байгаад байвал хотын энэ динамикаа төр засаг дийлэхгүй шүү. Энэ их төвлөрөл, хот хөдөөгийн тэнцвэрийн энэ асуудлууд. Би Сүхбаатар сайдыг томилогдоод анх томилогдож байх үе, сая 1 жилийн дараа энэ түгжрэлтэй холбоотой бас асуудлууд дээр хийсэн зүйлүүдийг нь ингээд харахад бол яг нэг хүн дагнаж хариуцах нь үнэхээр зөв юм байна лээ. Тэрнээс бүх хүн ийм том асуудлуудыг тухайлж хариуцахгүйгээр ажлынхаа заваар хийгээд, ажлын хэсгийг хийгээд бол энэ явахгүй юм байна лээ.

Тийм учраас би бас энэ томилгоо байх нь зөв гэж энэ бол Ерөнхий сайдын итгэл үнэмшил. Би энэ байр сууриасаа ухрахгүй. Илүү эрх зүйн хувьд минут дуусаж байна.

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ гүйцээж хариулна, гүйцээгээд хариулчих.

**Л.Оюун-Эрдэнэ:** Авлигын индекстэй холбоотой асуудал. Авлигын индекс ахихгүй байгаа учраас л ЗГ-аас авлигатай тэмцэх жил болгож зарласан л даа. Тэгэхээр энэ дээр бас би АН-ын бүлэг бас дэмжлэг үзүүлж ажиллаж байгаад талархдаг. Яагаад гэхээр бас нэг зүйлийг ингээд хүмүүс ойлгоод байдаг. Яагаад ЗГ аж ахуйн ажлаа хийхгүй авлигатай тэмцээд байгаа юм бэ гээд ингээд бас шүүмжлэл өрнүүлдэг л дээ. Гэтэл яг үнэн. Авлигын олон улсын индекс манайд буухгүй байгаа учраас энэ дээр тэгээд бас л хараад л ингээд л ухраад л байхад нь хараад ингээд дуугүй л яваад байх биш, барьж аваад л асуудлаа шийдвэрлэх л ёстой л ийм асуудал л даа. Тэгэхээр энэ жилийн хэдүүлээ авлигын индексийг харъя. Бид нар нэлээн олон бас ахицууд гаргасан. Энэ бол саяын тоонуудаар харагдаж байгаа. ДНБ-ий тэлэлт зэрэг олон зүйл дээр. Тэгэхээр хэдүүлээ авлигын төсөөллийн индекс энэ жил яаж гарах, тэрнээс би бас энэ авлигатай тэмцэх энэ ажиллагааг илүү эрчимжүүлэх эсвэл бас эрх зүйн орчны хүрээнд яаж ажиллах вэ гэдэг бас стратегиа тодорхойлно гэж

бодож байгаа. Түрүү жил цагаан сарын үеэр энэ чинь зарлагдсан шүү дээ тийм ээ. Тэгээд яг авлигын төсөөллийн индекс зарлагдсанаас 7 хоногийн дараа авлигатай тэмцэх жил болгоод ЗГ зарласан. Тэгээд 1 жилийн хугацаанд бас нэлээн олон л зүйл болж өнгөрлөө. Энэ дээр бас АН, АН-ын бүлэг бас дэмжлэг үзүүлж ажиллах нь бол зүйтэй болов уу гэж бодож байна.

Хүмүүс бас тэгж байгаа юм. Хоттой холбоотой асуудлыг надад их олон хүмүүс хэлсэн л дээ. Ингэж байхаар тэгээд л орхичихгүй юу даа л гээд. Орхихоор асуудал нь шийдэгддэг бол болж л байна. Тийм учраас би орхих биш энэ удаа хэдүүлээ их хотынхоо асуудал, энэ 30 жил бугшсан асуудлыг ёстой нэг тийм том хэмжээнд бас нэг хатгийг углуургаар нь шахаж гаргахгүй бол энэ цаашаа улам их ужгираад засагдахгүй хэмжээний ийм асуудал болчих бас том эрсдэл байна. Тэгээд дараа дараагийн хүмүүст хэдүүлээ асуудал өвлүүлж үлдээх биш, аль болохоор шийдэх гэсэн ийм хүсэл эрмэлзлээр л ажиллая. Энэ ч агуулгаар бас өнөөдөр Нямбаатар сайдыг хот руу явуулж байгаа эд нар бол ийм л агуулгаар харж байгаа юм. Их Хурал ЗГ-тайгаа илүү холбогдоод ажиллачхаасай билээ, шийдэл гаргачхаасай билээ л гэж бодож байгаа юм. Тэрнээс биш Нямбаатар сайдыг ЗГ-аас явуулах бол сонирхол Ерөнхий сайдын хувьд бол надад байхгүй байсан нь бол маш ойлгомжтой.

Тэгэхээр би бас парламентад суудалтай намын бүлгүүдээ бас уриалахад энэ яг энэ эрх зүйн түвшинд хэдүүлээ хаврын чуулганаар маш ачаалалтай ажилласан шиг энэ намрын чуулганыг бид нар энэ нэг нутаг дэвсгэрийн нэгж, хот байгуулалт энэ бүх зүйлүүдээ нэг цогц байдлаар нэг эргэж харъя. Тэгээд энэ асуудал дээр нэлээн тийм том дүгнэлт хийе. Энэ маань өөрөө бас дараа дараагийн асуудлууд ч гэсэн их тийм чухал байх болов уу. Энэ дээр бас Нямбаатар сайд өөрөө яг энэ хууль зүйн салбарт ажиллаж байсан хүн илүү



турилагатай ажиллах болов уу? Энэ дээр нь Их Хурал, ЗГ бас дэмжээд өгчихье. Тэгээд магадгүй 3, 4 жилийн хугацаанд шийдэгдэх байсан асуудлыг бид нар эрх зүйн хувьд нь адаглаад чиг хандлагынх нь хувьд энэ намрын чуулгандаа бас багтаагаад томоохон хэмжээний шийдэл гаргаж чадвал нийслэлчүүдэд маань илүү тийм чухал байх болов уу. Тэгээд бид нар ер нь барьж аваад л асуудал ард нь гарах л ёстой шүү дээ. Тэрнээс биш асуудлаас зугтаагаад ямар асуудал хэвээрээ л үлдэх юм чинь. Би тэгж л бодож байна.

Тийм учраас парламентын гишүүд та бүхнээс бас гүйцэтгэх засаглалын тэргүүний хувьд уриалж байна. Хэдүүлээ их хотынхоо асуудалд намрын чуулганаа бүхэлд нь нэг зориулчихъя. Би ч бас ЗГ дээр ийм тусгайлсан тогтоол гаргасан. ЗГ-ын салбар салбарын сайдуудыг зөвхөн нийслэлд анхаар гэж байгаа юм. Болохгүй байгаа зүйлүүдийг хэдүүлээ сайхан дэлбэлье, болохгүй байгаа асуудлууд дээр хариуцлага тооцъё, цэгцэлье, идээ бээрийг нь шахъя. Тэгээд ирээдүйн чиг хандлагыг нь тодорхойлоход бас дэмжлэг болгоё. Эрх зүйн орчных нь хүрээнд Нямбаатар сайд, мөн Улаанбаатар хотоос сонгогдсон парламентын гишүүд маань бас нийлж байгаад бүүр нэг тийм том хэмжээний тийм реформ хийх энэ зүйлийг иргэдтэйгээ хамт, олон нийттэйгээ хамт хэдүүлээ хийгээд үзье. Тэгээд би бас нийслэлчүүдээ ч гэсэн уриалж байна. Их Хурал, ЗГ бас энэ намрын чуулганаар нийслэл Улаанбаатар хот руу нэлээн чиглэл чиглэх нь. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ жижиг хэмжээнд намчирхаж талцсан ч юм уу ийм хандлагаа жоохон хойш нь тавьж байгаад яг бодитой үндсэн агуулгын шийдэл юу байх вэ гэдэг дээр илүү олон нийтээрээ ярилцаж шийдэл гаргая.

Тэрнээс нэг үе болохоор нэг буужигнаад л, тэгснээ намдаад л, нэг асуудал болохоор л 2, 3 хоног баахан савж юм ярьж ярьж байснаа тэгээд мартаад л ингэж явмааргүй байна. Одоо хэдүүлээ нийслэлийг бол нэлээн бүхэлчилж харъя

гэж бодож байна. Тэгээд энэ агуулгаараа нийслэлтэй шууд холбогдох нийслэлийн асуудлыг бас ЗГ руу орох мэдээлэх дэмжлэг үзүүлэх ийм гүүр зайлигүй хэрэгтэй байгаа. Энэ бол тэгээд яам биш нэг л хүн шүү дээ. Гэхдээ энэ асуудал маань өөрөө том байгаад байдаг.

Боомт ч гэсэн тэгээд би энэ бүтэц бас зөв байжээ л гэж бодож байгаа. Өнөөдөр боомтууд сэргэж байна. Та бүхэн тоо худлаа ярьдаггүй, экспортын оролт гаралт энэ бүх статистикуудаа хараарай. Хэдүүлээ бас болж байгаа зүйлээ болж байгаа гэж бас хэлэх нь зүйтэй. Бидний мөрөөдөл л байсан шүү дээ 74 их наяд руу Монгол Улсын эдийн засаг хүрч, ДНБ 6000 ам.долларт хүрнэ гэдэг бол. Одоо бид нар ирэх жил очих гэж байна. Харин яаж бид нар 7000 руу, 8000 руу явах вэ гэдэг дээрээ л чиглэвэл Монгол Улсад л хэрэгтэй. Тэгэхээр Боомтын сайд энэ бүтэц бол зөв байсан гэж би харж байгаа. Би бас тэгээд Сүхбаатар сайд бас эрх зүйн хувьд нэлээдгүй тийм олон зүйлүүдийг хийсэн байна лээ. Би зүгээр Дэлгэрсайхан сайдын хувьд бол бас авто зам, төмөр зам дээр олон жил ажилласан аж ахуйн хүн. Энийг бол бас том түвшинд шийдчих болов уу. Ер нь бол аж ахуйн хүн байх нь зүйтэй юм байна гэж би бодсон. Одоо би бас нугаад яах вэ. Би Баатарсайхан Ерөнхийлөгчид бас санал тавьсан юм энэ ажлыг хийгээч гэж.

Тэр нь нөгөө нэг улс төрч гэдэг агуулгаараа биш, яг нэг тийм бизнесийн менежер, төр хувийн хэвшлийн түншилэлээр нийслэлийн асуудлыг илүү хурдасгаад шийдчихээч гээд энэ агуулгаар. Тэгэхээр би бол бас Дэлгэрсайхан гишүүн ингээд сайд болоод яг энэ илүү авто замын сүлжээ, хүчдэлээс авхуулаад их олон зүйлүүд дээр зөвхөн нөгөө нэг төсвийн хөрөнгө биш, нийслэлийн хөрөнгө биш, төр хувийн хэвшлийн түншилэлээр бас их олон асуудлуудыг шийдэж чадах болов уу. Хувийн хэвшлийнхэнтэйгээ илүү их тийм хамтарч ажиллах тийм боломж гарах

болов уу гэсэн ийм бодолтой байна гэдгээ бас хэлье.

Тэгээд бизнесийн орчинтой холбоотой Худалдаа аж үйлдвэрийн танхимын шинэ удирдлагуудтай бид нар бас холбогдсон. 30 жил болсон байна манай хувийн хэвшил төлөвшин хөгжжөөд. Компанийн хууль бараг 1996, 1997 оны хууль одоо хүртэл хэвээрээ байна. Энэ бараг Корпорацын хууль болохоос авхуулаад их олон зүйлүүд дээр бас эрх зүйн тийм том шинэчлэл хэрэгтэй байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ дээр бас хувийн хэвшлийн төлөөлөл болж байсан парламентын гишүүдтэйгээ бас хамтраад бас энэ 30 жил дээр нь бас нэг тийм дүгнэлт хийгээд, тэгээд танхимтай ЗГ илүү хурдтай, илүү хувийн хэвшлийнхээ бизнесийн орчныг сайжруулахын төлөө, энэ дээр төрийн оролцоог бас багасгахын төлөө ЗГ бол идэвхтэй, хурдтай бас хамтарч ажиллана гэдгээ бас илэрхийлье. Тэрэн дээр бас АН-ын бүлгийн даргын хувьд та бас идэвхтэй оролцвол талархах болно гэдгээ илэрхийлье.

**Г.Занданшатар:** Болохгүй дэгээрэй Ерөнхий сайд болон томилогдох этгээдээс л асууна, бас учиртай байх нь.

**Г.Занданшатар:** Ням-Осорын Учрал гишүүн.

**Н.Учрал:** Энэ Монгол Улсын ЗГ-ын 5Ш ажиллагааны хүрээнд энэ ажиллагаа эхлээд тэр *shilen.gov.mn* гээд нээлттэй мэдээллийн санд хандалт бол 30 сая авсан. Тэгээд энэ шилэн ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Ерөнхий сайд албан даалгавар гаргаад 4 сарын хугацаанд ЗГ-ын эргэн төлөгдөх нөхцөлтэй 7 сангаас яг өнөөдрийн байдлаар бол 32 тэрбум төгрөг эргэж төлөгдсөн байгаа юм. Тэгэхээр энэ бол маш бас сайн үзүүлэлт юм байна. Эдийн засагт бас эергээр энэ авлигатай тэмцэх ажил бол бас үр дүнгээ өгч байгаа гэж бас харж байгаа. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд бол тэр нөгөө төрийн албаны

нууц, албаны нууц гээд нэг тамга дараад нууцалдаг байсан олон мэдээлэл хуульд бичигдсэнээрээ өнөөдрийн энэ шилэн ажиллагаа ил тод байдал бол биеллээ олж байгаа.

Тэгэхээр энэ цахимжилттай холбоотой энэ 4 багц хуулийг бол Нямбаатар сайд бас Хууль зүйн яамнаас санаачилж өргөн барьж батлуулсан. Тэгэхээр Нямбаатар сайдын энэ хууль зүйн салбарт оруулсан өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажил бол бас нүдэн дээр харагдаж байгаа. Тэгэхээр жишээ нь энэ 4 хуулиас гадна энэ *egate* нэвтрээд эхэлчихсэн их сайн үр дүнтэй ажил. Энэ гадаадын хөрөнгө оруулагч нар компани ААН-үүдээр нь *F* регистр олгоод эхэлчихсэн байна. Анх удаа иргэний үнэмлэх дээр нь чип суулгаад тоон гарын үсэг тарааж эхэлснээс хойш 800 мянгад бас өнөөдрийн байдлаар хүрсэн гээд сайн үзүүлэлтүүд бол маш их байгаа. Тэгэхээр би Энхбаяр сайдад бол энэ сайн ажиллаж байсан сайдын ажлыг үргэлжлүүлж хийнэ гэдэг бол маш их хариуцлага, хурд, хүч шаардах байх. Тэгэхээр ийм хурдтай ажиллаасай гэж бас хүсэж байна.

2-т бол өнгөрсөн парламентын үед Бүртгэлийн хууль дээр ажлын хэсэгт ажиллаж байхад та бол дэд сайд байхдаа энэ дэд ажлын хэсгийг ахалж байсан. Тэгээд саяын яг хэлдгээр энэ нөгөө *opendataburtgel*, *opendata.gov.mn* гэдэг 2 нээлттэй мэдээллийн сан байрлаж байрлаж байгаа. Гэтэл яг үнэндээ өнөөдөр жишээ нь танд бас хэлэхэд энд нэг хоорондоо байгууллага хоорондын зөрчлүүд маш их бий болчихоод байгаа юм. Жишээ нь УБЕГ бол өнөөдөр иргэний цахим гарын үсгийг олгоод 600 мянгад хүргэсэн. 5 байгууллагад тоон гарын үсэг олгох гэрчилгээг олгож байгаа нь Цахим хөгжлийн сайд олгодог. Тэр 5 байгууллагын олгож байгаа тоон гарын үсгийн асуудлыг нь Үндэсний Дата төв хариуцдаг. Ингээд *g-sign* бол бүртгэлийнх, *e-sign* бол ИМонгол академийнх гээд. Ингээд энэ хоорондын зөрчлөөс болоод ийм нэг хамтарч тэр

дүрэм журмын хувьд ийм нэг түгжэрлүүдээс болоод бол нэлээдгүй олон ажлууд бол бас саатах гээд байгаа нөхцөл байгаа.

Тэгэхээр цаашидаа бол бас нэг кабинетад ажиллахын хувиар энэ ажлуудыг их хүргэж уялдаа холбоог нь хангах нь бол та бидний хувьд их чухал байна. Таны тэр ажиллаж байсан үеийн тэр opendata дээр тавигдсан тэр нээлттэй мэдээллийн сан өнөөдөр shilen.gov.mn-тэй холбогдох ёстой байтал төрийн 3 байгууллага энийг хувааж эзэмшиж байгаа юм. Сая шилэн ажиллагааны хүрээнд газар олголтын мэдээллүүдийг 25 жилийн газар олголтын мэдээллийг ил болгоход газар зүй, зураг зүй, Геодези, зураг зүйн газар, Байгаль орчны яам, нийслэл, дүүрэг, аймаг, сум бүгдээрээ газар олголтын мэдээлэл нь тусдаа байсан. Тэгээд энийг нь нэгтгээд шилэн дээр байрлуулах гэж бүүр үйлээ үзсэн. Тэгэхээр цаашидаа энэ мэдээллүүдийг нэгтгэхгүй бол өмнө нь нөгөө Их Хуралд хууль батлуулаад ингээд ажиллаж байхад яг нөгөө хөрсөн дээрээ нөхцөл байдал ямар байгаагаа төдийлөн бас бид мэддэггүй. Тэгэхээр яг энэ хөрсөн дээрээ бол энэ байдал бол нэлээн бас анхаарал татаж байгаа.

Тэгэхээр Нямбаатар сайдтай бол өнгөрсөн хугацаанд энэ ажлыг хооронд нь холбох гэж бас сайн хамтарч ажилласан. Тэгэхээр энэ ажил дээр таныг бас анхаарлаа хандуулж, олон нийтэд мэдээлэл авах, ил тод байх, цаашидаа энэ авлигын төсөөллийн индексийг бууруулахад хамтарч хичээн зүтгэж ажиллаасай л гэж хүсэж байна.

**Г.Занданшатар:** Үг хэллээ, санал тавилаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр ЗГ-ын үйл ажиллагаатай холбоотой ер нь бол өнөөдрийн эрх баригчидтай холбоотой юм яримаар байна. Тэгэхээр МАН өөрсдийнхөө хийсэн нүүрсний хулгайтай тэмцэний үр дүнд Монгол Улсын хилээр

гарч байгаа нүүрс дээр авлигал хээл хахуулийг бий болгож, хүнд суртлыг бий болгодог нөхдүүд нүүрсний тэр салбараас холдсоны үр дүнд экспорт өдөртөө 350 мянга хүрсэн мэдээ гарсан байгаа. Энэ бол сайн үр дүн. Тэгээд энэний үр дүнд төсвийн орлого хагас жилийн байдлаар 23 хувиар нэмэгдсэн гэдэг ийм мэдээлэл гарсан. Энэ бол Монголын ард түмэнд хэрэгтэй. Тэгэхдээ иргэд бол үнэхээр энэ Боловсролын зээлийн сан, Хөгжлийн банк, нүүрсний хулгай, төмөр замын хулгай, энэ ногоон автобус, тэгээд С зөвшөөрөл гээд бас нэг юм байна. Улирал тутамд 8 мянган машинд нэг машин 20 сая төгрөгийн авлигал өгөөд ингээд С зөвшөөрлөө аваад 160 тэрбум төгрөгийн авлигал улирал тутам яваад л байгаа. Тэрэн рүүгээ ордоггүй.

Энэ бүх зүйл чинь бол хэрээсээ хэтрээд энэ Монголын эдийн засгийг хойшлуулах араги нь тавих бүх зүйлийг хийгээд байна. Тэгээд хөдөөгүүр явж байхад, ярьж байхад бол ерөөсөө л нэг нэгэндээ барьцаалагдсан эрх баригчид нөгөөдөө ерөөсөө хариуцлага тооцохгүй байна гэж байна. Миний хүн нүүрсний хулгайд холбогдсон юм уу, чиний хүн чинь Хөгжлийн банкин дээр холбогдсон шүү дээ, тэрийг чинь шалгая. Тэгээд л нэгнийгээ чимээгүй болгодог. Тэрнээсээ болоод ямар ч хариуцлага тооцох механизм ерөөсөө ажилладаггүй ийм л байдалтай байгаад байна. Тэгэхээр одоо энэ мэдээж энэ ялангуяа энэ хүмүүсийн сошиалаар болон бусад энэ хэвлэл мэдээллийн хэрэгслээр нь хариуцлага нэхдэг энэ зүйл бол үнэхээр ард түмэн туйлдаа хүрсэн учраас маш тийм хатуу чанд чанга байх ийм нөхцөл байдал ялангуяа сонгуулийн үеэр харагдах юм байна гэж. Энэ дээрээ хүмүүстээ хариуцлага тооцохгүй бол цааш цаашидаа энэ Монголын эдийн засгийг хорлож байгаа энэ нөхдүүд мэдээж манай намын нөхдүүд ч байдаг, энэ их бүх сүүлийн үеийн хулгайчууд бүгдээрээ өнөөдрийн эрх баригчтай холбоотой. Тал талдаа хариуцлага тооцоод явахгүй бол болохгүй л гэж би бодож байгаа.

Магадгүй сая Одонтуяа гиш  
гишүүн рүү юм ярьдаг шиг над руу ярьж  
магадгүй. Тэгэхдээ би бол нам дотроо 50  
хувь нь тэмцэл хийдэг. Энэ болохгүй  
байгаа бүтэхгүй байгаа нөхдүүдийг дахин  
оруулж ирэхгүйн төлөө явдаг. Тийм ч  
учраас өнөөдрийг хүртэл энэ нам дотроо  
ад үзэгдээд явж байгаа. Тэгэхдээ АН энэ  
хулгайнуудыг хийх шийдлүүдийг гаргана.  
Хөгжлийн банкин дээр гадаадын банкны  
менежментийг оруулна. Эрдэнэс таван  
толгой, төмөр зам, төрийн өмчийн  
томоохон компаниуд дээр Эрдэнэт энэ  
тэр дээр ААН-үүдийн болон иргэдийн  
хяналтыг оруулах замаар тэдэнд 40  
хувийн хувьцааг нь олгоно, эзэмшүүлнэ.  
Автобус тэнд төр худалдан авалт хийж  
өгдөг биш, тэнд ажиллаж байгаа ААН-  
үүд, хувийн ААН-үүд өөрсдөө уралдаж  
хөрөнгө оруулалтаа хийдэг, тэнд нь төр  
шаардлага тавьдаг ийм эрх зүйн юу  
нөхцөл бололцоог бий болгоно. С  
зөвшөөрөл гэдэг юмыг огт байхгүй  
болгоно. Уулаасаа 2016 он хүртэл тэр С  
зөвшөөрлийг зүгээр нэг хүн дуртай хүн  
нь.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд  
Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Пүрэвдорж  
гишүүнтэй санал нэг байна. Яг үнэн. Бид  
нар авлига дээр нам харгалзахгүй яг  
тэмцэх яг энэ агуулгаараа л хандмаар  
байгаа юм. Бид асуудлыг нуугаад л яваад  
байж болох байсан. Хөгжлийн банкттай  
холбоотой асуудлыг, Таван толгойтой  
холбоотой асуудлыг, ингээд л Эрдэнэт  
гээд ингээд. Энэ ужгираад л байх байсан,  
ужгираад л байх байсан. Олон хүмүүс  
надад хэлдэг юм. Энэ асуудлуудыг гаргаж  
тавьснаараа нийгмийг их бухимдуулж  
байна та нар. Намынхаа нэр хүндийг  
унагааж байна, намынхаа журмын  
нөхдүүдийг хүнд байдалд оруулж байна  
гээд. Би яг энэ танхимд сууж байгаад л  
одоо өөрөө орж ирж сууж байгаад л  
журмын нөхдөө энэ танхимаас гаргах  
зүйлийн санал хураалт дээр би яг ингээд  
байж байсан. Надад хувь хүний хувьд

Аюурсайханд тэгж хандах хэцүү, байнга  
янз бүрийн мессежнүүд ирнэ.  
Бадамжунайгийн гэр бүлээс өшөө авна л  
гэдэг мессеж сүүлийн үед нэлээн л олон  
хүнд ирсэн. Нямбаатар сайд ч энийг авсан  
байх. Хувь хүний хувьд ингээд яваад байх  
төвөгтэй. Наад суудал чинь үүрдийн юм  
биш гээд л баахан хүмүүс мессеж бичдэг  
юм үнэн.

Гэхдээ бид нар ийм асуудлуудыг  
мэдсэн ч мэдээгүй юм шиг царайлж,  
нөхдөө хамгаалж, өмгөөлж явсаар  
байгаад л Монгол Улсыг ийм байдалд  
оруулчихсан нь үнэн байхгүй юу даа.  
Тэгэхээр би бас Пүрэвдорж гишүүний  
хэлж байгаа үгэнд бол талархаж байна.  
Яг л үнэхээр тийм зарчмаа та хэд маань  
барьж чадвал. Гэхдээ бид энэчээнээс  
цэвэрлэгээ хийх гэж оролдож байгаа,  
танай намынхан авлигачдаа  
бөөгнөрүүлж авч байгаа шүү. Энийг чинь  
олон нийт харж л байгаа. Би сая 21  
аймгаар тойрсон. Танай намын жирийн  
гишүүд чинь дургүй байна лээ шүү. Энэ  
дээр та хэд маань бас өөрсдөө дүгнэлт  
хийнэ биз дээ, чүй ай энэчээнээс нь ингээд  
нэг гаргах гэдэг, та нар тэгээд намдаа  
оруулж ирээд улс төрийн хамгаалалтад  
аваад нэр дэвшүүлээд, жагсаалтаар  
оруулаад ирвэл тэгээд ямар юмны ийм  
тэмцэл байх вэ дээ. Энэ дээр тэгээд  
Пүрэвдорж гишүүн хатуу байгаарай.

Дээрээс нь үнэн үнэн. Ер нь бол  
одоо бид нар бас суралцах ёстой.  
Хөгжлийн банкттай холбоотой асуудал 1,5  
тэрбум ам.долларыг аваад зүгээр та нар  
фракцаараа хувааж авсан шүү. Энэ  
асуудал чинь ингээд тэр нөгөө 1,4 их наяд  
нь одоо л төлөгдөж байна. Сая л бид нар  
дефолтоос гарсан шүү. Чингис бондыг  
төлж. Тэгээд өөрсдөдөө зориулаад та  
нар Өршөөлийн хууль баталчихсан шүү.  
Одоо хууль хяналтын байгууллагуудад  
хүндрэл болоод байгаа зүйл тэр Ил тод  
байдлын чинь тухай хууль. Авлигынхаа  
хэргийг та нар мэдүүлчихсэн. Ийм зүйл  
дахиж хэзээ ч гарч болохгүй. Энэ дээр та  
хэд маань бас дүгнэлт хийчих хэрэгтэй.



Эрдэнэтийн 49 хувьтай холбоотой асуудал 6 сарын 29-ний өдөр сонгуулийн өдөр шийдэгдсэн шүү. 6 сарын 20-ноос 29-нд 9 хоногийн дотор 400 сая долларыг 8 компаниар дамжуулаад нэг залууд өгсөн. Энэ таны хайртай ах Элбэгдоржийн чинь хийсэн ажил шүү. Та Элбэгдоржтой бас хатуу байх ёстой. Зарчим бол 2 үзүүртэй байх ёсгүй. Оюу толгой Сайханбилэг ЗГ-аараа хуралдуулаагүйгээр энэ асуудал болсон шүү. Ганцаараа захирамж зурсан. Тийм эрх Ерөнхий сайдад байхгүй. Одоо тэгээд нөгөөдөх нь зугтаачихсан. Нөгөө Сайханбилэг байхгүй байгаа учраас шүүх дээр нь хэргийнх нь бүрдэл нь хангагдахгүй гээд ингээд ийм асуудлууд прокурор дээр байж байгаа. Тийм учраас энэ энэ зүйлүүд дээр хаана хаанаа шүүмжлэлтэй хандъя. Би хотдоо хэлж байгаа шүү дээ. Хатуу хандана. Би өнөөдөр ч гэсэн энэ.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Би танд хэлсэн. Би энэ Их Хурал дээр явуулдаг тэмцэл бол миний тэмцлийн 50 хувь юм. Нам дотроо хийдэг тэмцэл маань миний тэмцлийн бас 50 хувь байдаг юм. Энэ 7 жилийн хугацаанд хамгийн их удаан хугацаагаар Их Хурлын гишүүнээр суусан нь би байх. Хамгийн их тэр өнгөрсөн хугацаанд энэ АН-ынхан зарим нэг нөхдүүдийн идээж уусан тэр зүйлүүдийн угаадас нь над руу хамгийн их цацагдсан байх. Тэгэхдээ би бол тантай нэг санал байна. Сайханбилэг ирэх хэрэгтэй. Үл бүтэх нөхдүүдийг жагсаалтад оруулахгүй байх тэр бүх тэмцлийг би энэ 24 оны сонгуулиар хийнэ. Ардын намтай хуйвалддаг, АН намаа худалддаг тэр нөхдүүд өнөөдөр ингээд нэг үг.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд Лувсанпүрэвийн Оюун-Эрдэнэ хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Пүрэвдорж гишүүнд баярлалаа. Би ч бас тийм зарчим барина. Та нар наад талдаа наад

авлигачдаа цэвэрлэ, бид бас цэвэрлэнэ. Ингэвэл Монголын төр тунгалаг болно.

**Г.Занданшатар:** Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

**Ш.Адьшаа:** Өнөөдөр ЗГ-ын гишүүнээр томилогдож байгаа Борхүүгийн Дэлгэрсайхан, Баттөмөрийн Энхбаяр нар нартаа бас амжилт хүсье. Ямар ажил, ямар хариуцлага, юу хийснийг цаг хугацаа, түүх харуулна. Та 2-оос асуух зүйл алга.

Ерөнхий сайдаас нэг асуулт асууя. Авлигатай тэмцэх энэ 30 жилийн хулгай луйврыг илчилсэн, ард түмний итгэлийг сэргээх талаар бас энэ ЗГ хамгийн сайн хийсэн юмны нэг гэж би хууль тогтоогчийн хувьд үздэг юм. Энэ амар байгаагүй. Төрийн өмчийг хулгайлдаг, газрын наймаа хийдэг, нүүрсний хулгай луйварт холбогдсон тэр Манан бүлэглэл гэж гэдэг энэ том этгээдүүд сиймхий хараад нэг хэрэг дээр дөрөөлж, толгойгоо өндийлгэхийг оролдож байна гэсэн ийм бодол надад төрж байна. Сая энэ ногоон автобусны хэрэг гэж ийм хэрэг гарч ирж, энэний буруутнуудын тухай бас нийгэмд талцуулсан олон талын мэдээллийг цацсан. Түүний дотор энэ асуудалд тагнуулын байгууллага энийг зохион байгуулсан. Түүний удирдлага оролцсон гэдэг юмыг олон нийтэд ийм байр суурийг илэрхийлсэн. Энэ дээр би санал нийлэхгүй байгаа, санал нийлэхгүй байгаагаа хариуцлагатай хэлье.

Энэ ЗГ-ын нэг гишүүн өөрчлөгдөхөөр тэр тухайн салбарын удирдагуудыг өөрчилдөг ийм тогтолцоо байдаг. Энэ авлигатай тэмцэх тэмцэлд, энэ хулгай луйвартай тэмцэх энэ амаргүй юунд энэ тагнуулд, хууль хүчний байгууллагын оролцоо бас нэлээн байсан гэдгийг гэдэгтэй хэн ч маргахгүй гэж бодож байгаа. Тэгэхээр энэ хууль хүчний байгууллагыг шинэ сайд томилогдсон энэ нөхцөлд өөрчлөгдөх үү, өөрчлөх ийм бодлого байх уу? Энэ талын нэг л хариултыг авмаар байна. Яагаад гэхээр

энэ хүмүүс аливаа нэгэн гэмт хэрэг дээр дөрөөлсөн, тэр өш хонзон авахыг оролдсон ийм оролдлогууд чинь өнөөдөр гарч ирэх нь, ийм юмыг зохион байгуулах ийм бодолтой ил далд үйл ажиллагаанууд явагдаад эхэлсэн байна. Энэ дээр нэг хариулт авъя гэж бодож байна.

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Авлигатай холбоотой бас энэ асуудал дээр ЗГ хууль хяналтын байгууллагууд ажиллаад ирэхээр шахагдаад нэг хэдэн авлигачид амь тавихдаа чарлаж байгаа юмыг би аж ажиглаж байгаа. Гадна, дотнын нөлөө байж ч магадгүй гэж бодож байгаа. Би Ерөнхий сайд байхдаа хууль хяналтын байгууллагуудын тэмцээж байгаа мөрдөстнүүдээ хамгаална. Би авлигачтай тэмцэнэ. Бас янз бүрийн асуудлын дүйвэн дундах энэ нүүрсний хэрэгтэй холбогдсон, Эрдэнэт гээд энэ том авлигатай холбогдсон нөхдүүд бас зохион байгуулалтад орж, энд тэнд уулзаж, янз бүрийн асуудлууд зохион байгуулж байгаа ийм мэдээллүүдийг авч байгаа юм. Би дахиад хэлчихье, би тэмцлээсээ сөөм ч ухрахгүй. Энийг бас хатуу хэлчихье.

Би Адьшаа гишүүний асуултад энэ нийслэлийн нийтийн тээвэртэй холбоотой асуудлыг сая бид нар бас нэлээн судалж үзсэн. Энэ 3 компани ер нь сүүлийн нэг 20-иод жилийг нь ингээд бүтэн хяналтдаа авчихсан юм байна. Тэгээд хотын удирдлагуудаа бас нэлээн барьцаалдаг юм байна. Ажил хаялт боллоо шүү, бид нар их хүнд хэцүү асуудлууд явж байгаа шүү гээд. Нийтийн тээвэртэй холбоотой энэ асуудлыг шинэчлэх энэ том төсвийг Их Хурал баталж өгсөн. Энэ бол зөв зорилгын хувьд. Гагцхүү тэр хуучин системийг бид нар яаж задлах вэ л гэдэг ийм асуудал байгаа юм. Би бас Гадаад яамаар дамжуулаад Энхбаяр дарга очоод бас энэ асуудал руу нэлээн орох байх. Гадаад яамаар дамжуулаад тэр Дэвү гээд компанийн нөхдүүдээс тэр

лавлагаануудыг нь авч байгаа юм. Энэ дунд бас олон асуудлууд болсон байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ энэ бол нэг удаагийн үйлдэл биш юм байна лээ. Өмнө нь бараг арваад удаагийн ийм үйлдэл.

Тийм учраас энэ дээр нийслэлийн хувьд бас нэг ийм систем дунд орчихсон. Энэ дунд нь бас тэр компаниудтай нь бас улс төрчид их холбоотой байж магадгүй ийм эхний мэдээллийг бол би авчхаад байж байгаа юм. Бас л хориод жил дотор олон л зүйл бас болсон байж магадгүй юм байна лээ дээ. Тэгээд л танай намын дарга байсан нөхрөөс авхуулаад л, манай нам дотор байсан Бадамжунайгаас эхлээд л, дунд нь Нийслэлийн иргэдийн Хурлын Төлөөлөгчид, одоо нэг их шударга ёс яриад байгаа нөхдүүд эд нар бүгдээрээ л нэг ийм юу яадаг юм байна 5 автобусны квот, 10 автобусны квот эд нар гээд нэг ийм чиглэлүүдээ авдаг юм байна. Яагаад гэхээр хүн суулгасан үгүйгээс үл хамааран километрээр дамжуулж мөнгө авдаг юм байна. Ингээд гол гол ийм зангилаа замууд бүгдээрээ тийм аль байх нь хамгийн чухал вэ гэдэг бол манай Нийслэлийн иргэдийн Хуралд сууж байгаа зарим нөхдүүдийн бас бизнес болсоор удсан байна. Яах вэ ийм асуудлууд байгаа учраас л хэдүүлээ бид нар нөгөө нийслэл рүүгээ нэлээн гүнзгий орохгүй бол болохгүй болчхоод байна гээд.

Би сая баярлаж байгаа юм. Энэ нөгөө нэг ЗГ-ын түвшинд санхүү нь тавигдсан учраас сая энэ чинь талбай дээр ил гарч байгаа байхгүй юу. Тэрнээс энэ чинь ингээд нөгөө 10,20-иороо, 30-аараа, 40-өөрөө ингээд л ороод л бид нар ерөөсөө анхаарал хандуулдаггүй. Тэгээд л энэ чинь их олон жил ингээд болоод ирчихсэн ийм асуудал юм байна. Тийм учраас энэ дээр хэдүүлээ нэлээн тийм нарийвчилж хөөхгүй бол асуудал ихтэй юм байна лээ. Тэгээд Сүхбаатар сайд ч гэсэн бас надад зовлонгоо ярьсан. Энэ асуудлуудыг бас ингээд илчлээд нэлээн тийм дэлгэрэнгүй бас ярих нь зүйтэй юм байна лээ.

*Ер нь би өнөөдрийн үгэнд та бүхэн ажигласан байх, хэдүүлээ ингээд нийслэлийн асуудлыг энэ нийслэл хэмээх нэг ийм бүтцэд даатгаад орхиод 30 жил болчихсон байдаг. Гэтэл хүн амын маань 50 хувь байгаад байдаг. Шууд ерөөсөө оролцож болдоггүй. Тэгээд л нэг ийм асуудлууд байгаад байдаг. Гэтэл энэ маань өөрөө их тийм ужгирчихжээ. Одоо хэдүүлээ нийслэлийн бүтцийг эргээж харахгүй бол бас болохгүй болсон байна.*

### **Г.Занданшатар:**

*Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.*

**Б.Бат-Эрдэнэ:** *Би 2 зүйл хэлээд орхиё. 1 дүгээрт бол бид энэ сүүлийн 33 жил, ер нь 30-аад жил энэ Монголын нийгэмд үүссэн өнөөгийн байдал, энэ гэмт хэрэг, зөрчил, тэгш шударга бус байдал энэ ерөөсөө олхиогүй болохгүй байгаа бүх юмны эх үндэс бол эндээс төрийн эрх барих үе үеийн энэ төрийн эрх барих дээд байгууллагад ажиллаж байсан, төрийн тамга эрх мэдэл барьж байсан энэ хүмүүсийн л хариуцлагатай энэ хүмүүсийн л байдлаас шалтгаалж байгаа ийм зүйл. Айл гэрт бол аав, ээжээс нь шалтгаална шүү дээ. Үүнтэй адилхан энэ улс гэр, нийгэм ямар байна гэдэг бол энэ төрийн эрх барих дээд байгууллагад байгаа хүмүүсийн энэ үйл ажиллагаанаас юм.*

*Энэ дотроо авлигал, хулгай, ашиг сонирхлын зөрчил энэтэй л шууд холбоотой. Яг энэ үндсэн гол гогцоог нь бол Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд бол үнэхээр сайн барьж авсан шүү. Энэнээсээ сая хэлж байна ухрахгүй гэж. Ухарч болохгүй, ухрах арга байхгүй. Ухрах л юм бол ер нь энэнээс цааш унах газар байхгүй л гэж бодоод байгаа юм. Бүүр л цаашаа хэцүү болно шүү. Би бол энэ 4, 5 бүрэн эрхийн хугацаанд бол энэ л асуудлыг тавьж, би бол туйлишдаг хүн л дээ. Өөрөө хөндлөн туйлираад, энэ хэрэглээгээ хумь, элдвийн юманд огт битгий оролц та нар. Энэ төрийн албыг төрлийн алба болгодог, төсөл тендер, концесс, лиценз, төр, ард түмний нэр*

*барьж авсан зээл, бонд, үгүй ээ энэ элдвийн юманд та нар битгий оролцооч гэдэг ийм шаардлагыг тавиад, бодлого шийдвэр санаачлаад, энэ дотор чинь ад болоод ингээд 20-иод жил болж байгаа хүн шүү.*

*Тэгээд заримдаа бол энэний сайн цагийг үзэхгүй юм байна даа гэж мохох, сэтгэл санаагаар унах ийм үе бол тохиолдож байсан. Гэтэл бол Оюун-Эрдэнэ энийг зоригтой эхлүүлээд ингээд хийх гээд явж байна. Та бид нар энэ Их Хурал, ЗГ хамтраад тэр Төрийн хэмнэлтийн хууль, энэ Эрүүгийн хуулийн хариуцлагыг чангатгах, энэ Авлига, ашиг сонирхлоос ангид байх энэ хуульд чинь өөрчлөлт оруулчихлаа шүү дээ. Одоо энэ хулгайчууд төсөл тендерт орж чадахгүй. Төр ард түмний нэр барьж авсан зээл, бондоос авахыг нь хаагаад өгчихсөн. Төрийн албыг төрлийн алба болгодог энэ байдлыг нь хаасан. Харин энэ дундуур би бас энэ хуулийг баталж байхад хэлж байсан. Наад дундуур чинь юм шургуулчихлаа шүү гэж. Одоо энэ хуулийн хэрэгжилтийг хангахад тэр этгээдүүд өөрийнхөө хамаарал бүхий этгээдүүдээ аваад үлдэх вий, энийг бүүр харах, анхаарах ёстой гэж ийм зүйлийг би хэлэх гээд байгаа юм. Одоо бол бид нарт юу 2 юм хэрэгтэй байна вэ гэхээр 1 дүгээрт бол өөрөө энэ олсон орлогоо нотолж чадахгүй бол нөгөө төрд хураалгадаг Синганур бусад улс орнуудын жишиг ийм сайн жишигийг хэрэгжүүлсэн хууль гаргах хэрэгтэй. Энэ хаана байна гэж ийм зүйлийг би асуух гээд байгаа юм.*

*Дараагийн нэг юм бол ингээд дүлийдээ найдаад гэдэг шиг яах вэ ингээд хэвлэл мэдээллээр ингээд л гүтгэж л байдаг гэдэг энэ далбаа дор энэ хулгайчид, авлигачид, луйварчид чинь энэ дотор ингээд 30 жил суусан байхгүй юу. Энэ хүмүүсийг ямар нэгэн иргэд, мэдээлэл, энэ хэвлэл мэдээлэл хаана ч байдаг юм энэ мэдээлэл өгсөн л бол тэрний дагуу шалгадаг, өөрөө сайн дураараа очоод цагдаа хуулийн байгууллага шалгадаг ийм зарчим руу л оруулах хэрэгтэй. Би энд 20*

жил суухдаа энэ зарчмыг л барьж байгаа. Өнөөдөр ч би цагдаагийн байгууллагад би энэ хэвлэл мэдээллээр гарсан надтай холбоотой асуудлыг би шалга гэдэг гомдлыг л би өгөөд байгаа юм. Хэрвээ надад асуудал байх юм бол надад хариуцлага тооц. Энэ нөхдүүд чинь тэгэхгүй байна шүү дээ. Хуулийн байгууллага нь прокурорын хяналт доор шалгаад, Ерөнхий прокурор бүрэн эрхийнхээ хүрээнд оруулж ирэхэд бол.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ хариулна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Олон нийтийг бас бухимдуулсан ийм асуудлуудыг гаргаж тавьж байгаа, ийм асуудлуудыг бас сая орон нутгаар явж байхад хүмүүс ярьж байна лээ л дээ. Зөв л гэж байна лээ. Яах вэ түр зууртаа бухимдаж болно. Гэхдээ дараад ямар ингээд яваад байлтай нь биш дээ. Зөв өө зөв гэж л байна лээ. Тийм учраас бид нар цаашдаа ч гэсэн ийм бухимдах асуудлуудыг гаргаж магадгүй, гаргахаас ч өөр арга байхгүй. Энэ дээр бол би зарчмын хувьд санал нэг байгаа.

Гэхдээ их том сургамж болж байгаа байх гэж би найдаж байгаа юм. Дахиж Хөгжлийн банкнаас зээл авах тийм парламентын гишүүн олдохгүй дээ, би энэнд итгэж байгаа юм. Дахиж энэ сангуудаас зээл авах ийм асуудлууд гарахгүй дээ. Гарвал их л мэдээлэл муутай эсвэл их л тийм дахиж сонгогдъё гэж бодохгүй эд нар тийм л хүмүүс л ийм зүйл рүү орох байх. Энэ бол бас их тийм том сургамж болсон. Дахиж парламентаар оруулахгүйгээр Эрдэнэт шиг том ордыг нэг хэдэн хүмүүс сонгуулийн 9 хоног дотор төрийн мөнгөөр хувьдаа авахгүй дээ. Дахиж Ерөнхий сайд ганцаараа захирамж гаргаж, Дубайн гэрээ хийхгүй дээ. Дахиж парламент өөрөө өөрсдийгөө хамгаалж Өршөөлийн хууль батлахгүй дээ.

Тэгэхээр яах вэ энэ бол ингээд бас эргээд бодоход бол ийм том сургамж

болж байгаа юм. Эцсийн хариуцлага гэм бурууг зөвхөн шүүх шийднэ. Шүүхийг нүд цавчилгүй хараарай гэж би дахин дахин хэлээд байгаа юм. Шүүх өөртөө дүгнэлт хийгээсэй л гэж бодож байгаа юм. Тэрнээс би шүүхэд нөлөөлөх гээд байгаа тийм агуулга биш. Ард түмнийхээ нийтлэг хүсэл эрмэлзлийг ойлгож ухаараасай билээ л гэж бодож байгаа юм. Энэ дээр нь бид нар эрх зүйн хувьд дэмжлэг үзүүлнэ. Ард түмний төлөөлөгчийн хувьд дуу хоолойгоо шүүхээр хориулахгүй. Энийг би бас хатуу хэлчихье.

Бат-Эрдэнэ сайд энэ дээр их олон жил асуудлыг хөндсөн. Тэгээд Энхбаяр сайд томилогдож байна. Ер нь бол авлигын нотлогдсон орлого бол улсын өмч байх ёстой, энэ эрх зүйн орчныг бол илүү чангатгах ёстой. Яагаад гэхээр мөнгө нь хэвээрээ үлдчихдэг юм байна лээ эд нар. Мөнгө нь хэвээрээ үлдчихдэг. Тийм учраас мөнгө аль нэг хэлбэрт ороод байж байгаа энэ асуудал нотлогдсон тохиолдолд тэр хөрөнгийг бол улсын өмч болгож хураах ёстой. Энэ дээр би бас нэг зүйлийг манай парламентын гишүүд бас ойлгож, ЗГ-т бас дэмжлэг үзүүлээсэй гэж хүсэж байна. Хувийн өмч, хулгайн өмч 2 бол өөр зүйл шүү. Хувийн өмч, хулгайн өмч 2 бол өөр зүйл. Баялаг бүтээгч, баялаг ашиглагч 2 бол өөр зүйл шүү. Энийг бид нар маш сайн ойлголцож, энэ дээрээ бас хууль, эрх зүйн орчноос авхуулаад улс төрийн соёлоо бас өөрчлөхгүй бол нэг ийм гоё нэршлийн цаана авлигын том систем бас нуугдаж, ургаж төлждөг юм байна лээ шүү. Одоо бид нар энийг гэхдээ ойлгож байна.

Гэхдээ саяын дүнгүүдийг та бүхэн төсөв дээр хараарай. ДНБ 21 оноос хойш 2 дахин тэлчихсэн байгаа шүү. Энэ бол ийм хэмжээний далд эдийн засаг бүртгэлжсэн гэсэн үг шүү. Энийг Сангийн сайд бас илүү дэлгэрэнгүй тайлбарлах байх. Үнэ ханиш бүгд тогтвортой байсан юу ч өөрчлөгдөөгүй. Энэ бол далд эдийн засаг, бүртгэлгүй мөнгө. Энэ мөнгөөр улс төр тогтворгүй байсан байхгүй юу. Өнгөрсөн 30 жилийн 1,5 жилийн настай



Засгийн газруудын хувь тавилан бол энэ байсан юм. Энэ байсан юм. Одоо энэ алдсан боломжоо буцааж авах гэж наад том системийн авлигачид чинь аль аль намыг нь худалдаж авах гэж энэ сонгуулиар их юм болно шүү. Ээ дээ битгий гэнэдээрэй, хатуу байгаарай. Тэр намын байрны юу гээд ийм зүйлээр наад Эрдэнэбилэгээсээ АН нь хол байгаарай гуйж байна.

Манай нам дотор байгаа системийнхээ хүмүүсийг зайлуулах гэж бид нар үйлээ үзэж байна. Та нар битгий халаасанд нь орчхоорой. Яг үнэн Пүрэвдорж гишүүнтэй би санал нэг байна. 3, 4 авлигын том асуудлаас болж огт буруугүй нөхдүүд нь өнөөдрийг хүртэл нүүр рүүгээ ус цацуулж байгаа биз. Авлигын хэрэг яг ийм байдаг. Тийм учраас энэ дээр бид нар хатуу цэг тавиад дуусах ёстой шүү. Нэг ч хүн ухарч болохгүй. Ингэж чадвал Монгол Улс маш.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. ЗГ-ын гишүүнийг чөлөөлөх, томилох тухай асуудлыг Монгол Улсын Ерөнхий сайд Улсын Их Хуралд танилцууллаа.

Энэ чинь албан ёсоор томилчхоод дараа нь тангараг өргөнө шүү дээ тийм ээ. Тэгээд юу яана. 30 минут энэ ширээ, сандал. 30 минут, ЗГ-ын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө. Тангараг өргөх ёслолын ажиллагаанд бэлдэх хугацаа шаардлагатай тул чуулганы нэгдсэн хуралдааныг 30 минут түр завсарлуулъя.

17.49 цаг

Хуралдаан 17 цаг 49 минутад түр завсарлаж, 18 цаг 20 минутаас үргэлжлүүлэн хуралдав.

### **Тав.Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа**

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Засгийн газрын

гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагаа эхлэхэд бэлэн болсон байна. Тангараг өргөх ёслолын ажиллагааг ямар дарааллаар явахыг танилцуулъя. Эхлээд Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ Засгийн газрын гишүүдээр томилсон тухай захирамжийг уншиж танилцуулна. Тэгээд ЗГ-ын гишүүд тангараг өргөнө. Эхлээд Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Борхүүгийн Дэлгэрсайхан тангараг өргөнө. Дараа нь Монгол Улсын ЗГ-ын гишүүн Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр тангараг өргөнө. Гишүүд чуулганы танхимд цуглая. Өлзийсайхан даргаа маргаашийн хуралд оруулсан нэмэлт, Үнэнбат дарга тэр юун дээрээ тавьчхаарай. Гишүүдийн зар, Даргын дэргэдэх зөвлөл дээр тавьж батлах ёстой юу үгүй юу?

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Засгийн газрын гишүүдийн тангараг өргөх ёслолын ажиллагааг эхэлье. Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ ЗГ-ын гишүүдээр томилсон тухай захирамжийг уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

**Л.Оюун-Эрдэнэ:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасныг үндэслэж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 160 дугаар захирамжаар Борхүүгийн Дэлгэрсайханыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны даргаар, 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 161 дүгээр захирамжаар Баттөмөрийн Энхбаярыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар тус тус томиллоо.

**Г.Занданшатар:** Баярлалаа. ЗГ-ын гишүүд тангараг өргөнө. Монгол Улсын ЗГ-ын гишүүн, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын Авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга Борхүүгийн Дэлгэрсайхан таныг тангараг өргөхийг урьж байна.

**Б.Дэлгэрсайхан:** Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс түүх соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.

**Г.Занданшатар:** Монгол Улсын Засгийн газрын гишүүн Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр таныг тангараг өргөхийг урьж байна.

**Б.Энхбаяр:** Монгол Улсын Засгийн газрын гишүүн би улсынхаа ашиг сонирхлыг эрхэмлэн, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг хүндэтгэж, Монгол Улсын Үндсэн хуулийг дээдлэн сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн хууль биелүүлэх ажлыг төр, ард түмэн, Монгол Улсын Ерөнхий сайдын өмнө биечлэн хариуцаж, Засгийн газрын гишүүний үүргээ чин шударгаар биелүүлэхээ тангараглая. Миний бие энэ тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ.

**Г.Занданшатар:** Баярлалаа. Монголын төр, ард түмний нэрийн

өмнөөс албан томилолт, үүрэг даалгавар өвөртлөн Засгийн газрын гишүүд Улсын Их Хуралд тангараг өргөлөө. Та бүхэнд ажлын их амжилтыг хүсэж, баяр хүргэе. Засгийн газрын гишүүдийн Тангараг өргөх ёслолын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдье.

18.30 цаг

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Гишүүдээ зарлал байна. Маргааш 10 цагаас чуулганы нэгдсэн хуралдаан эхэлнэ. Намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 6-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар эхлээд өглөө 10 цагаас цаг үеийн шинжтэй асуудлаар мэдээлэл сонсоно. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээлэл. Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан зам тээврийн салбарын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар сонсоно. Үдээс өмнөх цаг үеийн шинжтэй мэдээллийн асуудлаар бол та бүхэнд мэдээлэл өгсөн байгаа. Ингээд өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдэж, зарласан. Маргааш 10 цагт чуулганы нэгдсэн хуралдаанд цагтаа ирэхийг хүсье. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдсан уу? Төсөв 2 хуралдчихсан тийм ээ? Маргааш хуралдах шаардлагагүй.

18.31 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА